МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

# ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХӨГЖҮҮЛЭХ НЬ

/ГАРЫН АВЛАГА/



Улаанбаатар хот 2012 он

# ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХӨГЖҮҮЛЭХ НЬ

Гарын авлага



Гарын авлагыг бэлтгэсэн : Т.НАВЧАА
/Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль
Аялал жуулчлал-Экологийн
менежментийн тэнхимийн
эрхлэгч, дэд профессор, доктор/

Т.ПҮРЭВСҮРЭН
/Байгаль орчин аялал жуулчлалын
яамны тусгай хамгаалалттай
нутгийн удирдлагын
газрын мэргэжилтэн/

Эх бэлтгэлийг : Т.ПҮРЭВСҮРЭН

Хэвлэсэн : "ColorTeam" хэвлэлийн газар, 70110333

Энэ бүтээлийн аль нэгэн хэсгийг зөвхөн арилжааны бус зорилгоор ашиглах болон хэвлэн олшруулахдаа эх сурвалжийг нь дурдана.

Уг гарын авлага нь цөөн тоогоор хэвлэгдэх боловч цахим хувийг
БОАЖЯ-ны мэдээллийн сан болон www.mne.mn; Econet.mn
хаягаар хандан үзэх боломжтой.

# Агуулга

ӨМНӨХ ҮГ
ТАНИЛЦУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ БА АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖИЛ

1.1 Тусгай хамгаалалттай газар нутгийн хөгжлийн хандлага
1.2 Тусгай хамгаалалттай газар нутаг ба байгаль хамгаалал
1.3 Тусгай хамгаалалттай газар нутаг ба аялал жуулчлал
1.4 Монгол улсын аялал жуулчлалын хөгжлийн төлөв ба тусгай хамгаалалттай газар нутаг

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ БА ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

2.1 Эко аялал жуулчлалын тухай ойлголт, түүхэн хөгжил
2.2 Эко аялал жуулчлалын төлөвлөлт
2.3 Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын үзүүлэх нөлөөллүүд
2.4 Нутгийн иргэд, аялал жуулчлалын салбар, бусад бүс ба орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХӨГЖҮҮЛЭХ НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛЖ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН БИЙ БОЛГОХ НЬ

3.1 Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал хөгжүүлэх боломж ба нөөцийн үнэлгээ
3.2 Эко аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох алхамууд, бүтээгдэхүүний жишээ
3.3 Эко аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө боловсруулах алхамууд

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ДЭД БҮТЦИЙГ БИЙ БОЛГОХ БА ЖУУЛЧДЫН УРСГАЛ ЗОХИЦУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТ

4.1 Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын зориулалтаар бүсчлэл тогтоох, ашиглалтын хязгаарыг тодорхойлох менежмент
4.2 Тусгай хамгаалалттай газар нутагт Зорчигчийн нөлөөллийн менежментийг хэрэгжүүлэх нь
4.3 Аялал жуулчлалын зориулалтын байшин барилгуудад тавигдах шаардлагууд
4.4 Мэдээлэл, сурталчилгаа, танин мэдэхүйн үйл ажиллагаа

ТАВДУГААР БҮЛЭГ. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХӨГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА ХУУЛЬ ЭРХЗҮЙН АСУУДЛУУД

5.1 Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал эрхлэх хууль эрхзүйн үндэслэл, бодлогын баримт бичгүүд
5.2 Аялал жуулчлалын менежментийн багийг бий болгох ба хөгжлийн стратеги зарчмуудыг тодорхойлох нь
5.3 Тусгай хамгаалалттай газар нутгийн санхүүжилтийн механизм, эдийн засгийн тогтолцоо
5.4 Тусгай хамгаалалттай газарт аялал жуулчлалаас үзүүлэх нөлөөллийг үнэлэх, мониторинг хийх арга зүй

ДҮГНЭЛТ
ХАВСРАЛТ

# Тодруулга

| | |
|---|---|
| АЖГ | Аялал Жуулчлалын Газар |
| ААНБ | Аж ахуйн нэгж байгууллага |
| Ам.доллар | АНУ-ын мөнгөн тэмдэгт АНУ-ын доллар |
| БНГ | Байгалийн нөөц газар |
| БОАЖЯ | Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| БЦГ | Байгалийн цогцолборт газар |
| ДГ | Дурсгалт газар |
| ДЦГ | Дархан цаазат газар |
| ДНБ | Дотоодын Нийт Бүтээгдэхүүн |
| ДАЖБ | Дэлхийн аялал жуулчлалын байгууллага |
| ИНБНГ | Их нартын байгалийн нөөц газар |
| ТХГН | Тусгай Хамгаалалттай Газар нутаг |
| ТХГ | Тусгай хамгаалалттай газар |
| УТХГН | Улсын тусгай хамгаалалттай газар нутаг |
| УИХ | Улсын их хурал |
| IUCN | Олон улсын байгаль хамгаалах холбоо |



# Өмнөх үг

Аялал жуулчлалын үйлдвэрлэл нь аливаа улс орны хувьд зөвхөн эдийн засгийн нэгэн салбар төдийгүй, гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагаа, нийгэм-соёлын хөгжил, уламжлалт зан заншил, байгаль орчноо хадгалан хамгаалах үйл явц, орчин үеийн шинжлэх ухаан, технологийн дэвшлийг хослуулан хөгжүүлэх боломжийг олгодог өргөн цар хүрээтэй, харьцангуй нэгдмэл систем юм. Өргөн уудам нутаг дэвсгэртэй, харьцангуй цөөн хүн амтай манай оронд аялал жуулчлалын салбар сүүлийн хориод жилд харьцангуй эрчимтэй хөгжиж байгаа нь улам бүр даярчлагдаж буй өнөө үед унаган байгалийн дүр төрх, байгалийн ховор нандин үзмэр, нөөц баялаг, нүүдэлчин ард түмний уламжлал, зан заншил, соёлын өвөрмөц хэв шинжээ хадгалан үлдэх гол түлхүүр болно.

Монголын аялал жуулчлалын хөгжлийн хэтийн төлвийг тодорхойлох зорилгоор хийгдсэн томоохон судалгаа, стратеги, бодлогын хөтөлбөрүүдэд манай улсад хөгжүүлэх боломжтой аялал жуулчлалын хамгийн гол төрөл нь эко аялал жуулчлал хэмээн үзсэн байдаг. Эко аялал жуулчлал нь байгалийн нөхцөл нөөц, бүтээгдэхүүнд тулгуурласан байгальд эвсэг, нөөцийг бууруулахгүй өвлүүлэх, уламжлалт соёл зан заншлаа хадгалан, орон нутгийн ард иргэдийн аж амьдралыг дээшлүүлэхэд чиглэдгээрээ аялал жуулчлалын бусад төрлүүдээс ялгарах онцлогтой.

Одоогоор манай орны нийт нутаг дэвсгэрийн 16.4 хувийг эзэлж буй ТХГН нь аялал жуулчлалын үндсэн замнал, газруудыг

бүрдүүлж, гадаад, дотоодын жуулчдын дийлэнх хувь нь аль нэг тусгай хамгаалалттай нутгаар дайран өнгөрөх буюу саатан аялаж, аялагчдын тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх, хөгжүүлэхтэй холбоотой хууль эрхзүйн гол актууд нь "Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль", "Аялал жуулчлалын тухай хууль", 2009 онд батлагдсан "Тусгай хамгаалалттай газар нутгуудад аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр" зэрэг болно.

Хэдийгээр манай оронд эко аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөц, боломж ихтэй хэмээн үздэг ч эко аялал жуулчлалын талаар нэгдсэн ойлголт, эко аялал жуулчлалыг тусгай хамгаалалттай газар нутгуудад хэрхэн хөгжүүлбэл илүү үр дүнтэй болох талаар аргачилсан зөвлөмж, материал ихээхэн дутагдалтай байна. Мөн зарим тусгай хамгаалалттай газар нутгуудад аялал жуулчлалын даац, ачаалал хэтэрснээс үүдэлтэй сөрөг нөлөөлөл илэрч байна. Иймд тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын асуудал хариуцсан мэргэжилтэн, байгаль хамгаалагчид, орон нутгийн ард иргэдэд эко аялал жуулчлалын талаар тодорхой ойлголт бий болгох, эко аялал жуулчлалын боловсрол олгох зорилгоор энэхүү гарын авлагыг боловсруулав.

Монгол орны аялал жуулчлалын үндсэн нөөц, суурь дэвсгэр болсон ТХГН-уудад аялал жуулчлалыг байгаль орчин, экологид ээлтэйгээр, орон нутгийн хөгжилд хувь нэмэр үзүүлэхүйц түвшинд, эко аялал жуулчлалыг олон талын хамтын ажиллагаа, ойлголцлын үр дүнд тогтвортой хөгжүүлэхэд энэхүү гарын авлага тус дөхөм болно гэдэгт найдаж байна.

Энэхүү гарын авлагыг орон нутгийн байгаль орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн, хамгаалалтын захиргааны аялал жуулчлал хариуцан ажиллаж байгаа мэргэжилтнүүд, аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцогч, сонирхогч та бүхэнд зориулан гаргав.

Т.Навчаа
Т.Пүрэвсүрэн

# Танилцуулга

Монгол Улсын "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" хуулинд заасанаар Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс, Байгалийн цогцолборт газрын аялал жуулчлалын бүс, хязгаарлалтын бүс, Байгалийн нөөц газар, Байгалийн дурсгалт газруудад эрхлэхийг зөвшөөрдөг аж ахуйн гол төрөл нь аялал жуулчлалын үйл ажиллагаа юм. Ялангуяа "Байгалийн унаган төрхөө хадгалсан, түүх соёл, экологийн боловсрол, хүмүүжил, танин мэдэхүйн ач холбогдолтой аялал жуулчлал хөгжүүлэх зорилго бүхий газар нутаг" болох Байгалийн цогцолборт газрууд нь манай орны аялал жуулчлалын хөгжлийн гол суурь, төвлөрөлийн цөм болж байна. Нөхцөл, нөөцийн онцлогоосоо хамааран манай ихэнх тусгай хамгаалалттай газруудад эко аялал жуулчлалыг хөгжүүлэх бүрэн боломжтой. Харин хэрхэн зөв зохистой, байгаль орчин, нийгэм-соёлд сөрөг нөлөө, эерэг нөлөөлөлтэйгээр эко аялал жуулчлалыг хөгжүүлэх вэ?

"Тусгай хамгаалалттай газар нутагт эко аялал жуулчлалыг хөгжүүлэх нь" гарын авлага нь манай улсад мөрдөж буй хууль эрхзүйн хүрээнд улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад эко аялал жуулчлалыг хэрхэн хөгжүүлэх аргазүйн зөвлөмж хэлбэрээр бэлтгэгдсэн. Тус гарын авлага нь Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллага (World Tourism Organization), Олон Улсын Эко Аялал жуулчлалын нийгэмлэг (The International Ecotourism Society), Олон Улсын Байгаль Хамгаалах Холбоо (International union for conservation of nature) зэрэг байгууллагуудаас гаргасан Тусгай хамгаалалттай газар нутагт эко аялал жуулчлал хөгжүүлэх зөвлөмж, хөтөлбөр, Австрали, Шинэ Зеланд, АНУ, Япон зэрэг орны туршлагад тулгуурлан, манай улсад мөрдөж буй хууль, эрхзүйн хүрээнд эко аялал жуулчлалыг хэрхэн удирдан зохион байгуулж болох талаар онолын үндсэн ойлголт, олон улсын түвшинд мөрдөж буй зөвлөмж, аргачлал, гадаадын улс орнуудын жишээ, монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн жишээ гэсэн дарааллаар бичигдсэн болно.

Энэхүү гарын авлага нийт таван бүлгээс бүрдэх бөгөөд "Тусгай Хамгаалалттай Газар Нутаг (ТХГН) ба Аялал жуулчлалын Хөгжил" сэдэвт I бүлэг нь ТХГН-ийн хөгжлийн онцлог, ТХГН ба байгаль хамгаалал, ТХГН ба аялал жуулчлал, Монгол Улсын аялал жуулчлалын хөгжлийн төлөв ба ТХГН гэсэн агуулгын хүрээнд ТХГН-ийн үндсэн тодорхойлолт, Олон улсын хэмжээнд мөрдөж буй ангилал, Монгол Улсын ТХГН-ийн хөгжлийн түүх, байгаль хамгаалал ба аялал жуулчлалын уялдаа холбоо, аялал жуулчлалын үндсэн ойлголт, төрөл ангилал, Олон Улсын ба Монголын Аялал жуулчлалын хөгжлийн хэтийн төлөвийн талаар судалгааны баримтанд үндэслэн бичиж, "ТХГН дахь эко аялал жуулчлалын хөгжлийн туршлага", "Монгол улсын ТХГН-дад аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэдийн судалгааны дүн"

хэмээх жишээ, баримтыг хавсаргав.

"ТХГН ба Эко Аялал жуулчлал" II бүлэгт эко аялал жуулчлалын тухай үндсэн ойлголт, голлох тодорхойлолтууд, үүсэл, хөгжил, Эко аялал жуулчлалын төлөвлөлт ба ТХГН-ын менежментийн төлөвлөгөөний уялдаа холбоо, ТХГН-д аялал жуулчлалаас үүсэх нөлөөллүүд, нутгийн иргэд, аялал жуулчлалын салбар, бусад бүс ба орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах хамтын ажиллагааны механизмын талаар тайлбарлаж, "Дэлхийн Эко Аялал жуулчлалын Чуулган-2007"-аас гаргасан зөвлөмж, ТХГН дахь жуулчин байршуулах хэрэгсэлүүд, Өмнөд Африкт амжилттай хэрэгжсэн аялал жуулчлалын хөрөнгө оруулалтын жишээг багтаасан. "ТХГН-т аялал жуулчлал хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох нь" III бүлэгт ТХГН-т аялал жуулчлал хөгжүүлэх боломж ба нөөцийн үнэлгээ, эко аялал жуулчлалын бүтээгдэхүүн боловсруулах алхамууд, бүтээгдэхүүний жишээ, эко аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө боловсруулах аргазүйн талаар тайлбарлаж, Монгол орны Зүүн бүсийн аялал жуулчлалын өнөөгийн байдал, нөхцөл нөөцийн шинжилгээг жишээ болгон харуулав. Мөн эко аялал жуулчлалын бүтээгдэхүүн боловсруулах, менежментийн төлөвлөгөө хийх алхамуудыг Алтай Соёны эко бүс нутагт хийсэн судалгаагаар тайлбарлалаа. "ТХГН-т аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгох, жуулчдын урсгал зохицуулалтын менежмент" сэдэвт IV бүлэг нь ТХГН-т аялал жуулчлалын зориулалтаар бүсчлэл тогтоох, ашиглалтын хязгаарыг тодорхойлох менежмент, зорчигчийн нөлөөллийн менежмент, аялал жуулчлалын зориулалтаар ТХГН-т баригдах байшин барилгад тавигдах шаардлага, аялал жуулчлалын мэдээлэл, сурталчилгаа, танин мэдэхүйн үйл ажиллагааны талаарх ойлголтыг агуулсан бөгөөд манай орны Их Нартын БНГ болон Тайваны Он Хүрээлэнгийн жишээтэй.

"ТХГН-д аялал жуулчлал хөгжүүлэх удирдлага, зохион байгуулалт ба хууль эрхзүйн асуудлууд" V бүлэгт ТХГН-д аялал жуулчлал эрхлэх хууль эрхзүйн баримт бичгийн онцлог, хөгжлийн стратеги, ТХГН-ийн санхүүжилтийн механизм, эдийн засгийн тогтолцоо, ТХГН-т аялал жуулчлалаас үзүүлэх нөлөөллийн мониторингийн аргазүйг тодорхойлон Онон-Балжийн БЦГ-т аялал жуулчлалаас үзүүлж буй нөлөөллийн үнэлгээний үр дүнг жишээ болгон харууллаа.

Энэхүү гарын авлагад хавсаргасан жишээ баримтуудыг БОАЖЯ-ны захиалгаар хийгдсэн судалгааны ажил, төслийн тайлангуудаас (тухайлбал НҮБХХ-ийн "ТХГН-ын сүлжээг бэхжүүлэх нь" төсөл) тус яамны Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн Удирдлагын газрын зөвлөмжийн дагуу авсан бөгөөд зарим жишээ нь ХИС-ийн аялал жуулчлалын судалгааны багийн хүрээнд хийсэн ажлын үр дүн болно. Гарын авлагатай холбоотой санал зөвлөмжийг БОАЖЯ-ны Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн Удирдлагын Газарт ирүүлнэ үү.



# I ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ БА АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖИЛ

**АГУУЛГА:**


- Тусгай хамгаалалттай газар нутгийн хөгжлийн хандлага
- Тусгай хамгаалалттай газар нутаг ба байгаль хамгаалал
- Тусгай хамгаалалттай газар нутаг ба аялал жуулчлал
- Монгол улсын аялал жуулчлалын хөгжлийн төлөв ба ТХГН

## I.1. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэдэх Хүрээлэн буй орчны байгууллага, Дэлхийн аялал жуулчлалын байгууллага болон Дэлхийн байгаль хамгаалах холбоод хамтран "Тусгай хамгаалалттай газар нутгуудийг байгаль орчин, хүний үйл ажиллагаанд өртсөн байдал, байгалийн нөөц, цар хүрээ, тогтоц, өргөргийн онцлогоос хамааруулан дараах үндсэн 7 ангилал зэрэглэлд" оруулж үзнэ хэмээн 1983 онд тодорхойлсон (Хүснэгт 1.1) байдаг. Сүүлийн үед Олон улсын байгаль хамгаалах холбоо (IUCN), Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF), Мониторингийн төвөөс хамтран боловсруулсан тусгай хамгаалалттай газар нутгийн шинэ ангиллыг олон улсын түвшинд мөрдөх болсон[1].

Хүснэгт 1.1. *Тусгай хамгаалалтай газар нутгийн олон улсын ангилал зэрэглэл*

| Д/д | | Тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Хатуу хамгаалалттай дархан цаазат ба шинжлэх ухааны нөөц газар | Байгалийн бүсийн онцлог хэв шинжийг төлөөлж чадах, унаган төрхөө хадгалсан, шинжлэх ухаан хүн төрөлхтний соёл иргэншлийн онцгой ач холбогдолтой газар |
| 2 | Байгалийн цогцолборт газар | Байгалийн унаган төрхөө хадгалсан, түүх, соёл, экологийн боловсрол хүмүүжил, танин мэдэхүйн ач холбогдолтой, аялал жуулчлал хөгжүүлэх зорилго бүхий газар |
| 3 | Байгалийн дурсгалт газар | Ховор болон өвөрмөц тогтоц бүхий байгаль, соёлын онцгой дурсгал, гоо зүй болон соёлыг агуулж буй бүс нутаг |
| 4 | Байгалийн нөөц газар | Байгалийн нөөцийг нийгмийн хэрэгцээтэй уялдуулан тогтвортой ашиглах, нөхөн сэргээх, биологийн төрөл зүйлийг хамгаалах, зүй зохистой ашиглах, ирээдүй хойч үед өвлүүлэн үлдээх газар |

*1 IUCN, Guidelines for Protected Area Management Categories (1998). Gland and Cambridge*

| | | |
|---|---|---|
| 5 | Хамгаалагдсан ландшафт | Хуурай газар, далай тэнгисийн эрэг орчмын нутгийг хамрах бөгөөд биологийн төрөл зүйлийг хамгаалах, хүн байгалийн харилцан шүтэлцээг дэмжих экологи, соёл, гоо зүйн ач холбогдолтой газар |
| 6 | Антропологийн нөөц газар | Байгаль, хүний хоорондын харилцаанд хамгийн сүүлийн үеийн технологийг ашиглан уламжлалт аргад суурилан, нутгийн иргэдийн оролцоотойгоор байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах газар |
| 7 | Олон талын менежментийн зориулалттай ашиглах газар | Эдийн засгийн олон талт үйл ажиллагааны хүрээнд байгалийн дагалт баялгийг зүй зохистой ашиглахдаа байгаль орчинд халгүй байх |

Ихэнх улс орон өөрийн газар орны байгалийн бүс, бүслүүр тэдгээрийн онцлог, хосгүй сайхан тогтоцыг ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээж тэдний ашиг сонирхлыг зөрчихгүйгээр танин мэдэх, аялан зугаалах хэрэгцээг хангах зорилгоор дархлан хамгаалсан байдаг нь ТХГН-т аялал жуулчлал хөгжих боломжийг бүрдүүлсэн байна. Үүний тулд төр засгийн зүгээс онцгойлон анхаарч тэнд тусгай хяналт, дүрэм журмыг батлан гаргаж тусгай албыг томилон ажиллуулдаг онцлогтой. ТХГН-ийн ач холбогдол нь зөвхөн тухайн газар нутагт байгаа байгалийн өвөрмөц тогтоц, биологийн төрөл зүйлийн амьдрах орчинг хамгаалах, судлах, танин мэдэхүйгээр хязгаарлагдахгүй олон төрлийн үүрэгтэй, үнэ цэнэтэй гэдгийг улс орнуудын туршлага харуулж байна.

Хэдийгээр ТХГН-уудын ихэнх нь байгалийн унаган төрх, ан амьтан, ургамал буюу биологийн төрөл зүйлийг хамгаалах зорилгоор байгуулагдсан ч тэдгээр нь үндсэндээ хүний нийгэмд илүү ашиг тус хүргэхэд чиглэгддэг. ТХГН-д аялал жуулчлалыг оновчтой, тогтвортой хөгжүүлснээр улс үндэстний эдийн засгийн болон нийгмийн амьдралд үзүүлж байгаа нөлөөллийг олж мэдэх, түүнийг шийдвэр гаргагчид, санхүүжүүлэгчдэд ойлгуулснаар ТХГН-ийн ач холбогдлыг үнэлж, түүний хамгаалалтыг сайжруулахад нөлөөлөх боломжтой.

ТХГН-ийн хамгаалалтын үр дүнг дээшлүүлэхийн тулд



түүний байгаль орчны тэнцлийг хадгалах, байгалийн нөөц баялгийг хамгаалах замаар улсын эдийн засгийн хөгжил, орон нутгийн хүн амд үзүүлэх нийгмийн ач холбогдлыг таниулах, түүнийг өргөн сурталчилах шаардлага тулгарч байна.

Манай улсын хувьд 1990 он хүртэл тусгай хамгаалалттай газар нутгийг зөвхөн Дархан цаазат газар гэсэн ангиллаар авч үзэж байснаас гадна агнуурын нөөц газар гэсэн ангилал байжээ. Харин 1990 оноос ТХГН-ийн ангиллыг дэлхийн жишигт ойртуулах, нэгдсэн ангилал тогтоох, түүний хүрээнд хууль дүрэм боловсруулах ажлууд үе шаттайгаар хийгдэж ирсэн. Үүний дүнд ТХГН-ийн олон улсын ангиллыг баримтлан өөрийн орны өвөрмөц онцлогт тохируулан

- Дархан цаазат газар (ДЦГ)
- Байгалийн цогцолборт газар (БЦГ)
- Байгалийн нөөц газар (БНГ)
- Дурсгалт газар (ДГ) гэсэн 4 үндсэн ялгавартай ангиллаар тогтоож "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай"[2] Монгол Улсын хуулинд тодорхойлж өгсөн.

Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 16.4 % буюу 25,662 сая га талбай бүхий 74 газар улсын ТХГН-ийн сүлжээнд хамрагдаад байна (Зураг 1.1). Энэхүү ТХГН-ийн Сүлжээ нь байгалийн үзэсгэлэнт, дахин давтагдашгүй, ховор ховордсон амьтан, ургамалын гол тархац нутаг, түүх соёлын дурсгалт газруудыг төлөөлсөн байдгаараа эрчимтэй хөгжиж буй аялал жуулчлал, амралт зугаалгын гол төв болж байдаг. Мянганы хөгжлийн зорилтод зааснаар 2015 он гэхэд Монгол улсын

*2 Аялал жуулчлал. Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. БОАЖЯ, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Улаанбаатар хот, 2009 он.*

Засгийн газар ТХГН-ын хэмжээг нийт газар нутгийн 30 хувь хүртэл өсгөх зорилттой. Гэвч ТХГН-ын удирдлага, санхүүжилт энэ хурдацтай өсөлтийг хангаж чадахааргүй байгаа бөгөөд ТХГН-т аялал жуулчлалын үйл ажиллагаа эрчимжихийн хэрээр тухайн бүс нутгийн байгаль орчин, нийгэм, соёлд сөрөг нөлөөлөл ихэсдэг. Энэхүү сөрөг нөлөөллөөс сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахын тулд ТХГН-уудад явагдаж буй аялал жуулчлалын нөлөөллийг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн талаас нь үнэлж, үнэлгээний үр дүнд үндэслэн нөлөөллийг бууруулах стратегийг боловсруулан хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Мөн БОАЖЯ-ны сайдын 2009 онд баталсан "Тусгай Хамгаалалттай Газар Нутгуудад аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.4-т *"Аялал жуулчлалын үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх аливаа нөлөөллийг тогтмол хянан үнэлж, сөрөг нөлөөг бууруулах шаардлагатай арга замуудыг тодорхойлон хэрэгжүүлэх*" гэж заасан байдаг тул байгаль орчны хамгаалалтын асуудал хариуцсан мэргэжилтэн, менежерүүд ТХГН-д аялал жуулчлалыг хэрхэн зөв зохистой удирдан явуулах аргазүйд суралцах зайлшгүй шаардлагатай байна.



Зураг 1.1 . *Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ*



Корбетт үндэсний парк (Энэтхэг улс)

## I.2. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ БА БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ

«*Тусгай хамгаалалттай газар нутаг гэдэг нь биологийн олон янз байдал, байгалийн анхдагч унаган төрх байдал болон түүний дээрх соёлын үнэт зүйлсийг хамгаалах, хадгалан үлдээх онцгой зорилгоор эрх зүйн болон үйлчлэх чадвартай бусад арга хэрэгсэлээр үйл ажиллагааг нь зохицуулсан хуурай газар /далайн тодорхой хэсэг юм*» (Дэлхийн дархан цаазат газрын IV конгресс., 1992).

Олон Улсын Байгаль Хамгаалах Холбооноос (IUCN) тусгай хамгаалалттай газар нутгийг *«Байгалийн ба соёлын өв, биологийн төрөл зүйлийг зохистой ашиглах, хамгаалахад зориулан хуулийн хүрээнд хамгаалагдсан далай тэнгис ба хуурай газрын хэсэг нутаг юм»* гэж тодорхойлсон.

Тусгай хамгаалалттай газар нутгийн зорилго:

- Байгалийн болон соёлын өвийг хамгаалах,
- Нутгийн хүн амын амьдралын баталгааг хангах, сайжруулах
- Зах зээлийн эргэлтэнд нийцсэн, байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх.

Тусгай хамгаалалттай газар байгуулах нь байгаль, соёлоо хамгаалах дэлхий дахины хамгийн өргөн тархсан арга болоод байна. Дэлхийн хэмжээнд 130,000 гаруй ТХГН-ууд байгаа бөгөөд хуурай газрын 13 хувийг, далай тэнгисийн эко бүс нутгийн 1 хүрэхгүй хувийг эзэлж байна. Биологийн төрөл зүйлийн тухай конвенцийн хүрээнд 2020 он гэхэд хуурай газрын 17 % Далай тэнгисийн 10 % хувийг ТХГН-ийн сүлжээнд хамруулах зорилт тавьжээ. Байгаль хамгааллын нэг гол зорилт бол биологийн төрөл зүйл, түүний оршин тогтнох үндсэн нөхцөл болсон амьдрах орчин, ландшафт, экосистемийн олон янз байдал, түүний анхдагч унаган төрхийг хамгаалах асуудал юм. Амьдрах орчныг хамгаалах хамгийн үр дүнтэй нэг гол арга бол газар нутгийг ашиглалтын онцгой дэглэм бүхий тусгай хамгаалалтанд авч, түүнд хүний зүгээс үзүүлэх аливаа зохисгүй нөлөөллийг хязгаарлах явдал болох нь олон орны туршлагаар батлагдаад байна.

Өнөө үед газар нутгийг хамгаалалтанд авах цоо шинэ шаардлага бий болсон. Тухайлбал:

- Аливаа ургамал амьтны генофонд, байгалийн үл давтагдах онгон зэрлэг төлөв байдлыг хамгаалах
- Шинжлэх ухааны судалгаа, бүх нийтийн тогтвортой хөгжлийн боловсрол олгох

- Эко аялал жуулчлалыг хөгжүүлэх, нийтийн амрах бүс нутаг гаргах гэх мэт олон талт үйл ажиллагааг нэрлэж болно.

Тухайлбал, тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалалд гүйцэтгэх үндсэн үүргийг Төв Европын хэмжээнд дараах байдлаар тодорхойлж байдаг (Ssymank, 1997) Үүнд:

- Биологийн төрөл зүйлийг түүний зохион байгуулалтын бүх түвшинд (генетикийн, зүйлийн, амьдрах орчны олон янз хэлбэр) хамгаалах
- Байгалийн өвийг хамгаалах
- Хүний гараар бий болсон соёлын өв, уламжлалыг хамгаалах
- Суурь болон хавсарга судалгаа хийх
- Амралт сувилал хөгжүүлэх, хүмүүс байгалийн гоо сайхныг мэдэрч алжаал тайлах нутаг
- Хүмүүс байгаль, хүрээлэн буй орчны талаар мэдлэг олж авах, мэдээлэл, сурталчилгааны төв байх
- Хүрээлэн буй орчны төлөв байдал, өөрчлөлтөнд байнгын хяналт тавьж болзошгүй үзэгдлийн талаар урьдчилсан мэдээ боловсруулах
- Орчны нөөцийг хамгаалах (ус, агаар, хөрс) хамгаалах
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг экологийн баримжаатай, зохистой эрхлэхэд үлгэр авахуйц загвар нутаг байх зэрэг олон үүрэг юм.


Yellow Stone үндэсний парк (Америк улс)

Байгаль хамгааллын орчин үеийн үзэл санааны дагуу бий болсон анхны дархан цаазат газар бол 1872 онд байгуулагдсан АНУ -ын "Yellow stone" үндэсний парк юм. Энэ үеэс байгаль хамгааллын түүхэнд хөгжлийн нэгэн шинэ үе эхэлж тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулах хөдөлгөөн өрнөжээ. 1872 оноос эхлэн Yellowstone үндэсний парк олон нийтэд нээлттэй болж өнөөдрийг хүртэл олон гийчид тэнд очжээ. 1990-ээд он гэхэд нэг жилд энд амрах гэж ирэх гийчдийн тоо 400 саяас давах болж, энэ нь Yellowstone-г Америкийн хамгийн том аялал жуулчлалын зорих газар болгожээ.

## I.3. ТХГН БА АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Олон Улсын Байгаль хамгаалах Холбооны (IUCN) боловсруулсан тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрийн ангиллаар байгалийн цогцолборт газар, байгалийн дурсгалт газар, хамгаалалттай ландшафт гэсэн ангилалд багтах тусгай хамгаалалттай газруудад амралт, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн байдаг. Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал эрхлэх үйл ажиллагаа нь байгаль хамгаалал, нийгэм-эдийн засгийн хөгжлийн нэн чухал ач холбогдолтой. Унаган төрхөө хадгалсан байгалийн дүр төрх, сэтгэл татах үзэсгэлэнт өвөрмөц байдал нь өөрөө аялал жуулчлалын үндсэн гол хэрэгсэл болдог. Орчин үед аялал жуулчлалыг зөвхөн үйлдвэрлэл, үйлчилгээ гэж үзэхээс илүү ТХГН-ийн хамгаалалтыг сайжруулахад тодорхой үүрэг хүлээн байнгын тогтвортой ашиглалтын менежмент бүхий тогтвортой аялал жуулчлал болгон хөгжүүлэх үзэл баримтлалыг олон улсад баримталж байна. Ингэснээр зөвхөн байгаль орчноо хамгаалаад зогсохгүй улс орны эдийн засгийн хөгжилд чухал үүрэгтэй.

Монголд ирж буй гадаадын 10 жуулчин бүрийн 8 нь Монголын аль нэг ТХГН-т зочилсон байдаг ба 5/10 нь аяллынхаа явцад нэгээс дээш ТХГН-уудад хөтөлбөрийн дагуу аялж үзсэн байна (*Монголын Аялал Жуулчлалын Салбар ба Эдийн Засгийн Нөлөөлөл Дэлхийн Банк, 2011*). Тиймээс ч ТХГН-ууд нь Монголын аялал жуулчлалын бүтээгдэхүүний нийлүүлэлтийн үндсэн хэсэг болдог. Үнэхээр Монголын ТХГН-уудын дийлэнх нь гадаад, дотоодын жуулчдын сонирхолыг хүчтэйгээр татахуйц гол аялах обьект нь болдог учраас аялал жуулчлалын салбар өөрөө ТХГН-ын хөгжлийн нэг салшгүй бүрэлдэхүүн



хэсэг, нийлүүлэлтийн үйлдвэрлэлийн гол оролцогч тал нь болж өгдөг.

Олон Улсын Байгаль хамгаалах Холбооноос (IUCN) хийгдсэн дүгнэлт ёсоор "*ТХГН-уудад аялал жуулчлал хэрэгтэй, аялал жуулчлалд ТХГН хэрэгтэй. Эдгээрийн зохист харилцаа нь нийлж бүтэн цогцыг бүрэлдүүлэх бөгөөд аялал жуулчлал бол ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөний салшгүй чухал хэсэг төдийгүй түүнийг сайжруулах нэгэн хэрэгсэл болж чадна»*"(*Eagles, P.F.J., McCool, S.F and Haynes, 2002*) хэмээжээ.

Судлаачид тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ дараах асуудлуудыг чухалчлан үзэхийг анхааруулсан байдаг (Peter Valentine, 1992). Үүнд:

1. Тухайн тусгай хамгаалалттай газрын онцлогт тохирсон аялал жуулчлалын тохиромжтой хэлбэрийг тодорхойлох
2. Тур оператор болон тусгай хамгаалалттай газар нутгийн менежерийн хооронд тохиромжтой харилцааг тогтоох
3. Тусгай хамгаалалттай газар нутаг болон орон нутгийн байгууллагын хооронд түншлэл бий болгох
4. Тусгай хамгаалалттай газар нутаг дахь аялал жуулчлалын хамгийн бага нөлөөлөл буюу хяналт
5. Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх боломжит багтаамжийн түвшин, тохирох даацыг тогтоох

ДАЖБ-аас гаргасан "Аялал жуулчлал 2020 онд" судалгаанаас үзэхэд XXI зуунд аялал жуулчлалын дараах 5 төрөл давамгайлан хөгжих төлөвтэй байна (Зураг 1.2). Үүнд:

- Адал явдалт жуулчлал - Adventure tourism
- Эко жуулчлал - Ecotourism
- Тусгай сонирхлын жуулчлал - Special interest tourism
- Тойрон аялал - Round trip
- Соёл-танин мэдэхүйн жуулчлал - Culture tourism




Зураг 1.2. *Аяллын төрлүүд (Эх сурвалж: ДАЖБ, «Аялал жуулчлал 2020 онд» судалгаа)*

Хүснэгт 1.2. *Аялал жуулчлалын төрөл, тайлбар*

| **Эко аялал жуулчлал** | **Хүрээлэн буй орчныг хамгаалах, нутгийн иргэдэд дэмжлэг үзүүлж байгальд хариуцлагатайгаар аялах аялал** |
|---|---|
| Агро аялал жуулчлал | Орон нутгийн газар тариалан, тариачдын амьдралыг нэн түрүүнд сонирхон аялдаг аяллын нэг хэлбэр. Энэ төрлийн аялал нь газар тариалангийн аж ахуй хөгжсөн, хөгжиж буй жижиг улс орнуудад илүү тархсан бөгөөд аялагчид аж ахуйн өдөр тутмын ажилд оролцон дадлага туршлага олж авах боломжтойгоороо онцлог юм. |
| Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал | Орон нутгийн иргэд буюу тухайн газарт байнгын оршин суугчдын байгуулсан нөхөрлөлд жуулчдыг зочлуулж, хоол ундаа, орон байраар хангах үйлчилгээ бүхий аялал жуулчлал юм. Энэ төрлийн аяллын зорилго нь аялал жуулчлалын үйл ажиллагаа, хөгжилд орон нутгийн иргэдийн оролцоо, дэмжлэгийг нэмэгдүүлэх, аялал жуулчлалаас орж буй орлогыг шударга хувиарлан тэдэнд хүргэх явдал юм. |

| | |
|---|---|
| Ядуурлын эсрэг аялал жуулчлал | Хөгжиж буй улс орнуудын хүн ардад аялал жуулчлалаас орлого оруулах, замаар орон нутгийн эдийн засгийг сайжруулах зорилготой аяллын хэлбэр. Аялал жуулчлалаас орох хувь нэмрийг нэмэгдүүлэх, ядуу буурай иргэдийн аялал жуулчлалд оролцох оролцоог өсгөх боломжтой болох бөгөөд энэ аяллын хүрээнд орон нутгийн ядуу иргэдэд ажлын байрыг нэмэгдүүлэх, тэднийг шийдвэр гаргах түвшний үйл ажиллагаанд оролцуулах явдал юм. Энэ нь тусгай бүтээгдэхүүн, бие даасан салбар биш боловч аялал жуулчлалыг хөгжүүлэх менежментийн нэг арга зам болдог. |
| Хариуцлагатай аялал жуулчлал | Жуулчид хүрээлэн буй орчиндоо элгэмсэг хандаж, тухайн орны зан заншлыг хүндэтгэн, аялал жуулчлалаас гарах сөрөг нөлөөллийг багасган аялж байгааг хариуцлагатай аялал жуулчлал гэнэ. Илүү жуулчдад чиглэсэн зарчмыг баримталдаг. |

Байгальд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн гол бүрдэл нь унаган төрхөө хадгалсан үзэсгэлэнт байгаль, түүний өвөрмөц бүтэц, тогтоц, цэвэр агаар, тунгалаг ус, ховор, ховордсон ургамал, амьтан юм. Эдгээрийг товч тайлбарлья:

*Уур амьсгал (Climate):* Ер нь уур амьсгалын хүчин зүйл аялал жуулчлалын салбарт ихээхэн чухал хамааралтай байдаг. Ялангуяа ямар төрлийн аяллыг хэзээ хөгжүүлэх боломжтой вэ? гэдэг нь эн тэргүүнд уур амьсгалын хүчин зүйлээс шууд хамаардаг. Тэрчлэн ямар төрлийн жуулчдыг татах вэ? гэдэгт голлон нөлөөлдөг бодит хүчин зүйл болдгоороо онцлог юм. Тиймээс аливаа жуулчин хүнийг тухайн газар аялал зайлшгүй хийхэд хүргэж буй сэтгэл татах хүчин зүйлийн нэг нь уур амьсгал болдог.

*Байгалийн гоо үзэсгэлэн (Scenic Beauty):* Тухайн газар орны байгалийн үзэсгэлэнт байдал, гоо үзэмж нь аялал хийхэд нөлөөлөх томоохон хүчин зүйл, аяллын үзмэр болно. Ялангуяа хүний үйл ажиллагаанд өртөн хөндөгдөөгүй, унаган төрхөө хадгалсан байгалийн янз бүрийн хэв шинж тэдгээрийн хослон цогцолсон байдал нь жуулчдад тун чухал сэтгэгдэл төрүүлдэг. Нөгөө талаас байгальд түшиглэсэн аяллын төрөл хэлбэрүүд хөгжих боломжийг олгож байна. Тухайлбал:

- хээрийн аялал (camping and tenting)

- явган аялал (walking and hiking)
- ууланд авирах аялал (climbing)
- шувуу ажиглах аялал (bird watching) гэх мэтээр олон төрлийн аяллыг дурьдаж болно.



Какаду үндэсний парк (Австрали улс)

### Жишээ.1: ТХГН дахь Эко аялал жуулчлалын хөгжлийн туршлагаас

Эко аялал жуулчлал нь эдийн засгийн өсөлтийн гол эх сурвалж болохыг бусад орны туршлага харуулж байна. Тухайлбал уур амьсгалын хувьд манайхтай төстэй Канад улс байгалийн цогцолборт газрын аялал жуулчлалаар жил бүр 2.5 тэрбум канад долларын, Коста-Рика 330 сая америк долларын ашиг олдог ажээ. Тусгай хамгаалалттай газар нутаг нь байгалийн өвөрмөц тогтолцоо унаган төрх, ховор ургамал, ан амьтныг хамгаалах, шинжилгээ судалгааны чанартай мэдээ материалыг цуглуулах, экологийн хүмүүжил, боловсрол олгоход чиглэгдэхээс гадна аялал жуулчлалын хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал ТХГН нь Зүүн болон Өмнөд Америк, Коста-Рика, Эквадор, Энэтхэг, Непал, Индонез зэрэг орнуудад аялал жуулчлалын үндсэн цэг болдог байна. Саяхан болтол гадаадын аялал жуулчлал зөвхөн хоёрдахь зорилго нь болж байсан Ази, Өмнөд Америкийн олонхи орны үндэсний байгалийн хүрээлэн өнөөдөр үндэсний аялал жуулчлалын гол төв газар болжээ. Бразил, Аргентины үндэсний байгалийн хүрээлэн жил бүр 2 сая жуулчин хүлээж авдаг. Явагийн Кибодасын дархан газар, Тайландын Хао Яайгийн үндэсний байгалийн хүрээлэн, Энэтхэгийн Вхаратпурын үндэсний байгалийн хүрээлэн зэрэг нь дотоодын аялал жуулчлалд нэн ач холбогдолтой газар болжээ.

Австралид жуулчилж буй нийт жуулчдын 68 хувь буюу 3.5 сая жуулчид тус улсад хийх жуулчлалыг "байгалийн аялал жуулчлал" гэж тодорхойлдог байна. Эдгээр жуулчид муж/үндэсний байгалийн цогцолборт газрууд, ТХГН-аар аялах сонголтыг хамгийн ихээр хийдэг байна. Австрали улсын Какаду, Улуру-Ката Тжута Үндэсний паркууд, Грэйт Барриер Рийф далайн бүсийн паркууд нь жуулчдын үндсэн хөтөлбөрт зайлшгүй багтдаг ба улсын эдийн засагт ч их орлого оруулдаг байна. Дээр нэр дурдсан ТХГН-уудад жилд давхардсан тоогоор 83 сая хүн аялдаг гэсэн тоо гарна. Австрали ба бусад орны ТХГН-уудаар аялах жуулчдын тоо ийнхүү өсөж, жуулчдын амралт цэнгээний хөтөлбөр, үйл ажиллагааны төрөл улам бүр төрөлжин, олширч буй өнөөгийн хандлага нь

тэдгээр газар орнуудын байгалийн баялагт хүний хүчин зүйл, нөлөө ихээр үйлчилж байгаа юм биш байгаа гэсэн зүй ёсны хардлагыг бий болгож байна. Иймд ТХГН-ийн захиргаад, аялал жуулчлалын компаниуд, хувийн хэвшлийнхэн, жуулчид гийчид тухайн ТХГН-ийн байгаль, соёл, ёс заншил түүхийн өв, нөөцийг хамгаалах, нөгөөтэйгүүр жуулчид гийчдийн тав тух, сэтгэл ханамжийг хангах үйлчилгээний чанарыг хангах давхар зорилгыг биелүүлэхийн тулд зохистой мэдлэг, мэдээллээр бүрэн хангагдсан байх шаардлагатай байна.

Эх сурвалж: Guidelines for Tourism in Parks and Protected Areas of East Asia, IUCN – The World Conservation Union, 2001

*Далайн эрэг (гол, ус, мөрөн, нуур) (Beaches and Marine areas):* Үзэсгэлэнт гол, мөрөн, нуур, далай, тэнгис, түүний эрэг зэрэг нь аялал жуулчлалын чухал үзмэрт ордог. Үүнд түшиглэн янз бүрийн усан аяллын төрөл хэлбэрүүдийг хөгжүүлдэг. Далайн эргийн наран шарлагын газрууд нь жуулчдыг асар олноор татдаг.

*Амьд байгаль (Flora and Fauna):* Үүнд цэцэг ургамал, ой мод, ан амьтан тэргүүтэн байгалийн амьд эд эс бүхнийг хамруулан авч үздэг байна. Тухайлбал:

- тодорхой хяналттай ангийн аялал
- шувуу ажиглах
- цэцэг түүх
- агуйн аялал
- эрвээхэй ажиглах
- ургамал судлалын болон хөдөө аж ахуй, фермийн аялалууд нь амьд байгальд тулгуурлан явагдана.

*Байгалийн өвөрмөц тогтоцууд (Special Environmental*



*Features):* Энд байгаль, газарзүйн сонин тогтоц, өвөрмөц хэв маяг бүхий уул хад чулуу, геологийн ер бусын орчин, халуун рашаан, уурхай, галт уулын чулуулаг, үлдэц зэргийг хамруулан багтаажээ. Олон төрлийн аяллыг энэхүү үзмэрт түшиглэн зохион байгуулна. Тухайлбал:

- Ууланд авирах
- Оргилд хүрэх (climbing tour)
- Агуйн аялал (caving)
- Рашааны аялал
- Агуйг сонирхох зэрэг аялалуудыг нэрлэж болно.

*Эмчилгээ сувилгааны нөөц ба эрүүл мэндийн аялал (Health Tourism):* Дэлхий дахинаа эрчимтэй хөгжиж буй аяллын тоонд Эрүүл Мэндийн аялал зүй ёсоор ордог. Эрүүл мэндийн аялал нь үндсэн 4 төрөлд хуваагддаг. Энэ төрлийн аялал хийх үндсэн хүчин зүйлүүдийн тоонд эмчилгээний шавар, ус, рашаан, ургамал, агаар, чулуу, элс, зэрэг хүний биеийн төрөл бүрийн өвчнийг анагаах увидастай байгалийн гайхамшигт бүтээлүүд орно. Аялал жуулчлалын дэлхийн чиг хандлага өөрчлөгдөж амралтаараа далайн элсэн дээр хэвтэж, наранд биеэ шарж зугаа цэнгэл хөөцөлдөн амрахаас илүүгээр байгаль, ан амьтан, түүх соёлтой танилцах, өөрийн сонирхолд нийцсэн идэвхтэй хэлбэр рүү шилжиж байна. Ийм учраас соёлын аяллаар аялах аялагчдын тоо сүүлийн жилүүдэд улам их болох хандлагатай байна. "Partners in tourism" бүтээлээс үзвэл АНУ-ын насанд хүрсэн 33 сая жуулчны 17% нь түүх соёлын аяллаар аялдаг гэсэн тоо гаргажээ. Энэ нь эдүгээ дэлхий дахинд түүх соёлын аялагчид улам өсөж байгааг харуулж байна.




Зураг.1.3. *Жуулчны сэтгэл татах аяллын багц*
*(Эх сурвалж: Tourism Highligts, 2007)*

Аялал жуулчлалын ямар хэлбэрүүд хаана илүү хөгжиж байгааг судалж үзэхэд дараах байдалтай байна.

*Ази тив*: Энэ дундаа зүүн өмнөд Азийн улс орнуудад өдөр тутмын амьдралын хэв маягийг үзэж сонирхох аялал жуулчлал, урлагийн бүтээлүүдийг үзэж сонирхох аяллын төрлүүд дэлхийн бусад улс орнуудыг бодвол илүү их хөгжиж чадсан байна.

*Америк тив:* Америк тивд ялангуяа Өмнөд Америкт соёлын аялал жуулчлалын төрөл болох соёлын үйл явдлын аялал жуулчлал, урлагийн тоглолт үзэх зорилготой аялал жуулчлал, багт наадмыг сонирхох аялал жуулчлал илүү хөгжиж байна.

*Европ тив:* Европд соёлын асар их нөөц баялаг буй бөгөөд соёлын өв маш их байдаг учир соёлын өвийн аялал жуулчлал, хотын аялал хөгжсөн. Үүнийг дараах улсуудын жишээгээр авч үзвэл:

- Англи улсын Кент мужид орших МЭ 800 онд баригдсан Английн эртний Хаадын Рочестр цайз. Мөн тус мужид байдаг манай гаригийн хамгийн үзэсгэлэнтэй цайз гэж нэрлэгддэг Лиц цайзийг үзэхээр жилд 280 мянган гадаадын жуулчид ирдэг байна. Мөн байрны үнэ унаснаас шинээр баригдах зочид буудлууд нь байр эзэмшигч, түрээслэгчдэд шинэ боломжийг бий болгож байна.
- Соёлын аялал жуулчлал өндөр хөгжиж буй орон бол Франц юм. Францад ирдэг жуулчдын бараг тал хувь нь энэ төрлийн аяллаар аялдаг. Леноардо да Винчи, Пикасо, Рембрандт гэх мэтийн алдартай зураачдын зураг баримлууд нь дэлхий олон сая жуулчдын Францийг зорих шалтгаануудын нэг болдог. Мөн архитектурын гайхамшигийг харуулсан Францийн Дарь





Эхийн сүм, Италийн Ром хот зэрэг нь Европт дээрх төрлийн аялалыг хөгжүүлэх нөөц болдог. Европт тээш зөөгчтэйгээр саяхнаас аялах болсон байна. Жирийн жуулчид ч гэсэн хувийн байр сууриа харуулах онцлогтой аяллуудыг илүү сонирхох болжээ.

*Африк тив:* Африкийн зэрлэг зэлүүд тал, тэнд амьдран суух овог аймгууд нь угсаатны болон орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх үзвэр болдог. Энэ ч үүднээс энэ тив угсаатны болон өдөр тутмын амьдралыг үзэж сонирхох аялал жуулчлал хөгжих боломжтой.

*Австрали тив:* Австрали орны уугуул оршин суугчид болох Аборогенуудын өвөрмөц амьдралын хэв маягийг үзэх гэж жуулчид олноор ирдэг. Энэ бүхнээс дэлхийн соёлын аялал жуулчлалын чиг хандлага харагдаж байна. Соёлын аяллаар үйлчлүүлэхийг хүсэгчид өөрсдөө соёлын ямар зүйлсийг сонирхож байгаадаа хөтлөгдөн дээрх улс орнууд руу аялж байна. Жуулчлалаар очсон газар хэмээн томъёолж буй газрыг аялал жуулчлал судлалд "зорих газар" буюу Destination гэдэг. "Жуулчдын зорих газар гэдэг нь аялагчдын амралт чөлөөт цагаа ая таатай өнгөрүүлэхэд зориулагдсан үйлчилгээнүүд болон үзмэрүүдийг төвлөрүүлсэн газрыг хэлнэ". Тодорхойлолтоос үзвэл аялал жуулчлалын зорих газарт доорхи зүйлс зайлшгүй байх ёстой байна. Үүнд:

- Жуулчдын сонирхлыг татахуйц объектууд
- Жуулчдын аяллын явцад үүсэх аливаа хэрэгцээг хангахад чиглэгдсэн үйлдвэрлэл-үйлчилгээний иж бүрдэл
- Жуулчдын аюулгүй ба тав тухтай аялах боломжийг хангасан дэд бүтцийн болон хууль эрх зүйн найдвартай систем

Жуулчдын сонирхол татахуйц объектуудыг ерөнхийд нь жуулчдын сэтгэл татах үзмэр буюу Attraction гэдэг. Сэтгэл татах үзмэр нь маш олон хэлбэртэй байж болно. Үүнд:

- Байгалийн үзэсгэлэнт газрууд, өвөрмөц тогтоцууд
- Түүх соёлын дурсгалууд
- Урлагийн тоглолт, наадам, төрөл бүрийн фестиваль, шоу
- Адал явдалт аялал, рашаан эмчилгээ, төрөл бүрийн арга хэмжээ

Жуулчны сэтгэл татах үзмэрийг судлаачид янз бүрээр ангилсан байдаг.

- Хүрээлэн буй орчны /байгаль, нийгэм, соёлын/ үзмэрүүд
- Хүний гараар бүтээгдсэн бодитой орших үзмэрүүд
- Үйл явдлын үзмэрүүд

Жуулчдын аяллын явцад үүсэх аливаа хэрэгцээг хангахад чиглэгдсэн үйлдвэрлэл-үйлчилгээний иж бүрдэл гэдэг нь товчхондоо олон төрлийн байгууллагууд юм.

- Хүлээн авах ба дамжин өнгөрүүлэх байгууллагууд
- Нийтийн хоолны болон бусад үйлчилгээний газрууд
- Тээврийн үйлчилгээний байгууллагууд
- Амралт, зугаа цэнгээний болон спортын цогцолборууд

Хэдийгээр дэлхий дээр аялал жуулчлалд сөргөөр нөлөөлдөг терроризм, дайн, байгалийн гамшиг гэх мэт зүйлүүд давтагдан гарч байгаа хэдий ч нийтдээ аялал жуулчлал сүүлийн 3 дахь жилдээ өссөн дүнтэйгээр гарч байна.




Зураг 1.4. *Аялал жуулчлалын хөгжлийн хэтийн төлөв: 2010 ба 2020 он (Эх сурвалж: ДАЖБ, "Аялал жуулчлал 2020 онд" судалгаа)*

2020 онд жуулчдын тоо 1995 онтой харьцуулахад 3 дахин нэмэгдэж 1,6 тэрбумд хүрэх бөгөөд Ази, Номхон далайн бүс нутагт аялах жуулчдын тоо дэлхийн бусад бүсүүдээс илүү хурдацтай нэмэгдэнэ гэж судлаачид үзжээ. Энэ нь тус бүс нутагт эдийн засгийн өсөлт нэмэгдэж, худалдаа арилжаа ихээхэн либеральчлагдаж байгаатай холбоотой. Тухайлбал БНХАУ-д ирэх жуулчдын тоо жил бүр 8 хувиар өсөх төлөвтэй байгаа нь Монголд ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх таатай боломж юм. Иймд хөрш орнуудтай аялал жуулчлалын зах



зээл дээр идэвхтэй хамтран ажиллах шаардлагатай байна. Түүнчлэн ирэх 20 жилд Герман, Япон, АНУ, БНХАУ, Англи, ОХУ-ын иргэд гадаадад хамгийн их жуулчлах ба 55-59 насны жуулчид давамгайлж, 15-25 насны жуулчид дэлхийн нийт аяллын 20 орчим хувийг эзэлнэ гэж үзэж байна. Ер нь аялал жуулчлал нь эдийн засгийн өсөлт, хувь хүмүүсийн орлогын хэмжээнээс шууд хамааралтай хөгждөг бөгөөд иргэдийн орлого 2,5 хувиар өсөхөд аяллын зардал 4 хувиар өсдөг болохыг судлаачид тогтоожээ.[3] Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас гаргасан прогнозоос харахад 2020 онд нийтдээ 1,6 тэрбум жуулчин зорчино гэж үзэж байна. Энэ нь жил бүр 4,1 %-ийн өсөлттэй байх дүн юм. Тэгэхдээ Ази, Номхон далайн орнуудад жил бүр дунджаар 6,0% -ийн өсөлттэй байх бөгөөд 2020 он гэхэд нийтдээ 416 сая жуулчин хүлээн авна гэсэн магадлалтай байна. Энэ нь нийт зах зээлийн 26% байх үзүүлэлт юм.

*3 ДАЖБ, «Аялал жуулчлал 2020 онд» судалгаа*

## I.4. МОНГОЛ УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВ БА ТХГН

Монгол улс 1990 оноос зах зээлийн нийгэмд шилжсэнээр аялал жуулчлалын салбар зах зээлийн механизмаар харьцангуй хурдацтай хөгжиж байна. 2000 онд УИХ – аас Аялал жуулчлалын хуулийг баталсан нь салбарын эрх зүйн болон бодлогын орчин бүрдсэн бөгөөд 1998 – 1999 онуудад Европын холбооны Тасис хөтөлбөр, Япон улсын засгийн газрын дэмжлэгтэйгээр Монголын аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр Мастер төлөвлөгөөг боловсруулсан нь аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд чухал алхмууд болсон. 2003 оныг "Монголд зочлох жил" болгон зарлаж монгол орныг гадаадад сурталчлах, аялал жуулчлал хөгжих таатай нөхцөл бүрдүүлэх, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, жуулчдын аюулгүй байдлыг хангах, байгаль орчин, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах чиглэлээр бодитой ажлуудыг зохион байгуулсан бөгөөд аялал жуулчлалын салбарын хөгжлийг түргэсгэх зорилгоор Монголд зочлох жилийг 2004 онд үргэлжлүүлсэн. Монгол улсын Засгийн газар аялал жуулчлалыг эдийн засгийн чухал салбаруудын нэг болгон хөгжүүлэх зорилт дэвшүүлэн ажилласны дүнд салбарын орлого 2010 оны байдлаар 222.4 сая ам.долларт хүрчээ. 2010 онд 557,414 гадаадын иргэд Монгол Улсад зорчсоны 456,303 нь жуулчид байжээ. 2002 он хүртэл жуулчдын тоо тогтмол өсч байсан бөгөөд 2003 оны Азийн ханиад /SARS/, Иракийн дайн, 2008, 2009 онуудад дэлхийг хамарсан эдийн засгийн хямралын улмаас жуулчны тоо буурсан боловч 2010 онд өмнөх онтой харьцуулахад 10.8%-иар өсч сэргэх хандлагатай болсон. Одоогоор Монголд ирж байгаа жуулчдын 92 хувийг БНХАУ, ОХУ, БНСУ, Япон, АНУ, ХБНГУ, ИБУИНВУ, БНКУ, Австрали зэрэг 10 орны жуулчид бүрдүүлдэг.

Хүснэгт 1.3. *Монгол Улсад ирсэн жуулчид бүс нутгаар (2008-2010 он)*

| Бүс нутгаар | 2008 | 2009 | 2010 |
|---|---|---|---|
| Өмнөд ба Зүүн Ази болон Номхон далайн орнууд | 264213 | 239,704 | 261,765 |
| Европ | 159884 | 152,783 | 171,016 |
| Америк | 15817 | 14,179 | 16,522 |



| | | | |
|---|---|---|---|
| Австрали | 5433 | 4,492 | 6,325 |
| Африк | 592 | 482 | 636 |

Манай улсад 2010 онд АНУ-аас 16,522 жуулчин ирж Америкийн орнуудыг тэргүүлсэн бол мөн онд ХБНГУ-аас 8093 жуулчин ирж Европын орнуудыг тэргүүлж байна. Нийт жуулчдын 50 орчим хувийг БНХАУ-ын, 20 орчим хувийг ОХУ-ын жуулчид эзэлдэг нь жилд хүрэлцэн ирсэн нийт жуулчдын 70 гаруй хувийг зөвхөн хөрш хоёр орноосоо авсан үзүүлэлт гарч байна. Энэ үзүүлэлтээс харахад, бидний цаашид ажиллах аялал жуулчлалын гол зах зээл хоёр хөрш маань мэт харагдавч томоохон аялал жуулчлалын байгууллагууд голлох зах зээлээ Европ, Америк, Япон, Солонгос улс хэмээн үзэж, үлдсэн энэ 30 орчим хувиас аялал жуулчлалын салбарын гол орлого бүрдэж байгаа дүр төрх харагдаж байна.

Өмнөд, хойд хоёр хөршийн жуулчдын дийлэнх нь хувийн хэргээр зорчиж, харин бусад голлох зах зээлийн орнуудын жуулчид цэвэр аялал жуулчлалын зорилгоор ирдэг. Жуулчид Монголын аялалд дунджаар 2 долоо хоногийг зарцуулдаг ба нийт жуулчдын талаас илүү хувь нь 8-21 хоногийг аялалд зориулдаг байна. Аяллын үргэлжлэх хугацаа нь зах зээлийн сегментүүдээр харилцан адилгүй бөгөөд тухайн жуулчдын хаанаас Монгол орныг зорин ирж байгаагаас тэдний аяллын үргэлжлэх хугацаа хамаардаг байна. Америк, Герман, Англи зэрэг холоос зорин ирдэг жуулчдын хувьд Монголд аялах хугацаа нь хамгийн урт буюу 14 хоногоос дээш байхад харин ойрын зайнаас ирдэг Өмнөд Солонгос, Япон зэрэг Азийн орны жуулчид ойролцоогоор нэг долоо хоногийг аялалд зарцуулдаг

нь эдгээр улсын ажиллагсдын ээлжийн амралтын хоног цөөн байдагтай холбоотой байх магадлалтай. Харин дотоодын аялагч, жуулчдын талаарх сүүлийн үеийн бодит судалгаа, мэдээлэл алга байна.

АНУ-ын дэмжлэгээр Монголд хэрэгжсэн "Эдийн засгийн бодлогын шинэчлэлт, өрсөлдөх чадвар төсөл"-ийн 2005-2006 онд жуулчдын дунд явуулсан санал асуулга, судалгаагаар нийт жуулчдын 78% нь байгалийн үзэсгэлэнт газар, 60% нь монголын уламжлалт соёл, 32% нь адал явдалт аялал нь Монголд аялах гол шалтгаан болсон гэж хариулсан байдаг. Нэн ялангуяа Германы жуулчдын 89%, Японы жуулчдын 75% нь байгалийн үзэсгэлэнт байдлыг үзэхийг чухалчилсан бол Америк болон Английн жуулчдын 67 гаруй хувь нь байгалийн үзэсгэлэнг үзэхээс гадна нүүдэлчдийн амьдрал ахуй, соёл, иргэншилтэй танилцахыг гол зорилгоо болгосон үзүүлэлт гарсан байна.

Харин Солонгосын жуулчдын 70 орчим хувь нь уламжлалт соёлтой танилцах гэхээсээ илүү байгалийн үзэсгэлэнг үзэж байгальд амрахыг жуулчлалын гол шалтгаанаа гэж үзжээ. Мөн Английн жуулчдын 50 орчим хувь нь адал явдалт аялал хийхээр Монголыг зорьж ирсэн нь бусад орны хэрэглэгчдээс хамгийн өндөр үзүүлэлтэд тооцогдож байна. Мөн судалгаанаас Монгол орноор аялсан жуулчдын байршлыг харахад жуулчдын голлон аялдаг газрууд нь Хархорин (33%), Өмнөговь (29%), Тэрхийн цагаан нуур (21%), Хөвсгөл (20%), Тэрэлж (19%) зэрэг газрууд болж байна. Харьцангуй удаан хугацаагаар аялал хийж буй жуулчид болох АНУ, Англи, Германы жуулчид нь аяллын нэг газарт дунджаар 1 хонодог ба тэдний аяллын гол маршрут нь хамгийн урт буюу Тэрэлж, Говь, Хархорин, Архангайн, Тэрхийн цагаан нуур, Хөвсгөл байна. Харин Япон, Солонгосын жуулчид нь аяллын нэг газартаа 2-3 хонодог бөгөөд тэдний гол маршрут нь харьцангуй богино буюу Тэрэлж-Говь- Хархорин гэсэн маршрут байдаг [4].

---

*4 Олон улсын ба дотоодын аялал жуулчлалын талаар 2004 онд явуулсан судалгааны дүн. ЗТАЖЯ, Улаанбаатар, 2005*

*Тайлбар: АНУ-ын «Эдийн засгийн бодлогын шинэчлэлт, өрсөлдөх чадвар төсөл»-ийн 2005-2006 онд жуулчдын дунд явуулсан санал асуулга, судалгаанаас хойш дахин судалгааны ажил хийгдээгүй байна. Мөн дотоодын аялагч, жуулчдын талаарх сүүлийн үеийн бодит судалгаа, мэдээлэл алга байна.*

Хүснэгт 1.4. *Монгол орны ТХГН-д аялсан жуулчдын тоо, жуулчдын ангиллаар*

| | УТХГНутгуудын нэр/жуулчдын ангилал | 2009 | | 2010 | | 2011 | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дотоод | Гадаад | Дотоод | Гадаад | Дотоод | Гадаад |
| 1 | Богд хан уулын ДЦГ | 50067 | 1310 | 21250 | 2120 | 59950 | 1480 |
| 2 | Говийн Их Дархан цаазат газар «А» хэсэг | 132 | 12 | 1024 | 52 | 1700 | 17 |
| 3 | Говийн Их Дархан цаазат газар «Б» хэсэг | 9 | 27 | 180 | 46 | 3 | 5 |
| 4 | Говийн бага ДЦГ | - | 2014 | - | 4276 | - | - |
| 5 | Дорнодын УТХГ | 31 | 7 | 45 | 22 | 26 | 14 |
| 6 | Монгол Алтайн нурууны УТХГ | 229 | 939 | 265 | 956 | 563 | 947 |
| 7 | Нөмрөгийн ДЦГ | 184 | 29 | 15 | 22 | 21 | 25 |
| 8 | Отгонтэнгэрийн УТХГ | 1950 | 228 | 1721 | 215 | 2548 | 181 |
| 9 | Увс нуурын УТХГ | 2384 | 146 | 4356 | 435 | 8784 | 704 |
| 10 | Хар Ус нуурын УТХГ | 125 | 32 | - | - | 3000 | 500 |
| 11 | Хан Хэнтийн УТХГ | 36432 | 10000 | 59311 | 19482 | 71234 | 19263 |
| 12 | Хөвсгөлийн УТХГ | 10233 | 4021 | 14590 | 4620 | 20036 | 4664 |
| 13 | Хөх Сэрхийн нурууны ДЦГ | 65 | - | 299 | 540 | 450 | 250 |
| 14 | Хөгнө Тарнын БЦГ | 85 | 750 | - | 865 | 197 | 864 |
| 15 | Тужийн нарс УТХГ | - | - | 105 | - | 590 | - |
| 16 | Говь Гурван сайханы БЦГ | 1405 | 3414 | 3329 | 3280 | 4700 | 5520 |
| 17 | Дарьгангын БЦГ | 3500 | 100 | 3000 | 150 | 3800 | 95 |
| 18 | Их богд уулын БЦГ | 120 | 13 | 310 | 60 | 410 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | Мөнххайрханы БЦГ | 93 | 71 | 322 | 60 | 172 | 90 |
| 20 | Орхоны хөндийн БЦГ | 5507 | 2672 | 9911 | 3839 | 9844 | 3524 |
| 21 | Онон Балжийн БЦГ | 1107 | 163 | 1195 | 114 | 1100 | 130 |
| 22 | Хангайн нурууны БЦГ | 3922 | 3274 | 3786 | 3096 | 4739 | 3601 |
| 23 | Хустай нурууны БЦГ | 3419 | 6000 | 1816 | 8480 | 2611 | 9024 |
| 24 | Тарвагатайн нурууны БЦГ | 269 | 20 | 275 | 10 | 20 | 11 |
| | *Нийт жуулчдын тоо* | *121268* | *35242* | *127105* | *52740* | *196498* | *50999* |

Хүснэгт 1.5. *ТХГН-д аялсан жуулчдын тоо, жуулчдын ангиллаар, өсөлт хувиар*

| Жуулчдын ангиллаар | **Жилийн өсөлтийн хувь** | | | | | | | | | Жилийн дундаж өсөлт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2008/2007 | | 2009/2008 | | 2010/2009 | | 2011/2010 | | |
| Он | 2007 | | 2008 | | 2009 | | 2010 | | 2011 | 2007-2011 |
| Дотоодын жуулчин | 150574 | 122.7 | 184754 | 65.6 | 121268 | 104,8 | 127105 | 154,6 | 196498 | 111,9 |
| Гадаадын жуулчин | 61034 | 90.8 | 55399 | 63.6 | 35242 | 149,7 | 52740 | 96,7 | 50999 | 100,2 |

Тайлбар: ТХГНутгуудад аялсан жуулчдын тоог "Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх ажил үйлчилгээний нэг удаагийн тасалбар"-ын зарцуулалтын тайлангийн дүнгээр тооцсон болно.

Манайд "Монголын экотуризмын хөгжил" үндэсний зөвлөгөөн 2001 онд анх удаа болсон. Энэ зөвлөгөөний үр дүн нь төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийнхэн эрдэмтэн судлаачидтай хамтран Монголын эко аялал жуулчлалын тодорхойлолт, удирдамж, шалгуур, зохион байгуулалтын болон аюулгүй байдал санхүүгийн системийг хэрхэн зохион байгуулж шийдэх талаар санал зөвлөмжөө нэгтгэж, Монголын засгийн газарт дэвшүүлсэн юм.



Тус зөвлөгөөнөөс "*Байгаль орчин, нүүдлийн соёл иргэншил, уламжлалт ёс заншлыг танин мэдсэнээр тэдгээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгахад чиглэгдсэн байгаль хамгаалал ба нутгийн иргэдэд ашиг тус эерэг нөлөө бүхий аялал жуулчлалын хэлбэрийг эко аялал жуулчлал гэнэ"* (Монголын Экотуризмын Үндэсний Зөвлөгөөний эмхтгэл. 2001) хэмээн тодорхойлжээ.

### Жишээ 2:

### Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэдийн судалгааны дүн

Улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй нийт 202 аж ахуйн нэгж байгууллага байна. Монгол улсын хэмжээнд Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй нийт 1120 аж ахуйн нэгжийн 18.0 хувь нь Тусгай хамгаалалттай газар нутгуудад байрлаж байна.




Зураг 1.5. *Тусгай хамгаалалттай газар нутгуудад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн хариуцлагын хэлбэр, дүнд эзлэх хувиар*

Монгол улсын хэмжээнд Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй нийт 360 амралт, жуулчны бааз, гэр буудлын 51,6 хувь нь буюу 186 амралт, жуулчны бааз, гэр буудал Тусгай хамгаалалттай газар нутгуудад тогтмол болон улирлын шинж чанартай үйл ажиллагаа явуулж байна. Улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад үйл ажиллагаа явуулж буй 202 үйлчилгээний газрын 3 нь цогцолборын, 9 нь зочид буудлын, 109 нь жуулчны баазын, 45 нь гэр буудлын, 20 нь амралт, сувиллын газрын, 2 нь ангийн отгийн, 4 нь шашны буюу сүм хийдийн, 10 нь цанын баазын, хүүхдийн зуслан, гольф тоглоомын газрын, байгалийн музей, сургалтын төвийн үйл ажиллагаа эрхэлж байна. Нийт үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний байгууллагуудын 40,1 хувь нь нийслэл Улаанбаатар хот бөгөөд Богд хан уулын дархан цаазат газар, Хан хэнтийн УТХГазруудад байрлаж үйл ажиллагаагаа явуулж байна. Монгол улсын хэмжээнд зочид буудал, жуулчны баазын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлагыг хангасан нийт 67 одны зэрэглэлтэй зочид буудлын 3 нь, 74 жуулчны баазын 30 нь буюу 42.8 хувь нь ТХГН-т байна. 2010 онд Улсын тусгай хамгаалалттай газруудад үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний газрууд нь нийт 1690 өрөө, 10751 ор, 2329 гэрийн хүчин чадалтайгаар үйлчилгээ явуулсан байна.

Хүснэгт 1.6. *Аялал жуулчлалын үйлчилгээний газрын тоо, үйл ажиллагааны төрөл, ТХГНутгуудаар*

| | ТХГНутгуудаар/ үйлчилгээний төрлөөр | Цогцолбор | Зочид буудал | Жуулчны бааз | Амралт, сувиллын газар | Гэр буудал | Отог | Сум, хийд | Бусад | Бүгд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Богд хан уулын ДЦГ | 3 | | 11 | 2 | 4 | | 1 | 1 | 22 |
| 2 | Говийн Их Дархан цаазат газар «А» хэсэг | | | | | | | | | 0 |
| 3 | Говийн Их Дархан цаазат газар «Б» хэсэг | | | | | 3 | | | | 3 |
| 4 | Говийн Бага ДЦГ | | | | | | | | | 0 |
| 5 | Дорнодын УТХГ | | | | 1 | 1 | | | | 2 |
| 6 | Монгол Алтайн нурууны УТХГ | | | 1 | 1 | 2 | | | | 4 |
| 7 | Нөмрөгийн ДЦГ | | 4 | | | | | | | 4 |
| 8 | Отгонтэнгэрийн УТХГ | | | | 2 | | | | 1 | 3 |
| 9 | Увс нуурын УТХГ | | | 3 | 3 | 3 | | | | 9 |
| 10 | Хар Ус нуурын УТХГ | | | | 1 | 3 | | | с | 4 |
| 11 | Хан Хэнтийн УТХГ | | 2 | 47 | 3 | 2 | | 1 | 4 | 59 |
| 12 | Хөвсгөлийн УТХГ | | | 19 | | 4 | 1 | | | 24 |
| 13 | Хөх Сэрхийн нурууны ДЦГ | | | | | | 1 | | | 1 |
| 14 | Тужийн нарс УТХГ | | | | | | | | | 0 |
| 15 | Говь Гурван сайханы БЦГ | | | 3 | 2 | | | | 2 | 7 |
| 16 | Дарьгангын БЦГ | | | 2 | | | | | | 2 |
| 17 | Их богд уулын БЦГ | | | | 1 | | | | | 1 |
| 18 | Мөнххайрханы БЦГ | | | | | 3 | | | | 3 |
| 19 | Орхоны хөндийн БЦГ | | | | 1 | 19 | | 1 | 1 | 22 |
| 20 | Онон Балжийн БЦГ | | 3 | 1 | 1 | | | | | 5 |
| 21 | Хангайн нурууны БЦГ | | | 7 | | 1 | | | 1 | 9 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 22 | Хөгнө Тарнын БЦГ | | | 13 | | | | 1 | | 14 |
| 23 | Хустай нурууны БЦГ | | | 2 | 1 | | | | | 3 |
| 24 | Тарвагатайн нурууны БЦГ | | | | 1 | | | | | 1 |
| | Нийт дүн | 3 | 9 | 109 | 20 | 45 | 2 | 4 | 10 | 202 |

Улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй үйлчилгээний газруудад 2010 оны байдлаар нийт 2298 ажиллагчид ажилласнаас 819 нь үндсэн ажиллагчид, 1479 нь түр ажиллагсад байна. Манай улсын хувьд аялал жуулчлалын үйл ажиллагаа нь ихэвчлэн улирлын чанартай байдагтай холбоотойгоор аялал жуулчлалын саруудад түр ажиллагчид авч ажиллуулдаг байна.

Хүснэгт 1.7. *Аялал жуулчлалын үйлчилгээний газруудад ажиллагчдын тоо, ТХГНутгуудаар*

| № | ТХГНутгуудын нэр | Нийт ажиллагчдын тоо | Үүнээс | |
|---|---|---|---|---|
| | | | Түр ажиллагчид | Тогтмол ажиллагчид |
| 1 | Богд хан уулын ДЦГ | 506 | 107 | 399 |
| 2 | Говийн Их Дархан цаазат газар «А» хэсэг | 0 | | |
| 3 | Говийн Их Дархан цаазат газар «Б» хэсэг | 6 | 6 | |
| 4 | Говийн бага ДЦГ | 0 | | |
| 5 | Дорнодын УТХГ | 8 | 8 | |
| 6 | Монгол Алтайн нурууны УТХГ | 0 | | |
| 7 | Нөмрөгийн ДЦГ | 17 | 9 | 8 |
| 8 | Отгонтэнгэрийн УТХГ | 55 | 55 | |
| 9 | Увс нуурын УТХГ | 102 | 84 | 18 |
| 10 | Хар Ус нуурын УТХГ | 48 | 48 | |
| 11 | Хан Хэнтийн УТХГ | 575 | 360 | 215 |
| 12 | Хөвсгөлийн УТХГ | 291 | 266 | 25 |
| 13 | Хөх Сэрхийн нурууны ДЦГ | 2 | 2 | |
| 14 | Тужийн нарс УТХГ | 0 | | |
| 15 | Говь Гурван сайханы БЦГ | 78 | 39 | 39 |
| 16 | Дарьгангын БЦГ | 7 | | 7 |
| 17 | Их богд уулын БЦГ | 8 | 7 | 1 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 18 | Мөнххайрханы БЦГ | 89 | 86 | 3 |
| 19 | Орхоны хөндийн БЦГ | 245 | 223 | 22 |
| 20 | Онон Балжийн БЦГ | 31 | 26 | 5 |
| 21 | Хангайн нурууны БЦГ | 64 | 43 | 21 |
| 22 | Хөгнө Тарнын БЦГ | 109 | 95 | 14 |
| 23 | Хустай нурууны БЦГ | 53 | 12 | 41 |
| 24 | Тарвагатайн нурууны БЦГ | 4 | 3 | 1 |
| | *Нийт дүн* | *2298* | *1479* | *819* |



Өвөрхангайн "Dream land" жуулчны бааз



# II

# ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ БА ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

**АГУУЛГА:**

- Эко аялал жуулчлалын тухай ойлголт, түүхэн хөгжил
- Эко аялал жуулчлалын төлөвлөлт ба ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөний уялдаа холбоо
- ТХГН-т аялал жуулчлалаас үүсэх нөлөөллүүд: байгаль орчин, нийгэм соёл, эдийн засгийн нөлөөлөл
- Нутгийн иргэд, аялал жуулчлалын салбар, бусад бүс ба орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах

## II.1. ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТҮҮХЭН ХӨГЖИЛ

Эко аялал жуулчлал гэдэг ойлголт нь анх XIX-р зууны эцсээр Европт бий болсон гэж үздэг бөгөөд тухайн үедээ гол төлөв байгаль судлаач, сайн дурынхны аяллуудыг хамруулан ойлгодог байжээ. Аялал жуулчлалын үйлдвэрлэлд эдийн засгийн бусад салбарыг хамарсан завсрын секторууд олноор хөгжсөнөөр 1980-аад оны сүүлд жунглийн аялал жуулчлал буюу эко аялал жуулчлалын тухай ойлголт олон нийтэд бий болж эхэлжээ. Үүнээс хойш аялал жуулчлалыг хүмүүс өөрөөр харах болж, байгаль, дэлхийг хайрлан хамгаалах сэтгэлгээ гүнзгийрсэн билээ. Түүнчлэн хэн нэг нь нийгмийн ухамсраа, нөгөө нэг нь боловсролоо, гуравдахь нь байгаа хөрөнгөө үр ашигтай бөгөөд хүмүүст тустайгаар зарцуулах гэсэн хүсэл эрмэлзлэлээс эко аялал жуулчлал үүсчээ. Эко аялал жуулчлал гэсэн үгийг Эко аялал жуулчлалын зөвлөгөө өгөх олон улсын байгууллагын тэргүүн, Дэлхийн байгаль хамгаалах холбооны зөвлөгч Гектор Цибаллос Ласкуриан 1983 онд гаргажээ. Тэрээр "*Ургамал ан амьтан, соёлын дурсгалт газруудын дүр төрхтэй танилцах, биширэх, суралцах гэх мэтчилэн тодорхой зорилтын хүрээнд унаган төрхөө харьцангуй хадгалан үлдсэн доройтол, бохирдолд бага өртсөн нутаг дэвсгэрт аялахыг эко аялал жуулчлал гэнэ*" хэмээн тодорхойлжээ. Үүнээс хойш энэхүү тодорхойлолтыг боловсронгуй болгох, илүү тодотгох ажилбарууд янз бүрийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн байна *(Рекреаци ба аялал жуулчлал, 2005).*

Эко аялал жуулчлалын үүсэл, хөгжилд хэд хэдэн хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Аялал жуулчлал нь дэлхийн эдийн засгийн нэг гол салбар болж хөгжихийн хирээр аяллын төрлүүд нэмэгдэж, хотжилтын цар хүрээ, түүнээс үүдэлтэй олон үр дагавар нь хүмүүсийн оюун ухаан болоод бие махбодид сөргөөр нөлөөлж, үүнээс түрч гэсэн холдож байгалийн сайхныг мэдэрч, амрах зорилгоор ихээхэн аялах болсон нь дэлхийн улс орны экосистемд ихээхэн сөрөг нөлөө үзүүлэх болсон. Нөгөө талаас аялал жуулчлалыг зөв, оновчтой зохион байгуулах нь эргээд байгальд нөхөн сэргээлт хийхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, тухайн нутаг орны унаган байдлыг хадгалан үлдээхэд зохих хувь нэмрээ оруулах боломжтой нь тодорхой болсон.
- Саяхныг хүртэл газар нутгийг тусгай хамгаалалтанд аван хамгаалах үйл явц нь зөвхөн хамгаалах, хадгалах, хориглоход чиглэгдсэн, нутгийн оршин суугчдын

амьдрал ахуй, уламжлалтай уялдаа холбоо багатай байлаа. Олон жилийн туршлагаар газар нутгийг дархлан хамгаалахад орон нутгийн оршин суугчдын оролцоо чухал гэдэг нь батлагдаж, тэдний амьдрал ахуйг дээшлүүлэхэд анхаарч эхэллээ. Үүний нэг хэлбэр нь тухайн тусгай хамгаалалттай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ нутгийн иргэдийг татан оролцуулж буй явдал юм.

- Хүмүүсийн хэрэгцээ сонирхол өөрчлөгдөхийн хирээр харьцангуй уламжлалт амралтаас хөндийрч байгальд амрахыг эрмэлзэх болсон. Ингэснээр танин мэдэхүйн идэвхтэй амралтыг илүү сонирхогчид давамгайлах болсон.

Байгаль хамгаалал ба аялал жуулчлалыг зэрэгцүүлэн хөгжүүлж буй олон жишээ байна. Тухайлбал: Канад, АНУ, Австралид 1960-1970 аад онд үндэсний парк, унаган байгальд аялах, амьтдын амьдралын ажиглах аяллууд ихээр явагдах болжээ. Тэр үед далайн халимын популяцид нүүрлээд байсан аюултай холбоотой тэдгээрийг ажиглах аялал АНУ- д маш ихээр явагдах болж олон нийтийн шаардлагаар зарим халимыг хатуу хамгаалалтанд авч байв. Альпийн нурууны ландшафт 1970-аад оны эцэст рекреацийн хэт их ачааллын улмаас аюулт байдалд ороод байгаа талаар сэтгүүлч Л. Люкшандерль 1983 онд "Альпийг аваръя. Европын орой дахь ой аюулд ороод байна" номондоо бичжээ. Иймд Альпийн улсууд байгальд ээлтэй зөөлөн аяллын зарчмыг боловсруулан улмаар бодит амьдралд хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэ үед Альпийн таван улс "Альпийн конвенц"-ийг гаргасан. Уг конвенци нь тухайн бүс нутгийн байгаль, соёлын өв уламжлалыг хадгалах, экологийн зарчмыг мөрдөх үндсэн дээр хөгжүүлэх урт хугацааны стратегийг тодорхойлжээ. Уг





конвенцид зөөлөн аялал жуулчлалыг хөгжүүлэх тухай тусгасан. Ингэж Баруун Европт байгальд түшиглэсэн, нийгэм ба экологийн хариуцлагатай аялал хөгжиж эхэлсэн байна.

Эко аялал жуулчлалын талаар олон янзын тодорхойлолт байдаг ч ихэнх улс орнууд Олон Улсын Байгаль Хамгаалах Холбооноос (IUCN) 1996 онд гаргасан "*Эко аялал жуулчлал нь байгальд хийгдэж байгаа, хүрээлэн буй орчинд хариуцлагатай хандсан, бага нөлөө үзүүлэх, байгаль хамгаалалд хувь нэмрээ оруулах, орон нутгийн иргэдийн нийгэм эдийн засагт идэвхтэй дэмжлэг үзүүлэх зорилгоор хийгдэж байгаа аялал*" хэмээх тодорхойлолтыг өргөн хэрэглэж байна.

Мөн Олон Улсын Эко аялал жуулчлалын Нийгэмлэгээс (International Ecotourism Society) "*Тусгай зорилготойгоор байгальд хийгдэж байгаа тухайн экосистемийн цогц байдалд халгүй, нутгийн соёл болон байгалийн орчинг гүн гүнзгий ойлгож мэдэх гэсэн байгалийн нөөцийг хамгаалах, нутгийн иргэдэд ашиг тусаа өгөх аялал*" гэж тодорхойлжээ. Хэдийгээр эко аялал жуулчлал нь хурдацтай хөгжиж байгаа хэдий ч Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллагын шинжээчдийн судалгаанаас харахад аяллын энэ төрөлд тус салбарын мөнгөний эргэлтийн 10-15% ноогдож байна.

**Эко аяллын таван үндсэн зарчим:**

- Байгальд хандсан, түүний нөөц баялгийн хэрэглээнд суурилагдсан
- Байгалийн тогтвортой байдлыг алдагдуулахгүй, хүрээлэн буй орчинд халгүй
- Байгаль хамгаалал, экологийн боловсрол олгоход чиглэсэн
- Орон нутгийн соёлыг хадгалан үлдээхэд анхаарсан
- Эдийн засгийн ашигтай, тухайн нутгийн хөгжлийн тогтвортой байдлыг дэмжсэн байна.

**Эко аялал жуулчлалын үндсэн шинжүүд:**

- Аялагчдын хэрэглэж буй тээвэр нь байгаль орчинд сөрөг нөлөө бага
- Аялагчдын хоол хүнс нь экологийн цэвэр, нутгийн бүтээгдэхүүн оролцуулсан
- Аялал нь мэргэшсэн тусгай хөтөчтэй, экологийн таатай, сонирхол татахуйц байгалийн болон соёлын ландшафтын орчинд зохиогддог.
- Аяллын хөтөлбөрт тухайн нутгийн экологийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, орон нутгийн байгалийн

музей үзэх, экологийн сургалтын төвүүдтэй танилцах

- Хог хаягдлыг экотехнологийн дагуу устгах
- Түр зогсоол болон хоноглохдоо заагдсан газарт байрлах, түүдэг галыг тусгай зориулагдсан хэсэгт асаах.
- Мөөг, жимс, цэцэг, эмийн ургамал болон байгалийн дурсгалыг зөвшөөрөгдсөн нөхцөлд авах
- Аялагчдын байрлах хэрэгслүүдийг хүрээлэн буй орчны хэвийн тогтвортой байдалд халгүй, орчны байдлыг алдагдуулахгүй байрлуулах
- Аялагчдын байршуулах хэрэгслүүдийг байгаль орчинд хор нөлөөгүй материалаар хийсэн, ус болон энергийг хэмнэлттэй ашигладаг, хог хаягдал, бохир усыг цэвэрлэж дахин ашигладаг
- Нутгийн иргэд уламжлалт мал аж ахуйгаа эрхлэхийн зэрэгцээ аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцдог
- Аялагчид нутгийн соёл уламжлалд хүндэтгэлтэй хандан, түүнийг ойлгож танин мэдэхийг эрмэлздэг
- Тухайн нутгийн экологийн тулгамдсан асуудлыг шийдэхэд аялагчид оролцдог
- Аялал жуулчлалаас орж буй ашиг орон нутгийн мэдэлд байдаг[1].

Хүснэгт 2.1. *Эко аялал жуулчлалын төрөл, ангилал*

| | |
|---|---|
| **Эко аялал жуулчлалын ангилал (Е. Катер,1985)** | Тусгай хамгаалалттай газар нутаг, унаган болон харьцангуй бага эвдэгдсэн байгальд явагдаж буй аялал. Энэ нь эко аялал жуулчлалын сонгодог хэлбэр бөгөөд Австрали загвар ч гэж нэрлэгддэг |
| | Тусгай хамгаалалттай газар нутгийн гадна, зохиомол буюу хүний үйл ажиллагаагаар бий болсон ландшафтад хийгддэг эко аялал |
| **Эко аяллыг зорилгоор нь:** | Экологийн мэдлэг олох зорилгоор унаган болон зохимол байгальд ажиглалт хийх, судлах |
| | Гоо сайхны болон сэтгэл ханамж авах зорилгоор |
| | Байгалийн хүчин зүйлийг хэрэглэн эрүүлжих |
| | Адал явдал хайх болон спортын аялал |

1 *Cater E (1994). «Ecotourism»*

| | |
|---|---|
| **Эко аяллыг судалж буй зүйлээс нь хамааран:** | Ургамал судлал, амьтан судлал, геологийн |
| | Экологи, угсаатан судлалын, археологийн, экологи-соёлын |
| | Хөдөөгийн амьдралын хэв маягийг судлах |
| | Усны, уулын гэх мэт |

Эко аяллыг ангилах бас нэгэн чухал үзүүлэлт бол аялагчдын нас, бие махбодын чадвар болон аялагчдын тоогоор ангилж болно[2]. Эко аялагчдын онцлог шинж чанарууд:

- Хүрээлэн буй орчны өндөр мэдлэгтэй
- Адал явдал болон дадлага туршлагыг нь нэмэгдүүлэх үйл ажиллагааг эрхэмлэдэг
- Аялалдаа ихээхэн зардал гаргадаг
- Өндөр боловсролтой
- Тав тух тансаг байдлыг бага шаарддаг
- Орон нутгийн үйлчилгээг худалдан авахыг хүсдэг
- Үнэн зөв, чанартай мэдээллийг шаарддаг
- Аяллын ихээхэн туршлагатай хүмүүс байдаг байна.

Хүснэгт 2.2. "*Эко аялал жуулчлалд тавигдах шаардлагууд*" *(Butler., 1992[3])*

| | | |
|---|---|---|
| **1** | Хүрээлэн буй орчинг хамгаалсан | Жуулчдыг хүрээлэн буй орчноо хүндэтгэн үзэхийг дэмжсэн байна |
| **2** | Байгалийн нөөцөд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх | Ан, гөрөө, загасчлал, байгальд мотоциклоор зугаалах зэрэг нь эко аялал жуулчлалд ордоггүй |
| **3** | Өөрийн үндсэн зорилгыг чухалчилдаг | Хамгаалалттай газруудад барилга байшин барьж үйлчилгээ явуулж болох хэдий ч тэдгээр нь жуулчдыг татах бие даасан сонирхол татах үзмэр биш учир байгалийн нөөцөд сөрөг нөлөө үзүүлж болохгүй |

*2 Hector Ceballos – Lascurain (1996). "Tourism, ecotourism and protected area". IUCN*

*3 Butler, James R. 1992. Ecotourism: Its Changing Face and Evolving Philosophy*

| | | |
|---|---|---|
| 4 | Хүрээлэн буй орчинд гол анхаарлаа хандуулдаг байх | Эко жуулчид нь тухайн байгалийг байгаагаар нь хүлээн авах ба өөрсдийн сонирхолд нийцүүлэн ямар нэг өөрчлөлт хийхийг шаардахгүй байх |
| 5 | Хүрээлэн буй орчин болон зэрлэг байгальд ашигтай байх | Экологийн бүрэн бүтэн байдалд илүү ашигтай байх |
| 6 | Байгальтай шууд харьцах боломж олгосон байх | Байгаль дээр байгаа амьтан ургамлыг үзэж ажиглах |
| 7 | Нутгийн иргэдийг аялал жуулчлалд идэвхитэй оролцуулах | Эко аялал жуулчлал нь нутгийн иргэдийг ажлын байраар хангаж орлогыг нь нэмэгдүүлэхээс гадна байгаль хамгаалах үйл хэрэгт татан оролцуулдаг. |
| 8 | Мэдлэг боловсрол дээр тулгуурласан байх | Унаган байгальд аялж, ан амьтан, байгалийн үзэсгэлэнг мэдэрч, байгалийн үнэ цэнийг ойлгох нь эко аяллын гол утга учир юм. |
| 9 | Эко аялал жуулчлалд оролцогч талуудын мэдлэг боловсрол өндөр байх | Эко аялал жуулчлал нь түүнийг эрхэлж байгаа тал, оролцож байгаа жуулчид хоёулангаас нь мэдлэгийн өндөр түвшинг шаарддаг. |



Хүснэгт 2.3. *Эко аялал жуулчлалыг тодорхойлох 7 шалгуур (Martha Honey., 1999)*[4]

| | | |
|---|---|---|
| 1 | Байгалийн үзэсгэлэнт газруудаар аялах | Эдгээр нутаг дэвсгэр нь ихэвчлэн алслагдсан байх ба олон улсын, үндэсний, орон нутгийн болон хувийн хамгаалалт дор байдаг |

*4 Martha Honey.1999. Ecotourism and Sustainable Development: Who Owns Paradise?*

| | | |
|---|---|---|
| 2 | Нөлөөллийг бууруулах | - Байгалийн материал ашиглан барилга барих<br>- Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах<br>- Тухайн газар ирэх жуулчдын тоо, тэдгээрийн шинж чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлох, зарим талаар хязгаарлах үйл ажиллагааг авах |
| 3 | Байгаль орчны боловсрол олгох тогтолцоог бий болгох | Нутгийн иргэд болон жуулчдад эко аялал жуулчлалын хөтөлбөр, түүний шинж чанарын талаар төсөөллийг бий болгодог<br>- Байгаль орчин, түүх соёлын өндөр мэдлэг, ёс суртахууны зарчмуудыг баримтлагч хөтөч бэлтгэн гаргах<br>- Орон нутгийн иргэдэд экологийн боловсрол олгох |
| 4 | Байгаль хамгаалалд шууд хөрөнгө оруулалтыг дэмжих | - Хамгаалалттай нутаг дэвсгэрт нэвтрэх хураамж<br>- Тээврийн хэрэгсэлд төлбөр тогтоох<br>- Сайн дурын байгаль хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх |
| 5 | Нутгийн иргэдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх | - Аялал жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний салбарт нутгийн иргэдтэй хамтран ажиллах<br>- Нутгийн иргэдэд хяналт мониторингийн эрх олгох |
| 6 | Нутгийн нийгэм соёлд бага нөлөөтэй байх | - Нийгэм соёлд бага нөлөөтэй байхын тулд тухайн нийгмийн шинж чанар, түүх соёл, уламжлал зэргийг судлах хэрэгтэй |
| 7 | Хүний эрх архилсан хөгжлийг дэмжих | Эко жуулчин нь аялж буй орны улс төр, нийгмийн орчинд урьдчилан анхаарал хандуулж хүний эрхийг дэмжих үйл хэрэгт оролцох |

**Эко аялал жуулчлалын нөөц.** Эко аяллын нөөц бололцоонд тухайн газар нутгийн байгалийн байдал, үйл явц болон эко аяллын бүрэлдэхүүнд тохирохуйц нөхцөл, хэрэгсэл ба тухайн аяллын хөтөлбөрийн хэрэгжүүлэлт зэргийн нэгдэл багтана (Хүснэгт 2.4).

Хүснэгт 2.4. *"Эко аялал жуулчлалын нөөц, түүнийг үнэлэх арга"*

| | Эко аялал жуулчлалын нөөц | Үнэлэх арга | |
|---|---|---|---|
| 1 | Байгалийн болон зохиомол ландшафтууд ба тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүд | Ландшафтын үүсэл, түүх, давтагдашгүй байдал, хамгаалагдсан эвдрээгүй байдал, сэтгэл татам байдал болон олон төрөл зүйлийн агууламж (ургамал, амьтан гэх мэт) | Тусгай хамгаалалттай газар нутаг (дархан газар, үндэсний болон байгалийн цогцолборт газар, олон амьтны цэцэрлэгт хүрээлэн, усан паркууд |
| | | | Байгалийн түүхийн музей, мөн экологийн зарчимд тулгуурласан байгалийн нөөцийг ашиглаж байгаа сонирхолтой, судлууштай обьектууд |
| | | | Сонирхол татахуйц байгалийн ба зохиомол ландшафтууд, түүх соёлын үнэт дурсгал бүхий газар нутаг орно |
| 2 | Эко аяллын хэрэгслүүд (хөтөлбөр, маршрут) | Экотехнологийн агууламжаар нь | Экотехнологийн тээврийн төрлүүд, эко байршуулах хэрэгсэлүүд, эко аялагчдын тоноглол хэрэгслүүд |
| | | | Экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүн, ихэвчлэн орон нутгийн гаралтай |
| | | | Экологич, мэргэшсэн хөтөч, мэдээллийн материалууд зэрэг орно |
| 3 | Аяллыг явуулах нөхцлүүд | Экологийн болон аюулгүй байдлын зөвшөөрөгдөх хэм хэмжээгээр | Экологийн таатай орчин (бохиролтгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан, байгалийн аюул багатай байх) |
| | | | Тухайн газар нутаг нь аяллын зорилгод нийцсэн, хүрч очих боломжтой байх |
| | | | Рекреацийн ачаалал, ус, эрчим хүчний болон бусад нөөцийн хэрэглээний хэмжээ, аяллын хэлбэр, хугацаа боломжит хэмжээнд байх |

Ceballas – Lascurain (1996) эко аялал жуулчлалын үзмэрийг 3 категорид хуваасан байна (Зураг 2.1).




Зураг 2.1. *Эко аялал жуулчлалын татах үзмэр* [5]

**Эко аялал жуулчлалын бүтээгдэхүүн.** Аялал жуулчлалын мэргэжлийн байгууллагаар дамжуулан зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагаа, нөөц бололцоо, үйлчилгээний нэгдэл юм. Эко аялал болон бүтээгдэхүүний дараах үндсэн төрөл байх бөгөөд эдгээр аяллын үйлчилгээ ба бүтээгдэхүүнээс иж бүрэн хөтөлбөр бүрэлдэх ёстой (Хүснэгт 2.5).

Хүснэгт 2.5. *Эко аялал болон бүтээгдэхүүний төрөл (А.В.Дроздов., 2005)*[6]

| |
|---|
| Сайтар боловсрогдсон, бодитоор хэрэгжсэн, хяналттай байнгын маршрут, экологийн жим |
| Олон хэлбэрийн боловсролын болон зөвлөгөө өгөх үйлчилгээ |
| Спортын, адал явдалт, хөдөөгийн, эрүүлжүүлэх аяллын байгууллагууд |
| Экологийн болон экологи - соёлын тусгай аяллууд |
| Тойрон аялал, тусгай хамгаалалттай газар нутаг дахь тойрон аялал |
| Тусгай зориулалттай арга хэмжээнүүд (үзэсгэлэн, дуудлага худалдаа, фестиваль, конкурс) |
| Хяналттай бэлтгэсэн байгалийн бүтээгдэхүүн |
| Орон нутгийн экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний худалдаа |
| Экологийн орон байр тээврийн хэрэгслүүд |
| Аялалын тоноглол хэрэгсэл, хөлслүүлэх үйлчилгээ |

*5 Hector Ceballos – Lascurain (1996). "Tourism, ecotourism and protected area". IUCN*
*6 А. В. Дроздова. 2005. Основы экологического туризма*

| |
|---|
| Бэлэг дурсгалын зүйлсийн үйлдвэрлэл болон худалдаа |
| Орон нутгийн экологийн символ бүхий тэмдэгийн худалдаа, реклам сурталчилгааны материалууд |
| Тусгай аудио, видео, фото болон кино материал, бүтээгдэхүүн боловсруулалт, худалдаа зэрэг орно |



**Байгальд тулгуурласан аялал жуулчлал ба эко аялал жуулчлал:** Байгалийн аялал жуучлал нь харьцангүй хөгжингүй орнуудын байгалийн үзэмж, уул нуруудын, усны онцлог, ургамал болон амьтад гэх мэт байгалийн нөөцөөс шууд хамааралтай аялал жуулчлал юм. Иймээс байгалийн аялал жуулчлал нь ан гөрөө, хээрийн мотоциклтой аялал, уулын голоор завиар аялах орох ба энд тухайн жуулчид байгаль орчинд хэрхэн хандах нь хамаагүй байдаг байна (Ceballos-Lascurain., 1996). Их хэмжээний хяналтгүй жуулчдын урсгал маш олон байгалийн болон соёлын өв газруудыг сүйтгэх, соёлын онцлог байдал болон биологийн төрөл зүйлүүдийг мөхөөх, мөн түүнчлэн уугуул нутгийн орлогын эх үүсвэрийг үгүй хийх зэрэг сөрөг үр дагаваруудыг дагуулж байна. Эко аялал жуулчлал нь тодорхой нэг тогтсон хэр хэмжээг шаарддаг, нэг ёсондоо өнөөдрийн жуулчид өөрсдөөсөө хойно ирэх жуулчдийн эрх ашгийг бодолцон тухайн байгалийн үзэсгэлэнт газар, түүний экосистем, биологийн төрөл зүйлд ямарваа нэг хор хүргэхээс зайлсхийн аялна гэсэн үг юм. Farrel, Runyan (1991)[7] нар байгалийн аялал жуулчлал болон эко аялал жуулчлалын ялгааг дараах байдлаар гаргасан байна (Хүснэгт 2.6).

Хүснэгт 2.6 *"Эко аялал жуулчлалын байгалийн аялал жуулчлалаас ялгарах шинжүүд"*

| |
|---|
| Дэлхий дахинд танин мэдэгдсэн тусгай хамгаалалттай газраар аялах нь өндөр эрэлттэй |
| Эко жуулчлалыг хатуу чанга горимоор зохион байгуулдаг |
| Байгаль орчинд бага нөлөөлдөг |
| Нутгийн иргэд уламжлалт зан заншлаар аж төрөнгөө жуулчдад ажил үйлчилгээ үзүүлж байгаль хамгаалах үүрэг хүлээдэг |
| Амралт зугаацал , экологийн боловсрол хослуулсан өвөрмөц аяллын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг |

*7 Farrell, B .H. & Runyan, D. ( 1991 ). Ecology and tourism. Annals of Tourism Research, 18, 26-40*

Хүснэгт 2.7 *"Байгалийн аялал жуулчлал болон эко аялал жуулчлалын ялгаа"*

| Байгалийн аялал жуулчлал | Эко аялал жуулчлал |
|---|---|
| Жуулчны хүсэл санаан дээр тулгуурласан байдаг | Аялал жуулчлалын байгууллагууд тухайн нутгийн иргэдтэй зөвшилцөн тодорхой төлөвлөгөө боловсруулж байгаль хамгаалах зорилготойгоор аялал жуулчлалыг зохион байгуулдаг |
| Жуулчдад байгалийн үзэмжтэй газруудыг харах үзэх тэнд аялах боломжийг санал болгодог | Тухайн газрын экосистемд хоргүй байхаар, нутгийн иргэд болон жуулчдийг хоорондоо зөв ойлголцоход тус болох ба жуулчдын аюулгүй байдлаас гадна байгальд үзүүлэх сөрөг нөлөөллийг давхар тооцдог байна. |
| Нөлөөллийг бууруулах, нутгийн соёл дурсгалыг хамгаалах механизм байдаггүй | Нөлөөллийг хамгийн бага байлгах, уугуул нутгийн соёлыг хүндэтгэж аялдаг |

**Эко аялал жуулчлалын үүрэг**. Тусгай хамгаалалттай газруудад аялал жуулчлал эрхлэх нь зайлшгүй шаардлагатай юм. Учир нь жуулчид өөрсдийн биеэр байгалийн сайхныг харж түүнийг мэдэрснээр байгалийг байгаа чигээр нь үнэлэх, түүний жинхэнэ үнэ цэнийг ойлгон байгалийг хайрладаг болох юм. Үүнээс гадна аялал жуулчлалаас олж байгаа орлогыг зөв зохистой зарцуулбал тухайн хамгаалалттай газрыг хамгаалж арчилахад гарах зардлыг нөхөөд зогсохгүй дэд бүтцийн болон судалгаа шинжилгээний ажлуудыг санхүүжүүлэх боломжтой. Эко аялал жуулчлалын хөгжлийн асуудал нь тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент, стратегийн нэг хэсэг нь байдаг (Зураг 2.2).






Зураг 2.2. *Тусгай хамгаалалттай газар нутагт эко аялал жуулчлалын гүйцэтгэх үүрэг (Ross & Wall ., 1999)*

**Жишээ 3:** "Дэлхийн Эко аялал жуулчлалын Чуулган 2007"-аас эко аялал жуулчлалыг зохистой хөгжүүлэх талаар доорх зөвлөмжийг гаргасан байна (Хүснэгт 2.8).

Хүснэгт 2.8. *Эко аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх үндсэн зарчмууд*

| | Бодлого | Хүрэх арга зам |
|---|---|---|
| 1 | Нутгийн иргэд рүү чиглэж ажиллах | • Нутгийн иргэдэд аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцох боломжийг гаргаж өгөх<br>• Нутгийн дэд бүтцийг сайжруулах, ажлын байр бий болгох<br>• Хөдөө аж ахуй, газар тариалан эрхлэхэд дэмжлэг үзүүлэх<br>• Нутгийн иргэдийн хийсэн гар урлалын бүтээлийг сурталчилж худалдаалах<br>• Нутгийн иргэдийн холбоо, байгууллагыг олон улсын байгууллагуудтай холбож, туршлага судлуулах |

| | | |
|---|---|---|
| 2 | Байгалийн ба соёлын өвийг хамгаалах | • Жуулчид болон нутгийн иргэдэд экологийн боловсрол олгох<br>• Тухайн газрын биологийн төрөл зүйлд хяналт тавьж, судалгааны ажил явуулах<br>• Аялал жуулчлалын нөөцөд санхүүгийн дэмжлэг үзүүлэх<br>• Хамгийн бага сөрөг нөлөөг үзүүлэх |
| 3 | Экологийн боловсролыг дээшлүүлэх | • Эко аялал жуулчлалын боловсрол, практик дадлага, бизнесийн түлхүүр чадваруудыг нэмэгдүүлэх буюу бэхжүүлэх<br>• Телевиз, радио, веб-хуудас, интернэтийн хэлэлцүүлэг зэрэг сувгуудаар хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх<br>• Сүүлийн үеийн шинэ техник технологийг сургалтанд ашиглах<br>• Эко аялал жуулчлалын зарчмыг дагаж мөрдөхийг уриалан, аялал жуулчлалын эерэг талыг нэмэгдүүлэх<br>• Олон улсын эко аялал жуулчлалын байгууллага, үндэсний болон орон нутгийн эко аялал жуулчлалын нийгэмлэгүүдтэй харилцаагаа гүнзгийрүүлэх |
| 4 | Эко аялал жуулчлалын бодлого төлөвлөлтөнд шинэлэг санааг нэвтрүүлж байх | • Эко аялал жуулчлалын зарчмыг дагаж мөрдөх байдлыг сайжруулах<br>• Эерэг нөлөө үзүүлдэг нийгмийн байгууллагууд руу чиглэж ажиллах<br>• Аялал жуулчлалын үйлдвэрлэлийн бусад хэсгүүдэд тогтвортой хөгжлийн зарчмуудыг нэвтрүүлэх<br>• Тухайн газрын соёлд бодит ба бодит бус хамгаалалтыг үзүүлэх |



## **Жишээ 4:** *ТХГН дахь жуулчин байршуулах хэрэгсэл /accommodation/ болон бусад тохижилтын шилдэг туршлагууд*

| Үйл ажиллагаа | Арга барил | Хэрэгжүүлсэн газар, төсөл |
|---|---|---|
| Нийгэмд үзүүлэх эерэг нөлөө | Нутгийн иргэдийг хөтчөөр ажиллуулах | Кенийн наран шарлагын газар- Kenya beach house accomodation |
| | Нийгмийн байгууллагуудад хувь нэмэр оруулах /компьютерийн лаборатор, номын сантай болгох, анги танхим тохижуулах гэх мэт/ | Индонезийн тансаг амралтын газар- Indonesia luxury beach resort |
| | | Филиппины Хинунанган наран шарлагын зочид буудал – Hinunangan Bay beach hotel, Philippines |
| | Нутгийн иргэдтэй хамтарч ажиллах / морь унуулах бизнес эрхэлэхэд хүүгүй зээл олгох/ | Эквадорын эколоож-Ecuador ecolodge accomodation |
| | Нутгийн иргэд хоршоо нөхөрлөл байгуулах | Аросмари, баруун Критийн зуслангийн байшингууд-Cottages in Western Crete, Arosmari |
| | Нутгийн иргэдэд экологийн боловсрол олгох | Флорис дахь Комодо луу эколоож- Komodo Dragon ecolodge in Flores |
| Худалдааны бодлого | Нутгийн иргэд газар тариалан эрхлэх | Кирала зочид буудал-Kerala B&B accomodation |
| | Нутгийн иргэдийн хийсэн уламжлалт гар урлалын бүтээлийг зарж, сурталчлах | Энэтхэгийн Канха ширэнгийн ойн лоож-Kanha jungle lodge accomodation |
| | Өөрийн орны нөөцийг ашиглах | Сновдониа зочид буудал- Snowdonia B&B campsite |
| | Амьтан тэжээх | |
| | Байгалийн жимс ногоог худалдаж авах | Махери, Критийн Вилла-Villa holidays in Crete8 Maheri |
| | Байгалийн гаралтай бүтээгдэхүүн болон амьтан дээр туршаагүй ариун цэврийн бүтээгдэхүүн худалдаалах | |

| | | |
|---|---|---|
| Байршуулах хэрэгсэл барих | Байгалийн үнэгүй материал /сүрэл, мод гэх мэт/ -ыг ашиглах | Тиомон арал, Малайзийн наран шарлагын газар-Malaysia beach resort, Tiomon island |
| | Нутгийн барилгачдыг ажиллуулах | Тобаго наран шарлагын газар-Tobago beach accomodation |
| | Уламжлалт арга барилаар барих /дэрс боож баглах гэх мэт/ | Дайдис воллое касба зочид буудал-Dades valley kasbah accomodation |
| | Гэрэлтүүлэг болон агааржуулагчийг картын системээр ажиллуулах | Грекийн Лисвос холидэи зочид буудал- Lesvos holiday accomodation |
| | Халуун хүйтэн агаартай өрөөг тусгаарлах | |
| | Нийтийн талбайд гэрэлтүүлэг хийх | |
| | Дулаан алдахаас сэргийлсэн орчин үеийн аргуудыг хэрэглэх /элс шохой хольж хийсэн 60 см-ийн өргөнтэй хавтангаар хана хийдэг/ | Коста дэ ла луз зочид буудал-Costa de la Luz hotel |
| Хог дахин боловсруу -лалт | Шил, металл, цаас, хуванцар эдлэлийг ангилж дахин боловсруулах | Норфок дахь улсын зочид буудал-Country hotel in Norfolk |
| | Амьтдыг хүнсний хог хаягдлаар хооллох | Алъяскийн эколоож-Alaska lodge accomodation |
| | Хүнсний хаягдлыг бордоо болгох | Италийн Ривериа –Italin Riveria B&B |
| | Өөрсдийн даавуун ууттай байх | Данийн баруун инди, Саба эколоож-Saba ecolodge, Dutch west Indies |
| | Хогийн уут ашиглах | |
| | Дахин боловсруулсан бүтээгдэхүүнийг барилгын материалд ашиглах /хуванцраар шат, тавцан хийдэг/ | |
| | Хэрэглэхээ больсон эдлэл хэрэглэлээ хүмүүнлэгийн байгууллагад өгөх | Руанда зочид буудал-Rwanda B&B accomodation |
| | Сурталчилгааг интернэтээр хийх | |
| | Танилцуулга болон сурталчилгааны материалыг дахин боловсруулсан цаасан дээр хэвлэх | Напиер зочид буудал-Napier B&B holiday accomodation |
| Сэргээгдэх эрчим хүч | Био энергийг гэрлийн үүсгүүрт ашигладаг | Саадани парк, Танзани сафари лоож |

| | | |
|---|---|---|
| Энергийг хадгалах арга зам | Хөргөгч хөлдөөгчний хүчин чадлын хэмжээг шалгах | Ли Марше, Итали дахь байршуулах газар-Farmstay in italy, Le Marche |
| | Бага энерги зарцуулдаг гэрлийн шилийг хэрэглэх | |
| | Модны оронд хатуу шахмал цаасыг хэрэглэх | |
| | Дулаан ялгаруулдаг бусад материалыг хэрэглэх | |
| | Ус болон цахилгаан бага зарцуулдаг жижиг данхыг хэрэглэх | |
| | Лааг хэрэглэх | |
| | Дахин боловсруулсан модны нүүрс хэрэглэх | |
| Амьд байгаль | Амьтан ургамлыг хамгаалах | Сейшелийн яст мэлхий хамгааллын сайн дурынхан-Turtle volunteering in the Seychelles |
| | Уугуул амьтан ургамлыг сэргээн нутагшуулах | Өмнөд Африк, Дракенсбургийн байршуулах газар-Farmstay accomodation in Drakensburg, South Africa |
| | Цэцэрлэгт хүрээлэнд цэцэг, ургамал тарих | Канхагийн нөөцийн бар зуслан-Tiger camp in Kanha Reserve |
| | Шувуудын амьдрах орчинг бүрдүүлж өгөх | Шри ланк дахь Нигомбо наран шаралгын зочид буудал-Negombo beach hotel in Sri lanka |
| | Жуулчин болон нутгийн иргэдэд экологийн хүмүүжлийг олгох | Өмнөд Африкийн байгалийн нөөц газар- South Africa Wildlife Reserve |
| | Байгальд эвсэг цэвэрлэх бүтээгдэхүүн хэрэглэх /нимбэгтэй цэвэрлэгээний бүтээгдэхүүн/ | Катоомба-Blue mountains retreat, Katoomba |
| | Уугуул амьтан ургамлыг хамгаалдаг байгууллага байгуулах | Коста рика, Оса Пенинсула халуун орны эколоож-Osa Peninsula rainforest wildlife lodge, Costa Rica |
| | Жуулчдыг мод тарихад туслуулах | Тамил Наду уулын байр |
| | Ургамлын үрийг хамгаалах ажил зохион байгуулах | Вангануй байршуулах газар-Wanganui accomodation, self catering &camping |
| | Машинаас илүү дугуй унах | Аркадийн Сирали амралтын газар-Cirali beach resort, Arcadia |
| | Модыг тавилга болон түлшинд ашиглах | Италийн Пинаска байршуулах газар-Pinasca accomodation, Italy |

## II.2. ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨЛӨВЛӨЛТ



Эко аялал жуулчлалын төлөвлөлтийг хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал болон тэдгээртэй холбоотой үйл ажиллагааны загвар гаргахад ашиглахаас гадна

- Тусгай хамгаалалттай газрын менежерүүд эко аялал жуулчлалын үр дүнг үнэлэхэд туслах
- Эко аялал жуулчлалын стратегийн үр дүн нь төлөвлөлтийн үйл явцын хэрэгсэл болох
- Төлөвлөлтийн үйл явцын суурь нь болдог.

Эко аялал жуулчлалын стратеги нь 3 үе шаттай.

- Нэгдүгээр үе: Одоогийн аялал жуулчлалын байдал, боломжийг үнэлэх
- Хоёрдугаар үе: Хүсч байгаа аялал жуулчлалын байдлыг шийдвэрлэх ба тэр байдалд хүрэх алхмуудаа тодорхойлж гаргах
- Гуравдугаар үе: Эко аялал жуулчлалын стратегийг тодорхойлж бичих

Хүснэгт 2.10. *Эко аялал жуулчлалын стратеги төлөвлөлтийг хэрэгжүүлэх үе шат*

| Хэрэгжих газар | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хэрэгжүүлэхэд хэрэгтэй мэдээлэл |
|---|---|---|
| Хамгаалалттай газар дотор | Байгалийн нөөцийг тодорхойлох | • Ямар үндэслэлээр тусгай хамгаалалтанд авсан бэ?<br>• Байгалийн нөөцийг тодорхойлох (аялал жуулчлал, уул уурхай, ангийн гэх мэт)<br>• Ургамал амьтдын тоог гаргах<br>• Аялал жуулчлалын боломжит үзмэр |
| | Жуулчдын мэдээлэл | • Жилд хичнээн жуулчин ирдэг<br>• Гадаадын болон дотоодын жуулчдын харьцаа<br>• Жуулчдын тухай бусад мэдээлэл<br>• Жуулчид юу хийдэг вэ? (үйл ажиллагаа, нийтийн газарт, хаана хичнээн мөнгө зарцуулдаг гэх мэт)<br>• Зах зээлийн боломж нь юу байна? |
| | Хамгаалалттай газрын дэд бүтэц | • Тусгай хамгаалалттай газрын бүх дэд бүтцийн жагсаалт (жуулчдын мэдээллийн төв, аялал, амралтын өрөө гэх мэт) эдгээр нь ашиглагдаж байгаа эсэх? Нөхцөл байдал?<br>• Боловсролд хэрэгтэй материал байгаа эсэх? Сонсогчид хэн байна?<br>• Паркд эдийн засгийн хандив тусламж ирэх ямар боломж байна? Оршин суугчдад очдог эсэх, очдог бол яаж? |

| | | |
|---|---|---|
| Хамгаалалттай газрын бүсээс гаднах хэсэгт | Хамгаалалтын захиргааны хүний нөөц | • Хичнээн ажилчид жуулчидтай шууд харьцдаг? Ямар мэргэжилтэй байдаг? Сайн дурааараа юу үндсэн ажилчид байдаг уу? Санхүүгийн эх үүсвэр нь хаанаас байдаг?<br>• Сургалт, судалгааны явц<br>• Хамгаалалттай газрын нөөцийг хамгаалахад хүний нөөц хангалттай эсэх? |
| | Нутгийн иргэдтэй хамтран ажиллах | • Хамгаалалттай газарт нутгийн иргэд болон төрийн бус байгууллагуудын аялал жуулчлалд оролцох оролцоо болон нөлөөллийг гаргаж ирэх<br>• Нутгийн иргэдэд зориулж аялал жуулчлалын ач холбогдол, үнэ цэнэ нь юу вэ?<br>• Аялал жуучлалын төрлүүд, бусад бүтээгдэхүүн үйлчилгээнд ард иргэдийг татан оролцуулах |
| | Бүсийн дэд бүтэц | • Дотоодын ба гадаадын жуулчид яаж ирдэг вэ?<br>• Замын нөхцөл байдал |
| | Бусад бүсийн үзмэрүүд | • Тухайн бүс нутагт аялал жуулчлалын үзмэр байгаа эсэх ?<br>• Хамгаалалттай газарт багтдаг аяллын багц байдаг эсэх?<br>• Хамгаалалттай газрын дотор худалдааны газар байдаг эсэх? |
| | Үндэстний хэтийн төлөв /хууль, бодлого, төсөв/ | • Хамгаалалттай газар доторх аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах хуулийн бичиг баримт, дүрэм журам байдаг уу?<br>• Хэн аялал жуулчлалын бодлогын мониторинг, тогтвортой байдлыг хариуцах вэ?<br>• Хаанаас орлого ордог вэ? Хамгаалалттай газар руу орох төлбөрийн систем нь ямар байдаг?<br>• Тусгай хамгаалалттай газрын үйлчилгээний санхүүгийн эх үүсвэр нь хаанаас байдаг? Хангалттай эсэх? |
| | Хувийн байгууллагуудын оролцоо | • Хамгаалалттай газарт хувийн байгууллагууд нь аялал жуулчлалын үйл ажиллагаатай хэрхэн холбогддог?<br>• Аялал жуулчлалын тур оператор, компаниуд нь хамгаалалттай газрыг яаж сонгодог?<br>• Хамгаалалтын оролцоо<br>• Хамгаалалттай газрын захиргаа болон засгийн газарт хувийн байгууллагуудыг зохицуулах бодлого төлөвлөлт байдаг эсэх? |
| Олон нийтийн байгууллагууд | Зорилго | • Оролцогч талуудын төлөөлөгчдийг авчрах (нутгийн иргэд, аялал жуулчлалын үйлдвэрлэл эрхлэгчид, байгаль орчны болон аялал жуулчлалын яам, хамгаалалттай газрын захиргаа)<br>• Эко аялал жуулчлалын эвсэл, холбоог байгуулах<br>• Эко аялал жуулчлалын хөгжлийн үзэл баримтлалыг гаргаж ирэх<br>• Үзэл баримтлалыг үргэлжлүүлэх стратегийг тодорхойлох |
| | Эко аялал жуулчлалын стратеги | • Хамгаалалттай газар дахь эко аялал жуулчлалын хөгжилд шаардлагатай үйл ажиллагаануудын жагсаалтыг гаргах<br>• Мониторингийн системийг багтаах- идэвхтэй үйл явц |

| Стратегийн зорилтууд | | |
|---|---|---|
| | Байгалийн нөөц | • Экологийн нөлөөлөлд мониторингийн механизмыг ашиглах<br>• Экосистемийн төрөл зүйл, тухайн газрыг тооллогод хамруулах |
| | Жуулчдын мэдээлэл | • Жуулчдын статистик тоо баримтыг бичих<br>• Жуулчдын судалгааг төлөвлөх |
| | Хамгаалалттай газрын дэд бүтэц | • Мастер төлөвлөгөөг зохиох<br>• Нэн тэргүүний үйл ажиллагаа, хэрэгжүүлэлтийг жагсаах /нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглах/ |
| | Хүний нөөц | • Шаардлагатай боловсон хүчнийг ажилд авах, чадваржуулах<br>• Шаардлагатай сургалтыг хэрэгжүүлэх |
| | Хамгаалалттай газар ба нутгийн иргэдийн оролцоо | • Нутгийн иргэдтэй харилцаагаа үргэлжлүүлэх - тэд аялал жуулчлалд оролцоход ямар үүрэгтэй оролцох вэ гэдгийг тодорхойлох<br>• Эко аяллын нөхөрлөл хороо болон нутгийн иргэдтэй уулзалт зохион байгуулах |
| | Бүс нутгийн дэд бүтэц ба хамтын ажиллагаа | • Бүс нутгийн хөгжлийг сайжруулах (зам, эмнэлэг, зочид буудал гэх мэт)<br>• Засгийн газар болон хувийн байгууллагууд шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэх<br>• Бусад ойролцоо орших аялал жуулчлалын үзмэрүүдийг хөгжүүлэх |
| | Үндэстэний хэтийн төлөв | • Хамгаалалттай газарт аялал жуулчлалын менежментийг хянах бүлгийг байгуулах<br>• Гадаадын болон дотоодын жуулчдын хамгаалалттай газарруу нэвтрэх үнийн дүнг тодорхойлох<br>• Хамгаалалттай газрын төсвийг хуваарилах |
| | Хувийн байгууллагуудын оролцоо | • Тур операторуудын үүрэг ба ямар тур операторуудтай хамтран ажиллах вэ гэдгийг шийдвэрлэх<br>• Жуулчдын эрэлт хэрэгцээний тухай тур операторуудаас мэдэх<br>• Хамгаалалттай газрын зах зээлийг хэрхэн сайжруулахаа шийдвэрлэх |
| | Стратегийн баримт бичгийг хэвлэх, тараах, бичих | • Тухайн газрын ерөнхий менежментийн төлөвлөгөө<br>• Эко аялал жуулчлалын хороогоор батлуулж өөрчлүүлэх ёстой<br>• Хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөнд нэгтгэх<br>• Энэ үед хэрэгтэй зөвлөхийг ажилд авч бас болно |

## II.3. ТХГН-Т АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛҮҮД



**ТХГН дахь аялал жуулчлалын байгаль орчны үнэ цэнэ.** Аливаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, төслийн нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүд нь урт хугацааны мониторингийн үр дүнгээр тодорхойлогддог. Тухайн ТХГН-т амьдарч буй оршин суугчдын амьжиргааг дээшлүүлэх, байгаль орчны урт хугацааны тогтвортой байдлыг хангах үүднээс аялал жуулчлалаас орчинд үзүүлж буй нөлөөллийн мониторинг байнга хийгдэж байх хэрэгтэй (Зураг 2.3). Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх нь төслийн хүрээнд *"Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын үзүүлэх байгаль орчин, нийгэм эдийн засгийн нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд"* (2011)-ийг боловсруулсан байдаг. Энэхүү шалгуур үзүүлэлтүүдийг нэгтгэсэн баримт бичиг нь аялал жуулчлалаас тусгай хамгаалалттай газарт үзүүлж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг байгаль орчин, нийгэм-эдийн засаг, соёл, менежмент, дэд бүтцийн хүрээнд дэлгэрэнгүй тайлбарлаж, үнэлгээний арга зүйг тодорхой тусгасан.

| Менежментийн зорилго & үнэлгээний хамрах бүрдлүүдийг тодорхойлох | Менежментийн бүрэлдэхүүн-үнэлгээний хэрэгцээ, шаардлага | ТХГН-ийн түвшинд нөхцөл байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд (ургамалжилтанд гарч буй өөрчлөлт, аялагчдын хэрэгцээнээс үүдэлтэй сөрөг үр дагаварууд г.м) |
|---|---|---|
| ТХГН-ийн үнэ цэнэ, ерөнхий тодорхойлолт /байгалийн, нийгэм-эдийн засгийн/ | | Байгаль орчны бүрэлдэхүүнд гарч буй өөрчлөлтийн шалгуур үзүүлэлтүүд (ойн санд, нууранд, элсэн манханд, хөрсөнд г.м) |
| Аялал жуулчлалаас үүдэн байгаль орчинд учирч болох аюул, осол | | Аюул, ослын шалгуурууд (явган аяллаас үүдэлтэй аюул г.м) |
| Аялал жуулчлалын үйл ажиллагаанд ашиглагдаж буй газар, орчинд хийгдэх мониторингийг тодорхойлох | | |
| Тухайн шалгуур үзүүлэлтүүд аялал жуулчлалтай хамааралтай эсэхийг тогтоох | | Аялал жуулчлалын нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүд (ТХГН-т) |

Тухайн газар орны онцлогоос хамааран шаардлагатай шинэ шалгууруудыг тодорхойлох

Нөлөөлөл, шалгуур үзүүлэлтийн жагсаалт боловсруулах

-Тэсвэрлэлт
-Нөлөөллийн чухал эсэх
-Шалгуур үзүүлэлтүүдийг сонгох

Сонгож авсан шалгуур үзүүлэлтүүдийг үнэлэх мониторингийн хөтөлбөр

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, бууруулах зөвлөмж боловсруулах

Аялал жуулчлалын нөлөөллийн үр ашигтай менежмент

Өөрчлөлтөнд дасан зохицох менежмент

Зураг. 2.3. *Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөнд аялал жуулчлалаас үзүүлэх нөлөөллийг тусгах нь*

ТХГН-т аялал жуулчлалын үзүүлэх нөлөөг шууд болон шууд бус нөлөөлөл гэж ангилж болохоос гадна байгаль орчин, нийгэм, эдийн засаг, соёл, менежмент, дэд бүтцийн нөлөө талаас нь мөн ангилж үзэж болох юм (Зураг 2.4).

ТХГН-т аялал жуулчлалын үзүүлэх нөлөөллийг тус тусад нь авч үзье.

Хүснэгт 2.11. *Аялал жуулчлалын үзүүлэх байгаль орчны нөлөөлөл*

| | Байгаль орчны эерэг нөлөөлөл | Байгаль орчны сөрөг нөлөөлөл |
|---|---|---|
| 1 | БЦГ болон ТХГН нь байгальд тулгуурласан аялал жуулчлалд шаардлагатай бүхий л экологийн хамгаалалтыг бий болгож, дэмжлэг үзүүлдэг | Тухайн бүс нутгийн онгон байдалд сөргөөр нөлөөлөх |
| 2 | Хог хаягдлын менежментийг сайжруулдаг | Хурдацтай хөгжил, хэт төвлөрөл зэрэг нь бүс нутгийн экосистем болон байгаль орчныг тасралтгүй өөрчилж байдаг |

| | | |
|---|---|---|
| 3 | Байгальд тулгуурласан аялал жуулчлалын эрчимжилт болон хөгжлөөс хүрээлэн буй орчны тухай ойлголт болон мэдээллүүд ихээхэн нэмэгдэж байна | Далайн эрэг, БЦГ, цэцэрлэгүүд нь хэт их ачаалал, менежмент муутайгаас доройтолд орж болох юм |

Хүснэгт.2.12. *Аялал жуулчлалын байгаль орчинд үзүүлэх шууд ба шууд бус нөлөөлөл*

| Экосистемийн бүрэлдэхүүн | Нөлөөлөл | Шалтгаан |
|---|---|---|
| Хөрс | | |
| Шууд нөлөөлөл | - Хөрсний бүтэц өөрчлөгдөх<br>- Ялзмагшилт багасах<br>- Хөрсний физик өөрчлөлт буюу эх чулуулгийн элэгдэл | - Дэд бүтэц барьж байгуулах<br>- Ил гал түлэх<br>- Хог хаягдлын хуримтлал<br>- Машин зам<br>- Ургамал нөмрөг алдарснаар хөрс ус болон салхиар зөөгдөх<br>- Гадаргын урсац өөрчлөгдөх |
| Шууд бус | - Хөрсний чийг багасах<br>- Хөрсний нүх сүвэрхэг чанар муудах<br>- Хөрсөн дэх микро организмууд устах | - Хөрсний өнгөн хэсгийн угаагдал<br>- Хөрсний хими\физик шинж өөрчлөгдөх |
| **Геологи, геоморфологид гарах өөрчлөлт (нуур, намаг, агуй, хад цохио, элсэн манхан, мөсөн бүрхэвч, цэвдэгийн үе г.м)** | | |
| Шууд нөлөөлөл | Физик өөрчлөлт (эвдэрч, элэгдэх) | Нөлөөлөл ихтэй үйл ажиллагаа, аяллын хэлбэрүүд (ууланд авирах, ууланд дугуйгаар аялах, морин аялал г.м) |
| Шууд бус нөлөөлөл | - Харагдах байдал өөрчлөгдөх<br>- Хөрсний элэгдэл, ус зүйн өөрчлөлт | Нөлөөлөл ихтэй үйл ажиллагаа, аялал (ууланд авирах, ууланд дугуйгаар аялах, морин аялал г.м) |
| | Ус, усан орчин | |
| Шууд нөлөөлөл | Усны чанар муудах, бохирдох | АЖ-ын барилга байгууламж, жуулчны үйлчилгээнд гадаргын болон гүний ус ихээр хэрэглэх, ус цэвэрлэх болон бохир ус зайлуулах хэлбэр |
| Шууд бус нөлөөлөл | - Усны хомсдол<br>- Гүний усны түвшин доошлох | |
| **Ландшафтад үзүүлэх нөлөө** | | |

| | | |
|---|---|---|
| Шууд нөлөөлөл | - Ургамал нөмрөгийн алдрал<br>- Газрын гадаргын хэлбэрт нөлөөлөх | Гэр бааз, майхантай хээр хоноглох, замгүй газраар дугуйгаар аялах, уулын дугуйн аялал, мод, модлог ургамлыг түлшинд хэрэглэх, ил гал түлж отоглох г.м |
| Шууд бус нөлөөлөл | - Харагдах орчны үзэмж буурах | Гэр бааз, майхантай хээр хоноглох, замгүй газраар дугуйгаар аялах, уулын дугуйн аялал, мод, модлог ургамлыг түлшинд хэрэглэх, ил гал түлж отоглох г.м |
| **Ан амьтан** | | |
| Шууд нөлөөлөл | Ан амьтны зан төлөвт нөлөөлөх:<br>- Идэш тэжээлийн хэлхээнд өөрчлөлт гарах,<br>- Өсөлт үржлийн хэв шинж өөрчлөгдөх<br>- Бусад өөрчлөлтүүд<br>- Амьдрах орчны өөрчлөлт<br>- Агнаж үргээх, шархдуулах | - Аялагчдын зан төлөв (зураг авах, гэрэл, дуу чимээ), аялагчдын бөөгнөрөл<br>- Гэрэл, дуу чимээ (жуулчны бааз, амралтын газар зэрэг хүмүүс олноороо цугласан газраас)<br>- Дэд бүтэц, барилга байгууламжаас үүдэн хөрс, ургамал бүрхэвч эвдэрч элэгдэх<br>- Хүнс тэжээлийн хомсдол,<br>- Зэрлэг ан амьтантай зохисгүй харьцах (хэт ойроос зураг авах)<br>- Замын осол,<br>- Ан агнуур, загасчлах, ангийн олзвор цуглуулах |
| Шууд бус нөлөөлөл | - Эрүүл мэнд муудах<br>- Үхэл хорогдол ихсэх<br>- Нөхөн үржил, өсөлт буурах<br>- Төрөл зүйл өөрчлөгдөх<br>- Популяцийн тоо толгой багасах, өөрчлөгдөх | |
| **Ургамал** | | |
| Шууд нөлөөлөл | - Ургамал нөмрөгийн алдрал<br>- Ургамлын өсөлт, өндөр багасах<br>- Ургацын хэмжээ, гарц багасах<br>- Биомассын хэмжээ багасах<br>- Төрөл зүйл устах<br>- Мод, ой бүхий талбай багасах | Жуулчны бааз, рекреацийн үйл ажиллагаа, замгүй газраар машинаар явах, уулын дугуй, морин аялал, түлшинд мод, сөөгийг хэрэглэх, ил гал түлж отоглох |
| Шууд бус нөлөөлөл | - Ургамлын төрөл зүйлийн өөрчлөлт<br>- Популяцийн өөрчлөлт<br>- Микро уур амьсгалын өөрчлөлт | |

Хүснэгт 2.13. *Аялал жуулчлалын үзүүлэх эдийн засгийн нөлөөлөл*

| | Эдийн засгийн зерэг нөлөөлөл | Эдийн засгийн сөрөг нөлөөлөл |
|---|---|---|
| 1 | Аялал жуулчлал нь орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг бий болгодог | |
| 2 | Аялал жуулчлал нь дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээг өдөөж өгдөг | |
| 3 | Аялал жуулчлал нь тухайн улсад гадаад валютыг бий болгож, орон нутгийн эдийн засагт шинэ мөнгө болон капиталыг оруулдаг | Аялал жуулчлалаас шалтгаалсан өндөр эрэлт нь газар, байшин болон өдөр тутмын амьдралд шаардлагатай өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийг өсгөж магадгүй |
| 4 | Аялал жуулчлал нь орон нутгийн эдийн засгийг олон боломжтой болоход тусалдаг | Аялал жуулчлалын идэвхтэй улиралд эрүүл мэндийн үйлчилгээ болон цагдаагийн үйлчилгээний эрэлт нь орон нутгийн татварт тулгуурладаг зардлыг өсгөж болно |
| 5 | Аялал жуулчлалын хөгжлөөс ирэх ашиг нь замын систем болон дэд бүтцийг сайжруулахад дэмжлэг болдог | |
| 6 | Ядуучуудад эдийн засгийн нөхцлөө сайжруулахад дэмжлэг болдог | |
| 7 | Аялал жуулчлалаас орох орлого нь татварын орлогыг нэмэгдүүлдэг | |



Хүснэгт 2.14. *Аялал жуулчлалын үзүүлэх нийгмийн нөлөөлөл*

| | Нийгмийн зерэг нөлөөлөл | Нийгмийн сөрөг нөлөөлөл |
|---|---|---|

| | | |
|---|---|---|
| 1 | Аялал жуулчлал нь эдийн засгийн өргөжилтөөр дамжуулан нийгмийн амьдралын чанарыг дээшлүүлдэг | Аялал жуулчлалын хурдацтай өсөлт нь орон нутгийн үйлчилгээний байгууллагууд эрэлтийг бүрэн хангаж чадахгүй байх нөхцөлийг үүсгэж болзошгүй |
| 2 | Гадаадын болон дотоодын аялагчдын адилаар орон нутгийн иргэд нь аялал жуулчлалд зориулсан амралтын болон соёлын байршуулах хэрэгслийг ашиглах боломжтой | Зөв төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалт байхгүй бол хогны асуудал, бохирдол, гэмт хэрэг, зөрчил аялал жуулчлалыг дагалдаж байдаг |
| 3 | Нийтийн эзэмшлийн газар нутаг нь аялал жуулчлалын үйл ажиллагаанаас хөгжиж болно | Аялал жуулчлал нь тээврийн хэт их ачаалал, түгжрэлийг бий болгодог |
| 4 | Аялал жуулчлал нь орон нутгийн хүмүүсийн хүндлэлийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ төрөл бүрийн боловсрол, мэдлэгтэй хүмүүсийг харилцан ойлголцох, харилцах боломжийг бүрдүүлж өгдөг | Залуучууд нь аялал жуулчлалаас ирэх эдийн засгийн хүлээлтээс шалтгаалан уламжлалт амьдралын хэв маягаа алдах талтай |
| 5 | | Нийгмийн бүтэц өөрчлөгдөж болно |
| 6 | | Аялал жуулчлалын эрэлтээс шалтгаалан нийгмийн болон соёлын орчны унаган байдал өөрчлөгдөж болно |

Хүснэгт 2.15. *Аялал жуулчлалын үзүүлэх соёлын нөлөөлөл*

| | Соёлын эерэг нөлөөлөл | Соёлын сөрөг нөлөөлөл |
|---|---|---|
| 1 | Аялал жуулчлал нь орон нутгийн соёлтой холбоотой мэдлэгийг нэмэгдүүлдэг | Залуучууд жуулчдын хувцас болон хэл яриаг дуурайж эхэлдэг |
| 2 | Аялал жуулчлал нь археологийн олдвор, түүхэн барилга болон бүс нутгийг хамгаалах зардалд нэмэр болох орлогыг бий болгодог | Аялал жуулчлалын хөгжил болон даацаас шалтгаалан түүх дурсгалт газрууд эвдэрч сүйдэх магадлалтай |

| | | |
|---|---|---|
| 3 | Соёлын талаарх мэдлэг болон туршлагаа хуваалцах замаар орон нутгийн уламжлал болон урлагийг сэргээх боломжтой | Соёлын уламжлал болон соёлын үнэт чанар нь урт хугацаанд элэгдэн хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнээс ихээр соёлыг өөрчилдөг |

**Жишээ.6.** Аялал жуулчлалаас байгаль орчин, нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, үнэлгээг тооцох талаар Монгол улсад хийгдсэн ажлууд. Аялал жуулчлалын хөгжилтэй уялдуулан, түүний байгаль орчин, нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөллүүд болон жуулчны сэтгэл ханамжийн судалгаанууд тодорхой төвшинд хийгдсэний дотроос:

- 2000 онд Японы ЖАЙКА байгууллагын гүйцэтгэсэн "Монголын аялал жуулчлалын мастер төлөвлөгөө",
- Мөн үед Европын Холбооны ТАСИС хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр боловсруулагдсан "Монголын аялал жуулчлалын стратеги төлөвлөгөө" нь үндсэн судалгааны хамарсан хүрээ, санал, зөвлөмж болгосон хөтөлбөр, төслүүдийн үр дүнгээр одоо хүртэл ач холбогдолтой хэвээр байна.

Монголын аялал жуулчлалын хөгжлийн тулгамдсан асуудлуудаар холбогдох судалгаа хийх, байгаль орчин, нийгмийн асуудлуудтай уялдуулан төсөл, хөтөлбөрүүд боловсруулж, сургахад олон улсын хандивлагч байгууллагууд (нэн ялангуяа GTZ, USAID, WWF) техникийн туслалцаа үзүүлж ирсний үр дүнд:

- Олон улсын аялал жуулчлалын талаар 2002, 2004, 2006 онуудад явуулсан судалгааны тайлангууд, (АНУОУХА, ДБХЯ)
- Хан Хэнтийн ДЦГ болон бусад ТХГН-уудад боловсруулсан аялал жуулчлалын төлөвлөгөө, сургалт судалгаанууд (GTZ)
- Нидерландын вант Улсын Засгийн Газрын санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Байгаль Орчны шинэчлэл 2" төслийн судалгаанууд,
- МҮХАҮТ-ын "Ногоон шошго" хөтөлбөр
- Аялал Жуулчлалын Тогтвортой Хөгжил Төвөөс сүүлийн жилүүдэд ТХГН, орон нутагт болон НИТЭЖ-ын шалгуур үзүүлэлтийг тогтоох чиглэлээр гүйцэтгэсэн төслүүд зэрэг багагүй судалгаанууд нь Монгол улсад тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын сөрөг нөлөөллийг багасгахад тодорхой хувь нэмэр оруулсан байна.

## II.4. НУТГИЙН ИРГЭД, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР, БУСАД БҮС БА ОРОН НУТГИЙН БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ




Зураг 2.5. *Эко аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хамтын оролцоо, түншлэл нэн чухал*

Хамтын ажиллагаа/түншлэл нь байгаль хамгааллын үүсгэл санаачлагуудыг хэрэгжүүлэх гол үндэс болно. Энэ нь энгийн ойлголт мэт боловч харин хэрэгжүүлэхэд тийм ч хялбар биш. Хамтран ажиллах бүлэг, нөхөрлөлүүдийг байгуулан ажиллуулахад нэлээд хүч чармайлт шаардагдана. Талууд аялал жуулчлал, хүрээлэн буй орчин, бусад холбогдох асуудлаар өөрсдийн мэдлэг, туршлагаа хуваалцан ажилладаг байх хэрэгтэй. Хамтран ажиллах байгууллагууд байгаль хамгааллын бүлэг нөхөрлөлүүд, судалгааны байгууллагууд, амьтны хүрээлэнгүүд, их дээд сургуулиуд, музей зэрэг нь орж болно. Төрийн бус байгууллага (ТББ)-уудтай хамтран ажиллах нь ТХГН-уудын төлөвлөлт, менежментийг үр дүнтэй явуулахад чухал



ач холбогдолтой. ТББ-ууд нь байгаль хамгааллын тодорхой асуудлуудыг шийдвэр гаргах хэмжээнд дэвшүүлэн тавьдаг байх буюу олон нийтийн хөгжлийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх буюу асуудалд ерөнхийд нь буюу өргөн хүрээгээр ханддаг байж болно. ТББ-ууд нь ТХГН-уудын менежментийг сайжруулах арга замуудыг төр засгийн газарт хүргэх, байгаль хамгааллын асуудлаар олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, сайн дурын ажиллагааны удирдамж чиглэлүүдийг боловсруулахад хувь нэмэр оруулдаг байна. Хэрэв нутгийн иргэдийг төлөвлөлт, менежментийн үйл ажиллагаанд оролцуулах гэж байгаа бол эхлээд тэднийг чадавхижуулахад анхаарлаа хандуулах хэрэгтэй. Үүний тулд шаардлагатай сургалтуудыг гадны байгууллага компанитай хамтран зохион байгуулах нь илүү үр дүнтэй байж болно. Сургалтыг тухайлбал хөгжлийн гадаадын /олон улсын тусламжийн хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж болно. Гадны мэргэжлийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах нь орон нутгийн/ дотоодын байгууллагуудын ур чадварыг дээшлүүлэх чадавхжуулахад чухал ач холбогдолтой. Орон нутгийн хэмжээнд чадварлаг байгууллагуудтай байх нь тэд төлөвлөлт, шийдвэр гаргах явцад байнга оролцдог байж, чадварлаг бүтэц зохион байгуулалтыг орон нутагт бий болгоно. Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг хангах гол түлхүүр элемент бол тухайн газар, аялагч жуулчид болон тухайн газрын нутгийн иргэдийн хооронд харилцан уялдсан холбоо харилцаа байдаг. Тавьж байгаа зорилт нь тухайн газарт ирж байгаа аялагч жуулчдын сэтгэл хангалуун байдлыг алдагдуулах, нутгийн иргэдийг ашиглах/завших, нөөцийг доройтуулахаас аль болох зайлсхийх хэрэгтэй. Нутгийн иргэдэд түшиглэсэн түншлэл нь тухайн газрын онцлог чанарыг хадгалах, амралт зугаалга аялал жуулчлалын боломжуудыг хөхүүлэн дэмжих, нутгийн иргэдийг дэмжин туслахад хувь нэмэр оруулж чадна. Хамтын ажиллагааны явцад хийж болох өөр нэг чухал ажил бол шинээр хамгаалалтанд авах газар нутгийг тогтоох буюу одоогийн байгаа ТХГН-уудын хилийн зааг өөрчлөлт оруулах ажил орж болно. Ийм томоохон ажил, зорилтыг төр засгийн холбогдох шатны байгууллагууд болон олон нийттэй зөвлөлдөх замаар хэрэгжүүлнэ (Parks Canada, 1994)[8]. Мадикве Гэймийн нөөц газар Жишээ 5-д хамтын ажиллагаа нь ямар ач холбогдолтой болохыг харуулсан.

### Жишээ 7: Мадикве Гэймийн нөөц газар (Өмнөд африк) – аялал жуулчлал, аялал жуулчлалын хөрөнгө оруулалтыг татах зорилготой экологийн нөхөн сэргээлт/ жишээ

*8 Parks Canada. (1994a). Guiding Principles and Operational Policies. Parks Canada, National Parks Directorate, Hull, PQ, Canada*

Тус нөөц газар нь 1991 онд байгуулагдсан бөгөөд Өмнөд Африкийн баруун хойд бүс нутгийн хамгаалалттай газруудын зөвлөлд харъяалагддаг. Тус нөөц газарт нөхөн сэргээлт хийгдсэн тал хээрийн экосистем ордог. Өмнө нь тус нөөц газрын ихэнх хэсгийг ашиглахаа больсон тариалангийн талбайнууд, тэдгээрийг даган барьсан олон жижиг байшин, барилга байгууламж, хэдэн зуун километрт үргэлжлэх хуучин хашаа эзэлж тэдгээрийг дагасан хогийн ургамлуудыг устгажээ. Харин нөхөн сэргээх ажлыг хийхдээ уг байшин барилгуудын ихэнх хэсгийг авч хаян /цөөн тооны байшинг паркийн ажилтнууд бусад зорчигчдын байрлах газар болгон үлдээж/, харийн зүйл ургамлуудыг устгажээ. Заан болон бусад томоохон махчдыг гадагш гаргахгүй байх зорилгоор нөөц газрын 60,000 га талбайг тойруулан 150 км-т хашаа барьжээ. Хашаажуулах болон ашиглагдахаа больсон олон жижиг байшин, хашаа байгууламжуудыг буулгах, зарим газарт шинэ байшин, зам, далан, оромж барих ажлуудыг гүйцэтгэхдээ орон нутгийн иргэдийг татан оролцуулсан байна. Одоогоор анчдын хэд хэдэн байр оромж барьсан бөгөөд бусад зориулалтын байшин, отгуудыг цаашид барихаар төлөвлөсөн. 1991 оноос буюу тухайн нөөц газрын хамгаалалтын хашааг барьж дуусахын өмнө зарим ан амьтдыг нутагшуулах ажлыг эхлүүлсэн. Фоениксийн ажиллагаа гэж нэрлэгдсэн ан амьтдыг нутагшуулах уг хөтөлбөр нь энэ чиглэлээр дэлхийн хэмжээнд хэрэгжүүлсэн хамгийн том ажил болсон юм. Уг хөтөлбөрийн хүрээнд заан, хирс, зэрлэг үхэр, арслан, анч нохой, цөөвөр чоно, анааш, цоохор тахь, гөрөөсний нэлээд олон зүйл болон өвсөн тэжээлтэн амьтад зэрэг нийт 28 зүйлийн 10,000 гаруй амьтдыг тус нөөц газарт нутагшуулжээ. Тус нөөц газарт өмнө ирвэс байдаг байсан. Уг нөөц газрыг анх байгуулахдаа Баруун хойд бүсийн паркуудын зөвлөл, хувийн салбар, нутгийн иргэд гэсэн 3 талыг





уг нөөц газрын менежментэд оролцогч, ашиг хүртэгчид байна гэж тогтоосон. Уг 3 тал байгаль хамгаалал, аялал жуулчлалын үйл ажиллагааг хамтран явуулж, харилцан ашиг хүртдэг болсон. Паркуудын зөвлөл нь Мадикве-ийн хамгаалалттай газрын өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай дэд бүтэц, менежментийг хариуцан ажилладаг. Түүнчлэн уг зөвлөл нь тус нөөц газрын хэмжээнд аялал жуулчлалын үйл ажиллагааг өргөжүүлэх үүднээс шинээр ашиглаж болох газруудыг тогтоон хувийн салбарын бизнес эрхлэгчдэд түрээслүүлэх ажлыг хариуцан ажилладаг. Хувийн салбар нь тус нөөц газарт ангийн отог барих, өөрсдийн барьсан түр буудаллах байруудын зарим хэсгийг зах зээлд гаргах эсвэл өөрсдөө ажиллуулах, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх, спорт ан агнуурын үйл ажиллагааг эрхлэн явуулдаг. Эдгээр үйл ажиллагааг хувийн салбар тус нөөц газарт эрхлэн явуулдаг болсноор төр засгийн дэмжлэг, санхүүжилт гэх бус харин хувийн салбарын хөрөнгө оруулалтыг уг нөөц газарт, татан оруулдаг болсон. Өмнө газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлж байх үед буюу 1999 он гэхэд барихаар төлөвлөж байсан 10 жижиг байшин/түр буудаллах байрны зөвхөн 3-ыг барьсан байсан. Харин аялал жуулчлалын эдийн засгийн нөлөө газар тариалангийн бизнесээс хавьгүй өндөр гэдэг илт харагдах болсон. Харин уг төслийн ажиллагааг талуудын хамтын ажиллагааны үр дүнд амжилттай хэрэгжиж чадсан. 1998 онд Мадиквегийн ан амьтдын нөөц газар, паркийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд Английн Айрвэйс/ Олон улсын байгаль хамгаалах холбоо дэмжлэг тусламж үзүүлсэн. Уг төсөл нь төр засаг/хувийн салбарын хамтын ажиллагаа, байгалийн аялал жуулчлалын маш сайтар боловсруулсан дизайны үр дүнд амжилттай хэрэгжсэн экологийн нөхөн сэргээлтийн маш гайхалтай жишээ болсон.

Төслийн ажиллагааг амжилттай хэрэгжүүлж ирсэн нь талууд төслийн бүхий л үйл ажиллагаанд хамтран оролцож, маркетинг, цогц бүтээгдэхүүний багцыг бий болгон, тээврийн сүлжээг бий болгон, үйлдвэрлэл/бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх замаар бизнесийн үр ашгаа нэмэгдүүлж чадсантай холбоотой. Тухайлбал: аялал жуулчлалын олон жижиг газруудыг тус бүрд нь бус харин тэдгээрийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэгтгэн цогц болгон аль болох олон жуулчид, аялагчдыг татах зорилго тавьсан. Бие даасан тус тусдаа ажиллах олон жижиг газруудад жуулчид зөвхөн ганц нэг үйлчилгээ авахаар тухайн газрын зорихгүй байх учраас тэд тэдгээр олон жижиг газруудыг нэгтгэн үйлчилгээ бүтээгдэхүүний цогц байдлыг санал болгож чадсанаар илүү олон жуулчдыг чадаж чадсан. Ингэж хамтран ажиллахдаа хөгжлийн үйл ажиллагаатай холбоотой хэрэгжүүлсэн үйл ажиллагааны зардлаа хуваадаг болсон байна.

**Вэб хуудас: http://www.parks-nw.co.za/madikwe/index.html**

## Жишээ 8: Аялал жуулчлалын үйлдвэрлэлд оролцдог байгууллагуудад өгөх зөвлөмж

Тусгай хамгаалалттай газар нутгийн (ТХГН) захиргаа байгаль орчны тогтвортой байдлыг хангахын тулд:

- Байгалийг тэтгэх даац, чадавхийн хүрээнд нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах, экологид халгүй цэвэр технологийг дэмжих бодлогыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд баталгаажуулах
- ТХГН-ийн ойр орчмын агаар, ус, хөрсний бохирдлыг багасгаж, иргэдийн ажиллаж амьдрах эрүүл орчинг бүрдүүлэх
- Хог хаягдлыг тусгай цэг дээр ангилалтайгаар хаядаг болгох
- Экологийн хувьд доройтож байгаа, экосистемийн тэнцвэрт байдал алдагдсан газруудад төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах
- Амьтан, ургамлын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах менежментийг сайжруулж, тэдгээрийн байгалийн жамаар өсөж үржих, нөхөн сэргэх таатай нөхцөлийг бүрдүүлэх
- Аялал жуулчлалын эрхзүйн орчныг боловсронгуй болгох, жуулчлалын бүсийн дэд бүтцийг сайжруулах замаар жуулчдын тоог нэмэгдүүлэх
- Байгаль орчны захиргааны хяналтыг сайжруулан, байгалийн нөөц баялгийн халдашгүй байдлыг хангах үүрэг, хариуцлагыг чангатгах
- Аялал жуулчлал эрхлэгч байгууллагуудтай гэрээний дагуу хамтарч ажиллах
- Хамгаалалттай газар руу орох үнийг тогтоож өгөх

- Хууль дүрмийг сайн мөрдөж байгаа иргэд, малчдыг шагнаж урамшуулах

Аялал жуулчлалын үйлдвэрлэл эрхлэгчид

- Тусгай хамгаалалттай газрын хууль дүрмийг чандлан сахих
- Аялал жуулчлалын үйл ажиллагаанд нутгийн иргэдийг татан оролцуулах
- Нутгийн иргэдийн гар урлалын болон боловсруулсан бүтээгдэхүүн, хүнсний ногоог жуулчидад санал болгох, авч хэрэглэх
- Эко аялал жуулчлалын зарчмыг дагаж мөрдөх
- Олсон ашгийн тодорхой хувийг ТХГ-т бодит болон бодит бусаар олгож байх
- Уламжлалт заншилаа хадгалсан, өөрийн орны байгалийн баялгийг жуулчидад таниулсан аяллын хөтөлбөрүүдийг явуулах
- Жуулчидад ТХГ-ын дүрэм журмыг танилцуулж, дагаж мөрдүүлэх
- Жуулчны бааз нь сэргээгдэх эрчим хүч хэрэглэх, ус ашиглалтыг хязгаарлах
- Жолооч нар дурын замаар явж газар нутгийг талхлахгүй байх
- Амьтан ургамлыг нөхөн сэргээх, хамгаалахад гар бие оролцох
- Зөвхөн урьдчилан мэдэгдсэн жуулчдыг Тусгай хамгаалалттай газар руу нэвтрүүлэх



Нутгийн иргэд ба нөхөрлөл

- Нутгийн иргэд ТХГ-ын онцгой бүс рүү малаа бэлчээрлүүлэхгүй байх
- Нутгийн иргэд өөрсдөө бэлэн болон бэлэн бус бүтээгдэхүүнийг бэлтгэх
- Хог хаягдлаа замбараагүй хаяхгүй байх
- Хууль бусаар ан хийхгүй байх
- Хүрээлэн буй орчноо нөхөн сэргээхэд туслах, мод тарих
- Хоршоо нөхөрлөлүүд аялал жуулчлал эрхлэгч байгууллагатай хамтарч ажиллах
- Хоршоо нөхөрлөлүүд ТХГ-т амьдардаг нутгийн иргэдэд эко аяллын үр ашгийг таниулан сурталчилах

Жуулчид буюу эко аялагчид аялахынхаа өмнө

- Тухайн газрынхаа түүх соёл, байгаль, домог, ёс заншил зэргийг мэдэж авсан бол сайн байдаг.

- Тэр орны зарим нэгэн хэллэгийг сурсан байх Сайн уу?, баярлалаа, туслаарай гэх мэт
- Өөрт хэрэгцээтэй өдөр тутам хэрэглэдэг эд зүйлсээ авч явах
- Тухайн газарт очоод байрлах газраа сонгосон байх
- Хүрээлэн буй орчинд хамгийн бага нөлөөг учруулах тээврийн хэрэгслийг сонгох

Аялж байх үедээ:

- Өөрийнхөө ард хөлийн мөрөөс өөр ямар ч мөр үлдээхгүй байх
- Дурсгал болгож зураг авч байх
- Мод хад чулуунд ямар ч бичиглэл үлдээхгүй байх
- Ямар ч хог хаяхгүй байх
- Бусдын хувийн амьдрал болон үзэл бодлыг хүндэтгэж байх. Бусадтай зургаа авахуулахдаа зөвшөөрөл авч байх
- Ховор ба ховордсон ургамал болон амьтны гаралтай эд зүйлс худалдан авахыг цээрлэх
- Маршрутын дагуу явж сурах
- Амьтан, ургамал болон тэдний амьдрах орчныг сүйтгэхгүй байх
- Үнэ хаялцах худалдаанаас зайлсхийх
- Нутгийн хөтчийг хөлслөх
- ТХГН-ын дүрмийг чандлан сахих
- Байгаль хамгаалах ажилд гар бие оролцох
- Явган юмуу экологийн цэвэр техникээр зорчихыг эрхэмлэх
- Нутгийн соёл, аж ахуйг хүндэлж байх

Аяллын дараа:

- Эко аяллын тухай гэр бүл, найз нөхөдтэйгээ хуваалцах
- Тусгай хамгаалалттай газар нутгийг хойч үедээ үлдээхийн тулд хандив тусламж өгөх





# III

# ТХГН-Т АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХӨГЖҮҮЛЭХ НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛЖ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН БИЙ БОЛГОХ НЬ

**АГУУЛГА:**

- ТХГН-т аялал жуулчлал хөгжүүлэх боломж ба нөөцийн үнэлгээ
- Эко аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох алхамууд, бүтээгдэхүүний жишээ
- Эко аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө боловсруулах алхамууд

## III.1.ТХГН-Т АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ БА НӨӨЦИЙН ҮНЭЛГЭЭ

Ихэнх улс орны туршлагаас харахад тусгай хамгаалалттай газар нутаг нь тухайн улсын хувьд эко аялал жуулчлалын гол суурь байдаг. Мөн аялал жуулчлал нь тусгай хамгаалалттай нутаг дэвсгэр, түүний орчны бүсэд амьдардаг иргэдийн хувьд эдийн засгийн нэмэлт ашиг орлого олох үндсэн эх үүсвэр нь болдог. Эко аялал жуулчлалыг хөгжүүлэх байгалийн нөхцөл бололцоо, нөөц тусгай хамгаалалттай газар бүрт харилцан адилгүй байдаг (Хүснэгт 3.1).

Хүснэгт 3.1 *«Эко аялал жуулчлалын нөөц, түүнийг үнэлэх арга»*

| | Эко аялал жуулчлалын нөөц | Үнэлэх арга | |
|---|---|---|---|
| 1 | Байгалийн болон зохиомол ландшафтууд ба тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүд | Ландшафтын үүсэл, түүх, давтагдашгүй байдал, хамгаалагдсан эвдрээгүй байдал, сэтгэл татам байдал болон биологийн төрөл зүйлийн агууламж (ургамал, амьтан г.м) | Тусгай хамгаалалттай газар нутаг (дархан газар, үндэсний болон байгалийн парк, нөөц газар г.м) ба байгалийн дурсгал, ургамал болон амьтны цэцэрлэгт хүрээлэн, усан паркууд |
| | | | Байгалийн түүхийн музей, мөн экологийн зарчимд тулгуурласан байгалийн нөөцийг ашиглаж байгаа сонирхолтой, судлууштай обьектууд |
| | | | Сонирхол татахуйц байгалийн ба зохиомол ландшафтууд, түүх соёлын үнэт дурсгал бүхий газар нутаг орно |
| 2 | Эко аяллын хэрэгслүүд (хөтөлбөр, маршрут) | Экотехнологийн агууламжаар нь | Экотехнологийн тээврийн төрлүүд, эко байршуулах хэрэгслүүд, экотехнологийн аялагчдын тоноглол хэрэгслүүд |
| | | | Экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүн, ихэвчлэн орон нутгийн гаралтай |
| | | | Экологич, мэргэшсэн хөтөч, мэдээллийн материалууд зэрэг орно |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | Аяллыг явуулах нөхцлүүд | Экологийн болон аюулгүй байдлын зөвшөөрөгдөх хэм хэмжээгээр | Экологийн таатай орчин (бохирдолгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан, байгалийн аюул багатай байх) |
| | | | Тухайн газар нутаг нь аяллын зорилгод нийцсэн, хүрч очих боломжтой байх |
| | | | Рекреацийн ачаалал, ус, эрчим хүчний болон бусад нөөцийн хэрэглээний хэмжээ, аяллын хэлбэр, хугацаа боломжит хэмжээнд байх |

ТХГН-д аялал жуулчлал хөгжүүлэх нөөцийн үнэлгээг хэрхэн хийж болох аргазүйн жишээг Монгол орны Зүүн бүсийн Тусгай хамгаалалттай газруудад хийсэн судалгаагаар тайлбарлья.

### Жишээ. 9: Монгол орны зүүн бүс нутгийн онцлог, аялал жуулчлалын өнөөгийн байдал

Монгол орны зүүн бүсэд Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгууд багтдаг. Эдгээр аймгуудад дэд бүтэц бусад аймгуудыг бодвол харьцангуй сайн хөгжсөн. Энэ бүс нутгийн онцлог нь Эзэн Чингисийн өлгий нутаг, түүх дурсгалын үнэт өв соёл, харьцангуй унаган төрхөөр нь хадгалж үлдсэн дэлхийн шим мандлын нөөц газрын сүлжээнд хамрагдсан Монгол Дагуурын тал. Үүнээс гадна Дорнодын тал, Онон, Улз, Балж, Хан-Хэнтий, Дарьгангын үзэсгэлэнт газар зэрэгт түшиглэн аялал жуулчлал, судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулах бүрэн боломжтой бүс нутаг юм. Хэнтий аймгийн чиглэлд Монголын тур операторуудын 40 % орчим нь аяллын маршрут-хөтөлбөрийг зохион байгуулж аялал жуулчлалын улиралд 5-7 хоногийн хугацаатай аяллыг 5-7 удаа зохион байгуулж байна. Харин Дорнод аймгийн чиглэлд Монголын тур операторуудын 35% нь аяллын маршрут-хөтөлбөрийг зохион байгуулж аялал жуулчлалын улиралд 7-10 хоногийн хугацаатай аяллыг 3-5 удаа зохион байгуулж байна.




Зураг.3.1. *Зүүн бүсийн аялал жуулчлалын товч замнал*

**Зүүн бүсийн аялал жуулчлалын нөөц.** Тус бүсийн аялал жуулчлалын нөөц нь харьцангуй унаган төрхөө хадгалсанаараа онцлогтой. Энд Дарьганга, Монгол дагуур, Дорнод Монгол, Онон-Балж болон эртний түүхтэй холбоотой үзмэрүүдэд түшиглэн түүх, соёл, эрдэм шинжилгээний аялал болон тусгай сонирхлын аялал жуулчлал ихээхэн явагддаг бөгөөд эко аялал жуулчлал болон эко зарчмыг агуулсан аяллын шинэ төрлүүдийг хөгжүүлэх боломжтой.

Хүснэгт. 3.2. *Монгол орны зүүн бүсэд орших улсын тусгай хамгаалалттай газар*

| | Улсын тусгай хамгаалалттай газар | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Дорнод Монголын тал ДЦГ | Дорнод Монголын тал хээрийн биологийн төрөл зүйл, ялангуяа цагаан зээрийн амьдрах орчныг хамгаалах зорилгоор 1992 онд хамгаалалтанд авчээ. (Дорнод, Сүхбаатар аймаг) |
| 2 | Монгол Дагуурын ДЦГ | Дагуурын чийглэг тал хээр, болон том жижиг нуур, цөөрөм, гол горхи намгархаг газар бүхий энэ орчин Зүүн өмнөд Азиас, Хойд мөсөн далай хүртэл нүүх шувуудын буудаллах газар, халуун орны олон зүйл усны болон эргийн шувуудын өндөглөн зусах газар болохын хувьд 1992 онд хамгаалалтанд авсан |

| | | |
|---|---|---|
| 3 | Нөмрөгийн ДЦГ | Монголын зүүн хязгаарын үзэсгэлэнт нутаг болох Хянганы экосистем, дэлхийд ховордсон биологийн төрөл зүйлийг хамгаалах зорилгоор 1992 онд хамгаалалтанд авсан |
| 4 | Хан-Хэнтийн ДЦГ /зүүн талын ихэнх хэсэг/ | Төв Азийн бүсэд оршдог, ой багатай Монгол орны өвөрмөц тайгын бүсийн байгаль, Туул, Онон, Хэрлэн голын эх, Хэнтий нурууны биологийн төрөл зүйлийг хамгаалах, Эзэн Чингисийн өлгий нутгийн түүх дурсгалын үнэт зүйлсийг үеийн үед өвлөн үлдээх, байгалийн хувьсал өөрчлөлтийг судлах, шинжлэх ухааны мөнхийн загвар нутаг болох зорилгоор 1992 онд хамгаалалтанд авчээ. (Хэнтий, Төв, Сэлэнгэ аймаг) |
| 5 | Онон-Балжийн БЦГ | Ойт хээрийн бүсийн ландшафтын хэв шинж, иж бүрдэл, ландшафт экологийн тогтоц, ойт хээрийн бүсийн амьтан, ургамал, Монгол оронд багахан хэмжээгээр тархсан нарсан ойн экосистемийг хамгаалах, түүнчлэн байгалийн болон түүхийн дурсгалт газруудыг түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх зорилготойгоор 2000 онд хамгаалалтанд авчээ. (Дорнод, Хэнтий аймаг) |
| 6 | Дарьганга БЦГ | Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төвөөс 12 км-т орших салхины нүүдлээс үүссэн хурмал элсэнд хаагдаж тогтсон нуур бөгөөд энэ орчмын нутгийн уулын хээр, говийн бүсийн шилжилтийн заагт орших экосистем, цэнгэг уст үзэсгэлэнт нуурыг хамгаалах зорилгоор 1993 онд хамгаалалтанд авсан |
| 7 | Тосон хулстайн БНГ | Цагаан зээрийн төллөх, идээшлэх, бэлчээрийн гол газар нутаг бөгөөд унаган төрхөөр нь хадгалан хамгаалах, нөхөн үржих таатай нөхцлийг бүрдүүлж тархац нутгийг өргөтгөх зорилгоор 1998 онд хамгаалалтанд авчээ. (Дорнод, Хэнтий аймаг) |
| 8 | Угтам БНГ | Ховор амьтан, ургамал бүхий энэ уулын ландшафтыг хамгаалах зорилгоор 1993 онд хамгаалалтанд авчээ. (Дорнод аймаг) |

| | | |
|---|---|---|
| 9 | Яхь нуурын БНГ | Цагаан зээр, нүүдлийн шувууд, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах зорилгоор 1998 онд хамгаалалтанд авчээ. (Дорнод аймаг) |
| 10 | Хар ямаат БНГ | Биологийн төрөл зүйл, ландшафтын өвөрмөц хэв шинжүүдийн хослол бүхий онцлог нутгийг уламжлалт мал аж ахуйтай зохицуулан хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, судалгаа шинжилгээний төв болгох зорилгоор 1998 онд хамгаалалтанд авчээ. (Хэнтий аймаг) |
| 11 | Лхачинвандад уул БНГ | Лхачинвандад уулын байгалийн үзэсгэлэнт байдал, ой модгүй ууланд нутагшин үржиж буй буга, бор гөрөөс, илбэнх зэрэг амьтдыг хамгаалах зорилгоор 1965, 1995 онд хамгаалалтанд авчээ |
| 12 | Шилийн богд уулын ДГ | Дарьгангын тэгш өндөрлөгийн мужид 200 орчим галт уул байгаагийн дотор хамгийн өндөр нь 1778 м өндөр Шилийн богд уул юм. Энд 60 шахам хүн чулуун хөшөө бий. Энэхүү өвөрмөц сонин байгаль эхийн бүтээлийг хамгаалах зорилгоор 2004 онд хамгаалалтанд авчээ |
| 13 | Хөргийн хөндийн ДГ | Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төвөөс зүүн хойш 45 км зайд Хөргийн хөндий хэмээх хойноос урагш чиглэлтэй нарийн хөндийн дунд долоон хүн чулуун хөшөө бий. Энэхүү байгаль түүхийн үнэт дурсгалыг хамгаалах зорилгоор 2006 онд хамгаалалтанд авчээ |



Хүснэгт. 3.3. *Түүх соёлын дурсгалт газрууд*

| | Сум | Түүх соёлын дурсгал |
|---|---|---|
| **Хэнтий аймаг** | | |
| 1 | Батширээт | Рашаан хадны полеолит, мезеолит, неолитын үеийн суурин |
| 2 | Батширээт | Үзүүр цохионы хадны зураг |
| 3 | Батширээт | Рашаан хадны зураг, дурсгал |
| 4 | Батширээт | Биндэрийн буган хөшөө |
| 5 | Өмнөдэлгэр | Жаргалантын буган хөшөө |
| 6 | Дэлгэрхаан | Гүн бүрдийн хүн чулуу |
| 7 | Батширээт | Живхээстэйн амны хүн чулуу |
| 8 | Өндөрхаан | Хүн чулуу |
| 9 | Биндэр | Асгатын дөрвөлжин булш |
| 10 | Биндэр | Бор булгийн амны булш дурсгал |
| 11 | Жаргалтхаан | Дуулга уулын хүннү булш |
| 12 | Баян-Адарга | Дуурлиг нарсны хүннү булш |
| 13 | Өмнөдэлгэр | Дээд өлзийтийн дөрвөлжин булш |
| 14 | Батширээт | Ёлын байцын дөрвөлжин булш |
| 15 | Өмнөдэлгэр | Төгс өндрийн булш |
| 16 | Цэнхэрмандал | Устын амны дөрвөлжин булш |
| 17 | Өмнөдэлгэр | Хурх-Жаргалантын булш |
| 18 | Дэлгэрхаан | Хүйтэн хошууны монгол булш |
| 19 | Батширээт | Эгийн живхээстэйн булш |
| 20 | Дэлгэрхаан | Аваргын булш |
| 21 | Мөрөн | Баруун хэрэм |
| 22 | Мөрөн | Зүүн хэрэм |
| 23 | Батширээт | Өглөгчийн хэрэм |
| 24 | Батширээт | Рашаан хадны түрэг бичээс |
| 25 | Мөрөн | Салбар уулын бичигт ханангийн их, бага бичээс |
| 26 | Баянхутаг | Сэрвэн хаалганы бичээс |
| 27 | Цэнхэрмандал | Цэнхэрмандалын түрэг бичээс |
| 28 | Өмнөдэлгэр | Бэрээвэн хийд |
| 29 | Өндөрхаан | Гүндгаравлин хийд, сэцэн ханы Алтан жан өргөө |
| **Дорнод аймаг** | | |
| 30 | Чойбалсан | Баруун Өлзийтийн неолитын буудал, суурин |
| 31 | Чойбалсан | Овоотын суурин ба сууц |
| 32 | Матад | Ловхын хүн чулуу |
| 33 | Сүмбэр | Шонх таван толгойн хүн чулуу |
| 34 | Гурванзагал | Гурванзагалийн дөрвөлжин булшууд |
| 35 | Булган | Норовлингийн неолитын булш |

| | | |
|---|---|---|
| 36 | Чойбалсан | Бүлэг булш |
| 37 | Чойбалсан | Неолитын үеийн булш |
| 38 | Цагаан-Овоо | Тогоонтөмөр вааны Барс хот-3 |
| 39 | Цагаан-Овоо | Хэрлэн барс хот |
| 40 | Гурванзагал, Дашбалбар, Баяндун, Баян-Уул, | Чингисийн хэрмэн зам |
| 41 | Сүмбэр | Их бурхант |
| **Сүхбаатар аймаг** | | |
| 42 | Мөнххаан | Устай Бургастайн шинэ чулуун зэвсгийн суурин |
| 43 | Онгон | Бударын чулууны хадны зураг |
| 44 | Дарьганга | Алтан овооны хүн чулуу |
| 45 | Дарьганга | Гөхөлийн ширээний хүн чулуу |
| 46 | Дарьганга | Ламтын хүн чулуу |
| 47 | Онгон | Тавантолгойн хүн чулуу |
| 48 | Дарьганга | Хөргийн хөндийн хүн чулуу |
| 49 | Онгон | Шивээтийн хүн чулуу |
| 50 | Түвшинширээ | Бага Өлзийтийн монгол булш |
| 51 | Түвшинширээ | Дэлгэрхаан уулын дурсгалууд |
| 52 | Дарьганга | Сүмтийн туурь |
| 53 | Эрдэнэцагаан | Халтарын балгас |
| 54 | Онгон | Замын нуурын хадны бичээс |
| 55 | Наран | Сөдөтийн цагаан чулууны бичээс |
| 56 | Эрдэнэ цагаан | Егүзэр хутагтын хүрээ |

Хүснэгт. 3.4. *Зүүн бүсийн түүх соёлын дурсгал*

| | Түүх соёлын дурсгал | Тоо | Монгол улсын хэмжээнд эзлэх % |
|---|---|---|---|
| 1 | Чулуун зэвсгийн бууц, суурин, дархны газар | 5 | 26,3% |
| 2 | Хадны зураг | 3 | 4,1% |
| 3 | Буган хөшөө | 2 | 4,2% |
| 4 | Хүн чулуу | 12 | 17,1% |
| 5 | Булш, хиргисүүр, хөшөө чулуу | 18 | 32,1% |
| 6 | Эртний хотын туурь, хэрэм, балгас | 11 | 32,3% |
| 7 | Гэрэлт хөшөө, бичээс, бунхан, овоо | 6 | 9,5% |
| 8 | Сүм хийд, суврага | 4 | 10% |

Хүснэгт 3.4-өөс үзэхэд Монгол орны зүүн бүсэд хүн чулуу, булш, хиргисүүр, эртний хотын туурь, хэрэм, балгас, чулуун зэвсгийн үеийн бууц, суурин харьцангуй их байгаа нь тус бүс нь түүх соёлын дурсгалаараа баялаг болох нь харагдаж байна.



**Монгол орны зүүн бүсийн байгалийн үзэсгэлэнт газар, ан амьтны нөөц.** Дорнод аймгийн нийт нутгийн 4/5-ийг тэгш тал, гүвээ толгод бүхий тал хээр эзэлдэг ба зүүн өмнө хэсэгт Дорнод Монголын (Мэнэн, Тамсаг, Матад) өргөн уудам тэгш тал үргэлжилдэг. Мөн энд Монгол улсын хамгийн нам дор газар болох Хөх нуур (д.т.д 560) оршдог. Монгол улсын улаан номонд бүртгэгдсэн 40 гаруй зүйлийн эмийн ургамал, 10 орчим зүйлийн ашигт ургамалтай ба өөр улсад ургадаггүй, ховор, олон төрлийн ургамал энэ бүс нутагт ургадаг. Дорнод аймгийн тал хээрийн бүсэд төв Азийн цагаан зээрийн 70 гаруй хувь нь нутагладаг онцлогтой. Онон, Улз, Халх голын сав нутгуудад дэлхийн улаан номд орсон буга, хандгай, баавгай, гахай, ондатр, илбэнх, шилүүс, зэрэг 20 орчим зүйлийн ховор амьтан, 22 зүйлийн ховор шувуудаас гадна бүх нутгаар үнэг, хярс, чоно, дорго, мануул, бор гөрөөс, цагаан зээр, төрөл бүрийн махчин шувууд амьдардаг. Улз голын сав газар ба Азаргын голын адаг, Ташгай нуур орчимд гадаадын шувуу сонирхогчид, жуулчдын сонирхол татах, дэлхийд ховордсон цэн тогоруу, цагаан тогоруу, алаг тогоруу, хар тогоруу, реликт цахлай, хургач бор, цууцал, монгол бялзуухай зэрэг нийт 38 зүйлийн ховор жигүүртэн шувууд байдаг. Сүхбаатар аймгийн Дарьганга суманд 200 гаруй сөнөсөн галт уул, Онгон, Дарьганга суманд 127-248 хавтгай дөрвөлжин км талбай эзлэх Онгон, Молцогийн элс, Наран сумын нутагт Баяндулаан, Талын агуй, Мөнххаан сумын Баян-Уулын орчмын 70 гаруй агуй зэрэг олон агуй, Лог, Будар, Дэлгэрхаан, Харгилтай зэрэг нуруу хөндий олон байдгийн дээр чулуужсан яс зэрэг амьтан ургамлын үлдэгдэл Байшинт, Ходоодын говь, Хорголжингийн талаас олддог юм. Энд өмнө дурьдсан амьтдаас гадна Бүрэнцогтын хаданд аргаль, янгир нутагшиж байна. Хэнтий нь түүх соёл дурсгалын арвин их баялагтай аймаг юм. Энд Хэнтийн нурууны зүүн хэсэгт орших тайгын ландшафт бүхий байгалийн үзэсгэлэн бүрдсэн орчинтой бөгөөд Хангал нуур, Хар зүрхний хөх нуур, Онон-Балжийн байгалийн цогцолборт газар зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудтай.

**Зүүн бүсийн байгалийн хүчин зүйлүүдийн рекреацийн үнэлгээний үр дүн.** Рекреацийн үнэлгээний өвөл, зуны улирлын ялгаагаар үнэлэх (Веденин, Мирошниченко., 1969) аргыг ашиглан зүүн бүсийн Дорнод, Сүхбаатар аймгуудыг голчлон авч үзэж рекреацийн нөхцөл байдлын тааламжийн үнэлгээ хийлээ.

Хүснэгт. 3.5. *Зүүн бүсийн байгалийн хүчин зүйлүүдийн рекреацийн үнэлгээний үр дүн*

| Д | Үнэлгээний шалгуур | Нэн тохиромжтой /4 балл/ | | Тохиромжтой /3 балл/ | | Харьцангуй тохиромжтой /2 балл/ | | Тохиромж багатай /1 балл/ | | Тохиромжгүй /0 балл/ | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хүчин зүйлс | Өвөл | Зун | Өвөл | Зун | Өвөл | Зун | Өвөл | Зун | Өвөл | Зун |
| 1 | Агаарын температур (хоногийн тоо) | 90> | 120> | 60-90 | 90-120 | 30-60 | 60-90 | 10-30 | 30-60 | <10 | <30 |
| 2 | Нарны гийгүүлэлтийн үргэлжлэх хугацаа (цаг) | 600> | 1000> | 550-600 | 900-1000 | 500-550 | 800-900 | 450-500 | 700-800 | <450 | <700 |
| 3 | Цасан бүрхүүл тогтох хугацаа (хоног) | 120-150 | - | 90-120 | - | 60-90 | - | 30-60 | - | <30 | - |
| 4 | Цасан бүрхүүлийн зузаан (см) | 20> | - | 15-20 | - | 10-15 | - | 5-10 | - | <5 | - |
| 5 | Салхины хурд 6 м/с-ээс бага байх хоногийн тоо | 70> | | 70-50 | | 50-30 | | 30-10 | | <10 | |
| 6 | Усзүйн сүлжээний нягтшил (м/км2) | 250> | | 150-250 | | 50-150 | | 10-50 | | <10 | |
| 7 | Харьцангуй чийгшил (%) | 70> | | 60-70 | | 50-60 | | 40-50 | | <40 | |
| 8 | Хотгор гүдгэр | Дундаж ба өндөр уул | | Дундаж ба нам уул | | Нам уул, цав толгод | | Ухаа гүвээт тал, хөндий | | Хэрчигдэл ихтэй газар | |
| 9 | Ургамал нөмрөг | Шилмүүс ба навчит ой | | Сийрэг ой, ойн төгөл, нугат хээр | | Уулын хээр, голын татам | | Хуурай хээр, цөлийн хээр | | Цөл | |

Хүснэгт. 3.6. *Зүүн бүсийн зуны улирлын рекреацийн үнэлгээний үр дүн*

| Бүсийн нэр ба үнэлгээний шалгуур үзүүлэлт | Агаарын температур | Хоттор гүдгэр | Ургамал нөмрөг | Усзүйн сүлжээний нягтшил | Нарны гийгүүлэлтийн үргэлжлэх хугацаа | Харьцангуй чийгшил | Нэгдсэн үнэлгээ, балл | Дундаж үзүүлэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зүүн бүс | 3 | 1 | 1 | 2 | 3 | 2 | 12 | 2 |

Хүснэгт. 3.7. *Зүүн бүсийн өвлийн улирлын рекреацийн үнэлгээний үр дүн*

| Бүсийн нэр ба үнэлгээний шалгуур үзүүлэлт | Агаарын температур | Хоттор гүдгэр | Ургамал нөмрөг | Цасан бүрхүүлийн тогтох хугацаа | Цасан бүрхүүлийн зузаан | Нарны гийгүүлэлтийн үргэлжлэх хугацаа | Салхины горим | Нэгдсэн үнэлгээ, балл | Дундаж үзүүлэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зүүн бүс | 2 | 1 | 1 | 2 | 1 | 3 | 1 | 11 | 1,6 |

Зүүн бүсийн байгалийн хүчин зүйлүүдийн рекреацийн үнэлгээний дүн зуны улиралд 2 буюу харьцангуй тааламжтай, өвлийн улиралд 1,6 гарч байгаа нь тааламж багатай гэсэн үнэлгээтэй гарч байна. Энд хүний биеийн эрүүл мэндэд нөлөөлөх үзүүлэлтүүд харьцангуй сайн үнэлгээтэй байгаа бол амралт сувилал, жуулчлалыг хөгжүүлэх, зохион байгуулахад нөлөөлөх үзүүлэлтүүдийн үнэлгээ доогуур байна. Энэ үзүүлэлт нь хоёр аймгийг голчлон авч үзсэн учир ийм дүн гарч байгаа юм. Тийм учраас зүүн бүсийн амралт сувилал, жуулчлалыг хөгжүүлэх, зохион байгуулахад нөлөөлөх үзүүлэлтийг нарийвчилсан байдлаар хийх шаардлагатай юм.

**Зүүн бүсийн байгалийн нөхцөлийн аялал жуулчлалын тааламжийн үнэлгээний үр дүн:** Аялал жуулчлалын тааламжийн үнэлгээний шалгуурыг О.Сүхбаатар, Д.Даш, Н.Сарантуяа, нарын боловсруулсан аргачилалыг үндэслэн 0-4 оноогоор дүгнэж зүүн бүсийн байгалийн нөхцөлийн аялал жуулчлалын тааламжийн үнэлгээг хийлээ.

Хүснэгт. 3.8. *Монгол орны зүүн бүсийн байгалийн нөхцөлийн аялал жуулчлалын тааламжийн үнэлгээний үр дүн*

| Оноо | Үзүүлэлт | 4 | 3 | 2 | 1 | 0 |
|---|---|---|---|---|---|---|
| A1 | Дундаж температур нь $10^0$С-аас давах хоног | | | 110 | | |
| A2 | Жилд нар гийгүүлэх хугацаа (цаг) | | | 2800-3000 | | |
| A3 | Цэлмэг өдрийн тоо /нийт үүлшилтийн олон жилийн дунджаар/ | | 80-100 | | | |
| A4 | 7 сарын харьцангуй чийг (%) | | 50 | | | |
| A5 | $30^0$С-аас давж халах өдрийн тоо | | 5,7-17 | | | |
| A6 | Хүйтрэлгүй үргэлжлэх хугацаа (хоног) | | 130 | | | |
| A7 | $-30^0$С-аас бууж хүйтрэх өдрийн тоо | 20-30 | | | | |
| A8 | Хүчтэй салхитай өдрийн тоо | 10 | | | | |
| A9 | Цастай байх өдрийн тоо | | 90 | | | |
| A10 | Цасны зузаан (см) | | 10 | | | |
| A11 | Тунадасны хэмжээ (мм) | | 188-391 | | | |
| A12 | Голын сүлжээний нягтшил( км/км$^2$) | | | 0.03 | | |
| A13 | Зуны улиралд гадаргын усны дулаан | Бүлээн | | | | |
| A14 | Замын элс, шавар, намаг усны бартаа | | Бага зэрэг | | | |
| A15 | Газрын гадаргын хотгор гүдгэрийн байдал | Нам уул, тал хосолсон | | | | |
| A16 | Нэн ховор ургамлын зүйл | Их олон | | | | |
| A17 | Нэн ховор, ховор амьтны зүйл | Их олон | | | | |
| A18 | Олон улсын хэмжээний хамгаалалттай газар | | Олон | | | |
| A19 | Улсын тусгай хамгаалалттай газар | Их олон | | | | |
| A20 | Улсын хамгаалалттай түүх, соёлын дурсгал | Их олон | | | | |

Тухайн газар дахь тааламжийн үнэлгээг олох томъёо:

$$K=\frac{\sum A_n}{n}$$ (*Тэгшитгэл 3.1.*)

K-байгалийн нөхцлийн тааламжийн итгэлцүүр

n-үзүүлэлтүүд

$\sum A_n$ -үзүүлэлтүүдийн онооны нийлбэр

$$K=\frac{(4*8)+(3*9)+(2*3)}{20}=3.25$$ (*Тэгшитгэл 3.2*)

Тааламжийн итгэлцүүрийн үнэлгээ **3,25** байгаа нь зүүн бүсийн байгалийн нөхцөл, нөөц нь аялал жуулчлалын үйл ажиллагаанд тааламжтай гэдэг нь харагдаж байна. Аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэхэд аялан жуулчлах газрын тав тух, байгалийн болон аялал жуулчлалын нөхцөл, нөөц зэрэг нь чухал үүрэг гүйцэтгэдэг учир дээрхи үнэлгээг хийлээ.

**Монгол орны зүүн бүсэд аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж, нөхцөл байдлын шинжилгээ:** Монгол орны зүүн бүсийн аялал жуулчлалын өнөөгийн нөхцөл байдал болон бүсийн нутаг дэвсгэрт хийсэн судалгааны баримт мэдээлэлд тулгуурлан SWOT шинжилгээний аргаар аялал жуулчлалыг хөгжүүлэх давуу болон сул тал, боломж болон эрсдэлийг авч үзлээ.



Хүснэгт. 3.9. *Монгол орны зүүн бүсэд аялал жуулчлалыг хөгжүүлэх нөхцөл байдлын шинжилгээ*

| Давуу тал | Сул тал |
|---|---|
| -Эзэн Чингисийн өлгий нутаг, түүх дурсгалын үнэт өв соёлоороо онцлогтой.<br>-Дэлхийн шим мандлын нөөц газрын сүлжээнд хамрагдсан Монгол Дагуурын тал тус бүс нутагт оршдог.<br>-Цэлмэг өдрийн тоо олон тул шөнийн оддыг ажиглах.<br>-Өргөн уудам тал нутаг, харьцангуй унаган төрхөөр нь хадгалж үлдсэн байгальтай.<br>-Монголд төдийгүй дэлхийд ховордсон ховор амьтан, ургамал, шувуудтай учир шувуу ажиглах, амьтан ажиглах, цэцэг ажиглах аяллыг зохион байгуулж хөгжүүлэх.<br>-Нүүдлийн соёл иргэншил, ахуйг өнөө хүртэл хадгалсан ард түмэн, ястны уламжлал зан заншил бүхий нутаг. | -Дэд бүтэц, зам тээврийн сүлжээ бусад бүс, аймгуудыг бодвол харьцангуй хөгжиж байгаа хэдий ч аялал жуулчлалын үйл ажиллагаанд хараахан шаардлага хангаж чадахгүй байгаа.<br>-Гадаргын усны нөөц ихээхэн дутмаг, хуурайшилт ихтэй, хөрсөн бүрхэвч нь элэгдэл, эвдрэлд амархан өртөмтгий зэрэг экологийн эмзэг орчинтой. |
| **Боломж** | **Эрсдэл** |
| -Байгаль орчинд эвсэг аяллыг нутгийн иргэдэд түшиглэн зохион байгуулж, тэднийг ажлын байр, орлогын эх үүсвэртэй болоход нь дэмжлэг үзүүлэх<br>-Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх<br>-Бүсийн нийт нутаг дэвсгэрийн 9,8 гаруй хувь нь ТХГН-ын сүлжээнд хамрагдсан учир ТХГН дахь эко аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой<br>-Монгол улсын «Эрчим хүчний нэгдсэн сүлжээ» хөтөлбөрт тусгагдсаны дагуу зүүн бүсийн аймгуудыг төвийн бүстэй эрчим хүчний нэгдсэн сүлжээгээр холбосноор аялал жуулчлал болон бусад үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд түлхэц болох юм<br>-Эко аялал жуулчлалыг хөгжүүлэх | -Сул менежмент, хэт ачааллаас хамгаалалттай бүс нутаг, байгалийн нөөц, үзмэрүүд өртөж, сүйдэх<br>-Эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай тул байгалийн ямар нэгэн гэнэтийн үзэгдэлд өртөх магадлал өндөр<br>-Аялал жуулчлалын үзмэрүүдэд хадгалалт хамгаалалт дутагдан элэгдэж муудан ач холбогдол нь буурах<br>-Уул уурхайн олборлолт нь байгалийн унаган төрх байдал, экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулах |

Дээрхи SWOT шинжилгээнд үндэслэн давуу талыг ашиглан боломжоо нэмэгдүүлэх, сул талыг багасгах арга замыг тодорхойлон эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэхэд ач холбогдолтой.

Зүүн бүсийн хувьд аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжуудыг амжилтын магадлалаар нь, эрсдэл буюу аюулыг тохиолдох магадлалаар нь зэрэглэн авч үзвэл:



Хүснэгт. 3.10. *Таатай боломжуудын үнэлгээ буюу боломжийн матриц*

| | | Амжилтын боломж | |
|---|---|---|---|
| | | Их | Бага |
| Анхаарал татах байдал | Их | 1, 4, 5 | |
| | Бага | 2, 3 | |

Хүснэгт. 3.11. *Аюулын зэрэглэл буюу аюулын матриц*

| | | Гарч болзошгүй магадлал | |
|---|---|---|---|
| | | Их | Бага |
| Ноцтой байдал | Их | 1,2,3 | 4 |
| | Бага | | |

## III.2. ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН БИЙ БОЛГОХ АЛХАМУУД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖИШЭЭ

***Аялал жуулчлалын бүтээгдэхүүн:*** Үүнд жуулчдад үзүүлэх үзмэрүүд, тээврийн хэрэгсэл, байршуулах хэрэгсэл, зугаа цэнгэл гэх мэтийг багтаасан цогц үйлчилгээ багтана.

Аялал жуулчлалын бүтээгдэхүүн = Бүтээгдэхүүний хүрээ + Бүтээгдэхүүний төрөл

Бүтээгдэхүүний хүрээ гэдэг нь ижил зах зээлээс ижил ашгийг санал болгодог хоорондоо нарийн холбоо хамаарал бүхий багц бүтээгдэхүүнийг хэлнэ. Жишээлбэл: соёлын бүтээгдэхүүн – музей, хөшөө дурсгал, ХБО-ы бүтээгдэхүүн явган аялал, загасчилах, зугаа цэнгээний бүтээгдэхүүн – казино, шөнийн цэнгээний газрууд гэх мэт. Бүтээгдэхүүний төрөл гэдэг нь янз бүрийн зах зээлд нэвтрүүлж болох, харилцан адилгүй үнэ өртөгтэй, өөрийн гэсэн онцлог шинж чанартай аялалын багцыг хэлнэ.

**Эко аялал жуулчлалын бүтээгдэхүүн.** Аялал жуулчлалын мэргэжлийн байгууллагаар дамжуулан зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагаа, нөөц бололцоо, үйлчилгээний нэгдэл юм. Эко аялалын бүтээгдэхүүний үндсэн бүрэлдэхүүнийг дараах байдлаар жагсааж болно (Хүснэгт 3.12).

Хүснэгт 3.12. *Эко аялал жуулчлалын бүтээгдэхүүний багц*

| |
|---|
| Сайтар боловсрогдсон, бодитоор хэрэгжсэн, хяналттай байнгын маршрут, экологийн жим |
| Олон хэлбэрийн боловсролын болон зөвлөгөө өгөх үйлчилгээ |
| Спортын, адал явдалт, хөдөөгийн, эрүүлжүүлэх аяллын байгууллагууд |
| Экологийн болон экологи - соёлын тусгай аяллууд |
| Тойрон аялал, тусгай хамгаалалттай газар нутаг дахь тойрон аялал |
| Тусгай зориулалттай арга хэмжээнүүд (үзэсгэлэн, дуудлага худалдаа, фестиваль, конкурс) |
| Хяналттай бэлтгэсэн байгалийн бүтээгдэхүүн |
| Орон нутгийн экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний худалдаа |
| Эко орон байр, байгаль орчинд сөрөг нөлөө багатай тээврийн хэрэгслүүд |
| Аялалын тоноглол хэрэгсэл, түрээслэх үйлчилгээ |
| Бэлэг дурсгалын зүйлсийн үйлдвэрлэл болон худалдаа |
| Орон нутгийн экологийн символ бүхий тэмдэгийн худалдаа, реклам сурталчилгааны материалууд |
| Тусгай аудио, видео, фото болон кино материал, бүтээгдэхүүн боловсруулалт, худалдаа зэрэг орно |

Өөрөөр хэлбэл эко аялал жуулчлалын бүтээгдэхүүн нь түүнийг бий болгоход шаардлагатай бүхий л зүйлс, үйл явц, нөөцийг багтаасан аяллын үйлчилгээ ба хөтөлбөрийн иж бүрдэл юм. Эко аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хэрхэн бүрдүүлэх талаар тодорхой жишээн дээр тайлбарлая.

### Жишээ.10: Алтай Соёны эко бүс нутагт эко аялал жуулчлалыг хөгжүүлэх таатай нөхцөл, түүнд хүрэх алхамууд[1]

**1. Эко аялал жуулчлалын нөөцийг хөгжүүлэх боломж:**

**а. Байгалийн нөөц.**

- Эко бүс нутаг дахь тусгай хамгаалалттай газруудын зөвшөөрөгдөх менежментийн бүсүүдэд аялал зохион байгуулах
- Эко аялал жуулчлалаар дамжуулан байгаль хамгаалах ухамсарт үйл ажиллагаанд нутгийн иргэд, орон нутгийн байгууллага, гадаад дотоодын жуулчид, аялал жуулчлалын байгууллагуудын

1 *ХИС-ийн «Аялал жуулчлал судлал»-ын судалгааны багийн материалаас*

хамтын оролцоог бий болгох

- Эко бүс нутгийн нэн ховор ургамал амьтдыг аяллын сонирхол татах үзмэр болгон ашиглах, тухайлбал: Алтайн ууланд цоохор ирвэс, аргаль, бөхөнг хамгаалах, ажиглах аялал зохион байгуулах.
- Түүх соёлын дурсгалт газруудын судалгаа шинжилгээ, арчилгааг сайжруулах.



**b. Эко аяллын хөтөлбөр, маршрут**

- Байгаль орчинд сөрөг нөлөө багатай эко технологийн тээврийн хэрэгсэл ашиглах, (морин тэрэг, сарлагтай тэрэг, үхэр тэргээр аялах, тэмээ унах, ууланд мориор аялах)
- Экологид ээлтэй байршуулах хэрэгсэл, эко бааз, эко лоож байгуулах. Байршуулах хэрэгслийн барилгын архитектурт нутгийн уламжлалт хэв маягийг тусгах. Монгол гэр нь хөрсийг гэмтээдэггүй ургамалд үзүүлэх сөрөг нөлөө багатай, нүүдэллэн сэлгэж барих боломжтой учир үндэсний хэв маяг онцлогийг илэрхийлсэн гэрүүдэд жуулчдыг байршуулах боломжтой юм. Түүнчлэн уламжлалт гэрийг жуулчин байршуулахад зориулж тохижуулах, уламжлалт хэв маяг болоод орчин үеийн шийдлийг нэгтгэж тав тухтай орчинг бүрдүүлэх. Интерьер дотоод зохион байгуулалтын засал чимэглэлд натурал, байгалийн гаралтай зүйлсийг ашиглах (чулуун шигтгэмэл мозаик, цэцэгсийн хатаамал цуглуулга, эсгий ноосоор хийсэн гар урлалын бүтээгдэхүүн)
- Жуулчны баазуудын байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг хамгийн бага байлгах: -Эко баазын шаардлага хангахуйц тоног төхөөрөмж ашиглах, эко аяллын нөөц (ТХГН, түүх соёлын дурсгалт газар, ховор амьтан, ургамал, цэцэг, шувуу ... гэх мэт) бүхий газар эко жуулчны бааз байгуулах.

- Жуулчны баазын үйлчилгээний ажилтанг орон нутгаас сонгон шалгаруулан авч сургаж ажиллуулах
- Жуулчны баазыг байгуулахдаа дараах зүйлсийг анхаарах:
    - Баазын нийт талбайг хамгийн тохиромжтойгоор шийдвэрлэх
    - Орчиндоо бага нөлөөлөхөөр газрыг сонгох
    - Ургамал араатан жигүүртний чухал төрөл зүйлд

ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй байх
- Орон нутгийнхний чухал газрыг сонгохгүй зөрчилдөхгүй байх
- Төвлөрсөн хог хаягдал, бохирдсон зүйлийг ариутгах цэг хүргэх бололцоо
- Хөрсний элэгдэл
- Гүний усны нөөц
- Гол мөрний усыг ашиглах боломж
- Нийтийн цахилгаан хангамж болон байгалийн эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах, бололцоо
- Хог хаягдлыг экотехнологийн дагуу устгадаг байх
- Экологийн гаралтай хүнсний бүтээгдэхүүн хэрэглэх. Жуулчдын хоол ундыг бэлтгэх хүнсний зүйлсийг тухайн орон нутгаас худалдан авах, ихэвчлэн орон нутгийн гаралтай хүнсийг авч хэрэглэх (сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногоо, жимс жимсгэнэ гэх мэт)
- Экологич, мэргэшсэн хөтөч, мэдээллийн материалууд:

- Байгаль орчныг хамгаалах, шинжилгээ судалгааны экологич бэлтгэх.
- Нутгийн иргэдээс хөтөч бэлдэх, байгаль орчин, түүх соёл, ард түмний язгуур урлаг, зан заншлын талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулах, жуулчид, нутгийн иргэдийн хооронд харилцааг зохицуулах, хөтчийн ёс зүйд сургах.
- Аялал жуулчлалын үйлчилгээнд нутгийн иргэд, ялангуяа эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг зохион байгуулах сургалт явуулж, бусад орон нутгийн иргэд, сургуулийн сурагчид дотоодын аялагчдад зориулсан аяллын хөтөлбөрийг бие даан зохион байгуулах, аялал удирдан зохион байгуулах боломжийг олгох замаар нутгийн иргэдийн аялал жуулчлалаас олох орлогыг нэмэгдүүлэх.
- Аялал эхлэхээс өмнө жуулчдад байгаль орчин экологийн мэдээлэл өгөх, уугуул нутгийн түүх соёл уламжлалд хүндэтгэлтэй хандах, аяллын явцад анхаарах зөвлөмжүүдийг боловсруулан товхимол болгон тараах.

**c. Аяллыг явуулах нөхцлүүд**

- Экологийн болон аюулгүй байдлын зөвшөөрөгдөх хэм хэмжээнд нийцэхүйц байгалийн аюул багатай бохирдолтгүй газраар жуулчдыг аялуулах
- Аяллын зорих газар нь хүрч очих боломжтой,

жуулчдад сэтгэл ханамж үлдээх, сонирхол татахуйц байх

- Рекреацийн ачаалал, аялал жуулчлалын даацыг тооцож, тухайн бүс нутгийг зорих жуулчдын хэмжээг нэмэгдүүлэх бус зохистой түвшинд барих.
- Ус, эрчим хүчний нөөцийн хэрэглээг боломжит түвшинд байлгах
- Аяллын төрөл хэлбэр нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй байхаар зохион байгуулах. Аяллын хугацааг жуулчдын сэтгэл зүйн онцлог, байгалийн нөхцөл байдалд тохируулан төлөвлөх

## 2. Эко аялал жуулчлалын аяллын төрөл, бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх боломж

Алтай Соёны эко бүс нутагт хөгжүүлж болох дараах аяллын төрөл бүтээгдэхүүн үйлчилгээ байж болно (Хүснэгт 3.13).

Хүснэгт 3.13. *"Алтай Соёны эко бүс нутагт хөгжүүлж болох аяллын төрөл"*

| | Эко аяллын төрөл | Хөгжүүлж болох нөөц боломж |
|---|---|---|
| 1 | Амьтан ажиглах аялал | Алтай Соёны эко бүс нутаг нь Төв Азийн болон Сибирийн амьтны аймгийн мужийн уулзвар дээр оршдог бөгөөд энд говь цөлөөс авахуулаад уулын тундрыг хүртэл маш баялаг амьтны аймагтай. Энд хүрэн баавгай, зээх, шилүүс, булга, жирх, буга, зээр, хар сүүлт, хулан, гөрөөс,чоно элбэг бөгөөд бүс нутгийн бэлэг тэмдэг болсон дэлхийд нэн ховор амьтад болох цасны ирвэс, бөхөн, аргаль зэрэг нэн ховор амьтад, нь энэ төрлийн аяллыг хөгжүүлэх нөөц боломж болно. |
| 2 | Шувуу ажиглах аялал | Их нууруудын хотгорын цөл талын нуурууд, намагнууд нь устаж буй олон шувуудын гэр болдог. Түүний дотор ховор цасан цагаан ЕвроАзийн цахлай зун энд ирж нутагладаг байна. Дэлхийн тогорууны төрөл зүйлүүдийн 15 төрөл зүйл нь энд амьдардаг байна. Энд сойр, хөх ногтруу, эр хур, харцага, шар шувуу, сэгсгэр хөлт бүгээхэй, гурван хуруут тоншуул, хөөндэй зэрэг 300 – аад төрөл зүйлийн шувуу байдаг. Мөн энэ бүс нутаг нь Ус намгархаг газрыг хамгаалах Рамсарын конвенцид орсон Увс нуур, Ачит нуур, Хар Ус нуур байдаг нь нуурын эрэг дээр шувуу ажиглах боломжтой болохыг харуулж байна. |

| | | |
|---|---|---|
| 3 | Цэцэг ажиглах аялал | Алтай болон бүс нутгийн хойт хэсгийн ихэнх уулсын систем нь уулын хээр, уулын тайга мөн өндөр уулын бүслүүртэй. Алтай нь 974 ургамлын төрөл зүйлтэй бөгөөд 60 нь эндемик. Энд ихэвчлэн 3000 м – ээс өндөрт уулын таг чийглэг асганд хосоороо ургадаг, монголын улаан номонд орсон вансэмбэрүү цэцэг, үхэшгүй мөнхийн цагаан уул цэцэг болон цагаан цээнэ, даль, сибир хундгана, саадганцэцэг, бөлбөө цэцэг, зүрхэн цэцэг, алтан гагнуур, алтайн жамьянмядаг, шар хөх яргуй, хонхон цэцэг, холтсон цэцэг, ургадаг бөгөөд байгалийн ландшафт дээр тулгуурлан цэцгийн хүрээлэн байгуулах боломжтой юм. |
| 4 | Эрдэм шинжилгээний аялал | Түүхчид археологчид энэ бүс нутгийг хүн төрөлхтний соёл иргэншлийн өлгий нутаг хэмээн нэрлэдэг. Олон зууны туршид энд эртний түрэг, уйгар, финчүүд, ираны олон соёл хутгалдан орших мөн харилцан бие биендээ уусч байжээ.Увс нуурын ай сав нь Хүнну, Түрэг зэрэг овог аймгуудын уугуул нутаг болдог бөгөөд 4000 гаруй археологийн дурсгалыг агуулдаг |
| 5 | Түүх соёлын аялал | Бүс нутаг нь эртний түүх соёлын хосгүй уламжлалтай өвөрмөц нутаг. Эко бүсийн хэмжээнд 17 буган хөшөө, 23 хүн чулуу, 26 хадны зураг, 3 булш хиргэсүүр, 2 хотын туйр, 12 гэрэлт хөшөө бичээс, 1 сүм хийд бүхий түүх соёлын дурсгалт зүйлс байна. |
| 6 | Нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлал | Эко бүс нутагт уламжилсан амьдралын хэв маяг, байгалийн баялгийг олж хэрэглэх заншлаа хадгалсаар байгаа Казак, цаатан зэрэг ард түмэн, уламжлалт нүүдлийн мал аж ахуй эрхлэн амьдардаг уугуул нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой. |
| 7 | Уулын аялал | Эко бүс нутагт Монгол Алтайн нуруу, Алтай Таван Богд, Тагнын нуруу, Хархираа 4037 Түргэний уулс 3965м , Цагаан шувуут 3496м Хорьдол Сарьдагийн нуруу, Улаан тайга зэрэг 3000 – 4000 м – ийн өндөртэй уул нуруud байх ба энд уулын аялал хөгжүүлэх боломжтой. |
| 8 | Усан аялал | Монгол орны хамгийн том нуур болох Увс нуур, хамгийн гүн Хөвсгөл нуур, томоохон нуурууд болох Үүрэг, Хяргас, Хар Ус нуур, Ачит нууруудад усан аялал хөгжүүлэх боломжтой. |
| 9 | Тусгай хамгаалалттай газар нутаг дахь тойрон аялал | Эко бүс нутгийн хэмжээнд ДЦГ -4, БЦГ – 7, БНГ – 5, ДГ – 1 байгаа бөгөөд Дэлхийн өвд бүртгэгдсэн Увс нуурын ай сав нь Увс нуур, Алтан элс, Түргэний уулс, Цагаан шувуутаас бүрд эхэлсэн, манхан говь нутгаас хээр тал, уулын хээр, ой мод, тагийн бүс, мөнх цаст оргил зэрэг 5 бүсийг хамарсан байдаг нь тусгай хамгаалалттай газар нутгийг тойрон аялах боломжийг олгоно. |

## 3. Алтай Соёны эко бүс нутгийн эко аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх боломж.

- Жуулчны мэдээллийн төв байгуулж, экологи байгаль орчны мэдлэгийг жуулчид болоод нутгийн иргэдэд түгээх, жуулчдыг сонирхсон мэдээллээр хангах, эко бүс нутгийг сурталчлах болон ховор амьтан ургамал, биологийн төрөл зүйл, байгаль



хамгааллын талаар боловсрол олгох. Үүргэвчтэй аялагчдад зориулсан аяллын тоноглол хэрэгсэл, байршуулах хэрэгсэл болон тээврийн хэрэгсэл, аяллын явцад анхаарах зөвлөмж зэргийг өгөх

- Ардын гар урлалын бүтээгдэхүүн, бэлэг дурсгалын зүйлс (эсгий урлал, дархан, сийлбэр, сүрлэн наамал, зээгт наамал, керамик ваар шавран урлаг, үндэсний хувцас, ноос ноолууран хувцас, уран хатгамал, оньсон тоглоом) – ээр үзэсгэлэн гаргах, жуулчдад худалдаалах.
- Үндэсний чанартай фестиваль, соёлын арга хэмжээ зохион байгуулах. (Монгол Туургатны Олон Улсын Монгол Хувцасны Фестиваль, Цаатан фестиваль, мөсний баяр, Бүргэдийн баяр, Ардын язгуур урлагийн тоглолт, Алтайн магтаал, бие биелгээ, хөөмий, тууль хайлах)
- Эко бүс нутгийн байгалийн өвөрмөц тогтоц, биологийн төрөл зүйл, ургамал амьтны ертөнц, цаатан ард иргэд, нүүдэлчдийн амьдралын хэв маяг онцлогийг видео, фото, марк, ил захидал дээр буулгах, богино хэмжээний кино хийж бүс нутгийг сурталчилж жуулчдыг татах, тэдэнд аяллын дурсамж үлдээх.

## III.3. ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ

**Эко аялал жуулчлалын менежментийн төлөвлөлт.** Эко аялал жуулчлалын менежментийг газар нутгийн менежмент болон жуулчны менежмент гэж ангилна. Газар нутгийн менежмент нь жуулчдын үйлчлүүлж буй газар, дэд бүтцийг зохицуулахад оршино. Жишээ нь: жуулчны бааз, зам тээвэр харилцаа гэх мэт. Жуулчны менежмент нь жуулчдын тоо хэмжээ, цаг хугацааг зохицуулж байдаг. Эко аялал жуулчлалын менежмент нь чиглүүлэгч бүхий хууль дүрэм, итгэмжлэл болоод бодит эерэг дадлага туршлага зэргийг багтааж байдаг[2].

*2 David A. Fennel, Ross K. Dowling «Ecotourism policy and planning*




Зураг 3.2. *Эко аялал жуулчлалын менежментийг төлөвлөх үйл явц*

Менежментийн ерөнхий төлөвлөлт нь аялал жуулчлалын зорилгын боломжит газар нутгийг тогтоон түүнийг бүсчлэх үйл явцаар мөн тодорхойлогдоно. Эко аялал жуулчлалын менежментийн төлөвлөлтийг алхам алхамаар бэлтгэнэ (Зураг 3.2). Энэ нь шугаман үе шат бүхий үйл явц байдаг бөгөөд төлөвлөлтийг боловсруулагчид зарим үед нэг эсвэл түүнээс ч их алхамаар ухрах тохиолдол байдаг. Жишээ нь, төлөвлөлтийн баг Мэдээллийн дүн шинжилгээ хийх шатанд ирээд Мэдээлэл цуглуулах хэсэгт чухал гэсэн мэдээллүүдийг оруулаагүй тохиолдолд буцах хэрэгтэй болдог.

Менежментийн төлөвлөлтийг эхнээс нь эцэс хүртэл хэдий хэр хэмжээ зарцуулах вэ? Төлөвлөлтийн үйл явцын үргэлжлэх хугацаа нь дараах хэд хэдэн нөхцлөөс хамаарна

- **Санхүүжилтийн хэмжээ ба бодит боломж.** Хэрэв санхүүжилт төлөвлөлтийн эхний үе шатаас л хангалттай сайн байвал эко аялал жуулчлалын менежментийн төлөвлөлтийг илүү хялбарчилж өгнө.
- **Тусгай хамгаалалтын нутаг дэвсгэрийг ашиглаж буй аялал жуулчлал, олон нийтийн бүрдэл.** Хэрэв олон тооны жуулчид, тур операторууд мөн жуулчдын зорин ирж буй олон газрууд байвал төлөвлөлтөнд их хэмжээний мэдээ мэдээлэл цуглуулах шаардлагатай болно. Хэдий чинээ бодит, чанартай мэдээлэл байна төлөвлөлтийг хийхэд төдий чинээ хялбар байна.






Зураг 3.3. *Төлөвлөлтийн үйл явцад оролцогч талууд*

- **Төлөвлөлтийн багийн хүчин чармайлт.** Төлөвлөлтийн багийн гишүүд бүр үүрэг хариуцлагаа сайн ухамсарлаж чадвал эко аялал жуулчлалын менежментийн төлөвлөлт нь урт хугацааны турш амжилттай үргэлжлэх хандлагатай байдаг.
- **Төлөвлөлтийн баг бусад (хувьцаа эзэмшигч) байгууллагуудаас дэмжлэг туслалцаа авах.** Орон нутгийн зүгээс, тур операторууд болоод бусад оролцогч талуудын дэмжлэгийн тусламжтайгаар төлөвлөлтийн үйл явц үр бүтээлтэй болдог. (Зураг 3.2)
- **Төлөвлөлтөнд нарийн тодорхой зүйлсийг шаарддаг.** Төлөвлөлт нь тухайн үеийн бодит нарийн тодорхой мэдээ мэдээллийг шаарддаг.




Зураг 3.4. *Эко аялал жуулчлалын менежментийн болон хөгжил төлөвлөлтийн үйл явцын ерөнхий тойм*

**Хамгаалалтай газрын менежмент** гэдэг нь тухайн газрын нөөцийг зөв зохистой зохион байгуулна гэсэн үг юм. Менежментийн бүсүүдийг тухайн газрын байгалийн болон соёлын үнэ цэнэ, тодорхой эмзэг газрууд, тухайн газрын ачаал -лыг тооцож гаргана. Менежментийн бүсүүдийг тогтоосноор тухайн газрын бүсүүдэд тохирсон менежментүүдийг тус тусад нь хэрэгжүүлэх, тухайн бүсүүдийн онцлогийг илүү харуулж өгөх, нөөцийг зөв зохицуулах боломж олгоно. Хамгаалалттай газрууд нь дараах дөрвөн бүсэд хуваагдаж болно (Хүснэгт 3.14).

Хүснэгт 3.14. *Хамгаалалттай газрын менежментийн бүс*

| | |
|---|---|
| Хатуу хамгаалалтай бүс (strict protection zones) | • Энэ бүсэд жуулчдыг огт оруулдаггүй. |
| Зэрлэг онгон байгалийн бүс (wilderness zones "restricted use" zones - хязгаарлалтын бүс) | • Энэ төрлийн бүсүүдэд жуулчид зөвхөн явган аялах боломжтой байдаг. |

| | |
|---|---|
| Аялал жуучлалын бүс (moderate tourism use zones | • Тухайн паркийн байгаль хүрээлэн буй орчин соёлд сөрөг нөлөө багатайгаар жуулчдад зориулсан үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг<br>• Ийм бүсүүдэд аялал жуулчлал хязгаарлагдмал байгальд бага нөлөө үзүүлдэг бөгөөд тухайн хамгаалалтай газрын нөөцийн бүх хэсгээс байх хэрэгтэй.<br>• Байгалийн гоо үзэмжийг жуулчдад харах боломж олгох, өвөрмөц соёлтой ард иргэдийн амьдрал ахуй, зан үйлтэй танилцуулах, тухайн паркад байгаа байгалийн болон түүх соёлын нөөцүүдээс дээж болгон үзүүлэх |
| Хөгжүүлэлтийн бүс | • Тухайн паркийн байгууламжууд байрлах хязгаарлагдмал газар (жуулчдад зориулсан барилга байгууламжууд, паркийн менежментийн болон бусад ажилчдад болон судалгаа шинжилгээнд зориулсан барилга гэх мэт). |

## Жишээ.11: Монгол орны зүүн бүсэд аялал жуулчлалыг тогтвортойгоор хөгжүүлэх стратеги, менежментийн хувилбар

Энэхүү хувилбарыг Аялал жуулчлалын тогтвортой хөгжилд баримтлах зарчим (2008), Байршуулах үйлчилгээний бизнесийг тогтвортой хөгжүүлэхэд баримтлах зөвлөмжүүд (АЖТХ., 2009), Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний үйлдвэрлэл, нийлүүлэлт дэхь үр өгөөжийн хамаарал (АЖТХ., 2009) зэрэг баримт болон зүүн бүсийн аялал жуулчлалын өнөөгийн байдалд тулгуурлан боловсруулсан болно.

### Үндэслэл шаардлага

Монгол улсад аялал жуулчлал нэрийдлээр байгаль орчныг бохирдуулж, экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулж, орон нутгийн иргэдэд аялал жуулчлалаас орж буй орлогын хэмжээ тун бага байна. Тийм учраас аялал жуулчлалыг тогтвортойгоор хөгжүүлэх болон шинэ аялал жуулчлалын төрөл хэлбэрүүдийг хөгжүүлэх шаардлага нэн тэргүүнд тавигдах асуудлын нэг болоод байна. Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Мянганы хөгжлийн зорилтод аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгоно гэж заасан билээ.

### Аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөц, боломж

Монгол орны зүүн бүсэд байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан газар нутаг, дэлхийд ховордсон ан амьтан, жигүүртэн шувууд, ургамал байдаг учраас тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх эх үүсвэр болж байгаа юм. Жишээ нь Дэлхийн Байгаль Хамгаалах Сан /WWF/-аас дэлхий нийтийн хэмжээнд зайлшгүй хамгаалах шаардлагатай 200 орчим эко

бүс нутгийг тогтоогоод байгаа бөгөөд, манай улсад бий 2 эко бүсийн нэг нь Монгол Дагуурын хээр тал /Дорнод/ учраас энд аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөц боломж байна. Мөн Монгол улсын нутаг дэвсгэрийн 14,4%-ийг эзлэх 65 тусгай хамгаалалттай газар нутаг байдаг бөгөөд үүнээс 13 буюу 20% нь энэ бүсэд байна.

**Аялал жуулчлалыг тогтвортойгоор хөгжүүлэх зорилго**

Монгол улсын аялал жуулчлалын салбарт тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэн, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилготой.

**Аялал жуулчлалыг тогтвортойгоор хөгжүүлэх стратегийн зорилт**

- Аялал жуулчлалаас байгальд нөлөөлөх нөлөөллийг хамгийн бага байлгах арга замыг олох
- Аялал жуулчлалын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт дэхь үр өгөөжийг нэмэгдүүлэх
- Тогтвортой аялал жуулчлалыг олон нийтэд таниулах, сурталчилах

**Хэрэгжүүлэх арга хэмжээ буюу баримтлах стратеги**

Хүснэгт. 3.15. *Хэрэгжүүлэх арга хэмжээ буюу баримтлах стратеги*

| Аялал жуулчлалаас байгальд нөлөөлөх нөлөөллийг хамгийн бага байлгах арга замыг олох чиглэлээр: | |
|---|---|
| Стандартад нийцсэн барилга байгууламж, жуулчны бааз байгуулах | Жуулчны баазын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага MNS 4934:2002 |
| Жуулчны баазын ус ашиглалт, хог хаягдлыг зөв зохистой ашиглах, устгалд оруулах | Ус хэмнэх, зохисгүй хэрэглээг багасгахын тулд:<br>• Зуны улиралд үйлчлүүлэгчдэд хувцсаа хүйтэн болон нарны илчээр бүлээсгэсэн усаар угаах сонголтыг бий болгох, гадна хатаах боломжийг бүрдүүлэх.<br>• Угаалгын машины сэгсрэгч хатаагчаас гарсан хэт бохир бус хаягдал усыг гадна орчны талбай, машин цэвэрлэхэд дахин ашиглах.<br>• Усыг хэмнэх технологид суурилсан сантехникийн тоног төхөөрөмж сонгох.<br>• Ажилчид болон жуулчдад усны зохистой хэрэглээний талаарх санамжийг байрлуулах.<br>• Борооны ус тосон цуглуулах систем байрлуулах.<br>Хог хаягдлын менежментийг оновчтойгоор хэрэгжүүлэх:<br>• Гялгар уут болон тийм уутанд савлагдсан бүтээгдэхүүний хэрэглээг аль болох хязгаарлах.<br>• Үйлчилгээний явцад гарах хог хаягдлыг ангилах, тусгайлан ялгасан хогийн савуудыг байрлуулах, органик хаягдлыг ашиглах, бордоо хийх аргуудыг нэвтрүүлэх, дахин боловсруулагдах хаягдлыг бүрэн ашиглах, бусад хаягдлыг төвлөрсөн цэгт хүргэн устгуулах. |

| | |
|---|---|
| Жуулчны баазын гэрэл цахилгааныг сэргээгдэх эрчим хүчээр хангах | Салхин сэнс болон нарны эрчим хүчний хураагуур ашиглан гэрэл цахилгаанаар хангах. |
| Одоо байгаа жуулчны баазуудыг байгаль орчинд ээлтэй техник технологийн хэрэглээг зээл, татварын бодлогоор дамжуулан хэрэгжүүлэх | |
| Эко-тээврийн хэрэгслийг аялалд ашиглах | Цахилгаан эрчим хүчээр ажилладаг автомашиныг ашиглах. |

| Аялал жуулчлалын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт дэхь үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр: | |
|---|---|
| Тур оператор | • Тогтвортой аялал жуулчлалд баримтлах зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулах.<br>• Тухайн орон нутгаас хоол хүнс болон бусад хэрэгцээт бүтээгдэхүүн үйлчилгээг худалдан авах.<br>• Орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах.<br>• Орон нутгийн ажиллагсдад зах зээлийн жишигт нийцэх цалин хөлсийг олгох.<br>• Жуулчдад аялах газрын талаарх мэдээллийг сайтар өгөх.<br>• Орон нутгийн бизнес, санаачлагыг дэмжих.<br>• Жуулчдад орон нутгийн нөхөрлөл, иргэдийг дэмжих боломжоог бүрдүүлэх.<br>• Орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжин зөвлөгөө өгөх, гар урлал зэрэг орон нутгийн бүтээгдэхүүнийг худалдан авах боломжоог жуулчдад олгох.<br>• Орон нутгийн засаг захиргаа, ТХГН-ийн бизнес эрхлэгчтэй хамтран ажиллах. |
| Гэр бааз | • Орон нутгаас хоол хүнс, үйлчилгээг авах.<br>• Зочид үйлчлүүлэгчдэд ус, түлээ гэх мэт нөөцийг хэмнэх талаар зөвлөх, мэдээлэл өгөх.<br>• Орон нутгийн туслах аж ахуйг нутгийн иргэдийн оролцоотойгоор хөгжүүлэх.<br>• Орон нутгийн засаг захиргаа, ТХГН-ийн бизнес эрхлэгчтэй хамтран ажиллах.<br>• Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн гар урлал, бэлэг дурсгалын зүйлсийг жуулчдад борлуулахад туслах. |

| | |
|---|---|
| Аймгийн захиргаа болон тусгай хамгаалалттай газар | • Аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх болон үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг боловсруулж, хамтран ажиллах.<br>• Жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих.<br>• Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг аялал жуулчлалтай холбох.<br>• Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх.<br>• Орон нутгийн дэд бүтцийг сайжруулах хөрөнгө оруулалтыг эрэлхийлэх.<br>• Хууль, дүрэм, стандартын хэрэгжилтэнд анхаарал хандуулах, зөвлөмжийг өгөх.<br>• Аялал жуулчлалын салбарын ажилтан, ажиллагсдад аялал жуулчлал болон эдийн засгийн хөгжлийн талаарх сургалтуудыг зохион байгуулах. |
| Жуулчид | • Орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах.<br>• Орон нутгаас авч буй үйлчилгээнд хөлсийг шударгаар төлөх.<br>• Аяллыг зохион байгуулж буй тур оператораас орон нутгийн эдийн засгийг дэмжих чиглэлээр хийж буй ажлуудад хувь нэмрээ оруулах.<br>• Орон нутгийн бизнес санаачлагчдыг дэмжих. |

| Тогтвортой аялал жуулчлалыг олон нийтэд таниулах, сурталчилах чиглэлээр: | |
|---|---|
| Тогтвортой аялал жуулчлалын төрөл хэлбэрийг нэмэгдүүлэх зорилгоор ийм төрлийн аялал явуулдаг компаниудыг татвараас хөнгөлөх арга хэмжээг дээд шатны удирдлагад санал тавих. | Эко аялал жуулчлал, хариуцлагатай аялал жуулчлал, нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлал, байгалийн аялал жуулчлал, ядуурлыг бууруулах аялал жуулчлал гэх мэт. |
| Эко болон тогтвортой аялал жуулчлалын талаар хурал семинар зохион байгуулж энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх сургалт зохион байгуулах. | |
| Монголын аялал жуулчлалыг гадаадад сурталчилах, маркетингийн үйл ажиллагааг үр ашигтай явуулах. | |
| Нутгийн иргэдийг аялал жуулчлалд татан оруулж тэдний нийгэм эдийн засагт туслалцаа үзүүлэх, тэдэнтэй хамтран ажиллах, тэдэнд аялал жуулчлалын талаарх боловсрол олгох. | |

## Хүрэх үр дүн

- Жуулчны баазад сэргээгдэх эрчим хүчийг ашигласнаар байгаль орчинд хаягдаж байгаа нүүрсхүчлийн хий болон бусад хорт хийн ялгарлыг бууруулан агаарын бохирдолтыг багасгахад үлэмж хэмжээний эерэг нөлөө үзүүлнэ.
- Зүүн бүсэд шинэ аялал жуулчлалын төрөл хэлбэрийг явуулснаар аялал жуулчлалын уламжлалт чиглэл, нэг хэв загварын үйлчилгээг өөрчилнө.
- Орон нутгийн иргэдийг аялал жуулчлалд татан оруулснаар тэдний амьжиргааны түвшин дээшилж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах болно.
- Орон нутгийн эдийн засагт орох орлого буюу үр өгөөж 20%-иар нэмэгдэнэ.

## Жишээ.12: Алтай Соёны эко бүс нутагт эко аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, менежментийн төлөвлөгөө

### 1. Байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, биологийн төрөл зүйлийг хамгаалах судалгаа шинжилгээний ажилд хөрөнгө оруулах зорилтын хүрээнд

| Бодлого төлөвлөлтийн хамрах хүрээ | Үйл ажиллагааны чиглэл | Хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|
| Байгалийн нөөц, хүрээлэн буй орчин | Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн бүсийн ангиллаар зөвшөөрөгдсөн газар аялал жуулчлал явуулах | Тур оператор, травел агентлаг, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага |
| | Байгаль орчинд ээлтэй, сөрөг нөлөө багатай аяллын төрөл хэлбэрийг хөгжүүлэх, нөлөөллийг хамгийн бага түвшинд барих | |
| | Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтэрч байгаа жуулчдын тоог гаргах, хамгаалалттай газрын менежментийг олон жуулчин хүлээн авахад биш, рекреацийн ачаалал, аялал жуулчлалын даацыг тооцож, жуулчдын тоог хязгаарлаж ачаалал нь хэтэрсэн газар луу аялуулахгүй байх, байгалийн нөөцийг сэргээн хамгаалах | ТХГН –ийн захиргаад БОАЖГазар |

| | | |
|---|---|---|
| Судалгаа шинжилгээ, мониторинг | Байгаль орчны хяналт мониторингийн ажлыг зохион байгуулах | БОАЖГазар АСТ |
| | Аялал жуулчлалын хүрээлэн буй орчин, эдийн засаг, соёлд нөлөөлөх эерэг сөрөг нөлөөллийг судалж нөлөөллийн хэмжээг бууруулах буюу хамгийн бага түвшинд барих | БОАЖГазар |
| | Спорт ан агнуур, зэрлэг ан амьтныг харах аялал жуулчлалын хэлбэрүүдийн нөлөөллийг судлах зорилгоор байгаль орчин, санхүү болон нийгмийн аудитыг хийж гүйцэтгэх | Ховд Их Сургууль. ЭШ хүрээлэн төвүүд |
| | Баян - Өлгийд зохион байгуулж буй бүргэдийн фестивалийн биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөг судлах | БОАЖГазар, АСТ, |
| | Уур амьсгалын өөрчлөлтийн зэрлэг ан амьтны идэш тэжээлд үзүүлэх нөлөөг судлах | Ховд Их Сургууль ЭШ хүрээлэн |
| Байгаль орчны үнэлгээ | Зэрлэг амьтан, ургамлын төрөл зүйлийг ex-situ хамгаалах саналуудыг бодитоор үнэлэх | АСТ, БОАЖГазар |
| | Мөнх цас, мөсний хайлалтаас үүдэх экологийн нөхцөлөөс биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөг үнэлэх | Ховд Их Сургууль, ЭШ хүрээлэн, АСТ |
| | Жуулчны баазын хүрээлэн буй орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх | |
| Эдийн засгийн хөшүүргийг бий болгох | Аялал жуулчлалаас олох орлогын тодорхой хувийг байгаль хамгаалах, биологийн төрөл зүйлийг хамгаалах ажилд зарцуулах механизм бүрдүүлэх | Сумын ЗД, ЗДТГ, Аймгийн ЗД, ЗДТГ, БОАЖГазар |
| | Зэрлэг амьтан ургамлын нөөц нэмэгдсэн тохиолдолд орон нутгийн иргэдэд байгаль хамгаалсны нөхөн төлбөр олгох туршилтын ажлыг авч хэрэгжүүлэх | Сумын ЗД, ЗДТГ, Аймгийн ЗД, ЗДТГ, БОАЖГазар, АСТ |
| Гадаад дотоод хамтын ажиллагааны хүрээнд дэмжлэг олох | Тухайн нэг жилийн хүрээнд байгаль хамгаалал хүрээлэн буй орчныг аль нэг чухал асуудлыг шийдвэрлэхээр тунхаглан төсөл хөтөлбөрийг дэмжих («Биологийн төрөл зүйлийн жил», «Цөлжилтийн эсрэг мод тарих жил», «Дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх жил», «Усны нөөцийн нэгдсэн менежментийн жил», «Дэлхийн өвийн жил» г.м) | БОАЖГазар |
| | Хууль бус агнууртай тэмцэх зорилгоор донор орнуудаас дэмжлэг олох | Аймгийн ЗДТГ, БОАЖГазар, АСТ |
| | Спорт агнуураас бусад санхүүгийн эх үүсвэр олох боломжуудыг дэмжих | БОАЖГазар АСТ |
| | Байгаль хамгаалах чиглэлээр тур оператор, нутгийн иргэд, орон нутгийн удирдлага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага болон засгийн газар хамтран ажиллах | Тур оператор, аймгийн ЗДТГ, ТББ, БОАЖгазар, АСТ |

## 2. Нутгийн иргэдэд аялал жуулчлалаас ашиг олоход туслах зорилтын хүрээнд

| Хамрах хүрээ | Үйл ажиллагааны чиглэл | Хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|
| Нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх | Нутгийн иргэдэд байгаль орчин экологийн боловсрол олгох | АСТ, ТББ, БОАЖГазар, ТХГН - ийн захиргаад |
| | Орон нутгийн иргэдээс эко хөтөч бэлтгэх | Тур оператор, Аймгийн ЗДТГ |
| | Эмэгтэйчүүдийг аялал жуулчлалын үйл ажиллагаа үйлчилгээнд оролцохыг дэмжих, ажлын байраар хангах | Тур оператор, жуулчны бааз, БОАЖГазар |
| | Нутгийн иргэдэд аялал жуулчлал эрхлэх сургалт зохион байгуулж аяллын хөтөлбөр зохиох, аялал зохион байгуулах боломж олгох | БОАЖГазар, ТББ |
| | Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахаасаа өмнө нутгийн иргэдээс санал авах | Тур оператор, ТББ, БОАЖГазар, Аймгийн ЗДТГ |
| Хүний эрх ардчилсан хөгжлийг дэмжих | Нутгийн иргэдэд өгөх цалин хөлс нь бусад ижил мэргэжлийн ажилчидтай адил тэнцүү байх, тэд аялал жуулчлалаас ашиг олдог байх | БОАЖГазар, тур оператор, жуулчны бааз |
| | Олон улсын санхүүжилттэй төсөл хөтөлбөрт хүний нөөц бүрдүүлэхдээ нутгийн иргэдийг ажилд авах | АСТ, БОАЖГазар, ТББ |
| | Нутгийн иргэдийн нийгэм соёлд аялал жуулчлалын үзүүлж байгаа нөлөөллийг үнэлэх, бууруулах арга хэмжээ авах | БОАЖГазар, Аймгийн ЗДТГ, тур оператор, ТББ |



### 3. Аялал жуулчлалыг байгальд хамгийн бага нөлөөтэй байхаар зохион байгуулж эко аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд

| Хамрах хүрээ | Үйл ажиллагааны чиглэл | Хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|
| Маркетинг идэвхжүүлэлт | Эко бүс нутгийг сурталчилах, бүс нутгийн хэмжээнд аялал жуулчлалын нэгдсэн сайттай болж олон улсын аяллын сүлжээ сайтуудтай холбоос тогтоох | ДБХС Монгол дахь хөтөлбөрийн газар, АСТ, БОАЖГазар |
| | Жуулчдад үнэн зөв мэдээлэл өгөх, брошур, тараах материал, судалгаа шинжилгээний ном товхимол хэвлүүлэх, бүс нутгийн хэмжээнд аялал жуулчлалын сэтгүүл англи монгол хэл дээр эрхлэн гаргах | БОАЖГазар Жуулчны мэдээллийн төв, Тур оператор, |
| | Жуулчны компаниуд, үйлчилгээний байгууллагуудын байгаль хамгаалах нутгийн иргэдийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ болон аялал жуулчлалын хариуцлага зэрэгт нь үнэлгээ өгч татварын хөнгөлөлт үзүүлэх | БОАЖГазар |
| | Гар урлалын бүтээгдэхүүн, сувенир, бэлэг дурсгалын зүйлсийг хөгжүүлэхэд нутгийн иргэдийг оролцуулах | БОАЖГазар, ТББ |
| | Экосистемийн эмзэг шинж чанарын талаар жуулчдад мэдлэг олгох, тухайн аялж буй газрынхаа байгаль, биологийн төрөл зүйл, түүх соёлын талаар бодитой мэдээлэл өгөх, нутгийн иргэдийн ёс заншил уламжлалд хүндэтгэлтэй хандаж сонирхон судлахад нөлөөлөх. | ТХГН-ийн захиргаа, тур оператор, |
| | Эко аяллын бүтээгдэхүүний үнэ бүрдүүлэхдээ ашиг гол биш, чанартай үйлчилгээ жуулчдын сэтгэл ханамж, байгаль хамгаалал, нийгэм соёлын ач холбогдол чухал гэдгийг тооцож үнийг хэт өндөр эсвэл хэт доогуур тогтоохгүй үнийн уян хатан бодлого баримтлах. | Тур оператор, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага |
| | Эко бүс нутгийн Оросын талтай хамтран ажиллаж тэндээс жуулчин хүлээж авах | БОАЖГазар, тур оператор |

| | | |
|---|---|---|
| Дэд бүтэц аялал жуулчлалын үйлчилгээний хөгжил | Зорих газарт хүрэх дэд бүтэц зам харилцааг сайжруулж аялал жуулчлалын үйлчилгээг хүртээмжтэй нийлүүлэх | Засгийн газар, |
| | Тусгай хамгаалалттай газар нутагт аялахдаа жимээр явж олон салаа зам гаргахгүй байх | Тур оператор |
| | Жуулчны байршуулах хэрэгсэл жуулчны баазуудыг эко баазын стандарт шаардлагад нийцүүлэх | БОАЖГазар |
| | Жуулчны тээврийн хэрэгслийг байгаль орчинд сөрөг нөлөө багатай байхаар сонгох, нутгийн уламжлалт тээврийн хэрэгслийг ашиглах, хамгаалалттай газар жимээр явган аялах | Тур оператор |
| | Жуулчны үйлчилгээ үзүүлэх ресторан зоогийн газар нь стандарт шаардлагад нийцсэн, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангахуйц тохилог байна | Жуулчны бааз |
| Хөрөнгө оруулалт | Эко бүс нутгийн хэмжээнд аялал жуулчлалаас олох орлого, жуулчны үйлчилгээний байгууллагаас авч байгаа татварын тодорхой хувийг эко аялал жуулчлалыг хөгжүүлэх, хамгаалалттай газрын арчилгаа судалгаа шинжилгээнд зарцуулах, эко аялал жуулчлалын нөөцийг нэмэгдүүлэх, сонирхол татах үзмэрүүдийг шинээр байгуулахад төсөвлөх. | БОАЖГазар |
| | Олон Улсын Байгууллагуудтай хамтарч төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр санхүүжилт авах. | БОАЖГазар, АСТ, ДБХС |
| | Эко бүс нутгийн Оросын талтай хамтарч судалгаа шинжилгээ явуулах. | АСТ, ДБХС, ТББ |

## 1. Төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- Байгаль орчны асуудалд тэр дундаа биологийн төрөл зүйлийг хамгаалах үйлст олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, аялал жуулчлалын байгууллагууд, жуулчид, нутгийн иргэдийн оролцоо нэмэгдэнэ.
- Эко аялал жуулчлал хөгжих суурь нөхцөл бүрдсэнээр эдийн засгийн хөгжлийн шинэ эх үүсвэрийг бий болгоно.
- Хулгайн болон спорт агнуурын үйл ажиллагааг хязгаарлах замаар эко аялал жуулчлалын гол нөөц болох биологийн төрөл зүйлийг зохистой хэмжээнд хүргэнэ.
- Энэхүү бүс нутагт эрт дээр үеэс амьдарч өөрийн байгаль хамгаалах уламжлал, ёс заншлыг хадгалан ирсэн ард түмний амьдралын хэв маягийг гээгдүүлэхгүй байх ба ингэснээр уламжлалт байгаль



хамгааллыг орчин үеийн шинжлэх ухаан, технологи, малчин ахуйтай хослуулснаар жуулчдын сонирхлыг татна.

- ТХГН-ийн менежментийг сайжруулж жилд ирэх жуулчдын тоог өсгөснөөр байгаль хамгаалах судалгаа шинжилгээний ажилд хөрөнгө оруулах эх үүсвэр бий болно.
- Аялал жуулчлалаас олох орлогын тодорхой хувийг дэд бүтцийн хөгжилд төсөвлөснөөр аялал жуулчлал нь жинхэнэ утгаараа эдийн засгийг хөгжүүлэх боломж нээгдэнэ.
- Нутгийн иргэдийг аялал жуулчлалаас орлого олох боломжийг бий болгосноор ажлын байр бий болж, иргэд байгаль хамгаалах ухамсарт үүргийнхээ үр дүнд орлого нэмэгдүүлэх боломжтой болно.
- Аялал жуулчлалын үзмэр нөөцийг сэргээн засварлаж, шинээр байгуулснаар аялал жуулчлалыг тогтвортой удаан хугацааны туршид хөгжүүлэхээс гадна жил бүр ирэх жуулчдын тоо нэмэгдэнэ.
- Байгаль орчны асуудлыг эмзэг гэдгийг жуулчид, нутгийн иргэд, олон нийтийн байгууллагад таниулан сурталчилснаар аялал жуулчлал нь зөвхөн эдийн засгийн хөшүүрэг болохоос гадна байгаль хамгаалах арга хэлбэр болно.
- Дэд бүтцийг сайжруулж, явган аяллын жим гаргаснаар олон салаа зам үүсч хөрсийг гэмтээхгүй байх бөгөөд жуулчдын сэтгэл ханамжинд эерэгээр нөлөөлөх болно.
- Эко бүсийн Орос, Казакстаны талуудтай хамтран ажилласнаар хил дамнасан тойрон аяллыг зохион байгуулж, хөрш зэргэлдээх орноос жуулчдын урсгалыг татах боломжтой.

**Тайлбар: Энэхүү менежментийн төлөвлөгөөнд нэмж тус үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа болон санхүүжүүлэх хэлбэр, санхүүжилтийн хэмжээ зайлшгүй тусгагдах шаардлагатай болно.**



# IV

## ТХГН-Т АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ДЭД БҮТЦИЙГ БИЙ БОЛГОХ БА ЖУУЛЧДЫН УРСГАЛ ЗОХИЦУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТ

**АГУУЛГА:**

- ТХГН-д аялал жуулчлалын зориулалтаар бүсчлэл тогтоох, ашиглалтын хязгаарыг тодорхойлох менежмент
- Тусгай хамгаалалттай газар нутагт Зорчигчийн нөлөөллийн менежментийг хэрэгжүүлэх нь
- Аялал жуулчлалын зориулалтын байшин барилгуудад тавигдах шаардлагууд
- Мэдээлэл, сурталчилгаа, танин мэдэхүйн үйл ажиллагаа

## IV.1. ТХГН-Д АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗОРИУЛАЛТААР БҮСЧЛЭЛ ТОГТООХ, АШИГЛАЛТЫН ХЯЗГААРЫГ ТОДОРХОЙЛОХ МЕНЕЖМЕНТ

### Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах боломжтой газруудад экологийн төлөв байдлыг алдагдуулахгүйгээр аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах, төлөвлөхөд бүсчлэлийг ашиглах

Бүсчлэл нь ТХГН-уудын менежментийн төлөвлөгөөний чухал хэсэг байдаг. Бүсчлэлийг ТХГН-уудад хамгаалал, ашиглалтын түвшинг тогтоож, тэдгээрийн аль хэсэгт ямар үйл ажиллагааг зөвшөөрөх ба хориглохыг тогтоож тэдгээрийг газрын зурагт харуулах үүднээс хийдэг. Бүсчлэлийг нарийвчлан тогтоохын зэрэгцээ аль болох энгийн ойлгомжтой байх нь чухал. Бүсчлэл нь ойлгомжтой байснаар аливаа менежментийн явуулах, холбогдох дүрэм журмуудыг дагаж мөрдөхөд хялбар дөхөм байна. Хүний үйл ажиллагааг зохицуулахын тулд ТХГН-уудын бүс бүр тодорхой үндэслэл бүхий зорилттой байх хэрэгтэй (Parks Canada, 1994). ТХГН-уудын бүсчлэлийг хамгаалалтын өндөр дэглэмтэй, ашиглалтыг маш бага хэмжээнд явуулах бүс (жишээ нь: тухайн бүсд зөвхөн шинжилгээ судалгаа явуулах буюу хүмүүсийг хөдөлгүүрт бус тээврийн хэрэгслээр цөөн тоогоор аялахыг зөвшөөрөх), эрчимтэй ашиглалтын бүс (аялагч, жуулчдад зориулсан угаалгын газар, хүлээн авах цэг, машины зогсоол, мэдээлэл сургалтын төв зэрэг), хамгаалалтын үйл ажиллагаа бүхий газар (хамгаалалтын захиргаа, засвар үйлчилгээний болон хог хаягдлын цэгүүд байрласан) зэргээр бүсчилж болно.

Хэрэв ТХГН-уудад нүүрлэж буй аюул заналууд болон оролцогч талуудын ашиг сонирхолд нийцсэн цогц менежмент явуулах шаардлагатай бол ашиглалтын олон хэлбэр бүхий бүс байгуулан тухайн бүсээр дамжуулан хэрэгжүүлж болно. Бүсчлэл нь ТХГН-уудын төвөвлөлтийг хийдэг хүмүүс, удирдлагуудаас нийгэм, байгаль орчны өнөөгийн болон ирээдүйн нөлөөллийг тогтоохыг шаарддаг (Agardy, 1993). Үүний тулд ашиглалтын хэлбэрүүд, тэдгээрийн хэм хэмжээг бүсчлэлээр тогтооно. Ашиглалтын олон хэлбэр бүхий бүсийн тогтоон үйл ажиллагааг төлөвлөх нь экологийн чухал ба онцлог газруудад үзүүлэх нөлөөллийг бууруулахад чиглэсэн байна. ТХГН-уудын дотор уг бүсийг тогтоох, зохицуулалтыг хийх нь тухайн газрын үндсэн зорилтоос хамаарна. ТХГН-ийн ашиглалтын олон хэлбэр бүхий бүсийг тухайн хамгаалалттай газрын үндсэн бүсүүд тухайн үйл ажиллагааны нөлөөнөөс ангид байхаар төлөвлөж тогтоох хэрэгтэй (Agardy, 1993). Зарим тохиолдолд байгаль орчин буюу соёлын чухал ач холбогдолтой газруудад тусгай менежмент явуулахыг

шаардаж болох бөгөөд харин тухайн тогтоосон бүсчлэл нь уг менежментэд төдийлөн нийцэхгүй ч байж болно. Иймээс менежментийн төлөвлөгөөнд тухайн газруудын хамгаалал, ашиглалтыг явуулах удирдамжийг тусгаж өгсөн байх хэрэгтэй (Parks Canada, 1994).



### Жишээ 13: ИНБНГ-ын дотоодод аялал жуулчлалын бүсчлэлийг тогтоох нь[1]

Их Нартад эко аялал жуулчлалыг хөгжүүлэх явдал бол тэнд явган аялахаас авахуулаад эко лоож хүртлэх өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулах боломжийг тус бүрийд нь харшлалгүйгээр олгох ёстой. Үүний тулд дотоод бүсчлэл, коридорчлол, зончлолыг зах зээлийн нөхцөлүүдийн онцлог шаардлага, бизнесийн онцгой давуу талуудтай нь байгаль, экологи, түүх соёлын үнэ цэнэтэй байдалд нь харшлалгүйгээр явуулах газар төлөвлөлтийн хийх ёстой. Иймээс аялал жуулчлалын зончлол гэдэг нь ИНБНГ-ын менежментийн ерөнхий төлөвлөлтөнд тусгагдсан бүсчлэлийн дагуу аялал жуулчлалын төрөл бүрийн үйлчилгээ, сегмент, зах зээлд нийцсэн бүтээгдэхүүнүүдийн ялгаатай онцлог шинж чанаруудыг дэмжих орон зайн орчныг бүрэлдүүлэхийг хэлж байна.

ИНБНГ-т аялал жуулчлалын бүсчлэлийг хийж гүйцэтгэхдээ аялал жуулчлалын даац, нөлөөллийн зэрэглэлийг анхаарч үзэх ёстой. Энэ нь аялал жуулчлалын экологийн даац, нийгмийн даац, техник үйлчилгээний даац зэргээр тодорхойлогдох ёстой.

ИНБНГ-ын гол үнэ цэнэ нь аргал хонийн байршил нутаг агаад чухамхүү үүндээ тулгуурлан "Аргал Судлалын Төв"-өөс анхаарлын үндсэн бүс түүнээс хамаарсан бусад тойрог бүсүүдийг гаргасан /Зураг 4.1/ нь аялал жуулчлалын зончлол явагдах тулгуур үндэслэл болно.

*1 Эх сурвалж: НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн «Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн сүлжээг бэхжүүлэх нь» төсөл: ИНБЦГ-ын Аялал жуулчлалын менежмент*




Зураг 4.1. *ИНБНГ-ын дотоод бүсчлэл /Эх Үүсвэр: Аргаль Судлалын төв/*

Аялал жуулчлалын зончлолыг янз бүрийн нөхцөл, орчинд хийж гүйцэтгэдэг. ИНБНГ-ын зончлолын зорилт нь аялал жуулчлалын хэрэглээний хүрээ даацаас хамаарч амралт-аяллын орчныг хамгаалалтын бодлогоор бэхжүүлэхэд орших болно. Үүнээс үндэслэж аялал жуулчлалын бүсчлэлийг гурван үндсэн хэсэгт хувааж үзэх боломжтой.Үүнд:

а). Хязгаарлагдмал хэрэглээний бүс
б). Дундаж хэрэглээний бүс
в). Өргөн хэрэглээний бүс гэж хувааж болно.

- Хязгаарлагдмал хэрэглээний бүс нь ИНБНГ-ын дотоод бүсчлэлийн аргалийн гол байршил нутгийг хамаарсан хэсэгт орших бөгөөд ийм бүс нь моторт техниктэйгээр жуулчдыг явуулахыг хязгаарлаж жуулчдын хоноглох үйлчилгээг хамгийн бага хэмжээгээр тодорхой зохицуулалтын дагуу хийж явуулах газар юм.
- Дундаж хэрэглээний бүсэд жуулчдыг хоноглох хийгээд хоол унд, шүршүүр, амралтын бусад үйлчилгээгээр хангах үндсэн үйлчилгээний газрууд байрладаг. Түүнчлэн боловсрол, танин мэдэхүйн лекц, цуглаан зэрэг сургалт, олныг хамарсан ажлуудыг хийж гүйцэтгэх үйлчилгээний тоног төхөөрөмжүүд бүхий газрууд байж болно. Хамгаалалтын захиргаа нь ихэвчлэн энэ бүсчлэлд байрлаж олон талт үйлчилгээнүүдийг хэрэглэгчдэд үзүүлж байдаг. Энэ зоныг бид анхаарлын бүсийн гадна талд аргалын байршлын 75% үзэгдэх хэсэгт буюу ИНБНГ-ын хойд хэсгийг хамааруулан оруулж байна.

- Өргөн хэрэглээний бүс нь ИНБНГ-ын аргалын 50 % үзэгдэх байрлалаас гадна орших хэсгийг хамаарах бөгөөд энд аялал жуулчлалын суурин хөдөлгөөнт аялалууд, 10-аас дээш хүнтэй групп аялагчдыг хүлээн авах боломж бүхий үйлчилгээнүүд байгуулах боломжтой юм.

Хүснэгт 4.1. *ИНБНГ-ын аялал жуулчлалын зон ба үйлчилгээний менежментийн зарчмууд*

| Аялал жуулчлалын бүсүүд | Байрлал | Аяллын Үйлчилгээ-ний онцлог | Дэд бүтэц | Аялагчдын тоо | Үйлчилгээний Тоо | Хориглох Зүйлс | Зохицуулалт |
|---|---|---|---|---|---|---|---|
| А. Зон | Аргалийн гол үндсэн байрш-лийн хэсэг | Паркаас гаргасан хөтөчтэй аялалууд | Зөвхөн гаргасан зам жимийн дагуу аялна. Тээврийн хэрэгсэл явахгүй | Нэг аялалд 10-аас дээш хүнтэй аялахгүй | Паркаас санал болгох тэмээн болон морь тэрэг, зөвшөөрөлтэй цөөн машин | Хөтөчгүй, зөвшөөрөлгүй хоноглох, чанга дуу чимээ гаргах, | ААНэгжтэй концессоор тогтвортой гэрээгээр, Жуулчдад замын тэмдэглэгээ хаалтаар |
| Б. Зон | Аргал 75% үзэгдэх хэсгийн дээд талд | Зөвшөө-рөлтэй жуулчдын бааз, эко лоож, бусад хоноглох үйлчилгээ, малчин айл байх хэрэгтэй | Халуун хүйтэн ус, нар салхины эрчим хүч, Монгол гэр бүхий байгуулам-жууд | Жуулчдын нэг өдөрт хоноглох дээд хэмжээ 60-аас ихгүй байна | Жуулчны байршуулах газруудыг хооронд нь хамтран ажиллуулах нэг газрын ор дүүргэлт 65% дутуугүй үед тоог нэмж өсгөж болно | Хэт дуу чимээтэй мотор ашиглах, ус ба хогны менежментгүй байх, цементэн байгууламж байрлах, хоорондоо харагдахуйц байрлах | Менежментийн гэрээ байгуулах, сургалт хийх, бизнес төлөвлөгөөг батлах |
| В. Зон | 50%-ийн Аргалийн байршил бүхий хойд нутаг | Амралт, эмчилгээ, зугаалгын аяллуу-дын үйлчилгээ | Модон байшин, суурин тоног төхөөрөм-жүүд, бага дуу чимээтэй хэрэгсэлүүд | Аяллын группын хэмжээ 10-ээс дээш байж болно | Үйлчилгээний газруудын тоог Менежмен-тийн зөв-лөлөөс жил бүр тогтооно | Цементэн байгууламж, дуу чимээ хэт ихтэй үйлчилгээн-үүдийг хориг-лоно | Менежментийн зөвлөл, хамгаалалтын захиргаатай гэрээ хийж ажиллана. |



**ТХГН-уудын хамгаалалтын дэглэмд нийцүүлэн ашиглалтын хязгаарыг тогтоох**: Тогтвортой аялал жуулчлалын менежментийн үндсэн суурь ойлголт бол нөөцийн ашиглалтын боломжит хязгаарыг тогтоож өгөх асуудал юм. Энгийнээр хэлбэл тогтвортой байдлыг хангах нөөцийн ашиглалтын хэлбэрүүд тэдгээрийн ашиглалтын түвшин ямар байхыг тогтоож өгөх юм. Уг хязгаарыг тогтоохдоо "байгаль орчинд хэдий хэмжээний хор хохирол учруулж болох?", "доройтлыг ямар хэмжээнд барьж байх нь аялагч жуулчлалын хувьд нийцэх?" зэрэг асуултууд тавьж болно. Хүрээлэн буй орчин илт доройтож, түүний ашиглалтын хэлбэр, түвшин өөрчлөгдөхөд зарим жуулчид тухайн газрыг бус харин өөр газрыг сонгодог (Valentine, 1992). Ашиглалтын хязгаарын

а) байгаль орчин ба хүрээлэн буй орчны,
б) соёлын ба нийгмийн,
в) сэтгэл зүйн гэсэн 3 хэлбэр байна.

**Хүрээлэн буй орчны даац** нь дээрх 3 хэлбэрийн дотор хамгийн уламжлалт ойлголт юм. Хүрээлэн буй орчны хязгаар нь "аялал жуулчлалын үйл ажиллагааны нөлөө тухайн экосистем, амьдрах орчин, ландшафтад ямар нэг хор хохирол учруулахгүй, тэдгээрийн байгалийн төрхийг алдагдуулахгүй байх түвшин"-г хэлнэ (FNNPE, 1993, p 26). Тогтоосон хязгаар нь улирлын байдлаас хамаарч харилцан адилгүй байж болно. Тухайлбал: ан амьтад үржлийн үе болон цаг агаарын нөхцөл, усны түвшин зэрэгт гарах өөрчлөлтөөс хамааран орчин тойрныхоо дарамтыг тэсвэрлэх чадвар харилцан адилгүй байна.

**Соёлын буюу нийгмийн даац**: "Эдгээр хүрээний даац хэтрэх тохиолдолд аялал жуулчлалын үйл ажиллагаа, ирж байгаа жуулчид нь тухайн орон нутгийн хүмүүсийн амьдралд муугаар нөлөөлж илүү дарамт учруулдаг" (FNNPE, 1993, p 26). Аялал жуулчлалын үйл ажиллагаа хэтэрхий өндөр байх нь тухайн орон нутгийн иргэд оршин суугчдын өдөр тутмын үйл ажиллагаанд саад учруулж, тэдэнд хүрэх эдийн засгийн орлого/ашиг тус үгүй болсноор нутгийн иргэд жуулчдад дургүйцэхэд хүрнэ. Нутгийн иргэдийн дунд нэгэнт ийм сөрөг нөлөө (хэтэрхий олон хүмүүс ирдэг болсноор тайван байсан орчин алдагдаж, түүх соёлын дурсгалт газруудад сөрөг нөлөө үзүүлэх) бий болсноор тухайн газрын жуулчдыг татах чадвар алдагдана.

**Сэтгэл зүйн даац**: Аялал жуулчлалын үйл ажиллагаа хэт төвлөрч, хязгаар даац алдагдсанаар хүмүүсийн ТХГН-уудыг зорьдог үндсэн шалтгаан (тайван чимээгүй орчин, хүн болон хөгжлийн үйл ажиллагаа багатай гм)-ууд үгүй болж болно (FNNPE, 1993, p 26). ТХГН-уудыг зорих аялагч жуулчин бүр өөр өөрийн гэсэн хүлээлттэй байдаг. Тухайлбал халуун өдөр



наран шарлагын газрыг зорьж очиж байгаа хүн тэнд маш олон хүн байгаа гэж тооцож очдог бол харин дугуйгаа унан хөдөө нутгийг зорьж буй хүн тэнд цөөн бараг хүнгүй газар гэж тооцож очдог. Иймд эдгээр хүлээлт нь сэтгэл зүйн даацанд ч хамаатай. Ер нь аялагч, жуулчдын тооцож байсан зүйл өөрөөр буюу эсрэгээр эргэх тохиолдолд тэд сэтгэл дундуур байдалд орох хүртэл таагүй нөхцөл байдал үүсч болно.

**Ашиглалтын боломжит түвшинг тодорхойлох ба учирч болох хор хохирлыг шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэн тогтоох**:

Хичнээн жуулчид, аялагчид тухайн газарт тохиромжтой байх вэ? Энэ асуултанд хариулахын тулд тусгай хамгаалалттай газрын төлөвлөлт хариуцсан ажилтнууд болон менежерүүд газар бүрт өөр өөр хязгаар тоо тогтоон, тухайн хязгаар тоо нь бодит байдалд хэр нийцтэй байна гэдгийг тодорхойлж болно (жишээ нь: тухайн тоог нэмэгдүүлж эсвэл бууруулж болох эсэхийг тооцох). Ийм хязгаарыг тогтоох нь нэлээд субъектив, өөр өөрсдийн тооцсоноор тогтоох талтай. Иймд уг хязгаарыг тогтоох төлөвлөлтийн үйл явц нь тухайн тооноос илүү чухал нарийн үйл явц байна. Аль нэг экосистемд аялал жуулчлалын үйл ажиллагаа хэт төвлөрүүлэх нь тухайн орчинд ямар нэг доройтол (жишээ нь: элэгдэл, соёлыг сүйтгэх буюу тодорхой нэг зүйлүүд устаж үгүй болох) илт үүсэх хүртэл уг үйл ажиллагаанаас үзүүлэх хор нөлөөг олж харахад хүндрэл гардаг. Амьдрах орчин буюу соёлын ач холбогдолтой газруудад байнга нөлөөнд өртдөг хэдийгээр тухайн газруудад нөхөн сэргээлт хийж болох хэдий ч хийхэд хүндрэлтэйн дээр өртөг өндөртэй болно. Иймд аливаа газар ялангуяа өвөрмөц онцлог газруудын даацыг тодорхойлохдоо маш нухацтай болгоомжтой авч үздэг байх хэрэгтэй.

**Ашиглалтын боломжит түвшин, хязгаарыг тогтоох төлөвлөлтийн үйл явц нь тухайн тооноос илүү чухал нарийн үйл явц байна.**

Даацыг тодорхойлоход гардаг хүндрэл/сорилын нэг бол тухайн даацын индикаторуудыг тодорхойлж, хэмжиж, хязгаарыг тогтоох явдал юм (McMinn, 1997). Энд тодорхой элементүүдийг нарийвчлал өндөртэй хэмжээсээр хэмжих шаардлага гарна (жишээ нь: тодорхой нэг зүйл загасны тоо толгойг тогтоосон хэмжээнээс бууруулахгүй байхын тулд зүйлийн тоо толгой нэмэгдэн нөхөн сэргээгдэх хүртэл спорт ан агнуур хийхгүй байх ба тоо толгойг хэтрүүлэн агнахгүй байх). Өөр бусад элемент ялангуяа нийгмийн элементүүдийг хэмжиж тогтооход илүү хүндрэлтэй байж болно. Газар бүр өөр өөрийн гэсэн хүчин зүйлстэй байдаг болохоор тухайн хүчин зүйлсээс хамааран тэдний даац (ялангуяа зөвхөн тухайн элементээс бус харин дүгнэлт хийж буй хүмүүсээс хамаарах субъектив шалгуур үзүүлэлтүүдийн олонхи нь) харилцан адилгүй байна. Заримдаа гаргаж байгаа шийдвэр нь улс төрийн шинжтэй болж, нийгэм эдийн засгийн ойрын хэрэгцээ шаардлагаа байгаль орчны урт хугацааны хүчин зүйлстэй харьцуулан тавих асуудал гардаг. Иймд богино хугацааны болон урт хугацааны хүчин зүйлсийн аль алиныг авч үздэг байх хэрэгтэй.

**Аялал жуулчлалаас үзүүлэх нөлөөлөлд хяналт тавих менежментийн хувилбарууд.**

Ашиглалтын хязгаарын асуудал нь тухайн газарт ирж байгаа жуулчдын тоотой бус харин жуулчдын ерөнхий хандлагатай холбоотой үүсдэг. Энэ хэсэгт жуулчдын тоо, аялал жуулчлалаас үзүүлэх нөлөөнд хяналт тавих стратегийг товч авч үзлээ. Ирж байгаа жуулчдын тоо үнэхээр асуудал мөн эсэхийг нарийн тогтоогоогүй байж, жуулчдын тоог бууруулах шийдвэр гаргахгүй байх хэрэгтэй. Ер нь ямар нэг шийдвэр гаргахын өмнө нөхцөл байдлыг үнэн зөвөөр тогтоосон үнэлэлт дүгнэлт гаргах нь зүйтэй. Ийм үнэлгээ хийхгүйгээр ямар нэг шийдвэр гаргаж, алхам хийх нь доройтолд орсон газрыг ямар шалтгааны улмаас уг газар доройтолд орсон эсэхийг нь тогтоохгүйгээр шууд засаж залруулах/нөхөн сэргээх арга хэмжээ авахтай адил юм. Ингэж авсан арга хэмжээ нь нэг бол тухайн газарт маш сайн тохирох эсвэл бүр тохирохгүй ч байж болно. Ирж байгаа жуулчдын тоог бууруулахгүйгээр жуулчдын ерөнхий хандлагад өөрчлөлт оруулах замаар аялал жуулчлалаас үзүүлэх сөрөг нөлөөг бууруулж болох уу? Уг асуудлыг авч үзсэний дараа хэрэв хэтэрхий олон жуулчид хэтэрхий олон сөрөг нөлөө үзүүлж байна гэж үзэж байгаа бол жуулчдын тоонд хандсан менежментийн өөр хувилбарыг авч үзэж болно. Уг хувилбарт дараахи асуудлыг хамруулж болно.



Үүнд:

а) Жуулчид хэтэрхий олноор ирдэг газруудын жуулчдын тоог бууруулах

б) Жуулчдын тоо хэт өсч тогтоосон хэмжээнээс хэтрэх түвшинд хүрч болох газруудын жуулчдын тоог бууруулах

в) Тодорхой нэг газарт ирдэг жуулчдын төрөл/ангилалд өөрчлөлт оруулах

Түүнчлэн жуулчдын тоог бууруулах нь бодит байдалд үнэхээр нийцэж байна уу үгүй юу гэдгийг авч үзэх. Тухайн газарт ирж байгаа жуулчдын тоонд хяналт буюу хязгаар тавих үнэхээр боломжтой юу гэдгийг бодож үзэх хэрэгтэй. Ер нь тэднийг урьдчилан бүртгэх, үр ашигтай маркетинг, мэдээлэл сурталчилгааны хэлбэрүүдийг ашиглан жуулчдын тоонд хяналт тавьж боломжтой.

Хэрэв ирж байгаа жуулчид байгаль орчинд хор нөлөө учруулж байгаа нь илт харагдаж байгаа бол тэдний хандлагыг өөрчлөхөд чиглэсэн арга хэмжээ/зорилго тавьж ажиллах нь чухал. Жуулчдаас үзүүлэх нөлөөнд хяналт тавих, захиргааны болон үйл ажиллагааны аргуудыг ашиглан нөлөөг бууруулж болно (*зарим газарт* даацыг нэмэгдүүлж болно). Тухайлбал бүсчлэл, төлбөр хураамж авах, ажиллах хуваарь тогтоох, үйл ажиллагааны зохицуулалт хийх, дэд бүтэц бий болгох, ашиглалтанд тоо хязгаар тавих, аялагч жуулчдыг шилжүүлэх, болон нэвтрэх цэгүүд бий болгох зэргийг ашиглаж болно.

### Жишээ 14: Ашиглалтын боломжит хязгаарыг тогтоох тухай

Фушаны ботаникийн цэцэрлэг нь Тайваны Ойн хүрээлэнгийн Фушаны судалгааны станцид харъяалагддаг. Уг цэцэрлэгийн зорилго нь бага ба дунд өргөрөгийн ургамлын зүйлүүдийг таримлажуулах, ургамалжуулалтыг системтэй сайжруулах, ойн судалгаа явуулах (сургалт судалгаа, дадлагын төв), байгаль орчин, экологийн боловсрол олгох, ойн экосистемийн генетикийн олон янз байдлыг хадгалахад чиглэдэг. Амралт зугаалгын ажиллагаа нь уг цэцэрлэгийн зорилгын багахан хэсгийг эзэлдэг. Уг цэцэрлэг нь Тайваны бусад газруудад амралт зугаалгын чиглэлээр ажилладаг цэцэрлэгүүдээс маш өөр. Уг цэцэрлэгийн нийт эдэлбэр газрыг 3 бүсэд хуваадаг бөгөөд уг бүсүүдийн зөвхөн нэг бүсийн багахан хэсэг нь нийтийн амралт зугаалганд нээлттэй байдаг. Хэдийгээр уг хэсэг газар нь нийтийн амралт зугаалгад нээлттэй байсан хэдий ч уг харуул хамгаалалттай учир маш цөөн хүмүүс ирж байжээ. Харин тухайн газрыг нийтэд нээлттэй болгож ямар нэг харуул хамгаалалтгүй болгоход тэнд ирж байгаа хүмүүс, жуулчдаас үзүүлэх нөлөө асар их нэмэгдсэн тул цэцэрлэгийн удирдлагын зүгээс ашиглалтын хязгаар тогтоох нь зүйтэй гэж үзсэн байна.

Уг цэцэрлэгт ирсэн хүмүүс нэг өдрийн туршид уг цэцэрлэгээр алхан цэцэрлэгийн 503 зүйлийн мод, ургамал, 103 зүйлийн шувуу болон уг цэцэрлэгт амьдардаг ховор ба ховордсон ан амьтдыг үзэж харах боломжтой байна. Нэг өдөрт дээд тал нь 400 хүн уг цэцэрлэгт орох боломжтой. Түүнчлэн цөөн тооны судлаачид тус хамгаалалттай газарт орж ажиллах зөвшөөрөл олгосон байна.

**Үе шат 1: Ямар нэг хяналт тавихгүйгээр нийтэд нээлттэй ажиллуулж байсан үе**:

Уг цэцэрлэгийг 1991 онд анх удаа ямар нэг хяналт тавихгүйгээр нийтэд нээлттэй болсон. Эхэндээ уг цэцэрлэгт ирж байгаа хүмүүсийг хүлээн авах, хаагуур явж юу үзэж харж болох талаар ямар ч мэдээлэл өгдөггүй, цэцэрлэгийн талаар танилцуулга мэдээлэл ирж байгаа хүмүүст өгдөггүй, ер нь цэцэрлэг нийтийн амралт чөлөөт цагаараа ирж очдог газрын нэг байлаа. Иймээс тэнд ирж байгаа хүмүүс хооллож ер нь юу дуртай, хүссэн зүйлээ хийдэг болсон. Ингэснээр маш богино хугацаанд уг цэцэрлэгийн ургамал, мод сүйтгэгдсэн. Үүний улмаас хүмүүс ч тэр бүр уг цэцэрлэгт ирэхээ больсон төдийгүй харин ч уг цэцэрлэгийн сүйтгэгдсэн хэсгийг нөхөн сэргээх, засварлах, хүмүүсийн орхисон хог хаягдлыг цэвэрлэх зайлуулах гээд хүн хүч хөрөнгө маш ихээр шаардагдах болсон. Түүгээр ч зогсохгүй уг цэцэрлэгийг төв замтай холбосон замын байдал ч муудсан. Ийм байдалтай үргэлжилсэн нэг сарын дараа уг цэцэрлэгийг хааж, цэцэрлэгийг нөхөн сэргээх ажил хийж, уг цэцэрлэгийн менежментийн бодлогыг дахин эргэн харах шаардлага гарч ирсэн.

**Үе шат 2: Ашиглалтын хязгаар тогтоож эхэлсэн үе**:

Амралт зугаалгын ажиллагаа нь уг цэцэрлэгийн хамгаалалтын зорилгод төдийлөн гол асуудал биш байв. Гэвч тухайн



цэцэрлэгт хэдэн тооны хүмүүс уг цэцэрлэгт амралт зугаалгын зорилгоор ирж очиж байх боломжтойг тодорхойлох хэрэгтэй болсон. Удирдлагын зүгээс уг нөөц газрын талбайг харгалзан ашиглалтын стандарт тогтоох хэрэгтэй гэж үзсэн. Үүний цаана гаргасан таамаглал бол 1 га талбайд 10 хүн/аялагч байх нь тухайн газрын байгалийн нөөцөнд ямар нэг нөлөө үзүүлэхгүй байх боломжтой гэж тооцжээ. Нөөц газрын нийт талбайтай харьцуулж үзэхэд уг газарт өдөрт 300 хүн орох боломжтой гэсэн тооцоо гарсан байна. Уг тоог тогтооход жишээ нь: нарийн замын өргөн /тус цэцэрлэг рүү орсон зам нь жижиг ба дунд оврын машин орох боломжтой/, машины зогсоолын тоо, талбай зэрэг олон хүчин зүйлсийг харгалзжээ. Цэцэрлэгт орж гарах хүний тоог өдөрт 300 хүн гэж тооцсон нь нэлээд боломжийн хязгаар болсон. Нэгэнт тус цэцэрлэгт өдөрт орох хүний тооны хязгаарыг тогтоосон болохоор ирэх хүмүүсийн захиалгыг мэйлээр урьдчилан авч бүртгэдэг, өдрийн хуваарьт оруулдаг ажил хийгдэх хэрэгтэй болж, хүмүүс 15-60 өдрийн өмнөөс бүртгүүлдэг болж, бүртгүүлсэн хүмүүст тасалбарыг эргүүлэн мэйлээр явуулдаг болсон. Захиалга өгсөн хүмүүсийн тоог өдөрт 300-аар тогтоосон болохоор уг тоонд орж чадаагүй хүмүүс өөр өдрийг хүлээх хэрэгтэй болсон. Ингэж ажилладаг болсноор тус цэцэрлэг 1993-12 сард дахин нээлтээ хийсэн.

Тус цэцэрлэг өөрийн үйл ажиллагаа, төлөвлөж байгаа ажлуудынхаа талаар хэвлэл мэдээллээр тусгай мэдээлэл хүргэсний үр дүнд тус цэцэрлэгт ирж байгаа хүмүүс тоо эрс нэмэгдсэн. Тухайлбал: өдөрт 1000 хүний захиалгыг хүлээн авдаг болсон байна. Энэ нь анх удаа нэвтрүүлж байгаа болохоор ямар нэг загвар гэх зүйл өмнө нь байгаагүй. Хүмүүсийн захиалга хүсэлтийг хүлээн авч зохицуулалт хийхэд хүндрэл гардаг болсон. Цэцэрлэгийн ажилтнууд хүмүүсийн захиалга хүсэлтийг хүлээн авах зохицуулахад маш их цагаа зарцуулж ажилладаг байсан ч жил гаруй хугацаа өнгөрсний



дараа өдөрт 100 хүний захиалга хүсэлт хүлээн авдаг болсон байна. Энэ нь тухайн цэцэрлэгт ирэх хүмүүсийн захиалга хүсэлтийг хүлээн авч байсантай холбоотой байсан. Жишээ нь: хэсэг бүлгээрээ ирэх хүмүүсийн тоог 20 гэж тогтоосон нь бодит байдалд /жишээ нь сургуулийн сурагчид, хамт олноороо ирж байгаа хүмүүсийн хувьд/ нийцэхгүй тоо байсан учраас уг тоог 50 болгон нэмэгдүүлж, өдөрт ирэх хүмүүсийн тоог 400 болгосон. Фушаны ботаникийн цэцэрлэгийн удирдлагууд ингэж тоог өөрчлөн нэмэгдүүлсэн нь тус цэцэрлэгт ирэх гадны судалгаа шинжилгээ болон дадлагын ажлаар ирэх хүмүүсийн тоог нэмэгдүүлэх болно гэж үзсэн.

**Үе шат 3: Тогтоосон ашиглалтын хязгаарыг дахин хянасан**:

Тус цэцэрлэгт өдөрт ирэх жуулчдын тоог өөрчлөн хэсэг хугацаанд үйл ажиллагаагаа явуулсны дараа уг цэцэрлэгийн захиргаанаас өөрийн бодлогоо эргэн харах хэрэгтэй хэмээн үзэж, эхний ээлжинд явган аяллын замын орчимд мониторинг хийжээ. Үр дүн нь уг замын дагуух хөрс, ургамалын бүрхэвчинд өөрчлөлт орж ямар нэг доройтол бий болсон зүйл байхгүй байна гэж үзээд өдөрт ирж байгаа хүмүүсийн тоо боломжийн гэж тооцсон байна. Мөн хогны асуудлыг мөн авч үзсэн, хүмүүст өгсөн мэдээллийн ачаар цэцэрлэгт хог хаях асуудал гарахгүй болжээ.

**Фушаны туршлага, менежментийн зарчмууд**:

Фушаны ботаникийн цэцэрлэгийг байгалийн төрхөөр нь хадгалж үлдэхэд нөлөөлсөн хамгийн чухал зүйл бол ашиглалтын хязгаарыг тогтоож, мөрдөж ирсэн явдал юм. Түүнчлэн байгалийн төрхийг хагас хэлбэрээр хадгалан үлдсэн энэхүү цэцэрлэг байгалийн нөөцийн тогтвортой байдлыг хангахад олон чухал үйл ажиллагааг төлөвлөсөн байна. Тухайлбал, хүн хамгийн ихээр ирдэг газруудад захиргаа болон бусад мэдээлэл өгөх газруудыг шилжүүлэн байрлуулснаар цэцэрлэгийн бусад газруудад үзүүлэх хүний шууд нөлөөг бууруулж чадсан. Мөн цэцэрлэгийг өглөөний 9:00 цагаас өдрийн 16:00 цагийн хооронд ажиллуулдаг нь уг цэцэрлэгт байдаг олон амьтдын хоол идшээ олж иддэг үетэй давхцуулахгүй байх боломжийг олгосон. Түүнчлэн цэцэрлэгийг жил бүрийн 3 дугаар сард хааж нийтэд үйлчилгээ үзүүлдэггүй нь цэцэрлэгийн ургамлын цэцэглэлт, ан амьтдын үржлийн үеийг хүний нөлөөнөөс хамгаалах боломж олгодог. Нийтэд нээлттэй байх хугацаанд цэцэрлэгт хувийн худалдаа тухайлбал хоол хүнс, ундааны зүйл худалдахыг хориглодог байна. Эдгээр менежментийн үр дүнд тус цэцэрлэгийн байгалийн төрх, экологийн эрүүл мэндийг хэвээр хадгалан үлдэж чадсанаар байгалийн сайхныг үзэж сонирхох гэсэн хүмүүсийн эрэлт хэрэгцээг хангаж байна.

## IV.2. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ЗОРЧИГЧИЙН НӨЛӨӨЛЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ



Аялал жуулчлал эхлэн болон эрчимтэй хөгжиж буй аль ч тусгай хамгаалалттай газар нутагт аялагч, зорчигчоос үүдэлтэй нөлөөлөл ямар нэгэн байдлаар үүсэж, үүнийг хэрхэн зохицуулах вэ гэдэг нь тухай ТХГН-ийн хамгаалалтын захиргаа, хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн нэг гол үүрэг болдог. Зорчигчийн нөлөөллөөс үүдэлтэй асуудлууд нь дараах агуулгаараа тодорхой менежментийн шийдлүүдийг шаарддаг. Үүнд:

1. Аялал жуулчлалаас үүдэлтэй нөлөөлөл нь тухайн хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын горимтой зөрчилдөх
2. Аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглах явцад үүсдэг бэрхшээлүүд
3. Хэдийгээр богино хугацаанд нөлөөлөл нь шууд мэдрэгдэхгүй боловч аажимдаа их хэмжээний хохирол учруулдаг нөлөөллүүд
4. Аялал жуулчлалаас үүдэлтэй урьдчилан тооцох боломж багатай нөлөөллүүд (эдийн засгийн сөрөг үр дагавар, гэмт хэргийн өсөлт г.м)

Иймд тухайн тусгай хамгаалалттай газарт Зорчигчийн нөлөөллийн менежментийн (Visitor Imact Management) хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нөлөөллийг багасгах, хурдцыг сааруулах алхам болдог. Зорчигчийн нөлөөллийг менежментийг хэрэгжүүлж, тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалаас үүдэн гарах нөлөөллийг бууруулахад хамгийн гол нь тухайн газар нутгийн даацыг тодорхойлох асуудал байдаг. Тусгай хамгаалалттай газар нутгийн даац, багтаамжийг тодорхойлох үйл явц нь 1960-д оноос рекреацийн менежментийн хөгжилтэй уялдан үүссэн (Wagar, 1964) гэж үздэг. ТХГН-ын аялал жуулчлалын даац, багтаамжийн тухай ойлголт нь тухайн газар орны экологи, экосистем, нийгэм-эдийн засгийн орчин, менежментийн онцлогт тулгуурлан аялал жуулчлалын зориулалтаар ашиглаж болох газрын хэмжээг илтгэдэг (Stankey & McCool, 1990). Улмаар аялал жуулчлалын даац, багтаамжийн тухай ойлголт нь тухайн орон нутгийн эзэн соёлд нийгэм-соёл, эдийн засгийн хөгжлийн үзүүлэх нөлөөг бас илэрхийлдэг болсон (Inskeep, 1988; Wolters, 1991).




Зураг 4.2 *Хүрээлэн буй орчны менежментийн зарим моделиудын харилцан уялдаа*

Тусгай хамгаалалттай газар нутгийн даац, багтаамжийг тооцох нь тухайн газар нутгийн ашиглалтын талаарх шийдвэр гаргалтын үндэс суурь нь болж өгдөг. Шийдвэр гаргалтын процесст өргөн ашиглагдаж буй зарим зарчмуудыг дурьдвал:

- Хүлээн зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаар (Limits of Acceptable Change-LAC),
- Зорчигчийн нөлөөллийн менежмент (Visitor Impact Management-VIM),
- Зорчигчийн Үйл ажиллагааны Менежментийн процесс (Vistor activities management Process-VAMP),
- Зорчигчийн туршлага ба нөөцийн хамгаалал (Visitor Experiences and Resource Protection-VERP).

Эдгээр зарчмууд нь ерөнхийдөө тухайн газар нутгийн рекреаци, аялал жуулчлалын нөөцийг оновчтой тооцож, хүн-байгалийн хоорондын харилцан хамаарал, нөлөөллийг үнэлсэний үндсэн дээр байгаль хамгааллын үйл явц, аялал жуулчлалын үйлдвэрлэлийг хослуулан хөгжүүлэх боломжит хязгаарыг тодорхойлох, менежментийн стратегиа боловсруулах боломжийг олгодог.

**Зорчигчийн менежментийн хэрэгсэлүүд**

Тусгай хамгаалалттай газарт аялал жуулчлалаас үүдэлтэй сөрөг үр дагаварыг бууруулахад дараах 4 төрлийн стратегийг түгээмэл ашигладаг. Үүнд:

1. **Аялал жуулчлалын нийлүүлэлтийг зохицуулах:** Орон байрны үйлчилгээг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын зориулалтаар ашиглагдах газрын хэмжээг тэлэх г.м
2. **Аялал жуулчлалын эрэлтийг зохицуулах:** тусгай хамгаалалттай газарт хоноглох хугацаа, зорчигчдын тоо, аяллын төрлийг нэмэгдүүлэх г.м
3. **Аялал жуулчлалын нөөцийг зохицуулах:** шинээр аялал жуулчлалын үзмэр бий болгох, тусгай хамгаалалттай газарт аялал жуулчлалын бүсчлэлийг бий болгох г.м
4. **Ашиглалтын нөлөөллийг зохицуулах**: аялал жуулчлалаас үүдэн гарч буй сөрөг нөлөөллийг багасгах, ашиглалтын хэлбэрийг өөрчлөх г.м.

### ТХГН-ын аялал жуулчлалын даацыг тодорхойлох аргазүй

ТХГН-ын аялал жуулчлалын даац гэдэг нь өргөн хүрээтэй, маргаантай ойлголт бөгөөд ерөнхийдээ "Нэгж нутаг дэвсгэр нэгж хугацаанд аялж, зорчиж болох жуулчдын дундаж стандарт хэмжээ" юм. Энэхүү дундаж стандарт хэмжээ нь тухайн газар орны экосистемийн онцлог, дэд бүтэц, үйлчилгээний байгууллагын хүчин чадал зэргээс хамаараад газар орон бүрт харилцан адилгүй байна. Аялал жуулчлалын даацыг тодорхойлохын тулд аялал жуулчлалын хүчин чадал гэсэн ойлголтыг авч үзнэ. Бүс нутаг, газар орны аялал жуулчлалын хүчин чадал нь жуулчдын сэтгэл ханамжтай байгаа эсэхээр хэмжигдэж болно. Аялал жуулчлалын хүчин чадал гэдэг нь "Тухайн газар нутагт айлчлан ирж буй жуулчид хүрээлэн буй орчинд хамгийн бага хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлж, дээд зэргээр сэтгэл ханамж авч чадах хамгийн зохимжтой түвшний хэмжээг хэлнэ". Өөрөөр хэлбэл тодорхой газар нутгаар байгалийн иж бүрдэлд төдийлөн сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр өндөр сэтгэгдэлтэй аялж, зугаалах жуулчдын зохистой тоо юм: Монгол орны нөхцөлд аялал жуулчлалын хүчин чадлыг хүн амын, дэд бүтцийн, уламжлалт ахуй соёл, байгалийн иж бүрдлийн онцлогоор тодорхойлох нь зүйтэй. Аялал жуулчлалын хүчин чадлыг (АЖХЧ) тооны хэлээр илэрхийлвэл:

АЖХЧ= Жуулчин хүлээн авч буй газар нутгийн хэмжээ/ Дундаж стандарт хэмжээ

Харин хүчин чадлыг эрэлтийн коэффциенттэй харьцуулан үржүүлсэн үржвэр нь өдрийн аяллын нийлдбэр юм.

Энэ нь: Нэг өдөрт аялах хүлээн авах жуулчдын тоо = Хүчин чадал* эрэлтийн коэффициент

Эрэлтийн коэфициент = Нэг өдөрт жуулчдыг хүлээн авах хугацаа/ жуулчдын байрлах дундаж хугацаа






Зураг 4.3. *Тусгай хамгаалалттай газар нутагт Зорчигчийн Нөлөөллийн менежментийн цар хүрээ*

## IV.3. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗОРИУЛАЛТЫН БАЙШИН БАРИЛГУУДАД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Бүсчлэлийг тогтоосноор ТХГН-уудад аялал жуулчлал хөгжүүлэх бүсийг тогтоож түүний дэд бүтэц, хамгаалалтын үйл ажиллагаанд шаардлагатай барилга хаана байх байршлыг тогтоох боломжтой болно. Хэрэв хамгаалалттай газар нутаг дотор болон орчны бүсэд дэд бүтцийг өргөжүүлэх шаардлагатай бол тогтоосон/дараах зарчмуудын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Дэд бүтэц, барилга байгууламжийн хэмжээг хамгийн бага түвшинд байлгах
- Аялагч, жуулчдад зориулсан мэдээллийн самбар, тэмдэглэгээ барих (жишээ нь: машины зогсоолын байршил, хэмжээ гм)
- Барилга байгууламжууд нь аль болох байгаль хүрээлэн буй орчин, экосистемд нөлөө бага үзүүлэхээр байна.
- Барилга байгууламжууд нь байгаль, хүрээлэн буй орчны төрхийг алдагдуулахаар аль болох орон нутгийн, уламжлалт материалаар хийгдсэн байна.
- Барилга, байгууламж нь байгаль орчинд ээлтэй дизайн, хэв маягаар хийгдэж, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулдаг байна. Тухайлбал хог хаягдлыг бууруулах, цуглуулах тогтолцоог бий



болгосон байх, эрчим хүчний хэмнэлт, сэргээгдэх эрчим хүчийг ашигладаг байх, хог хаягдлаа дахин боловсруулдаг байх, хаягдал усанд байгалийн шүүлтүүр ашиглах зэрэг байж болно.

- Байр, орон байр нь энгийн, тохилог, даруухан байх хэрэгтэй (The Royal Society for the Conservation of Nature, 1998).

Шаардлагатай тохиолдолд тогтоосон бүсчлэлийн гадна байж болно. Тухайлбал: Зарим жуулчид олон хүнтэй парк бус харин илүү тайван чимээгүй орчинд байхыг хүсдэг. Иймд хамгаалалтын гадна байрлах газартай байх хэрэгтэй. Тэнд хээрийн хоол хийх газар, мэдээллийн цэгүүд зэрэг аялагч жуулчдын энгийн наад захын хэрэглээний зүйлс байх шаардлагатай. Ийм ажиллагаанд хувийн салбарыг татан оролцуулж болно.

### Жишээ 16: Жуулчны баазын барилга байгууламжинд тавигдах шаардлага:

Аялал жуулчлалын бааз байгуулахад ихэвчлэн байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэдэг учир одоо манай улсад ажиллаж буй аялал жуулчлалын баазуудын олонхи нь тусгай хамгаалалттай газар нутагт оршдог. Тиймээс аялал жуулчлалын баазын төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийхэд тусгай хамгаалалттай газар нутгийн онцлог шаардлагууд, хамгаалалтын горим, байгаль орчны өвөрмөц байдлыг нь илүүтэй харгалзан үзэх шаардлагатай. "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" Монгол Улсын хуулийн хавсралтын дагуу улсын тусгай хамгаалалтад авсан газар нутагт хэрэгжих аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг зөвхөн Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шинжээчид хийж гүйцэтгэнэ. Харин орон нутагт ажиллаж буй шинжээчид нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын орон нутгийн хамгаалалтад авсан газруудын нутаг дэвсгэрт хэрэгжих төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг хийнэ.

Тусгай хамгаалалттай газар нутагт хэрэгжих төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийхэд дараахь асуудлуудыг эн тэргүүнд анхааран үзэх шаардлагатай. Үүнд:

1. "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" болон "Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай" Монгол Улсын хууль, бусад хууль тогтоомжийн шаардлагад тухайн төсөл нийцэж байгаа эсэх
2. Тусгай хамгаалалттай газраас тодорхой зориулалт, хугацаа, болзолтойгоор ашиглах гэж буй Монгол

улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын баримт бичиг нь хүчин төгөлдөр мөрдөж буй хууль, эрх зүйн шаардлагад хэрхэн нийцэж байгаа эсэх

3. Тухайн төслөөс тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчны төлөв байдал, биологийн төрөл зүйлд ямар сөрөг нөлөөлөл үзүүлэх, тусгай хамгаалалттай газар нутгийн байгалийн төрх байдлыг өөрчлөх
4. Дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц болон дурсгалт газрын нутаг дэвсгэрт оршиж буй байгалийн өвөрмөц тогтоц, геологийн хурдас, нэн ховор, ховор ан амьтан, ургамлын зүйл, булш бунхан, хадны сүг зураг, эртний хүмүүсийн бууц, чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн ул мөр, бичээс, буган ба хүн чулуун хөшөө, эртний хот, суурингийн туурь зэрэг түүх соёлын дурсгалт зүйлст тухайн төслийн үйл ажиллагаа хэрхэн нөлөөлөх.

Түүнээс гадна аялагч, жуулчлагч нарын ая тух, аюулгүй байдлыг хангах, тэднийг аяллаар явах замын маршрутыг тогтоох, ус хангамжийн найдвартай эх үүсвэрийг сонгох, хатуу хог хаягдал болон ахуйн бохир усыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах, барилга байгууламж, дамжуулах шугам сүлжээ, зам, бохир усны цооног, бие засах газар, автомашины зогсоол байгуулахад өртөж эвдэрсэн газрыг засч тэгшлэх, нөхөн сэргээх, мөн бохир усны цооног, хог хаягдлын цэг, бие засах газрын байршлыг зөв тогтоох зэрэг асуудлуудыг онцгойлон харгалзаж үзэх шаардлагатай. Аялал жуулчлалын баазын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үед анхаарах гол асуудлуудыг дараахь хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт. 4.2. *Аялал жуулчлалын баазын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үед анхаарах зүйлс*

| | |
|---|---|
| **Барилга байгууламж** | - Аялал жуулчлалын баазын барилга байгууламжийг эрх бүхий байгууллагаас баталсан зураг төслийн дагуу барьж байгуулах<br>- Аялал жуулчлалын баазын зэрэглэл бүхий хаяг, үйлчилгээний төрлийг заасан тэмдгийг MNS 4597:98 стандартын дагуу байрлуулсан байх<br>Аялал жуулчлалын баазын барилга байгууламж нь "Олон нийтийн барилга байгууламж төлөвлөлт" барилгын норм, дүрэм (2.08.02-98)-д заасан шаардлагыг хангасан байх<br>- Аялал жуулчлалын бааз нь зохих шаардлагыг хангасан албан ажлын байр, зочны байр, олон нийтийн буюу мэдээллийн байр, хооллох байр, дэлгүүр, амралт, тоглоомын талбай, угаалгын газар, тээврийн хэрэгслийн зогсоол, агуулах, ариун цэврийн болон бие засах газартай байх |

| | |
|---|---|
| **Эрүүл ахуйн талаар** | - Зочны байр нь18⁰С-20⁰С-аас доошгүй дулаантай, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн гэрэлтүүлэгтэй байх<br>- Унд-ахуйн усны эх булгийг “Ундны усны эрүүл ахуйн шаардлага” MNS 900:2005 стандартын дагуу сонгож, ус хангамжийн эх үүсвэрт ариун цэвэр, хамаалалтын бүс тогтоох<br>- Зөөврийн усан хангамжтай үед хүнсний зориулалтын саванд усыг хадгалах, мөн ус хадгалах савыг тогтмол хугацаанд цэвэрлэж, ариутгаж байх<br>- Эдэлбэр газрын талбай, гэр болон барилга байгууламжийн орчинд цэвэрлэгээг тогтмол хийх, хог хаягдлыг гэр, барилга байгууламжаас 50 метрээс ойргүй зайд тогтоосон цэгт хуримтлуулж, тогтмол хугацаааанд зайлуулах, бохир усны цооног, бие засах газарт ариутгал, халдваргүйжүүлэлтийг эрүүл ахуй норм, дүрмийн дагуу тогтмол хийх<br>- Бие засах газар, бохир усны цооногийг “Ахуйн бохир усны цооногийг доторлох, ашиглах журам”-ын дагуу байгуулж, баазын захын объектоос 20 метр, ил задгай усны эргээс 30 метрээс ойргүй зайд байрлуулах |
| **Аюулгүй байдал** | - Үер усны болон галын аюул, газар хөдлөл, аянга цахилгаан, ой хээрийн түймэр зэрэг гамшгаас сэргийлэх арга хэмжээг зохих заавар, журмын дагуу төлөвлөж хэрэгжүүлэх<br>- "Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" MNS 4244:94 стандартын дагуу жуулчид болон ажиллагсдын аюулгүй байдал, эрүүл мэнд, өмч хөрөнгийн хамгаалалтыг бүрэн хангасан байх<br>- Гал унтраах багаж хэрэгсэлтэй байх<br>- Гэр болон бусад байгууламжуудын хоорондын зай 5 метрээс багагүй байх<br>- Нийтэд зориулсан мэдээллийн тэмдгийг зохих газруудад байрлуулсан байх<br>- Тээврийн хэрэгслийн зогсоолыг үзэгдэх орчныг халхлахгүйгээр, галын аюулгүйн зайд байрлуулах, таних тэмдэгтэй байх |
| **Эдэлбэр газар** | - Аялал жуулчлалын зөвшөөрөгдсөн бүс нутагт ажил үйлчилгээ явуулах<br>- Байгаль орчны холбогдох хууль тогтоомжийн дагуу байгаль орчныг хамгаалах, үнэлгээ дүгнэлт гаргуулж, хүрээлэн буй орчин, амьтан, ургамлын аймгийг хамгаалах, мөн ус, агаар, хөрсийг бохирдуулахгүй байх<br>- Орчны тохижилтыг зориулалтын дагуу хийсэн байх. Үүнд:<br>• Мод, бут сөөг, зүлэг, цэцгийн мандал тарих, усан оргилуур байгуулах<br>• Явган хүний зам тавих<br>• Гэрэлтүүлэг хийх<br>• Наран шарлагын болон амралт, тоглоомын талбайтай байх<br>• Мэдээллийн самбар, анхааруулах санамж хуудсуудыг зохих газруудад байрлуулах<br>-Талбайн гэрэлтүүлгийг гэр болон бусад байгууламжуудыг бүрэн гэрэлтүүлэхүйцээр байрлуулах |

## IV.4. МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГАА, ТАНИН МЭДЭХҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Жуулчид, нутгийн иргэдэд зориулсан хүрээлэн буй орчин, соёл, өв болон байгаль хамгааллын бусад чухал асуудлын талаарх мэдлэг мэдээлэл олгох, танин мэдэхүйд тустай сургалт, танин мэдэхүйн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх**

Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны ажилтнууд, менежерүүд нь байгаль орчны боловсрол, мэдээлэл сурталчилгааг дээшлүүлэхэд голлох үүрэгтэй. Олон нийтийн мэдээлэл, сурталчилгаа, танин мэдэхүйн хөтөлбөрүүд хэрэгжиж, олон нийтэд байгаль орчны танин мэдэхүйн мэдлэг боловсрол дээшилснээр тэдний байгаль орчныг хамгаалах үйлсэд бие даан болон хамтдаа оролцох идэвхи нэмэгддэг. Жуулчдад мэдээлэл өгснөөр тэдний хүрээлэн буй орчин, соёл зан заншил, өвийн болон тухайн газар нутгийн төдийгүй бүс нутгийн хэмжээний асуудлын ойлголт дээшилж, олон нийтийн мэдээлэл, сурталчилгаа, танин мэдэхүйн хөтөлбөрүүд хэрэгжсэнээр байгаль орчны ёс зүйн хэм хэмжээг тогтоож, байгаль хамгаалахад үзүүлэх олон нийтийн дэмжлэг сайжирдаг байна (Parks Canada, 1994). Туршлагаас үзэхэд байгаль орчны мэдээллийн төв болон хамгаалалттай газруудын тухай гарын авлага, танилцуулга зэрэг хэвлэмэл материалуудыг /наад зах нь/ дараах 4 зорилгын аль нэгийг хангах зорилгоор гаргадаг байх хэрэгтэй. Үүнд:

1. **Нөөц буюу бусад онцлогууд** (жишээ нь: газар орон нутгийн тухай домог, түүх, өвөрмөц онцлог газрууд гм)**-ын талаарх олон нийт, жуулчдын мэдлэг мэдээлэл, танин мэдэхүйг хөгжүүлэх/ нэмэгдүүлэх**: энэ нь тухайн орон нутаг, оршин суугчдын талаарх ойлголт танин мэдэхүйн мэдлэг мэдээллийг тухайн газарт ирж байгаа хүмүүст өгнө.
2. **Жуулчид, орон нутгийн иргэдийн хандлагыг өөрчлөх**: тэдэнд аливаа зүйлийг хийхгүй байхыг шаардах ба зүгээр хэлэхийн оронд яагаад хийж болох эсвэл хийх ёсгүйг тайлбарлаж өгдөг байх хэрэгтэй. Жишээ нь: нэг шороон зам ашиглахыг хориглосон тэмдэг тавьсныг хараад хүмүүс тухайн зам яасан юм бол гэж гайхаад өнгөрнө. Харин "энэ замыг хэт ашигласнаас болж зам элэгдэлд ороод байгаа тул уг зам эргэн нөхөн сэргэх хүртэл уг замаар бус өөр зам сонгохыг зөвлөсөн" тэмдэг тэмдэглэгээ тавих нь илүү ач холбогдолтой.

### Жишээ 15: Байгаль орчны боловсролыг хөгжүүлэх стратегийн төлөвлөлт ба тогтвортой санхүүгийн эх үүсвэр

## - Мэй По ус намгархаг газар, Хонконг



**Байгаль орчны боловсрол:** Мэй По байгалийн нөөц газар нь 1995 онд Рамсарын конвенцид бүртгэгдсэн, Хятадын 7 томоохон ус намгархаг газруудын нэг. Тус байгалийн нөөц газар (нийт 380 га) бараг 3 км урт, 1 км өргөн талбайг хамран Дийп Бэй, Мэй По Рамсарын бүртгэлтэй газар (1500 га газрыг) газарт оршдог. Тус газрын хамгаалалтыг 1984 оноос Дэлхийн байгаль хамгаалах сангийн Хонконг дахь хөтөлбөрийн газар тус улсын Хөдөө аж ахуй, Загасны аж ахуй, байгаль хамгааллын газартай хамтран хариуцан ажиллаж байна. Мэй По нь Хонконгийн уламжлалт аргаар хамгаалж ирсэн цөөрөм, мангровын төгөл бүхий газар. Тус газарт өдрөөс өдөрт өргөжин тэлсээр байгаа хөдөө аж ахуй, үйлдвэрийн бохирдол, төв суурин газрын хаягдал усны нөлөө нэмэгдсээр Дийп Бэй ус намгархаг газрын шувууны популяцид асар их нөлөө үзүүлэх болсоны зэрэгцээгээр гүехэн устай байсан багахан хэмжээний цөөрмүүд нь будааны тариалангийн талбай болж хувиран, шинэ суурингууд үүсч, загасны аж ахуй бусад бизнес асар хурдтай хөгжиж эхэлсэн (Nelson, 1993). Иймд ДБХС-ийн Хонконг дахь хөтөлбөрийн газар тухайн жижиг цөөрмийн газруудыг эргүүлэн худалдаж авч хамгаалах арга хэмжээ авч эхэлсэн байна. Ойролцоогоор 4000 хүн Мэй По-д жил бүр ирдэг бөгөөд тэдгээрийн 4/1 нь оюутнууд байдаг. Тус газрын хамгааллыг орон нутгийн иргэдийн дэмжлэг, оролцоогүйгээр явуулах боломжгүй байлаа. Иймд ДБХС-ийн Хонконг дахь хөтөлбөрийн газар нь байгаль хамгаалалд орон нутгийн дэмжлэг, чадавхийг бий болгох үүднээс байгаль хамгааллын бодлого, хууль тогтоомжийг боловсруулах зорилго тавьжээ (Tilbury, 1999). Боловсролын хөтөлбөрийг юуны өмнө Мэй По нөөц газрын сургамжийг үндэслэн Хонконгийн ус намгархаг газруудад тулгараад байгаа асуудлуудад гол анхаарлаа хандуулж, байгаль орчны олон нийтийн мэдээлэл сурталчилгааны ажлыг явуулахаар шийдсэн байна. Олон нийтийн мэдээлэл сурталчилгаа, байгаль орчны боловсролыг ан амьтдын мэдээлэл сурталчилгааны төвөөр дамжуулан хэрэгжүүлэх болсон ба уг хөтөлбөрт газар тариалан, ус намгархаг газрын экологи, ан амьтад болон сам хорхойн аж ахуй гэсэн сэдвүүдийг хамруулсан. Тус нөөц газрын эргэн тойронд зам, гүүр тавьж төв суурин газруудтай холбож, шувуу ажиглах цэгүүдийг барьсан байна. Сургалт, танин мэдэхүйн хөтөлбөрийг голчлон сургуулийн сурагчдад хандан зохион байгуулж, сам хорхойн уламжлалт аж ахуйн ач холбогдол, түүнийг Мэй По нөөц газрын амьдрах орчныг хадгалан үлдэх зорилгоор байгуулсан тухай болон тус нөөц газрын экосистемийн олон янз байдал, мангровын төгөл болон бусад элементүүдийг хамгаалах асуудлын чухлыг ойлгуулахаар

зорьжээ (Nelson, 1993). 1998-1999 онд тус нөөц газарт бага ба дунд сургуулиудын 10,000 орчим сурагчид зочилж, 400 сургуулийн сурагчид хэсэг бүлгээр очсон тоо байна.

**Байгаль орчны боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын оруулсан хувь нэмэр**:

1980-аад онд боловсролын төв байгуулагдан хөтөлбөр хэрэгжүүлж эхэлж байх үед ус намгархаг газруудын ач холбогдлыг төдийлөн сайн мэддэггүй, байгаль орчны мэдлэг боловсролыг хөгжүүлэхэд төрөөс төдийлөн сайн анхаардаггүй байв. Түүнчлэн байгаль орчны боловсролыг бий болгох, жижиг цөөрөм, загасны нөөц бүхий нуур цөөрмүүдийг хамгаалах талаар бүх түвшинд мэдлэг хангалтгүй байсан тул ДБХС-ийн Хонконг дахь хөтөлбөрийн газар ус намгархаг газрын экологич авч ажиллуулан боловсролын төвийг нээн, хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг эхлүүлжээ. Түүнчлэн үндэсний мэргэжилтнүүд /экспертүүд, орон нутгийн иргэдийг газар дээр ажиллуулах, тэдний байгаль хамгааллын уламжлалт мэдлэгийг боловсролын хөтөлбөртэй уялдуулах зорилготой гэрээгээр авч ажиллуулж, орон нутгийн туршлагатай байгууллагуудыг мэдээлэл сурталчилгааны ажлыг төлөвлөх, шаардлагатай материалуудыг бэлтгэхэд туслуулж тэдэнтэй хамтран ажилласан байна. Мөн судалгаа шинжилгээний байгууллагууд, их дээд сургуулиудтай хамтран намгархаг газруудад судалгаа мониторингийн ажлуудыг хийж гүйцэтгэжээ.

**Байгаль орчны боловсролын хөтөлбөрийн үр дүн**, **хүрсэн үр дүн:**

1. **Байгаль орчны талаар мэдээлэл сурталчилгааг бий болгосон**: мэдээлэл танин мэдэхүйн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлснээр тус газарт ирж байгаа зорчигчид, сургуулийн сурагчид тус намгархаг



газруудын ач холбогдол, түүний хамгаалалд нүүрлэж байгаа аюул занал, шаардлагатай дэмжлэг туслалцааны талаар ойлголт мэдлэгтэй болсон. Үүний үр дүнд тогтвортой хөгжлийн ойлголт, тогтвортой төлөвлөлтийн асуудлыг илүү нухацтай авч үздэг болсон байна.

2. **Байгаль орчны боловсролын асуудалд төр засгийн зүгээс анхаарч, дэмжлэг үзүүлдэг болсон**: Мэй По ус намгархаг газрын тухай олон нийтийн мэдлэг мэдээлэл аажимдаа нэмэгдсээр түүний хамгааллын статус сайжирч, төр засгийн зүгээс анхаарал хандуулж дэмжлэг туслалцаа нэмэгджээ (I. Wong, personal communication. March 16, 2000). 1980-аад онуудад Боловсролын газар ДБХС-ийн Хонконг дахь хөтөлбөрийн газраас үйлчилгээг худалдан авч биологийн багш нарыг сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагуудыг биелүүлэхэд туслах аялалыг зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн бол 1990-ээд онд байгаль орчны боловсролд ач холбогдол өгч Боловсролын газар сургуулиудын танилцах аялалыг дэмжин санхүүжүүлэх нь байгаль орчны боловсролыг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр болно гэж үзэн сургуулиудаас зохион байгуулах аялалуудыг дэмжин санхүүжүүлсэн байна.

### *Жишээ 16: Олон нийтийн мэдээлэл сурталчилгааг сайжруулах: Гүн Галуутайн Байгалийн нөөц газар*

Орон нутгийн иргэд аялал жуулчлалд хамгийн их үүрэг гүйцэтгэдэг субъект нь учраас тэднийг зэрэг мэдээлэлээр хангаж өгсөнөөр тэднээс жуулчид мөн зэрэг мэдээллийг авч болно. Одоогийн байдлаар «Гүн Галуут» нутгийн иргэдийн холбоонд сумын зарим малчид, иргэд элсэн гишүүн нь болсон



бөгөөд уг зорилтын хүрээнд сумын хөдөлмөрийн чадавхитай бүх иргэдийг татан оруулахыг эрмэлзэж байгаа юм. Ингэсэнээр өрх бүрийн 2-4 гишүүд ажлын байраар хангагдаж, амьжиргааны түвшнөө дээшлүүлэх боломжтой юм.

**"Гүн Галуут" нутгийн иргэдийн холбооны гишүүнчлэл:**
Холбоонд 18-аас дээш насны, бие бялдар, сэтгэл санааны хувьд эрүүл чийрэг, харилцааны соёлтой, ерөнхий боловсролын мэдлэгтэй ямар ч хүмүүсийг "Тогтвортой ажлын гэрээ"-нд гарын үсэг зуруулан үнэ төлбөргүй элсүүлэх юм.

**"Гүн Галуут" Нутгийн иргэдийн сүлжээ**

*Сүлжээний зорилго*
"Гүн Галуутай" БНГ-т ирэх жуулчдад өдөр тутмын амьдралынхаа хэв маягаас танилцуулж, сонирхуулах, жуулчдыг тав тухтай байлган, жинхэнэ монгол амьдралыг жуулчдад таниулах юм.

*Чиг үүрэг*

- Цэвэр тохилог гэртэй, ариун цэврийг дээд зэргээр сахиж чадах, амьжиргааны боломжтой орлоготой 3-5 өрх хамтран нэг сүлжээг бий болгох.
- Сүлжээнд нэгдсэн айл өрхүүд жуулчдад зориулсан тусгай гэрийг гаргаж, шаардлагатай эд материалаар хангана.
- Айл өрх тус бүр ирсэн жуулчдад өөр өөр зан үйлээ сонирхуулна.
- Монгол орны байгаль орчныг эзний ёсоор хайрлан хамгаалах нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр экологийн аялал жуулчлал эрхлэх
- Жуулчид монголын олон ястан угсаатны зан үйлийг аж ахуйтай танилцахын тулд Увс, Хөвсгөл, Баян-Өлгий зэрэг алслагдсан аймгууд руу аялдаг ба энэ нь өртөг өндөртэй байдаг. Тиймээс "Гүн Галуутай"-д олон ястан аймгуудын нөхөрлөлийн сүлжээг бий болгох юм.

Дээрх зорилтод хүрэхийн тулд донор байгууллага, төсөлтэй хамтран ажиллаж, тус аймгийн ястан үндэстний гэрт байрлангаа ахуй амьдралтай танилцан суралцах бүрэн боломжтой хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Мөн нөхөрлөлийн сүлжээг бий болгоно. Үүнд:

1. Казак үндэстэний нөхөрлөл
2. Халх үндэстэний нөхөрлөл
3. Дөрвөд ястны нөхөрлөл
4. Баяд ястны нөхөрлөл

Нөхөрлөл тус бүр 3-5 гэртэй, ястан бүрийн онцлогийг харуулсан өдөр тутмын амьдралын хэв маягийг жуулчдад таниулна.

Хүснэгт 4.3. *"Амьдар сур" Сургалтын хөтөлбөр*

| Сургалтын нэр | Хугацаа\ Өдөр | Үнэ ($) |
|---|---|---|
| Дээл урлаж сурах | 6 | 250 |
| Монгол хэл сурах (Халх, дөрвөд, Баяд, Хотон) | 7 | 119 |
| Цагаан идээ хийж сурах | 5 | 206 |
| Үндэсний хөгжмөөр хөгжимдөж сурах | 6 | 116 |
| Нум сум  харвах, шагайгаар наадаж сурах | 3 | 65 |
| Үнээ сааж сурах | 3 | 70 |

Жуулчид дээрх сургалтуудын аль нэгийг нь болон холимог байдлаар сонгож сурч болно. 2007 оны байдлаар 60 орчим айл өрх энд амьдарч байна. Энэ бүсэд нутаглаж буй айлууд олноор ирж нутаглах, эсвэл өөр газраас зөвхөн мал авчирч бэлчээрлүүлэх болов. Иргэдийн амьдралд аялал жуулчлал эерэг нөлөө үзүүлж байгаа нь тэднийг Гүн Галуутай руу ирж нутаглах сонирхолыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ энэхүү нөхөрлөлд нэгдэх айл өрхүүд олон байх болно гэж найдаж байна.

**Жуулчдын сэтгэлд нийцсэн чанартай үйлчилгээг үзүүлэхийн тулд чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх шаардлагатай.** Үүний тулд дараах  хэлбэрийн сургалтыг явуулж болно (Хүснэгт 4.4).

Хүснэгт 4.4. *Орон нутгийн иргэдийг чадавхижуулах сургалтын хэлбэр*

| | Сургалтын нэр | Хугацаа өдөр | Сургалтыг удирдах мэргэжилтэн | Сургалтанд оролцогчид |
|---|---|---|---|---|
| 1 | Үйлчилгээний соёл | 2 | Аялал жуулчлалын мэргэжилтэн | Нутгийн иргэд |
| 2 | Жуулчдын зан төлөв | 2 | Аялал жуулчлалын мэргэжилтэн | Нутгийн иргэд |
| 3 | Анхны тусламж үзүүлэх сургалт | 2 | Орон нутгийн эмч | Нутгийн иргэд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | Жуулчдын аюулгүй байдлыг хангах | 2 | Аялал жуулчлалын мэргэжилтэн | Нутгийн иргэд |
| 5 | Жуулчдын эрүүл ахуй, ариун цэврийн хангамж | 2 | Аялал жуулчлалын мэргэжилтэн | Нутгийн иргэд |
| 6 | Үйлчилгээний болон анхан шатны англи хэлний мэдлэг олгох | 2 | Аялал жуулчлалын мэргэжилтэн | Нутгийн иргэд |
| 7 | Дадлага | 2 | | |

Сургалт судалгаа, Мэдээллийн төв. "Гүн Галуутай" БНГ-ы 2003 оноос орон нутгийн тусгай хамгаалалтанд аван, хамгаалалтын үйл ажиллагаагаа эхэлсэн. Тэр цагаас хойш дотоодын болон олон улсын судлаачдын анхаарлыг багагүй татдаг болов. Үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлж, хамгаалалтаа сайжруулж байгаа учраас уг бүс нутгийг улсын тусгай хамгаалалтанд авах талаар сүүлийн үед яригдаж байна. Эхний жилүүдэд БНГ-н хамгаалалтанд шаардлагатай боловсон хүчнийг орон нутгийн иргэдээс авч, тодорхой хэмжээний сургалтанд хамруулж байсан. Жил бүр үйл ажиллагаа улам өргөжүүлэхийн зэрэгцээ ажлын байрыг олноор бий болгож байгаа юм.

Мэдээллийн төв нь:

"Талын нүүдэлчид" жуулчны баазад сансрын VSAT төхөөрөмж суурилуулж, жуулчид, эрдэмтэн судлаачдад интернет болон телефоноор төлбөртэй үйл үйлчилгээг үзүүлнэ.

Гүн Галуутай-д хийгдсэн бүх судалгааны тайлан мэдээллийг цахим хэлбэрээр архивлан хадгална. Гүн Галуутай-д сүүлийн хоёр жилд хийгдсэн судалгааны материалд тулгуурлан эрдэм шинжилгээний тохимолыг хэвлүүлэх. ШУ-ы Биологийн Хүрээлэн болон, Эрдэм шинжилгээний байгууллагуудын холбогдох эрдэмтэн судлаачдыг Гүн Галуутайд урин авчирч, ойрны жилүүдэд хийх шаардлагатай судалгааны талаар санал солилцох уулзалт зохион байгуулах. Монгол Улсын Их Сургууль, Хөдөө Аж Ахуйн Их Сургуулиудтай эхний ээлжинд гэрээ хийж Биологийн ухааны чиглэлээр сурч буй шилдэг оюутан залуустай хамтран ажиллаж, судалгааны ажлуудыг хийлгүүлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах гол төв нь болох юм.



# V

## ТХГН-Т АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХӨГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА ХУУЛЬ ЭРХЗҮЙН АСУУДЛУУД

**АГУУЛГА:**

- ТХГН-д аялал жуулчлал эрхлэх хууль эрхзүйн үндэслэл, бодлогын баримт бичгүүд
- Аялал жуулчлалын менежментийн багийг бий болгох ба хөгжлийн стратеги зарчмуудыг тодорхойлох нь
- ТХГН-ийн санхүүжилтийн механизм, эдийн засгийн тогтолцоо
- ТХГН-д аялал жуулчлалаас үзүүлэх нөлөөллийг үнэлэх, мониторинг хийх аргазүй

## V.1. ТХГН-Д АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ЭРХЛЭХ ХУУЛЬ ЭРХЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

Монгол Улсад 1994 онд "Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай", 1997 онд "Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай" хуулиуд батлагдаж, 1995 онд дархан цаазат, байгалийн цогцолборт газрын нийтлэг болон тусгай гормг Засгийн газраас, 1998 онд "Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр"-ийг Улсын Их Хурлаас тус тус батлан мөрдүүлснээр тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх эрх зүйн үндэс бүхэлдээ бүрдсэн юм. Түүнчлэн төрийн бодлого, хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэх хүрээнд 30 орчим дүрэм, журам, зааврыг боловсруулан эрх бүхий байгууллагуудаар батлуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар ТХГН-т мөрдөгдөж буй дараах баримт бичгүүд байна (Хүснэгт 5.1).

Хүснэгт 5.1 *ТХГН-т мөрдөгдөж буй хууль эрх зүйн баримт бичгүүд*

| | Нэрс | Гарсан он |
|---|---|---|
| | 1.Монгол улсын хууль | |
| 1 | Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай | 1994 |
| 2 | Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай | 1997 |
| | 2. Улсын Их Хурлын тогтоол | |
| 3 | Тусгай хамгаалалттай газар нутгийн Үндэсний хөтөлбөр батлах тухай | 1998 оны 29 тоот |
| 4 | Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн батлах тухай | 1995 оны 26 тоот |
| 5 | Зарим нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай | 2004 оны 22 тоот |
| | 3. Засгийн газрын тогтоол | |
| 6 | Хилийн заагийг тогтоох тухай | 1997 оны 162 тоот |
| 7 | Норматив батлах тухай | 1997 оны 14 тоот |
| 8 | Дархан цаазат болон Байгалийн цогцолборт газрын горим батлах тухай | 1995 оны 169 |
| | 4. Байгаль орчны сайдын тушаал /журмууд/ | |
| 9 | УТХГН-т чоны тоог зохицуулж, зэрлэгшсэн нохой устгахад мөрдөх | 1995 оны 18 тоот |
| 10 | ТХГН-т нэвтрэн амарч зугаалах болон бусад төрлийн үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд тухайн газрын хамгаалалтын асуудал хариуцсан байгууллагаас үйлчлэхэд мөрдөх | 1995 оны 94 тоот |

| | | |
|---|---|---|
| 11 | Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт Газар ашиглуулах зөвшөөрөл олгох түр журам | 2001 он |
| 12 | Улсын тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа шинжилгээний ажил явуулах | 1996 оны 39 тоот |
| 13 | Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал явуулах журам | 2002 оны 117 тоот |
| 14 | Тусгай хамгаалалттай газар нутагт сүргийн бүтэц зохицуулах, судалгаа шинжилгээний зориулалттай дээж сорьц авах зорилгоор ан амьтан агнах, барих | 1996 оны 209 тоот |
| 15 | Тусгай хамгаалалттай газар нутагт орчны бүсийн зөвлөл байгуулж ажиллуулах журам | 1998 оны 159 тоот |
| 16 | Нийтлэг журам батлах тухай | 1998 оны 112 тоот |
| 17 | Тусгай хамгаалалттай газар нутагт рашаан ашиглах | 2000 оны 21 тоот |
| 18 | Улсын тусгай хамгаалалттай газар нутагт, газар ашглах тухай зөвшөөрөл олгох | 2000 оны 13 тоот |
| 19 | Газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай | 2000 оны 7 тоот |
| 20 | Байгаль хамгаалагчдад мэргэжил олгох түр сургалт явуулах | 2000 оны 37 тоот |
| 21 | ТХГН-ийн хамгаалалтын захиргаадын өөрийн үйл ажиллагааны орлогыг захиран зарцуулах журам | 2002 оны 47 тоот |
| 23. | ТХГН-т зориулалт өөрчлөн үйл ажиллагаа явуулсаны улмаас учруулсан хохирлыг тооцох экологи-эдийн засгийн үнэлгээний аргачлал | 2010 оны А-333 тоот |

Монгол улсын "Тусгай Хамгаалалттай газар нутгийн тухай" 1994 оны хуулинд улсын тусгай хамгаалалттай 4 төрлийн газар нутагт аялал жуулчлалыг зохион байгуулах талаар тодорхой заасан байдаг. Тусгай хамгаалалттай газрын дотор болон гадна аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахыг "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн заалтуудаар зохицуулах ба шинэ төслийг шалгаруулах үйл явцыг тодорхойлж шаардлагатай нөхцөлд байгаль хамгааллын төлөвлөгөөний агуулгыг тогтооно. Өнөөдрийн байдлаар уул уурхай зэрэг бусад салбаруудтай харьцуулахад аялал жуулчлалаас байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийн хэмжээ, үр дагаврууд харьцангуй бага байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хөгжлийн зорилтыг Монгол улсын хөгжлийн бодлогын бичиг баримтад дараах байдлаар томьёолон тусгажээ. Тухайлбал, Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол

Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого"-ын 6 тэргүүлэх чиглэлд дараах заалтуудыг оруулсан байдаг. Үүнд:

- "Экосистемийн тэнцвэрт байдлын алдагдлыг зогсоох, ***хамгаалан ашиглах*** замаар хөгжлийн тогтвортой орчин бий болгох",
- Улсын төсвийн бодлого нь санхүүгийн эх үүсвэрийг хөгжлийн тэргүүлэх чиглэлд оновчтой хуваарилах замаар нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр тусгасан бөгөөд орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн эрх хэмжээг нэмэгдүүлж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгон улсын болон орон нутгийн төсвийн бодит төлөвлөлтийн уялдаа холбоог сайжруулна;
- Экспортын баримжаатай үйлчилгээ, аялал жуулчлалын салбар, "брэнд" бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг татварын бодлогоор дэмжих, ***онцгой албан татварын нэр төрлийг нэмэгдүүлэх замаар зохисгүй хэрэглээг хязгаарлаж***, байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйлдвэрлэл, үйлчилгээнд ***экологийн татвар*** ногдуулах замаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх нь зүйтэй;
- Мөн бүсийн тулгуур төвүүдийн хөгжлийг татварын бодлогоор оновчтой дэмжихээр тусгасан байна. Аялал жуулчлалын томоохон цогцолборуудыг барьж байгуулан, аялагч, ***жуулчдын сонирхлыг татсан аялалын төрлүүдийг*** бүс нутгаар төрөлжүүлэн хөгжүүлж, улирлын хамаарлыг багасгаж, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулах нь аялал жуулчлалын хөгжлийн нэг гол стратеги,



- Бүс (Баруун, Хангайн, Төв, Зүүн, Улаанбаатар)-ийн тулгуур төв болох Ховд, Улиастай, Эрдэнэт, Хархорин, Дархан, Зуун мод, Өндөрхаан, Чойбалсан хотуудын болон аймаг, бичил бүсийн хөгжлийн хөтөлбөрүүд, суурин газруудын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах үйл явцад байгалийн экосистемийг оновчтой хамгаалах, аялал жуулчлалыг тухайн бүс нутагт хөгжүүлэх талаар болон тухайн нутаг дэвсгэрт байгаа ТХГН-ийн баялгийг оновчтой, бүхий л ***оролцогчдод хүртээмжтэй ашиглах нөхцлийг бүрдүүлэхэд*** холбогдох эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой тусгаж өгөх арга хэмжээ авах нь зүйтэй;
- Газар, газрын хэвлийн баялгийг зохистой ашиглах нэгдсэн бодлого хэрэгжүүлэх стратегийн зорилтын хүрээнд хууль хэрэгжүүлэх эдийн засгийн арга хэрэгсэл, хөшүүргийг нэвтрүүлж, ***өөрийгөө санхүүжүүлэх санхүүгийн механизмыг*** бий болгох замаар байгалийн нөөцийн менежментийг үндэсний болон орон нутгийн хэмжээнд сайжруулж, салбар хоорондын зохицуулалтыг боловсронгуй болгох, мөн Монгол үндэстний үеийн үед онцлон хайрлаж, онгон байдлаар нь хадгалан үлдээх газар нутгийн өвийн санг буй болгож, хамгаалалтад авах, ТХГН-ийн талаар баримтлах төрийн бодлого, менежментийг боловсронгуй болгох, түүний сүлжээг өргөжүүлэн ***удирдлагын тогтолцооны оновчтой бүтцийг бий болгож, орчин үеийн шаардлага хангасан хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэх*** нь зүйтэй.





Монгол Улсын Их Хурлын 2009 оны 38 дугаар тогтоолоор баталсан "Хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 82-д

- "Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө, хамгаалалтын менежмент, дотоод бүсчлэл зэрэг ойлголтуудыг шинээр томъёолж, үүнтэй уялдуулж хуулийн зорилтыг тодорхой болгох, байгалийн нөөц, дурсгалт газруудын статусыг дээшлүүлэн улсын төсвөөс санхүүжүүлэх тогтолцоонд шилжүүлэх, тусгай хамгаалалттай газар нутагт гарч буй зөрчлийг мэдээлсэн иргэдийг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх" чиглэлээр Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- Мөн Монгол Улсын Их Хурлын 2008 оны 36 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т Байгаль орчны тэнцвэрт харьцааг хангах талаар экосистемийн тэнцвэрт байдлыг хангахуйц байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх цогц бодлогыг хэрэгжүүлэн хөгжлийн тогтвортой орчныг бий болгох, түүнд түшиглэсэн аялал жуулчлалын цогц бодлого хэрэгжүүлэх;
- Улсын Их Хурлын 1998 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр"-ийн 6.2.2-т "Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2 дахь үе шат буюу 2005-2015 онд тусгай хамгаалалттай газар нутгийн чиглэлээр гарсан хууль тогтоомжийг тухайн үеийн нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн төгөлдөржүүлж, байгаль орчны чадавхийг дээшлүүлэх менежментийн арга хэрэгсэл болгон шинэчилнэ" гэж тус тус тодорхойлжээ.

Дээр дурдсан бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн таатай орчин бүрдүүлэх зорилгоор Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд дараах зарчмын шинжтэй өөрчлөлтүүдийг тусган УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн бариад байна.

1/ Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө, хамгаалалтын дэглэм, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ, **коридор газар нутаг (*Зурвас газар нутаг*)** гэсэн ойлголтуудыг шинээр тайлбарлан оруулсан.

2/ Тусгай хамгаалалттай газар нутагт гарсан зөрчлийн талаар бодитой мэдээлэл өгсөн иргэдэд урамшуулал олгохтой холбогдсон харилцаа;

3/ Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасны дагуу, тусгай хамгаалалттай нутгийн хамгаалалтын

менежментийн тодорхой хэсгийг төрийн бус байгууллагад тодорхой нөхцөл, болзолтойгоор гэрээний үндсэн дээр хариуцуулах, хийгээд тухайн нутагт байнга оршин амьдарч буй иргэдийн эрх, үүрэг;

4/ Дархан болон байгалийн цогцолборт газруудын хязгаарлалтын бүсэд хуулиар тогтоосон хамгаалалтын зарим дэглэмийг бүс нутгийн онцлогтой уялдуулан оновчтой хэрэгжүүлэх, мөн орон нутаг, хамгаалалтын захиргааны эрх үүргийг өргөжүүлж, хариуцлагыг нь өндөржүүлэх, төрийн захиргааны төв болон хамгаалалтын захиргааны хүлээх үүрэг, хариуцлага;

5/ Улсын нөөц болон дурсгалт газруудын хамгаалалтыг хамгаалалтын бие даасан захиргаадад хариуцуулахаар;

6/ Хамгаалалтын горим, дэглэмийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх торгуулийн хэмжээг нэмэгдүүлж, эрхээ хэтрүүлж зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцож байхаар тус тус тодорхой болгон тусгасан байна.



Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар:

- Төрийн хамгаалалтаар дархалсан газар нутгийн ашиглалт, хамгаалалтад оролцоо бүхий субьектүүдийн эрх үүрэг, ажлын уялдаа холбоо тодорхой болно.
- Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, нутгийн иргэд, орон нутгийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, зохион байгуулалт сайжирч, хамгаалалтын менежментээ бие даан хэрэгжүүлэх санхүүгийн нөөц, чадавхи нэмэгдэх боломж бүрдэнэ.
- Байгалийн нөөц болон дурсгалт газруудын хамгаалалтыг хамгаалалтын бие даасан захиргаадад хариуцуулснаар тухайн газар нутгуудын хамгаалалт хэрэгжих юм.

## V.2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЕНЕЖМЕНТИЙН БАГИЙГ БИЙ БОЛГОХ БА ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ЗАРЧМУУДЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

"Монгол Улсын ТХГН-ийн Үндэсний хөтөлбөр"-ийн 3.7, 3.11, 4.5.1 дэх заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор 2009 онд "Тусгай хамгаалалттай газар нутгуудад Аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг БОАЖСайд баталсан.

Хүснэгт 5.2. *ТХГН-т явагдах аялал жуулчлалыг хөгжүүлэхэд баримтлах бодлогын үндсэн чиглэл*

| | |
|---|---|
| 1. ТХГН-т аялал жуулчлалыг экосистемийн нөөц, даацад нийцүүлэн, тогтвортой хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх; | 2. Байгаль хамгаалах нэгдмэл зорилгын доvр ТХГН-т явагдах аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг хангах бодлогыг боловсруулах, түүнчлэн шийдвэр гаргах, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд холбогдох талуудын оролцоог дэмжих; |
| 3. ТХГН бүр менежментийн төлөвлөгөөндөө тухайн нутгийн байгалийн нөөц, нутгийн иргэдийн нийгэм, соёлын онцлог, жуулчдын эрэлт хэрэгцээг харгалзан аялал жуулчлалын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх; | 4. Аялал жуулчлалын үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх аливаа нөлөөллийг тогтмол хянан үнэлж, сөрөг нөлөөг бууруулах шаардлагатай арга замуудыг тодорхойлон хэрэгжүүлэх; |
| 5. ТХГН-ийн удирдлага, зохион байгуулалт, хамтын ажиллагааны төрөл бүрийн хэлбэрүүдийг (ТББ, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгжийн хамгаалж буй газар г.м) дэмжих; | 6. Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн ач холбогдлын талаарх олон нийтийн ойлголт, ухамсар, мэдлэгийг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулах; |
| 7. ТХГН-т үйл ажиллагаа явуулах жуулчны үйлчилгээний байгууллагуудын байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг холбогдох талуудын оролцоотойгоор хэлэлцүүлдэг байх; | 8. ТХГН-т үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, ТББ, аж ахуйн нэгж, иргэдийн нөхөрлөл нь «ашиглагч нь төлөх» зарчимд тулгуурлан тухайн нутгийн байгаль орчинд хохирол учруулсан тохиолдолд хариуцлага хүлээдэг байх; |

"Тусгай хамгаалалттай газар нутгуудад Аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 5 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны 3 дугаар сарын 31-ны өдрийн А-84 дугаар тушаалаар, Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах, оролцогч талуудын төлөөлөл бүхий Үндэсний зөвлөлийг байгуулсан бөгөөд "Үндэсний зөвлөлийн дүрэм"-ийг 2010 оны 11 дүгээр сарын 19-ны өдөр БОАЖСайд баталсан. Энэхүү Үндэсний зөвлөлийн зорилго нь: Монгол Улсын Тусгай Хамгаалалттай Газар Нутгуудад (ТХГН) явагдаж буй аялал жуулчлалыг тухайн нутгийн экосистемийн нөөц, даацад тулгуурлан, байгаль, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнийг алдагдуулахгүйгээр тогтвортойгоор хөгжүүлэх, байгаль хамгаалах нэгдмэл зорилгын дор бодлого боловсруулах, шийдвэр, үйл ажиллагаа төлөвлөх, хэрэгжүүлэхэд холбогдох талуудын оролцоог



хангахад оршино. Үндэсний зөвлөл нь УТХГН дахь аялал жуулчлалын сөрөг нөлөөллийг бууруулж, тогтвортой хөгжүүлэх, аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах, бодлого, зохицуулалтын асуудлаар мэргэжлийн санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус байгууллага юм.

**Үндэсний зөвлөлийн дарга**

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалтай нутгийн удирдлагын газрын дарга

**Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга**

БОАЖЯ-ны ТХНУГ-ын Аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн

**Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн**

/Холбогдох яам, агентлаг, эрдэм шинжилгээ болон мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллага зохих албан тушаалтан/

**Үндэсний зөвлөлийн орлогч дарга**

/Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын газрын дарга/

**Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга**

ТХГ-ын Хамгаалалтын захиргаадын дэргэд орон тооны бус салбар зөвлөлтэй байна

**Сүхбаатар:**

Зураг 5.1. *Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, зохион байгуулалт*

Хүснэгт 5.3. *Үндэсний зөвлөлийн эрх, үүрэг*

| | Үндэсний зөвлөл дараахь үүрэгтэй байна | Үндэсний зөвлөл дараахь эрхтэй байна |
|---|---|---|
| 1 | УТХГН-т баримтлах аялал жуулчлалын бодлогыг тодорхойлох, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгоход санал гаргах; | Хамтын оролцоотой менежментийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө, дундын санг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих асуудлыг зохицуулах; |
| 2 | УТХГН-ийн аялал жуулчлалын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад санал, зөвлөмж өгөх; | ТХГН-т аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага нь холбогдох стандарт, дүрэм журмыг зөрчсөн тохиолдолд эрхийг хүчингүй болгох, зогсоох санал, дүгнэлтээ гаргах; |
| 3 | УТХГН-т явагдаж буй аялал жуулчлалын үйл ажиллагаатай холбогдож үүссэн зөрчил, маргааны үед мэргэжлийн арга зүйгээр хангаж, дүгнэлт, зөвлөмж гаргах; | Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх, үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас шаардлагатай мэдээлэл, тайлан, судалгаа, баримт материалыг үнэ төлбөргүйгээр гаргуулан авах. |
| 4 | УТХГН-т аялал жуулчлалыг хөгжүүлэх, түүний үйл ажиллагааг зохицуулах асуудлаар салбар зөвлөлийн ажилд арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах; | Тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулж буй байгууллага аж ахуйн нэгж, иргэдийн аялал жуулчлалын талаархи мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сургалт, сурталчилгаа зохион байгуулах. |
| 5 | Салбар зөвлөлийн тайланг хэлэлцэх | Санал, дүгнэлт гаргахад шаардлагатай судалгаа шинжилгээ хийх |
| 6 | УТХГН-т явагдаж буй аялал жуулчлалын үйл ажиллагаатай холбогдолтой тулгамдсан асуудлыг тодорхойлж, талуудын оролцоотой шийдвэрлэх, сайдад зөвлөгөө өгөх, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | |
| 7 | УТХГН-т явагдаж буй аялал жуулчлалын хамтын оролцоотой менежментийн үйл явцад талуудын тэгш эрхтэй, харилцан ашигтай оролцох нөхцлийг бүрдүүлэх; | |

Хүснэгт 5.4. *Салбар зөвлөлийн эрх, үүрэг*

| Салбар зөвлөл дараахь үүрэгтэй байна | Салбар зөвлөл дараахь эрхтэй байна |
|---|---|
| 1. Тухайн салбар, орон нутгийн хэмжээнд УТХГН-т баримтлах аялал жуулчлалын бодлогыг тодорхойлох, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгоход санал гаргах; | Салбар зөвлөл нь Үндэсний зөвлөлийн адил заасан эрхийг хэрэгжүүлнэ. |
| 2. УТХГН-ийн аялал жуулчлалын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад санал, зөвлөмж өгөх; энэ дүрмийн 4.1, 4.2-д заасан үүргийг хэрэгжүүлэх; | |
| 3. Тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлалын үйл ажиллагаатай холбогдож үүссэн зөрчил, маргааныг шийдвэрлэхэд мэргэжлийн зөвлөмж, дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд Үндэсний зөвлөлд мэдэгдэх. | |




Зураг 5.2. *Аялал жуулчлал хөгжил ба хамтын ажиллагаа*



## V.3. ТХГН-ЫН САНХҮҮЖИЛТИЙН МЕХАНИЗМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТОЛЦОО

Санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, төсөв зардлыг төлөвлөх үйл ажиллагааг БОАЖЯ-ны Тогвортой хөгжил, стратегийн төлөвлөлтийн газрын санхүүгийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн хамгаалалтын захиргаадын нягтлангуудаас төсвийн саналыг нэгтгэн, ТХНУГ-ын саналыг тусган Сангийн яаманд БОАЖЯ-ны төсөвтэй нэгтгэн хүргүүлдэг. Сангийн яаманд Байгаль орчны салбарыг хариуцсан Төсвийн бодлого, зохицуулалтын газрын 1 мэргэжилтэн төсвийг хүлээн авч улсын төсвийн орлого, зарцуулалтын баланс, улсын эдийн засгийн байдал зэргээс хамаарч зарцуулалтыг төлөвлөдөг. Сангийн яамны орлогын хэлтсийн мэргэжилтэн ТХГН-ийн урьд оны орлогын гүйцэтгэлийг харгалзан ТХГН-уудад олох өөрийн орлогын төлөвлөгөөг баталдаг байна.

***ТХГН-ийн хамгаалалтын менежментийг сайжруулах талаар хууль тогтоомжид заасан санхүүгийн механизмууд, ТХГН-ийн орлогын одоогийн эх үүсвэрүүд.*** Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6-р зүйлд ТХГН-ийг хамгаалах ажлын төсөв нь байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг нөхөн сэргээх, газрыг засаж тохижуулах арга хэмжээг хэрэгжүүлэх, судалгаа, шинжилгээ хийх, сурталчлах, ажиллагсдын цалин хөлснөөс бүрдэхээр заасан бөгөөд санхүүжүүлэх хөрөнгө нь:

1/ Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

2/ Аялал, жуулчлалын болон бусад ажил үйлчилгээний орлого

3/ Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив тусламж

4/ "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого"-оос тус тус бүрдэхээр заасан байна.

10. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6.2.2, 11, 15, 16, 27.7 дахь заалтуудыг үндэслэн Байгаль орчны сайдын 2002 оны 6 дугаар 1-ний өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 117 дугаар тушаалаар ТХГН-т аялал жуулчлал явуулах журам, нэг удаагийн хөлс төлөх тасалбарын загвар, хөлсний хэмжээг тус тус баталсан байна. Тушаал нь Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээнд аялал жуулчлалын үйл ажиллагаа хамаарагддаггүй байхад ТХГН-т нэг удаагийн ажил үйлчилгээний хөлсийг авч тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын үйл ажиллагааг дэмжих зорилготой

батлагдсан. Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн 80 гаруй хувь нь ТХГН-т үйл ажиллагаа явуулж байна. Гэтэл аялал жуулчлалаас үзүүлж байгаа сөрөг нөлөөлөл ихэсч зарим газарт хог хаягдал, бохирдол ихэсч, биологийн төрөл зүйлийн амьдрах орчныг доройтуулснаас тэдгээрийн тоо толгойг бууруулах, экосистемийн тогтвортой байдалд нөлөөлсөөр байна.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуулиар зөвшөөрдөггүйгээс ТХГН-ийн хамгаалалтын захиргаад өөрсдөө аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх боломжгүй, аялал жуулчлалын үйлчилгээнээс олох орлого нь нэг удаагийн ажил үйлчилгээний орлогоор хязгаарлагддаг байна. Энэ хөлсийг олон улсад хэлж заншсаны дагуу ТХГН-т нэвтрэх хураамж болгож ***Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулинд өөрчлөлт оруулж нэр томъёог өөрчлөх*** шаардлагатай. Дээрх журам нь Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 14.1.4-т хуульд зааснаас бусад тохиолдолд төлбөр, хураамж авах зэргээр аливаа хэлбэрээр орлого олохыг хориглохоор заасныг зөрчиж байгаа тул холбогдох хуулинд зохих нэмэлт, өөрчлөлтийг оруулсны дараа уг журмуудыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд эрх хэмжээнийхээ хүрээнд дахин шинэчлэн батлах нь зүйтэй юм. Одоогийн хуулийн хүрээнд ТХГН-т орлого олж байгаа дээрх эх үүсвэрүүдийн хууль эрх зүйн зохицуулалт хэт ерөнхий, ТХГН-ийн санхүүжилтэд хэрхэн зарцуулах, хуваарилах талаар зохицуулсан журам байхгүй байна. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу тусгай санг хуулиар байгуулдаг. Уг хуульд тодорхойлсон нийт 23 төрлийн тусгай сангаас тус салбарт "Байгаль орчны сан", "Аялал жуулчлалын сан" байхаар заасан. Өөрөөр хэлбэл хуулийн 6-р зүйлд





"Байгаль хамгаалах сан"-гийн зонхилох хэсгийг улсын төсвийн хөрөнгөөр бусад хэсгийг хандив тусламж, донор орны зээлийн хөрөнгө, түүнчлэн ТХГН-т **байгалийн аялал, жуулчлал эрхлэх эрхийн бичиг олгосны хураамж**, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээ байхаар тус тус заажээ.

***ТХГН-ийн эдийн засгийн үр ашгийн хэлбэрүүд.*** ТХГН-тай холбоотой дараахь гурван чиглэлийн эдийн засгийн үр ашгийг тодорхойлсон байна. Үүнд:

1. **Зочдын зарцуулалт** - Байгальтай холбоотой зарцуулж байгаа жуулчид, зочдын зарлага нь экспортын чиглэлийн асар их нөөц бололцоог бий болгох боломжтой юм. Ийнхүү Засгийн газраас ТХГН-т зарцуулж байгаа зардал нь эдийн засагт хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хөшүүрэг болж өгдөг.
2. **Ажлын байрыг нэмэгдүүлэх** - ТХГН нь өөрөө төрөл бүрийн чадавхи бүхий ажлын байрыг бий болгож байна. Байгаль хамгаалагчид, судлаачид, хамгаалалтын захиргааны мэргэжилтэн, аялал жуулчлалын салбарын ажилтнууд гэх мэт. Нийт ТХГН-ийн бий болгож байгаа ажлын байр нь тухайн хамгаалалтын захиргаанд ажиллаж байгаа хүмүүсээс гадна тухайн орчинд ажиллаж байгаа аялал жуулчлалын баазын ажилтнууд түүнд зуучлах үүрэг гүйцэтгэж байгаа тур операторууд ч хамаатай.
3. **Засгийн газрын зарцуулалт, татварын орлого нэмэгдүүлэх үр ашигтай** –Засгийн газраас ТХГН-т оруулж байгаа хөрөнгө оруулалт нь эдийн засагт ихээхэн үр нөлөө үзүүлэх бөгөөд эргээд Засгийн газрын татварын орлогыг нэмэгдүүлэх болно. Засгийн газраас зарцуулж байгаа зардал тутмын үр ашгийг тооцох, ТХГН-ийн эдийн засгийн үр ашгийг мөнгөн хэлбэрээр илэрхийлэх боломжийг олгоно. Ийнхүү ТХГН нь бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих нөхцлийг бүрдүүлдэг. Ихэнх эдийн засгийн үр ашиг нь тухайн орон нутгийн хүмүүст үлдэх талд хууль эрх зүйн зохицуулалт манай орны хувьд хангалтгүй байна. Үүнд орлогын хуваарилалт, төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн зарчим нөлөөлж байна.

***ТХГН-ийн санхүүгийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх механизмууд.*** ТХГН-аас үзүүлж байгаа бүтээгдэхүүн үйлчилгээ нь бүхэлдээ хүнсний хангамжийн, экосистемийн зохицуулалтын болон соёлын үйлчилгээний

үүрэгтэй. Одоо хэрэгжиж байгаа хууль, хөтөлбөр, бодлого, журмыг гол төлөв улсын төсөв, хандивлагч орны хөрөнгөөр санхүүжүүлж байна. ТХГН-ийн үр ашгийг хэрхэн тэгш хуваарилж байгаад дүн шинжилгээ хийх, иргэдэд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлсноор санхүүгийн механизм нь нийгмийн хувьд хир хүлээн зөвшөөрөгдсөн болохыг илэрхийлнэ.

***Санхүүгийн тогтвортой байдлыг хангах шалгуур үзүүлэлт:***

- Урт хугацаатай
- Олон төрлийн санхүүжилтийн механизмууд болон хөрөнгө оруулагчид байх
- ТХГН нь санхүүгийн хувьд бие даах
- Үр ашгийг тэгш зарчмаар хуваарилах нийгэм эдийн засгийн зорилтыг хангасан байх шаардлагатай.

Санхүүгийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх санхүүгийн механизмуудыг түүний санхүүжилтийн эх үүсвэрээс хамааран 3 бүлэгт хуваан ангилж болно.

1. **Гадаад эх үүсвэрүүд** түүний дотор Засгийн газрын болон донор орнуудын төсөв, олон улсын болон дотоодын ТББ-ын тусламж, хувийн болон сайн дурын хандив тусламжийг татах болон удирдахад зориулагдсан санхүүгийн механизм
2. **Хамгаалалтад зориулах сан:** ТХГН-ийн газар нутаг, байгалийн нөөц, барилга байгууламжуудыг зохицуулах хувийн болон олон нийтийн удирдлага зохицуулалт, өртөг хуваах болон үр ашгийг хуваах, хөрөнгө оруулалт болон компани, байгууллагын сан. Санхүүгийн хэрэгсэл нь ТХГН-ийг ашиглаж түүнд нөлөө үзүүлж байгаа бүлэг этгээдүүдийг байгаль хамгаалахад зориулж санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх хамгийн гол эх үүсвэр болно.
3. **Үйлчилгээний төлбөр:** ТХГН-ийн бараа үйлчилгээг ашигласны төлөө зах зээлийн төлбөр болох экосистемийн үйлчилгээний төлбөр, аялал жуулчлалын хураамж, нөөц ашигласны төлөөс зэргийг ашигласнаар ТХГН-ийн үр шимийг хүртсний төлөө төлөхөд бэлэн байгаа боломжийг бүрэн хамруулахыг зорьж байна.

***Үр ашиг, орлогын хуваарилалт.*** 1980 оноос орон нутгийн иргэдийг ТХГН-ийн тэр дундаа биологийн төрөл зүйлийг хамгаалахад татан оролцуулж хамгаалах хандлага гарч эхэлсэн. Нутгийн иргэдэд түшиглэсэн хамтарсан хандлага нь дэлхийн улс орнуудад ихээр ашиглагдаж байна. Ихэнх ТХГН-ийн санхүүжилтийн стратегиуд нь түүний хажууд байгаа нутгийн



иргэдэд үр ашгийг хүртээх, орлогыг бүрдүүлэх, зарцуулах сангийн механизмыг хамруулаад байна. ТХГН-ийн дотор болон ойр орчимд амьдрах иргэдийн нөхөрлөлд зориулсан санг бий болгон ашиглахад төрөл бүрийн санхүүгийн механизмуудыг ашиглаж байна. Нутгийн иргэдийн санхүүгийн механизмууд нь янз бүрийн зорилготой байна. Тухайлбал, биологийн төрөл зүйлд сөрөг нөлөөлөхүйц үйл ажиллагааг хориглох, өөрчлөхөд чиглэсэн амьдралын хэв шинжийг бүрдүүлэхэд хөрөнгө оруулах сан гэх мэт. Зарим тохиолдолд, ТХГН-ийн менежментийг түүний ойр амьдрах иргэдэд шилжүүлэх арга хэмжээг бас авдаг байна. Тухайлбал, Танзаний Серенгэтийн БЦГ-ын ойролцоо амьдардаг иргэдэд биологийн төрөл зүйлийг ашигласны орлогоос хүртээх зорилгоор тэдэнд нөхөн олговор маягаар бус харин хүн ба паркийн харилцан холбооны тухай ойлголтыг сайжруулахад зориулан нийт паркийн орлогын 7,5 хувийг энэ арга хэмжээнд зарцуулдаг. Энэ сан нь тухайн нутгийн дэд бүтцийг бүрдүүлэхэд тухайлбал, сургууль, гүүр, зам барих, эмнэлэг, усан хангамжийн болон жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зардлын 70 хувьд зарцуулагдсан байна. Нутгийн иргэд болон Засгийн газрын хооронд тохиролцон ТХГН-ийн хураамжийн системийг тогтоож, аялал жуулчлалын орлогыг Засгийн газрын тусгай санд хуримтлуулж түүний орлогоос улирал бүр нутгийн иргэдэд ТХГН-ийн менежментэд зориулан өгдөг хувилбар байдаг байна. Энэ маягаар хамтарсан хэлэлцээрийн үр дүнд үр ашиг, орлогын тодорхой хэсгийг орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах харилцааг сайжруулах, биологийн төрөл зүйлийг хамгаалах хөшүүргийг бүрдүүлдэг байна.

Энэ механизм нь нутгийн иргэдийн хувьд шууд бус хөгжлийн үр ашигтай байх боловч биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагаанд зориулсан санхүүгийн шууд нөхөн олговор болж чаддаггүй. Хувийн хэвшлийн санхүүжилт нь Засгийн газрынхыг бодвол илүү оновчтой тодорхой чиглэгдсэн газар нутагт чиглэгдэж тухайн газрын хүмүүст үр ашигийг хуваарилах боломжтой байдаг. Мөн хувийн хэвшлийнхэн илүү оролцооны зарчмаар ажиллаж, зэрлэг амьтдыг хамгаалахад шууд оролцуулдаг байна. Сангийн зориулалт нь орон нутгийн иргэдэд шууд хүрэх боломжийг хангахын зэрэгцээ зөвхөн нийгмийн үр ашиг хүртээгээд зогсохгүй байгаль орчныг хамгаалахад чиглэгдсэн шууд санхүүгийн дэмжлэг байх бүрэн боломжтой. Энэ боломжийг бүрэн ашиглахын тулд байгаль хамгааллын төлөвлөгчид шийдвэр гаргагчидад орон нутгийн иргэдийн санхүүжилт нь ТХГН-ийн санхүүжилтийн нэг хэсэг байх ёстой гэдгийг ойлгуулах шаардлагатай. Тиймээс хамгаалалтын захиргаад ТХГН-ийн биологийн төрөл зүйлийг хамгаалахад шууд болон шууд бус аргаар оролцож байгаа нутгийн иргэдэд тодорхой хугацаанд зохистой хэлбэрээр хангалттай хэмжээний хөрөнгийг бүрдүүлэх шинэ механизмыг боловсруулах шаардлагатай.

***Өртөг хуваарилах.*** Улсын байгууллага ТХГН-ийн менежментийг хариуцах, санхүүжүүлэх, түүний доторхи байгууламжийн үйлчилгээг зохицуулах зөвхөн ганц хувилбар биш юм. Харин ТХГН-ийн менежментийн өртгийг бусад байгууллага, бүлэг, компанитай хуваалцах эсвэл гэрээгээр хариуцуулснаар ихээхэн хэмжээний орлогын эх үүсвэрийг бий болгох боломжтой юм. Өртгийг хувааж байгаа жишээнүүдэд төрийн бус байгууллага сайн дураараа менежментийн үүргийг хүлээн, ТХГН-ийн хамгаалалтын үйл ажиллагааг санхүүжүүлэх





олон тохиолдлуудыг дурьдаж болно. Тухайлбал ТХГН-т бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд, ТХГН-ийн захиргааны өмнөөс наад захын орчуулгын болон мэдээлэл түгээх, хяналт шалгалтын үүргийг ч гүйцэтгэдэг байна. Индонезид, аялал жуулчлалын байгууллагуудаас ТХГН нь мониторинг, сургалт хийх, усан завьны моторoop хангах, байгаль хамгаалагчдад завиар ажиллах цаг хугацааг олгох, хяналт харуул хийх, хайх аврах үйлчилгээ хийх зэргээр мөнгөн бус шууд үйлчилгээг хийлгэж өртгийг хуваадаг байна. Ийм ажиллагаанууд нь хэрвээ хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа бол илүү үр дүнтэй хэрэгжих боломжтой юм.

**Бизнесийн түрээс, гэрээлэх, арга нь** ТХГН-ийн байгууламжуудыг удирдах гадаад эх үүсвэрийг төвлөрүүлэх аргын нэг юм. Жишээ нь ТХГН-ийг бүхлээр нь ТББ-д хариуцуулан гэрээлэх, эсвэл тодорхой нэг үйл ажиллагааг эрхлэх эсвэл ТХГН-ийн тодорхой байгууламжийг, үйлчилгээг өөрөө ашгаараа ажиллуулах гэх мэт. Тухайлбал, Өмнөд Африкийн ТХГН-ийн захиргаа нь хувийн компанид ТХГН дотор аялал жуулчлалын бааз байгуулах удирдан ажиллуулах эрхийг олгож ажиллуулдаг байна. ТХГН-ийн тухай хуулиар ТББ хувь хүмүүс нь ТХГН-ийн менежментийг зохицуулж болох тухай заасан байдаг байна. Жишээлбэл, Хувийн болон ТББ аар ТХГН-ийг хариуцуулсан тохиолдолд аялал жуулчлалын орлого нь гол орлогын эх үүсвэр болох бөгөөд үйл ажиллагааны зардлыг хянаж мөнгөн бус хэлбэрээр гадны тусламжаар гүйцэтгүүлэх, Сайн дурынханаар техникийн туслалцаа, судалгаа шинжилгээ, болосон хүчнийг сургах, мэдээлэлийн болон сургалтын материалыг гаргах, багаж тоног төхөөрөмжийг суурилуулах, зах зээлийн сурталчилгаа хийх, менежментийн болон санхүүгийн дүн шинжилгээ хийлгэх зэрэг үйл ажиллагааг гүйцэтгүүлдэг байна.

Төрөл бүрийн байгаль хамгаалах үйл ажиллагааг олон улсын болон орон нутгийн ТББ-тай хамтран явуулдаг. Судалгаа шинжилгээний ажлыг Их дээд сургуулийн оюутнуудаар гүйцэтгүүлэх, урсгал зардлыг аялал жуулчлалын орлогоос бүрдүүлдэг байна. Байгаль хамгаалагчид нь зөвхөн зөрчлийг илрүүлэхэд анхаараад зогсохгүй тухайн экосистемийн өөрчлөлтийг тэмдэглэж өөрчлөлтийг мэдээлдэг байна. Үүний үр дүнд хулгайн ангийн хэмжээ буурч, нутгийн иргэдийн дэмжлэгийг ихэд авсан байна. Нутгийн иргэдийн экологийн боловсролыг нэмэгдүүлэхэд бас анхаарч хуучин загасчидыг байгаль хамгаалагчаар ажиллуулсан байна. Хамгийн гол

нь тухайн хувийн байгууллагын өөрийн сонирхол, туршлага мэдлэг тууштай санал санаачлага нь ихээр нөлөөлсөн. Мөн бизнесийн зарчмаар ажиллах боловч түүний зорилго нь бизнесийн бус харин биологийн төрөл зүйлийг хамгаалах, ашиг олохын төлөө бус өртөгөө нөхөх зарчим нь хамгийн чухал санхүүгийн зарчим юм. Хөрөнгө оруулалтын зардлыг олон улсын хандив тусламжаар байгуулсан болохоор их орлого олохыг зориогүй байна.

Байгаль хамгаалах хуулинд зарим нэг хөшүүргийг оруулсан нь ийм төрлийн биологийн төрөл зүйлийг хамгаалахад хөрөнгө оруулахад түлхэц болсон. Тухайлбал, Хуулинд хувийн хөрөнгө оруулалтад татварын хөнгөлөлт үзүүлэх, ТХГН-ийг хувийн байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх гэх мэт. Импортын хөнгөлөлт татварын хөнгөлөлтөөс өөр эрх зүйн урамшуулал байхгүй байсан. Энэ төслийн амжилт нь нутгийн иргэдтэй хамтран ажиллахад хөрөнгө төлөвлөж, оролцогч талуудтай зөвшилцөхөд зөвлөгөө авч ажилласан байна. Хуулиар байгаль орчинд халгүй техник технологи ашиглаж байгаа аж ахуйн нэгжийг татварын буюу ТХГН-ийг менежментийн гэрээгээр ашиглах эрхээр шагнах эдийн засгийн урамшууллын системийг тусгах боломжтой.

***Хувийн байгууллагын сан.*** Биологийн төрөл зүйлийн хувийн байгууллагын сангууд нь урт хугацаанд хөрөнгө оруулах санхүүгийн механизм мөн бөгөөд ихэвчлэн биологийн төрөл зүйлийг тогтвортой ашиглах, хамгаалахад үндэслэсэн бизнесийн болон техникийн нөхцөлтэй холбоотой байдаг. Энэ нь биологийн төрөл зүйлийг хамгаалах, тухайлбал, эко аялал жуулчлал эрхлэх, ойн тогтвортой ашиглалт, ойн дагалт баялгийг түүх бэлтгэх, зэрэг жижиг дунд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа гэсэн үг юм. Сүүлийн үед хүмүүсийн байгаль орчин, биологийн төрөл зүйлийг хамгаалахын ач холбогдлын талаархи ойлголт мэдлэг сайжирч байгаагаас биологийн төрөл зүйлийг хамгаалах бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зах зээлийг нэмэгдүүлж байна. Байгалийн гаралтай хүнсний хэрэглээ өсч, тогтвортой ашигласан ой мод, экотуризм нь улам илүү эрэлттэй болсоор байна. Харин жижиг дунд бизнес эрхлэгчдэд энэ төрлийн бизнесийг эрхлэх хөрөнгө санхүүгийн дэмжлэг хязгаарлагдмал байсан. Дэмжлэг нь ихэнхдээ ТББ, сан, тусламжийн байгууллагаас гардаг. Нөгөөтэйгүүр банкны байгууллага ч энэ төрлийн ойлголт муутай байдаг. Ихэнх төслүүд нь шууд хөрөнгө оруулалт хийх хувь маш бага учраас ихэнх сангийн хөрөнгө оруулалт өндөр үр ашигтай салбарт



чиглэгддэг байна. *Ихэнх тохиолдолд энэ санхүүжилтийн механизмыг тогтвортой амьжиргаа, биологийн төрөл зүйлд түшиглэсэн* бизнес, ТХГН-ийн газар зохион байгуулалт, зэрэгт зориулагддаг байна.

Зарим орнууд ТХГН-ийн удирдлага нь хувийн бизнесийн хөрөнгө оруулагч байгууллагатай гэрээ хийх замаар хууль эрх зүйн хувьд зөвшөөрсөн байдаг. Энэ механизм нь ТХГН-ийн менежментэд бизнесийн үйл ажиллагааг нэвтрүүлж байгаа нэг хэлбэр бөгөөд цаашид энэ механизмын тухай ТХГН-ийн байгууллагуудын мэдээллийг сайжруулах, Бизнесийн хөрөнгө оруулалтыг дэмжсэн хууль эрх зүйн орчинг сайжруулах, ТХГН-ийн үүрэг ач холбогдлыг сурталчлан таниулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

***Орлого олох боломж ТХГН-ийн төрлөөс хамаарах нь.*** ТХГН-ийн онцлогоос хамаарч орлого олох төрөл янз бүр байж болно. Тухайлбал:

- Аялал жуулчлал ихээр хөгжсөн газруудад нэвтрэх хураамж, гэрээ, ашиглалтын төлбөрийг нэвтрүүлэх
- Шинээр байгуулагдсан, ялангуяа дэлхийд ач холбогдол бүхий биологийн төрөл зүйлийн орчинтой хамгаалалтын захиргаадын хувьд олон талын болон хоёр талын итгэмжлэгдсэн сан байгуулах замаар үйл ажиллагаагаа эхлүүлэх нь илүү боломжтой.
- Үндэсний түүх дурсгалын үзмэр, соёлын өвд хамрагдах бол бусдаас илүүтэй Засгийн газрын татвараас бүрдэх сан, итгэмжлэгдсэн сан, хамтарсан хандив дэмжлэг авах боломжтой.

***Орлого нэмэгдүүлэх арга хэлбэр.*** Улсын төсвийн орлогыг

аялал, жуулчлалыг дэмжих замаар нэмэгдүүлэх, түүнээс ТХГН-ийн байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг нөхөн сэргээх, газрыг засаж тохижуулах арга хэмжээг хэрэгжүүлэх, мониторингийн аргаар судалгаа, шинжилгээ хийх, ажиллагсадын цалин болон захиргааны зардлыг оновчтой зарцуулах замаар байгалийн чадавхийг бууруулахгүйгээр нэмэгдүүлж байх нь анхааралдаа авах асуудлын нэг бөгөөд түүнээс гарах үр ашгийг тухай бүр тооцож, байнга шинэчлэл хийж байх нь чухал юм. Иймээс нэн тэргүүнд ТХГН-ийн ямар ангилалд хамаарах, экологи, эдийн засгийн үндэслэл, шалгуур үзүүлэлтийг оновчтой тогтоох, тэдгээр нь менежментийн хувьд ямар хэлбэртэй байх асуудалд анхаарах нь зүйтэй бөгөөд энэ нь цаашид ТХГН-т үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, жуулчлалаар ирж үйлчүүлж буй гадаадын иргэн болон тус улсын иргэдээс авах хураамжийн хэмжээг оновчтой, ялгавартай байдлаар тогтооход дөхөм үзүүлэх юм. Үүнээс гадна тухайн ТХГН-ийн онцлог, уг газарт хамаарагдаж буй байгалийн ховор үзмэр, тогтоцуудын ялгаа, аль бүсэд хамаарч байгаа болон онцлог байдлыг харгалзаж үзэх нь зүйтэй юм.



Тусгай хамгаалалттай газар нутагт орох орлогыг аялал жуулчлалаас шууд болон шууд бусаар олох Засгийн газрын орлогоос /улсын татвар болон аялал жуулчлалын татвараас/ голдуу бүрдүүлэх хэрэгтэй. Тусгай хамгаалалттай газарт газар ашиглан тусгай хамгаалалттай газрын гадна бизнес эрхэлж байгаа тохиолдолд хураамж, төлбөр (түр нэвтрэх хураамж, ашиглалтын төлбөр, болон зөвшөөрөлийн хураамжууд) мөн тусгай хамгаалалттай газар нутагт гэрээ байгуулж бизнес эрхлэх зөвшөөрөл олгосны төлбөрөөс бүрдүүлэх боломжтой.

***ТХГН-ийг санхүүжүүлэх Зах зээлийн механизмууд.*** ТХГН нь эдийн засгийн хувьд үнэ цэнэтэй ихээхэн баялгийг бий болгодог. Энэ үр өгөөж, баялгийг бий болгох өртөг нь их өндөр. Зах зээлийн үйл ажиллагаа олон эдийн засгийн статистик мэдээлэл нь ТХГН-ийн бүх үр ашгийг илэрхийлж үртгэж чаддаггүй. Яагаад гэвэл ТХГН-ийн үзүүлж байгаа олон үйлчилгээ нь маш бага үнэлэгдсэн эсвэл огт үнэлэгдээгүй, зах зээлийн үйлдвэрлэгч, хэрэглэгч нь биологийн төрөл зүйлийг хамгаалах талын ямар нэг сонирхол байдаггүйтэй холбоотой. ТХГН-ийн бараа үйлчилгээг ямарч үнэ төлбөргүй ашигладаг. Зах зээлийн журмаар ТХГН-ийн үнэ цэнийг мөн түүнийг санхүүжүүлэх гол арга хэрэгсэл гэдгийг ойлгож тогтоосонгүй явж ирсэн байна.

Жишээлбэл, ТХГН-ийн биомассын нүүрсхүчлийн хийг шингээх,

уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулах ач холбогдол, ТХГН-т өндөрлөгөөс эх авсан гол усны хангамж, түүгээр урсгалын доор усыг ашиглаж байгаа газар тариаланчид, оршин суугчид, эсвэл бизнесийн ашиг олдог загас нь ТХГН-ийн дотор урсах гол мөрнүүдэд байх, ойролцоох ашиглагч гэх мэт олон төрлийн үнэ цэнэ үр ашгийг үнэлж тогтооход дутагдалтай байна.

ТХГН-ийн энэ үзүүлж байгаа үр ашгийг үнэлснээр биологийн төрөл зүйлийг хамгаалах санхүүгийн хөшүүргийг бүрдүүлэхэд туслах юм. Төлбөр хураамжийг зөв тогтоож хэрэгжүүлснээр хамгаалалтын захиргаадын удирдлагыг үзүүлж байгаа үйлчилгээгээ сайжруулах, илүү бүтээлч ажиллах сонирхлыг нэмэгдүүлдэг.

Дараах 3 төрлийн зах зээлийн хэрэгслийг энд дурьдаж байна:

- Аялал жуулчлалын төлбөр
- Байгалийн нөөц ашигласны төлбөр, хураамж
- Экосистемийн үйл ажиллагааны төлбөр

***ТХГН-т аялал жуулчлал эрхэлсний төлбөр: ТХГН-т түр нэвтрэх хураамж, ТХГН-т нэвтрэх хураамжийг өсгөх үндэслэл, шаардлага***

Одоогийн мөрдөгдөж буй ТХГН-т ажил үйлчилгээ үзүүлсний нэг удаагийн хураамжийн хэмжээг 8 жилийн өмнө тогтоосон ба хэмжээ нь бага боловч голлох орлогын эх үүсвэрийг бүрдүүлж байна. Нэвтрэх хураамж хэлбэрээр ойлгогдож хэвшсэн ба энэ нь зарим аялал жуулчлал хөгжсөн тусгай хамгаалалттай газруудад их хэмжээгээр орлогыг бүрдүүлж, ТХГН-ийн хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болж байна. Нэвтрэх хураамжийн хэмжээ нь Тусгай





хамгаалалттай газар нутаг, түүний дотор үзүүлэх үйлчилгээ ба бүтээгдэхүүнийг бүрэн илэрхийлэхгүй байна. Тухайлбал, ТХГН-ийн онцлог, биологийн төрөл зүйлийн хамгаалалтын үйл ажиллагаа, эсвэл аялал жуулчлалын бүтээгдэхүүний хамгаалалтын үйл ажиллагаанаас хамааралгүй бүх хамгаалалтын захиргаанд нэг ижил хэмжээтэй тогтоогдсон байна. Ингэж ижилсгэн тогтоосноор ирж буй зочдын аяллын зорилго, тусгай хамгаалалттай газрын аялал жуулчлалын даац, экосистемд үзүүлэх нөлөөллийг зохицуулах боломжгүй болгож байна. Нэвтрэх хураамж гэх нэг удаагийн ажил үйлчилгээний хураамжийг хураах систем нь журамлагдаагүй, тасалбарыг зарим газарт байгаль хамгаалагч тасалдаг, хамгаалалттай газар нутгийн хил хязгаарыг тэмдэгжүүлэн хамгаалж, замбараагүй нэвтрэх цэгийг багасган төвлөрүүлж, оновчтойгоор байршуулж чадаагүй зэргээс хамаарч хураамжийг бүрэн хэмжээгээр авч чаддаггүй. Нэвтрэх хураамжийн хэмжээг нэмэгдүүлж тухайн газар нутаг дахь ажил үйлчилгээний нийт зардлыг хамруулан хураамжийг тооцож байгаагүй нь тусгай хамгаалалттай газрыг улсын нийтийн өмч гэж үзэн нийт хамгаалалтын зардлыг улсаас санхүүжүүлж ирсэнтэй холбоотой. Хураах бүртгэх тогтолцоог хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй, нийт иргэдийн зүгээс эсэргүүцэлтэй тулгарч магадгүй гэсэн болгоомжлолтой ч бас холбоотой.

Улсын төсвөөс хамгаалалтын үйл ажиллагааг байнга тогтвортой санхүүжүүлэх эдийн засгийн бэрхшээлтэй байгаа нөхцөлд бусад орнуудын жишгийн дагуу нэг удаагийн ажил үйлчилгээний хөлсийг нэмэгдүүлэн хуулийн дагуу тогтоосноор ТХГН-ийн хамгаалалтын зардлыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх, түүнчлэн тусгай хамгаалалттай газар нутгийн ач холбогдлыг өсгөх, нийт иргэд, жуулчдын дунд ТХГН-ийн үнэлэмжийг дээшлүүлэх боломжийг нээж өгөх юм.

Олон улсын туршлагаас харахад ТХГН-т ороход төлж байгаа хөлс нь тэдний зорин ирж үр ашгийг нь хүртэж байгаа тусгай хамгаалалттай газрын хамгаалалтыг сайжруулахад зарцуулагдана гэдгийг ойлгож мэдэрвэл хэд дахин илүү хэмжээний төлбөрийг төлөхөд бэлэн байдаг байна. Жишээлбэл: Ботсванд тусгай хамгаалалттай газар нутагт орох хураамжийг 9 дахин нэмэгдүүлсэн ч зочдын тоо багасаагүй байна. Эдийн засгийн хөгжилд ч бас аялал жуулчлалын гүйцэтгэх үүрэг их байгаа. Аялал жуулчлалын гол үзмэр, зорилтот газрууд тусгай хамгаалалттай газарт байдгаас жуулчны баазуудын 85 орчим хувь нь эдгээр газруудад үйл

ажиллагаа явуулдаг. Өөрөөр хэлбэл, тусгай хамгаалалттай газар нутагт орших байгалийн үзэсгэлэнт газрууд, ховор ургамал, амьтан, түүхийн дурсгалт газрууд нь Монголын аялал жуулчлалын гол бүтээгдэхүүн болдог. Одоогийн Аялал жуулчлалын хуулиар хариуцлагатай, байгаль орчинд халгүй, нийгэмд сайн үр нөлөөтэй, тогтвортой үйл ажиллагааг бэхжүүлэх чиглэлийг барьсан бус хэт сул чөлөөтэй, хариуцлага, хяналтын орчин бүрдээгүй байгаагаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихсэж, үйлчилгээний чанар хангалтгүй байгаагаас жуулчны давтан ирэлтийн тоо эрс буурч байна. Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах зорилгоор нэвтрэх хураамжийг хураах зохицуулалт хийж зочдын тоог зохицуулах боломжтой.

Хүснэгт 5.4. *ТХГН-д нэвтрэх хураамж тоогтоохоод харгалзах хүчин зүйлс*

| **ТХГН-т нэвтрэх хураамжийг тогтоохоод харгалзах үзүүлэлтүүд** | |
|---|---|
| Зочдын талаас:<br>ТХГН-т нэвтэрч байгаа аялагчдын төрөл, судлаачид, сонирхогчид, явган аялагчид, бүлэг жуулчин, гадаадын иргэд, кино зурагчид, тэдгээрийн тээврийн хэрэгсэл<br><br>Тусгай хамгаалалттай газар нутгийг зорин ирж байгаа жуулчид нь ямар нэг хэмжээгээр тухайн газар нутгийн ач холбогдлыг үнэлэн тодорхой хэмжээний цаг зарцуулж, төлбөр төлж ирж байгаа. Гэтэл тэдгээрийн хүртэж байгаа үр ашгийг харгалзалгүйгээр нэвтрэх хураамжийг адилтган үзэж болохгүй юм. Ирж байгаа аялагчдын төрлийн байгальд үзүүлэх нөлөөлөл нь тухайн газарт байх цаг хугацаа, явуулах үйл ажиллагаанаас хамааралтай. Иймд зочдыг ангилан аялалын зорилгоос хамаарсан хамаарлыг тооцож үзэх шаардлагатай. ТХГН-т хүрэлцэн ирж байгаа зочдын тоог энэ нэвтрэх хураамжийн олгосон тоо хэмжээгээр зохицуулах, зочдыг цаг өдрөөр захиалгаар үйлчлэх зэрэг арга хэмжээг зохион байгуулах боломжтой. | ТХГН-ийн талаас:<br>Тусгай хамгаалалттай газрын төрөл: Хамгаалалтад авсан үндэслэлийг ангилан биологийн төрөл зүйлийн ач холбогдол онцлог, түүх дурсгалт газар, байгалийн өвөрмөц тогтоц, усны нөөц бүрдүүлэхэд үзүүлэх хувь нэмэр, ойн сангийн хэмжээ, төрөл, хамгаалагдсан байдал зэрэг үзүүлэлтийг харгалзах шаардлагатай тухайн газрын аялал жуулчлалын маршрутыг хамтатган өгснөөр үнийг нэмэгдүүлэх боломжтой. |

Нэвтрэх цэгийн хураамжийг авч тусгай хамгаалалттай газарт орж байгаа зочдын тооны дээд хязгаараар байгалийн даацыг зохицуулах боломжтой.

Зорчин ирж байгаа тээврийн хэрэгсэл нь тодорхой хэмжээгээр нөлөөлөл үзүүлэх учраас тээврийн хэрэгслийн төрлөөс шалгаалсан төлбөрийг тээврийн хэрэгсэл бүрт ногдуулах боломжтой. Тусгай хамгаалалттай газар нутагт ямар нэг төрлийн үйл ажиллагаа явуулах, тодорхой байгууламжийг ашиглан үйл ажиллагаа

явуулсан нь тусгай хамгаалалттай газар нутгийн журмаар зохицуулагдаж төлбөрийг төлөх үүрэг хүлээх ёстой. Жишээ нь: Машин зогсоох, майхан суурилуулах, загасчлах, ан агнах, завиар явах, явган аялах, амралт зугаалгын үйл ажиллагаа явуулах, спортоор хичээллэх, зураг авах гэх мэт)

Хамгаалалтын онцлог байдал:

Байгалийн нөхцөл байдлаас шалтгаалсан шаардлагатай нөхцөлд зарим амьтны биотехникийн арга хэмжээнд шаардлагатай зардлыг харгалзсан байх /Зарим онцгой ач холбогдолтой газар нутагт илүү өндөр хэмжээтэй байж болно/

- Аялагчдын маршрутыг тогтоосон байдал: Замыг засч, хог хаягдлын менежментийг шийдсэн байдал: Аялан ирэгсдийн аялах зам чиглэлийг тогтоох, үзүүлэх бүтээгдэхүүнийг харгалзан засч тохижуулсан зам, холбогдох дэд бүтцийг бий болгох, гэрэл цахилгаан, хог хаягдал усан хангамж гэх мэт.
- Нэвтрэх цэгийн хураамжийг засч тохижуулсан байдал: Нэвтрэх цэгийг байршуулах, ажиллуулах холбогдох үйл ажиллагааны зардал, хураах төхөөрөмж, кассын машин, үнэт цаас хэвлүүлэх зардал гэх мэтийг хэрхэн зохион байгуулсан байдлыг тухайн газар энэ нөхцөл байдлыг өөрөө харгалзан үзэж болно.
- Аялал жуулчлалын дэд бүтэц / аялал жуулчлалын баазын тохилог байдал, ариун цэврийн үйлчилгээ, хүнсний үйлчилгээ/ Аялал жуулчлалын үйлчилгээний чанар нөхцлийг ерөнхийд нь харгалзах боловч тухайн үйлчилгээ явуулж байгаа байгууллага тусдаа төлбөрөө тогтоодог учраас энэ үзүүлэлтийг голчилж үзэхгүй.

## Орон нутгийн хүчин зүйл:

Тухайн газар нутагт ирэх тээврийн байдал:

Нийтийн тээвэртэй эсэх, зам харилцаа байгаа эсэх, усан хангамжийн үйлчилгээнд холбогдсон эсэх хүчин зүйлийг гадаад хүчин зүйл болгож харгалзан үзнэ. Дээрхи хүчин зүйлсүүдийг харгалзан хураамжийн хэмжээнд нөлөөлөх хувийг тооцоход 31 хувийг аялагчдын төрөл тэдний явуулах үйл ажиллагаатай холбоотойгоор, 60 хувийг тухайн хамгаалалттай газар нутгийн онцлог, хамгаалалтын үйл ажиллагаатай холбоотой, үлдсэн хувийг гадаад орчин буюу тухай хамгаалалттай газар нутагт зорчиж буй дэд бүтцийн байдлаас хамааралтай байхаар тогтоох боломжтой байна. Энэ хэмжээг хамгаалалттай газар нутаг бүрт харилцан адилгүй тогтоох боломжтой боловч хүн амын суурьшлын төвд ойрхон байрлах байдлаар ангилан, хөгжлийн бүсүүдээр ялгаварлан тогтоож болно. ТХГН-ийн нэвтрэх хураамжийн хэмжээг тухайн хамгаалалтын захиргаад өөрсдийн онцлог байдлыг дээрхи үзүүлэлтийн хүрээнд үнэлж Засгийн газраас хязгаар тогтоосны дараа ирэх зочдын эрэлт нийлүүлэлтийн үндэслэн тогтоох боломжтой байх хэрэгтэй. Ягаад гэвэл зарим газарт хүн очдоггүй байтал өндөр үнэ тогтоох шаардлагагүй гэхдээ тухайн газрын байгаль экологи, биологийн төрөл зүйлийн үнэ цэнийг харгалзан үзэж эмзэг, нөлөөлөлд орох боломжтой гэсэн газарт өндөр үнэтэй байх хэрэгтэй.

Нисэх буудлын татвар, Нэвтрэх цэгийн хураамжнаас гадна зарим орнууд аялал жуулчлалын байгууламжууд болон жуулчдаас шууд бус байдлаар татвар авч түүний зохих хувийг ТХГН-ийг санхүүжүүлэхэд зарцуулдаг байна. Тухайлбал, Нисэх буудал хилийн нэвтрэх цэгт хураах механизм нь байгальд түшиглэсэн жуулчлал ихээр хөгжүүлсэн орнуудад их хэрэглэгддэг. Манай орон ч энэ төрлийн татварыг (ойролцоогоор 1-5 доллар) авч байгаль хамгаалах санд хуримтлуулан түүнээсээ ТХГН-ийг санхүүжүүлэхэд зарцуулж болно. Ингэхийн тулд хууль эрхзүйн орчинг судлан журамлах хэрэгтэй. Татварын ерөнхий хуулинд экологийн татварын ойлголтыг суулгах хэрэгтэй.

**Т**ХГН дотор ажил, үйлчилгээ эрхэлсний төлбөр ТХГН-т аялал жуулчлал эрхлэх /зөвшөөрөл, газрын төлбөр, түр операторын үйл ажиллагаа, байгаль хамгаалах зардлын хэрхэн хариуцах талаар /ТХГН-т газар ашиглах зөвшөөрлийг Байгаль орчны сайдын 2001 оны 218 дугаар тушаалаар батлагдсан "Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт газар ашиглах, зөвшөөрөл олгох түр журам"-ыг баримталж ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан газар ашиглуулах чиглэл, байршил хэмжээний дагуу хүсэлт гаргаж байгаа иргэн, аж ахуйн нэгж нь тухайн хамгаалалтын захиргаа болон сум дүүргийн Засаг даргын саналыг авч БОАЖЯ-д хандана. БОНБҮ-ний дүгнэлтийг үндэслэн БОАЖЯ-ны шийдвэрийг гаргаж, газар ашиглах гэрчилгээг олгон Засаг дарга, хамгаалалтын захиргаатай гурвалсан гэрээг байгуулдаг. Гэрчилгээний үнэ, ТХГН-т аялал жуулчлал эрхлэх эрхийн бичиг олгосны хураамж 22500 төгрөг Байгаль хамгаалах санд оруулдаг. БОАЖЯ-ны ТХНУГ-ын дарга газар ашиглах тухай гэрээг батлах бөгөөд иргэн аж ахуйн нэгжийн үүрэгт байгалийн унаган төрхийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх талаар хамгаалалтын захиргаанаас өгсөн даалгаврыг биелүүлэх, тэдгээрийг хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулахаар тусгадаг боловч гэрээг зөрчсний хариуцлагыг удаа дараа зөрчсөн тохиолдолд л цуцлахаар заасан. Энэ нь тэдгээрийн үүрэг, хариуцлагыг оновчтой болгож тодруулах шаардлагатайг харуулж байна. Эрхийн бичгийн хураамжийн орлогыг ТХГН-т зарцуулахаар журамд заасан боловч энэ нь хуулиар тухайлбал, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулинд тодорхойлон заагдаагүй байна. ТХГН-т газар ашиглах, аялал жуулчлал эрхлэхэд газрын зөвшөөрлийг олгохдоо газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу сонгон шалгаруулалтын үндсэнд газар ашиглах эрхийг олгох үүний зөвшөөрлийн

хураамжийг нэмэгдүүлэх, гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд төнгөн торгуул ногдуулах ба тэрхүү торгуулийг тухайн ТХГН-ийн хамгаалалтын үйл ажиллагаанд зарцуулах гэх мэтээр хариуцлагын тогтолцоог нарийвлан заах, тусгай хамгаалалттай газар нутагт зарцуулах эрх зүйн үндсийг бий болгох шаардлагатай.

Хүснэгт 5.5. *Байгалийн нөөц баялаг ашигласны төлбөр хураамж*

| **Лиценз, зөвшөөрөл, татвар:** | **/Зарим ан амьтан агнах барих, ургамал ашиглах татварын орлогын хэсгийг ТХГН-ийн хамгаалалтад зориулах талаар хууль эрх зүйн зохицуулалт/** |
|---|---|
| Нөөц ашигласны төлбөр | Тухайлбал, загасчлах, зарим ан амьтан барих төлбөр, хураамж, лицензийн төлбөрийн тодорхой хувийг ТХГН-ийн хамгаалалтад зориулах эрх зүйн зохицуулалт шаардлагатай. Нөөц ашигласны зөвшөөрлийн хураамж тогтоох нь аялал жуулчлалтай харицуулахад тохиромжгүй байж болох талтай ч нөөцийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.<br>Үр ашгийг тэгш хүртэх боломжгүй бөгөөд ТХГН-ийн менежментийн гол зорилготой нийцэх эсэхэд маргаантай. Түүний төлбөр хураамжийг цуглуулах, хураах бүтэц, зохион байгуулалтын чадавхиас шалтгаална. |
| Биологийн төрөл зүйлийн судалгаа: | Сүүлийн жилүүдэд олон улсад ТХГН-ийн хамгаалалтын захиргаадын эрчимтэй хэрэгжүүлж буй «эко сайн дурын жуулчлал»-ыг хөгжүүлэх. Энэхүү тусгай сонирхолын жуулчдыг хүлээн авах нь: ТХГН-ийн гол үйл ажиллагаа болох судалгаа шинжилгээг явуулахад туслах. Судалгаа шинжилгээний зориулалтаар зарцуулах хөрөнгийг хэмнэнэ. ТХГН-ийн хамгаалалтыг нэмэгдүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эх үүсвэр болно. Тухайн хамгаалалтын захиргааны судалгаа шинжилгээний ажилтнууд гадаадын туршлагаас суралцах боломжоор хангагдана. |

Байгаль орчны сайдын 1996 оны 36 дугаар тушаалаар баталсан Улсын ТХГН-т судалгаа, шинжилгээний ажил явуулах журамд зааснаар гадаад, дотоодын эрдэм шинжилгээний байгууллага нь Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр сум дүүргийн ЗДТГ, болон хамгаалалтын захиргаатай гэрээ байгуулдаг байна. ТХГН-т судалгаа, шинжилгээний ажил явуулахад төлөх хөлсийг холбогдох журмын дагуу ялгавартай тогтоож гэрээнд тусгаж мөрдөхөөр заасан боловч

түүнийг хэдий хэмжээтэй хаана ямар дансанд оруулах, хэрхэн зарцуулах талаар ойлгомжгүй орхигдсон байна. Харин Байгалийн нөөц болон дурсгалт газарт судалгаа, шинжилгээ явуулах зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг даргаас авахаар заасан байна. Зөвшөөрөгдсөн бүсэд судалгаа, шинжилгээний ажиглалтын цэг, хоноглох байр барих ажлыг хамгаалалтын захиргаа хариуцахаар заасан байна. Үүнийг аялал жуулчлалын баазууд олноор байгуулагдсан одоогийн нөхцөлд өөрчлөх шаардлагатай байна. Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулиар ТХГН-т эко жуулчин ажиллуулснаас орох орлогыг төрийн санд төвлөрүүлэх ёстой байдаг. Гэтэл төрийн сангаас тухайн хамгаалалтын захиргаанд эко жуулчин ажиллуулах нөхцлийг хангах зардлыг эргүүлэн авах асуудал бэрхшээлтэй байдаг. Гэхдээ эко жуулчныг хамгаалалтын захиргаа шууд өөрөө хүлээн авах эрхзүйн орчин байхгүй, эко жуулчныг ажиллуулах асуудлыг жилийн өмнөөс төлөвлөн орлого, зарлагыг тооцох, шаардлагатай холбогдох зардлыг төсвөөс гаргуулахад хүндрэлтэй асуудал тулгардаг учраас улсын төсвийн зохицуулалтаар удирдахад тохиромжгүй байна. Манай орны хувьд ТББ-аар менежментийг хариуцуулан ажиллуулж байгаа Хустайн нуруу БЦГ-т үр дүнтэй хэрэгжүүлж байгаа туршлага байна. ТХГН-ийн тухай хуулинд эко жуулчны асуудлыг анхаарч, тусгай хамгаалалттай газар нутагт явуулах бусад үйл ажиллагааны төрөлд оруулж, судалгаа шинжилгээний ажилтныг байрлуулах, ажиллах нөхцөлөөр хангах эрх зүйн зохицуулалтыг байгаль хамгаалах сангийн болон аялал жуулчлалын сангийн зохицуулалтын журмаар зохицуулах боломжтой. Өнөөгийн нөхцөлд хамгаалалтын захиргаа төрийн бус байгууллагатай хамтран гэрээ хийж ТББ нь эко жуулчныг хүлээн авах жуучлалын үүргийг гүйцэтгэж,



тухайн эко жуулчныг хүлээн авч байрлуулах үйлчилгээ үзүүлэх аялал жуулчлалын бааз, судалгаа шинжилгээний ажлыг хийлгэх тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа хоорондын хамтарсан үйл ажиллагааг зохицуулах гэрээг байгуулж хөрөнгийг төвлөрүүлэх зарцуулах зохицуулалтыг удирдан зохион байгуулж болох юм.

***Экосистемийн үйлчилгээний төлбөр.*** *Энэ төлбөрийг усны ай савыг хамгаалах төлбөр, нүүрсхүлийн хийн шингээлт, биологийн төрөл зүйлийн хамгаалалт зэрэг ач холбогдлыг нь үнэлж түүний үр шимийг хүртэгсдээс авдаг. Орон оронд янз бүр байх бөгөөд экосистемийн үйлчилгээний зах зээл, худалдааны нөхцлийг бүрдүүлэх хуулийн зохицуулалтаас хамаарна. Экосистем ашигласны төлбөр нь хэрэглэдэггүй болон ашигладаггүй үр ашгаас орлого олох боломжийг нээж, ТХГН-ийн ойр амьдарч байгаа хүмүүст биологийн төрөл зүйлийг хамгаалсны нөхөн олговор хэлбэрээр үр ашгийг хүртээх боломжтой.*

• *Гэвч түүнийг мөнгөн хэлбэрээр илэрхийлэх тоо баримтыг олж тогтооход бэрх*

• *Нүүрсхүчлийн хийг шингээх, газрын доорхи усны нөөцийг хамгаалах зорилгыг биологийн төрөл зүйлийг хамгаалах зорилготой сөргөлдүүлж болзошгүй*

• *Бүх нийтээр хүртдэг усны нөөцийг хамгаалах үүрэг үр ашгийг үнэлж тогтооход бэрхшээлтэй боловч түүнийг хэрэглэгчдээс төлбөрийн олон хэлбэрээр авч болох юм. Тухайлбал, зарим хотын захиргаад тухайн хот суурингийн ойр орших ТХГН-ийн хамгаалалтад зориулан хөрөнгө зарцуулдаг байна. Энэ нь нэг ёсны экосистемийг ашигласны төлбөрийг өгч байгаа нэг хэлбэр байж болох юм.*

*Хүлэмжийн хийн /нүүрсхүчлийн хий/ худалдаа: Цэвэр хөгжлийн механизмын хүрээнд олон улсын худалдаанд оролцож ТХГН-ийн ойг хамгаалахад зориулж болно. Хүлэмжийн хийг шингээж байгаа ТХГН-ийн ойн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулахад гүйцэтгэж байгаа үүрэг ач холбогдол, үнэ цэнийг үнэлэх замаар олон улсын карбоны худалдаанд оролцож болох боломжтой. Тухайлбал, Коста Рика улсад 14 сая долларыг 1997 онд 6500 га талбайд ойжуулалт хийж, 10000 га талбайд менежмент хийх, 70000 га ойд хамгаалалтын ажил хийхэд зориулж зарцуулсан бөгөөд үүний 80 хувийг Засгийн газраас үлдсэн 20 хувийг нь нүүрстөрөгчийн олон улсын худалдаанаас олж авсан байна.*

## V.4. ТХГ-Д АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛААС ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ ҮНЭЛЭХ, МОНИТОРИНГ ХИЙХ АРГАЗҮЙ

**ТХГН-ууд тэдгээрийн ашиглалтанд мониторинг хийх хөтөлбөрийг гаргах, тодорхой хугацаанд тухайн хөтөлбөр/төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэн аялал жуулчлалын үйл ажиллагаа нь байгаль орчны стандартын хүрээнд явагдаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгдөг байх. Шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах**

Аялал жуулчлалаас үүдэн гарч байгаа өөрчлөлтөнд хяналт мониторинг хийж тухайн өөрчлөлтүүд нь байгалийн явцаар бий болж байна уу эсвэл хүний үйл ажиллагааны явцад бий болж байна уу гэдгийг тогтоодог байх хэрэгтэй (Parks Canada, 1994). Хэрэгжүүлж байгаа аялал жуулчлалын үйл ажиллагаанд мониторинг хийх нь тухайн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөө үзүүлж байгаа эсэхийг тогтоохоос гадна менежмент үр дүнтэй хяналт тавьж байгаа эсэхийг тогтооно.

Аялал жуулчлалын мэргэжлийн байгууллагууд, холбогдох ТББ-ууд, НҮБ-ын ДАЖБ (UNWTO), байгаль орчныг хамгаалах болон мэргэжлийн бусад байгууллагууд, судлаачид байгаль орчинд хариуцлагатай аялал жуулчлалын үйл ажиллагааг стандартжуулах, баталгаажуулахад чиглэгдсэн гол төлөв сайн дурын санал, санаачилгууд олныг дэвшүүлжээ. Үүний дотор хариуцлагатай болон эко аяллын ойлголт, тодорхойлолтууд, үйл ажиллагааны зарчим, биеэ авч явах ёс зүй, "тэргүүн туршлагууд", арга зүйн зөвлөмж, гарын авлага зэрэг багтаж байна. Эдгээр санал, санаачилгын арга хэмжээнүүд нь гурван үндсэн нийтлэг зорилготой:





1) Салбарын холбогдох стандарт, практикийг бий болгох, хөхүүлэн дэмжих,
2) Байгаль орчин болон нийгэм, соёлын хариуцлагатай үйл ажиллагааг хэвшүүлэх Байгаль орчин болон нийгэм, соёлын хариуцлагатай үйл ажиллагааг хэвшүүлэх,
3) "Ногоон" үйл ажиллагаатай байгууллага, үйлчилгээ, үзэх зүйлүүдийн талаар мэдээллийг аялагчдад сурталчлан хүргэх.

Аялал жуулчлалын салбарын хувьд олон улсын болон төр, засгийн холбогдох хууль тогтоомжоос хамааралгүй өөрийн сайн дурын дүрмийг тогтоох нь бас ач холбогдолтой юм. Дэлхийн Аялал Жуулчлалын Зөвлөлөөс (WTTC) аялал жуулчлалын салбарын өөрийн нийтлэг дүрэмтэй байх нь байгаль орчныг хамгаалах үндсэн зарчмыг хэрэгжүүлэхэд нийцнэ гэж үзсэн бөгөөд энэ талаар 1997 онд гаргасан "Байгаль орчны зөвлөмж"-д тодорхой заасан байна. Тэр байтугай Дэлхийн аялал жуулчлалын зөвлөл нь 1994 оноос "Ногоон бөмбөлөг" хөтөлбөрийг санаачлан дэмжсэн нь угтаа төр, засгийн бус салбарын өөрийн дүрмийг бий болгож тогтоох гэсэн эрмэлзэл хэмээн үздэг. Төр, засгийн бий болгосон хууль, дүрмүүд нь байгаль орчныг хамгаалах үзэл баримтлалтай нийцэхгүй байна гэж үзсэн учраас Дэлхийн Зөвлөл (EC), Дэлхийн аялал жуулчлалын зөвлөл (WTTC) ба Дэлхийн аялал жуулчлалын байгууллага (UNWTO) гэсэн гурван том байгууллагуудаас 1995 онд Риогийн тунхаглалыг дэмжиж "Аялал жуулчлалын үйлдвэрлэлийн хэлэлцэх асуудал 21" (**Agenda 21 for Travel and Tourism Industry**) баримт бичгийг гаргасан байна.

Хэдийгээр аялал жуулчлалын салбар нь өөрсдөө үйл ажиллагааны хэм хэмжээг тогтоосон дүрэм, журмыг санаачлан хэрэгжүүлж болох ч угаасаа бизнесийн бусад салбаруудын нэгэн адил төр, засгийн хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байдаг. Улс орон бүр өөрийн онцлогт тохируулан хүн-байгалийн зохистой байдлыг хадгалсан эдийн засаг, технологийн хөгжилд тулгуурласан стандартын хэм хэмжээг тогтоодог билээ. Тогтоосон стандартад нийцэх байдлыг лиценз буюу тусгай зөвшөөрөл, хяналт шалгалтын механизмаар хянаж байдаг нийтлэг үндэстэй. Мониторинг гэдэг нь цаг хугацааны тодорхой үе шатанд биофизикийн болон нийгмийн нөхцөл байдлыг тандан судлах үечилсэн, систем дэс дараалалттай хийгддэг ажиглалт юм. ТХГН-ын мониторинг нь дараах хоёр чиглэлээр хийгддэг. Үүнд:



- **Жуулчдын нөлөөг үнэлэх.** Аялал жуулчлалаас ТХГН-д үзүүлэх нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүдийг НҮБХХ-ийн "Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх" төслийн хүрээнд 2011 онд боловсруулан БОАЖЯ-ны мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан байдаг. Цаашид ТХГН-д аялал жуулчлалаас үзүүлээх нөлөөллийн үнэлгээг хийх, мониторингийн үйл ажиллагаанд уг шалгуур үзүүлэлтүүдийг үнэлэх асуулга, загваруудыг хэрглэх нь зүйтэй.
- **Үйлчилгээний чанарын мониторинг.** Төлөвлөлт нь аялал жуулчлалыг хөгжүүлэх хэрэгсэл, үйлчилгээний цар хүрээг өөртөө агуулсан байдаг. Аялал жуулчлалын үйлчилгээний мониторинг хийснээр жуулчдад хэрхэн ямар төрлийн үйлчилгээг ямар түвшинд үзүүлж буй, давуу талыг тодорхойлох, сул, дутагдалтай талуудыг цаашид засварлан хөгжүүлэх зэрэгт үнэлэлт дүгнэлт хийдэг.

Мониторингийн үйл ажиллагаа нь дараах хэд хэдэн онцлог газруудад зайлшгүй хийгдэх шаардлагатай. Үүнд:

1. Нөлөөлөл их илэрсэн нутаг дэвсгэрт:
   - Нөлөөлөлд өртөөгүй буюу харьцангуй өөрчлөгдөөгүй талбайг мөн сонгон авах шаардлагатай. Үүнээс гадна менежментийн шинэ үйл ажиллагааг хэрэгжүүлэх,
   - Онцлог элементүүд нь их өртсөн
   - Нөхцөл нь хэт хурдацтай өөрчлөгдөж буй нутаг
2. Менежментийн үйл ажиллагаа шинээр явагдаж буй нутаг дэвсгэрт.
3. Менежментийн үйл ажиллагааны үр дүн тодорхойгүй байгаа нутаг дэвсгэрт.

4. Мэдээлэл хомс нутгуудад.

ТХГН-ын хамгаалалтын захиргаад аялал жуулчлалын үйл ажиллагаанд үнэлэлт өгөх мониторингийн хөтөлбөрүүдийг тухайн газрын онцлогоос хамааруулан боловсруулах шаардлагатай. Байгалийн Унаган Төрхийг хадгалах байгууллага (The Nature Conservation, 1999) мониторингийн төлөвлөгөө боловсруулах зөвлөмжийг боловсруулсан байдаг. Үүнд:

- Мониторинг нь ерөнхий төлөвлөгөө болон менежментийн хөтөлбөрт тусгагдсан байх
- Мониторинг нь тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент болон иргэний хөгжлийн зорилтуудад хүрэхэд чиглэгдсэн байх
- Нөлөөлөх хүчин зүйлүүд тодорхойлогдсон, шинжлэгдсэн байх
- Тэдгээрийг үнэлэх шалгуурууд болон судалгааны аргууд тодорхойлогдсон байх
- Орон нутгийн иргэдийн оролцоог харгалзан үзсэн байх
- Мониторингийн аргазүй нь ажиглагчийн ур чадварыг шаардахгүй, цаг хугацаа болон хөрөнгө санхүүжилтээс үл хамаарсан байх
- Мониторингийн үр дүнд шинжилгээ хийж менежментийн зохистой аргуудыг заасан байх.

Аялал жуулчлалын мониторингийн төлөвлөгөө нь дараах үе шаттай хэрэгжинэ.

1. Мониторингийг төлөвлөх:
   - Зохицуулах зөвлөлийг бүрдүүлэх
   - Олон нийтийн уулзалт зохион байгуулах
2. Мониторингийн хөтөлбөр боловсруулах:
   - Нөлөөлөл болон шалгууруудыг тодорхойлох
   - Судалгааны аргазүйг сонгох
   - Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаарыг тодорхойлох
   - Мониторингийн хөтөлбөрийн хэрэжилтийг хөгжүүлэх
3. Мониторингийн гүйцэтгэх болон үр дүнг хэрэглэх:
   - Ажилчид, менежерүүд болон иргэдийн төлөөллийн дунд сургалт зохион байгуулах
   - Мониторингийн үр дүнг шинжлэх
   - Үр дүнг нийтэд түгээх
4. Мониторингийн үйл ажиллагааг үнэлэх болон сайжруулах:

- Мониторингийн хөтөлбөрийг дахин үнэлж, цаашид өргөтгөх, шаардлагатай шинэчлэлт хийх.

Мониторингийн хамгийн гол анхаарах зүйлийн нэг нь тухайн үйл ажиллагаанд оролцогчдын бүхий л талын төлөөллийи жигд хамруулах (жуулчин, туроперотар, орон нутгийн иргэд, засаг захиргааны байгууллага, хандивлагчид, судлаачид, шийдвэр гаргагчид г.м), төлөөллийн ялгаатай түвшин бүрд мониторингийн дүн шинжилгээ хийх аргазүйн чадвартай байх явдал юм.

### Жишээ 18. Онон-Балжийн Байгалийн цогцолбор газарт аялал жуулчлалаас үзүүлж буй нөлөөллийн үнэлгээний үр дүн[1]

Агуулга:

- Онон Балжийн БЦГ-ын байгаль орчны үнэлгээ
- Онон Балжийн БЦГ-ын нийгэм эдийн засгийн үнэлгээ


**Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль**
Аялал жуулчлал-Экологийн
менежментийн тэнхим

**Онон Балжийн БЦГ-т аялал жуулчлалаас үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ**

Улаанбаатар
2011

1 *Тайлбар: Энэхүү үнэлгээ нь эцсийн үр дүн бус бөгөөд үнэлгээний аргазүйн энгийнээр тайлбарлах үүднээс хавсаргав.*

## ТХГН-т аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглалт, газрын менежментийн зохистой байдлыг хадгалах

1. Хөрсөн бүрхэвчинд гарч буй өөрчлөлт

    1.1 ОББЦГ-ын бэлчээрийн ургамалжилтын төлөө байдлын доройтлын зэрэглээг тогтоосон судалгааны дүнгээр онцгой бүсэд бэлчээрийн ургамалжилт хэвийн, аялал жуулчлалын ба хязгаарлалтын бүсэд бага зэрэг, орчны бүсэд дунд зэрэг гэж тогтоов. /+1/

2. АЖ-ын зориулалтаар ашиглагдаж буй газар

    2.1 26,7% буюу 110965 га-д аялал жуулчлалын бүсэд хамаардаг. /+2/

3. ТХГН-т үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазын тоо, хоорондын зай

    3.1 Дадал, Биндэр сумдад 9 жуулчны бааз үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хоорондын зай нь 5-130 км зайтай байна. /+2/

4. АЖ-ын үйл ажиллагаанд зориулсан газрын менежмент

    4.1 Цогцолборт газрыг 2 хэсэгт хуваасан юм. Эдгээр газрууд хасагдсанаас нэн ховор, ховор амьтдын байршил, тархац, тэдгээрийн нүүдлийн зам, нутагшаагүй боловч цаашид нутагшиж болох газар нутаг, тусгай хамгаалттай газрын байгаль орчинд онцгой нөлөө үзүүлэх гол, голын эх гэх мэт экологийн онцгой ач холбогдол бүхий газрууд, мөн аялал жуулчлал хөгжүүлэх гол түшиц газрууд хилийн гадна үлдсэн билээ. /-2/

## АЖ-ын зориулалтаар ашиглагдаж буй тээврийн хэрэгсэл, түүнээс үүдэн гарах үр дагаварыг бууруулах

### Жуулчны тээврийн хэрэгсэл ашиглалтын төрөл

- Эдгээр тээврийн хэрэгслүүд нь А-80, Дезель түлш хэрэглэдэг бөгөөд ОББЦГ-т нэг жилд аялал жуулчлалыг зорилгоор 1500 авто машин зорих ба эдгээр нь 225000 л түлш зарцуулдаг байна. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгжүүд Япон улсад 1994-2007, 1989-1997 оны хооронд үйлдвэрлэгдсэн, тухайн улсад 5-7 жил хэрэглэгдсэн бага оврын автобус, жийп гэсэн авто тээврийн хэрэгслүүдийг ашигладаг. Мөн ОХУ УАЗ-452 маркийн бага оврын автобус ашигладаг. Эдгээр түлш нь шаталтанд орох үедээ 86,1%-ийн нүүрстөрөгчийг агаарт цацдаг байна.

### Тухайн тээврийн хэрэгслүүдээр АЖ-ын гол үзмэр сайтуудад хүрэх боломж

- Дээрх тээврийн хэрэгслүүд нь аялал жуулчлалын үйл ажиллагаанд тогтмол хэрэглэгддэг бөгөөд туулах чадвар сайтайд тооцогддог. ОББЦГ нь дэд бүтцийн хувьд харьцангуй сулд тооцогдох юм.

## Эрчим хүчний хэрэглээ, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг дэмжих

### АЖ-ын үйлчилгээнд ашиглагдаж буй эрчим хүчний төрөл, эрчим хүч хэмнэх хөтөлбөртэй эсэх

- Биндэр, Дадал суманд байх жуулчны баазууд бүгд дээрх сумдуудаас эрчим хүчний эх үүсвэрээ авдаг, зарим тохиолдолд нэмэлт эрчим хүчний үүсгүүр ашигладаг.

### Сэргээгдэх эрчим хүч хэрэглэдэг эсэх

- Байхгүй /-3/

## Усны зохистой хэрэглээ, усны нөөц, баялагийг хамгаалах

АЖ-ын салбарын усны хэрэглээ

| Хүн ам | | | Аялал жуулчлал | | | Бусад | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2009 | 2015 | 2021 | 2009 | 2015 | 2021 | 2009 | 2015 | 2021 |
| 0,603 | 0,832 | 0,912 | 0,024 | 0,030 | 0,045 | 0,127 | 0,159 | 0,319 |

Ахуйн хэрэглээний ус ашиглалт, чанарын нөлөөлөл

| Он | Жуулчны баазын хүчин чадал | Хоногт зарцуулах усны хэмжээ метр 3 | Ажиллах хоног | Нийт хэрэглээ | Нийт хоол метр3 | Нийт халуун ус метр3 |
|---|---|---|---|---|---|---|
| 2009 | 790 | 0,045 | 120 | 4266 | 2496 | 1125 |
| 2015 | 1000 | 0,045 | 120 | 5400 | 3168 | 1312,5 |
| 2021 | 1500 | 0,045 | 120 | 8100 | 4200 | 1875 /+1/ |

### Борооны усыг цуглуулан ахуйн хэрэглээнд ашигладаг байх, ус хэмнэх арга хэмжээний хөтөлбөртэй эсэх

- Чингисийн тоонот жуулчны баазад борооны усыг ашиглан баазын хэрэглээний хүнсний ногоог усладаг. /+1/

### Бохир ус зайлуулах цэвэрлэх технологи

- ОББЦГ жуулчны баазууд бохир усаа зайлуулахдаа 00-н бохирыг соруулах арга хэмжээ авдаг. /+1/

## Хог хаягдлын менежмент дахин боловсруулалт

### АЖ-аас үүдэлтэй хог хаягдлын хэмжээ

- Дотоодын аялагчдын хөдөлгөөнтэй холбоотойгоор Биндэр, Их Тахилгат овоо орчим их хэмжээний хог хаягдал /архины шил, усны хуванцар сав/ голдуу бөөгнөрдөг. Түүнчлэн самар, жимс түүгчид, хамт олноороо зугаалагсад хогоо хаа хамаагүй, зам дагуу замбараагүй хаях явдал нэлээд байна. /-2/

### АЖ-ын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, АНН иргэдийн нөхөрлөл нь хог хаягдлын дахин боловсруулж ашиглах хөтөлбөртай буюу ийм хөтөлбөрт хамрагдасан эсэх

- 2009 оны 6-р сарын 10-12 хороонд Дэлхийн байгаль хамгаалах сангийн ивээл дор ОББЦГ-ын мэргэжилтэн, байгаль хамгаалагч, идэвхтэнгүүдийг хамруулсан сургалт зохион байгуулсан бөгөөд үүнд байгаль орчныг хамгаалах талаарх сургалт зохион байгуулагдсан.

Оролцогчид нь:
- ТХГН-ийн захиргаа
- Хилийн застав
- Байгаль орчны байцаагч
- Нутгийн иргэд
- ИТХ-ын гишүүд, багийн засаг дарга нар оролцсон болно. /+2/

### Бүс нутгийн цогцолбор газар/паркийн бүтээн байгуулалт

- Зүүн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Хэнтий аймгийн хүрээнд аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэгч салбарын нэг болгох зорилго бүхий аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр

### ТХГН-т барьж байгуулсан зочин байршуулах байгууламжийн ХБО-д ээлтэй байдал

- Онон балжийн БЦГ-т баригдсан жуулчны байршуулах хэрэгслүүд нь Монголын уламжлалт сууц болох гэр байдаг бөгөөд энэ нь байгаль орчинд сөрөг нөлөө хамгийн багатай байршуулах хэрэгсэл юм. /+3/

### АЖ-ын зорин очих газрууд голлох үзмэрүүд, зам, маршрутын тэмдэг, тэмдэглэгээ

- Үзмэр рүү хүрэх замд замын тэмдэг тэмдэглэгээ байхгүй, үзмэрт ойртож очсон үед л жижиг хэмжээний тэмдэглэгээ байдаг. Үзмэрүүдэд хүрэхийн тулд байгалийн хөрсөн замыг ашигладаг. /0/

### Эко аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг дэмждэг эсэх

- Онон Балжийн БЦГ-ын менежментийн төлөвлөгөөнд хийсэн мониторингийн тайланд:
- 2014 он гэхэд хариуцлагатай аялал жуулчлал хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлдэг болсон байна гэсэн байгаа бөгөөд энэ нь одоогийн байдлаар 50%-ийн хэрэгжилттэй, 13,3%-ийн чанартай байна. /+2/

### Жуулчдын төлж буй төлбөр, татвараас ТХГН-н хөгжил ба хамгаалалтанд зарцуулагдах байдал

- Онон Балжийн БЦГ-ын менежментийн мониторингийн тайланд 2015 он гэхэд түймрийн тоог 2006-2010 оны дундажтай харьцуулахад 50 хувиар бууруулна. 2015 он гэхэд ойн менежментийг боловсронгуй болгож, доройтсон ой сангийн 10 хувийг нөхөн сэргээнэ. Мөн "Байгаль хамгааллын талаарх иргэдийн мэдлэгийн түвшинг 30 хувиар нэмэгдүүлнэ". Заасан байгаа бөгөөд 50-100%-ийн хэрэгжилттэй, 43-100%-ийн чанартай явагдаж байна. /2/

## ДҮГНЭЛТ

Олон Улсын Байгаль хамгаалах Холбооны (IUCN) боловсруулсан тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрийн ангиллаар байгалийн цогцолборт газар, байгалийн дурсгалт газар, хамгаалалттай ландшафт гэсэн ангилалд багтах тусгай хамгаалалттай газруудад амралт, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн байдаг. Энэ зарчмыг өнөөдөр манай улсад мөрдөж, тусгай хамгаалалттай газар нутгууд нь аялал жуулчлалын гол нөөц, цөм болж байна. Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал эрхлэх үйл ажиллагаа нь байгаль хамгаалал, нийгэм-эдийн засгийн хөгжлийн нэн чухал ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл аялал жуулчлалаар дамжуулан газар орныг хамгаалах үйл явц нь мөн орон нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх хамгийн тогтвортой шийдлийн нэг юм. Манай орны нөхцөлд байгаль хамгаалах үйл ажиллагааг орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулах, нийгэм-эдийн засгийн тогтовортой хөгжлийг хангах үүднээс эко аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.

"Эко аялал жуулчлал нь байгальд хийгдэж байгаа, хүрээлэн буй орчинд хариуцлагатай хандсан, бага нөлөө үзүүлэх, байгаль хамгаалалд хувь нэмрээ оруулах, орон нутгийн иргэдийн нийгэм эдийн засагт идэвхтэй дэмжлэг үзүүлэх зорилгоор хийгдэж байгаа аялал" (IUCN, 1996). Тусгай хамгаалалттай газар нутагт эко аялал жуулчлалыг амжилттай хөгжүүлэх хамгийн эхний алхам нь тухайн газар нутгийн нөөцийг тодорхойлох, даацад тохируулан ашиглалтын хязгаарыг оновчтой тогтоох юм. Тусгай хамгаалалттай газар нутагт түшиглэсэн эко аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ тухайн ТХГН-ийн менежментийн ерөнхий төлөвлөгөөний нэг үндсэн хэсэг нь эко аялал жуулчлал хөгжүүлэх менежментийн асуудал хэмээн үзэж бодлого, стратеги тодорхойлдог. Мөн эко аялал жуулчлалыг амжилттай эрхлэхэд орон нутгийн иргэд, жуулчид, засаг захиргааны байгууллага, сайн дурынхан, бизнес эрхлэгчид, судлаачид зэрэг бүхий л сонирхогч талуудын хамтран ажиллах, шийдвэр гаргах, гүйцэтгэх түвшинд жигд оролцох боломцоог хангаж өгөх шаардлагатай.

Эко аялал жуулчлалыг хөгжүүлэх байгалийн нөхцөл боломцоо, нөөц тусгай хамгаалалттай газар бүрт харилцан адилгүй байдаг. Эко аялал жуулчлалын бүтээгдэхүүн нь түүнийг бий болгоход шаардлагатай бүхий л зүйлс, үйл явц, нөөцийг багтаасан аяллын үйлчилгээ ба хөтөлбөрийн иж бүрдэл юм. Бүтээгдэхүүний багц нь мөн тусгай хамгаалалттай газруудад

харилцан адилгүй тодорхойлогдоно. Эко аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх гол стратегийн зорилтууд нь аялал жуулчлалаас байгальд нөлөөлөх нөлөөллийг хамгийн бага байлгах арга замыг олох, эко аялал жуулчлалын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт дэхь үр өгөөжийг нэмэгдүүлэх, эко аялал жуулчлалын боловсрол олгох, сурталчлах зэрэг болно. Эко аялал жуулчлалын менежментийн хүрээнд тухайн тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын нөөцийн ашиглалтын боломжит хязгаарыг тодорхойлдог. Ашиглалтын хязгаарыг

а) байгаль орчин ба хүрээлэн буй орчны,
б) соёлын ба нийгмийн,
в) сэтгэл зүйн гэсэн 3 хэлбэрээр илэрхийлдэг байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн даац, багтаамжийг тооцох нь тухайн газар нутгийн ашиглалтын талаарх шийдвэр гаргалтын үндэс болох ба шийдвэр гаргалтын процесст дараах зарчмууд өргөн ашиглагддаг. Үүнд:

- Хүлээн зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаар (Limits of Acceptable Change- LAC),
- Зорчигчийн нөлөөллийн менежмент (Visitor Impact Management- VIM),
- Зорчигчийн Үйл ажиллагааны Менежментийн процесс (Vistor activities management Process- VAMP),
- Зорчигчийн туршлага ба нөөцийн хамгаалал (Visitor Experiences and Resource Protection- VERP).

Тусгай хамгаалалттай газар нутаг дотор болон орчны бүсэд аялал жуулчлалын зориулалтаар дэд бүтцийг өргөжүүлэхдээ дараах зарчмуудыг баримтлах нь зүйтэй. Үүнд:

- Дэд бүтэц, барилга байгууламжийн хэмжээг хамгийн бага түвшинд байлгах
- Аялагч, жуулчдад зориулсан мэдээллийн самбар, тэмдэглэгээ барих (жишээ нь: машины зогсоолын байршил, хэмжээ гм)
- Барилга байгууламжууд нь аль болох байгаль хүрээлэн буй орчин, экосистемд нөлөө бага үзүүлэхээр байна.
- Барилга байгууламжууд нь байгаль, хүрээлэн буй орчны төрхийг алдагдуулахгүйгээр, аль болох орон нутгийн, уламжлалт, соёлд тулгуурласан, орон нутгийн материалаар хийгдсэн байна.
- Барилга, байгууламжийг байгаль орчинд ээлтэй дизайн, хэв маягаар барих, төлөвлөх.

Монгол Улсад "Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" (1994), "Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай" (1997) хуулиуд батлагдаж, 1995 онд дархан цаазат, байгалийн цогцолборт газрын нийтлэг болон тусгай горимыг Засгийн газраас, 1998 онд "Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр"-ийг Улсын Их Хурлаас тус тус батлан мөрдүүлснээр тусгай хамгаалалттай газар нутгийн талаархи эрх зүйн үндэс бүхэлдээ бүрдсэн гэж үздэг ба төрийн бодлого, хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэх хүрээнд 30 орчим дүрэм, журам, зааврыг боловсруулан эрх бүхий байгууллагуудаар батлуулан ажиллаж байна.

ТХГН-д санхүүжилтийн олон янзын арга хэлбэрүүд байдаг. Эко аялал жуулчлалыг хөгжүүлэх нь орон нутгийн иргэдийн орлогын эх үүсвэрийг тогтвортой болгох нэг гарц болно. Эко аялал жуулчлалыг хөгжүүлэхтэй зэрэгцэн ТХГН-ийн хамгаалалтын асуудал хариуцсан байгууллага, мэргэжилтнүүд аялал жуулчлалаас үүдэлтэй нөлөөллийг үнэлэх, мониторинг тасралтгүй хийж байх шаардлагатай байдаг. Мониторинг гэдэг нь цаг хугацааны тодорхой үе шатанд биофизикийн болон нийгмийн нөхцөл байдлыг тандан судлах үечилсэн, систем дэс дараалалттай хийгддэг ажиглалт юм. ТХГН-ийн мониторинг нь дараах хоёр чиглэлээр хийгддэг. Үүнд:

- Жуулчдын нөлөөг үнэлэх. Аялал жуулчлалаас ТХГН-т үзүүлэх нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүдийг НҮБХХ-ийн "Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх" төслийн хүрээнд 2011 онд боловсруулан БОАЖЯ-ны мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан байдаг. Цаашид ТХГН-д аялал жуулчлалаас үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийх, мониторингийн үйл ажиллагаанд уг шалгуур үзүүлэлтүүдийг үнэлэх асуулга, загваруудыг хэрэглэх нь зүйтэй.
- Үйлчилгээний чанарын мониторинг. Төлөвлөлт нь аялал жуулчлалыг хөгжүүлэх хэрэгсэл, үйлчилгээний цар хүрээг өөртөө агуулсан байдаг. Аялал жуулчлалын үйлчилгээний мониторинг хийснээр жуулчдад хэрхэн ямар төрлийн үйлчилгээг ямар түвшинд үзүүлж буй, давуу талыг тодорхойлох, сул, дутагдалтай талуудыг цаашид засварлан хөгжүүлэх зэрэгт үнэлэлт дүгнэлт хийдэг.

Эко аялал жуулчлалын нөлөөллийн үнэлгээ, мониторингийн үр дүнд тулгуурлан тухайн ТХГН-ийн ерөнхий менежментийн төлөвлөгөө, эко аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөнд засварлалт хийх, дахин сайжруулах ажлууд хийгддэг.

## ХАВСРАЛТ-1

БАТЛАВ: Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд /Л.Гансүх/

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГУУДАД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

### Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол орны газар нутгийн 15 орчим хувийг хамраад байгаа тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ нь байгалийн үзэсгэлэнт, дахин давтагдашгүй, ховор ховордсон амьтан, ургамлын гол тархац нутаг, түүх соёлын дурсгалт газруудыг төлөөлсөн байдгаараа эрчимтэй хөгжиж буй аялал жуулчлал, амралт зугаалгын гол бүс болдог. Эдгээр газруудад явагдаж буй байгалийн нөөцийн зохистой ашиглалт, хамгаалалтын менежмент хангалтгүй байгаагаас тусгай хамгаалалттай газрыг жинхэнэ утгаар нь хөгжүүлж чадахгүй байна. Аялал жуулчлалын баазуудын бөөгнөрөл, хөрсний талхагдал, усны бохирдол, хог хаягдлын асуудал нь байгалийн үзэсгэлэнт байдлыг алдагдуулан, нөөцийг доройтуулж, жуулчид татах үнэ цэнийг нь бууруулсаар байна. Тусгай хамгаалалттай газар нутгуудад явагдаж буй үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, соёлд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасган, олон нийтийн байгаль орчны ухамсарыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр болохуйц, үр нөлөө бүхий менежментийг бий болгох нь тулгамдсан асуудал болоод байна. Уг баримт бичгийг боловсруулахад "Биологийн олон янз байдлын конвенц"-ийг 2012 он хүртэл хэрэгжүүлэх "ТХГН-ийн хөтөлбөр"-ийн /CBD Programme of Work on Protected Areas/ санал болгож буй зорилтуудыг үндэслэл болгов.

### Хоёр.Зорилго

Энэхүү баримт бичгийн зорилго нь Монгол Улсын Тусгай Хамгаалалттай Газар Нутгуудад (ТХГН) явагдаж буй аялал жуулчлалыг тухайн нутгийн экосистемийн нөөц, даацад тулгуурлан, байгаль, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнийг алдагдуулахгүйгээр тогтвортойгоор хөгжүүлэхэд баримтлах бодлогын үндсэн чиглэл, түүнийг хэрэгжүүлэх арга замуудыг тодорхойлоход оршино.

## Гурав. ТХГН-т аялал жуулчлал хөгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл

Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ дараахи чиглэлийг баримтлана.

3.1 ТХГН-т аялал жуулчлалыг экосистемийн нөөц, даацад тулгуурлан, тогтвортой хөгжүүлэх;

3.2 Байгаль хамгаалах нэгдмэл зорилгын дор ТХГН-т явагдах аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг хангах бодлого боловсруулах, шийдвэр гаргах, үйл ажиллагаа төлөвлөх, хэрэгжүүлэхэд холбогдох талуудын оролцоог дэмжих;

3.3 ТХГН бүр менежментийн төлөвлөгөөндөө тухайн нутгийн байгалийн нөөц, нутгийн иргэдийн нийгэм, соёлын онцлог, жуулчдын эрэлт хэрэгцээг харгалзан аялал жуулчлалыг боловсруулан хэрэгжүүлэх;

3.4 Аялал жуулчлалын үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх аливаа нөлөөллийг тогтмол хянан үнэлж, сөрөг нөлөөг бууруулах шаардлагатай арга замуудыг тодорхойлон хэрэгжүүлэх;

3.5 ТХГН-ийн удирдлага, зохион байгуулалт, хамтын ажиллагааны төрөл бүрийн хэлбэрүүдийг (ТББ, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгжийн хамгаалж буй газар г.м) дэмжих;

3.6 Аялал жуулчлалын байгууллагуудын бизнес, байгаль орчинд халгүй технологийн хэрэглээ, түншлэлийг дэмжих;

3.7 ТХГН-т үйл ажиллагаа явуулах жуулчны үйлчилгээний байгууллагуудын байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг холбогдох талуудын оролцоотойгоор хэлэлцүүлдэг байх;

3.8 ТХГН-т үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, ТББ, аж ахуйн нэгж, иргэдийн нөхөрлөл нь "ашиглагч нь төлөх" зарчимд тулгуурлан тухайн нутгийн байгаль орчинд хохирол учруулсан тохиолдолд хариуцлага хүлээдэг байх

## Дөрөв. Үйл ажиллагаа

4.1 Аялал жуулчлалын хөгжилд ТХГНутгуудын үзүүлж буй эдийн засаг, нийгэм, соёлын нөлөөлөл, одоогийн баримтлаж буй бодлого, хууль эрх зүйн зохицуулалт,

санхүүжилтийн байдалд үнэлгээ хийх;

4.2 Аялал жуулчлалыг байгалийн нөөцийг тогтвортой ашиглах, байгаль хамгаалдлыг санхүүжүүлэх нэг хэлбэр, хамгаалалтанд нутгийн иргэд болон бусад талуудыг оролцуулах эдийн засгийн хөшүүрэг болгох эрх зүйн өөрчлөлтийн саналуудыг боловсруулж, холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлэн, шийдвэрлүүлэх;

4.3 ТХГН болон түүний орчны бүсэд аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг хангах зорилготой, оролцогч талуудын төлөөлөл бүхий ТХГН-ийн сүлжээний үндэсний болон салбар зөвлөлүүдийг байгуулан чадваржуулах;

4.4 ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөний аялал жуулчлалын хэсгийг боловсруулах нэгдсэн агуулга, бүтцийн зөвлөмж боловсруулах;

4.5 ТХГН болон түүний орчны бүсийн менежментийн төлөвлөгөөнд аялал жуулчлалын хэсгийг талуудын оролцоотой боловсруулж, хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд шинэчлэх;

4.6 ТХГНутгуудын аялал жуулчлалын нөөц, даацыг тодорхойлох, байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг, сөрөг нөлөөг үнэлэх, хяналт мониторинг хийх аргачлалыг боловсруулан хэрэгжүүлэх;

4.7 Аялал жуулчлалын экологи, нийгэм, соёлын шалгууруудыг боловсруулан мөрдүүлэх ("Ногоон гэрчилгээ" олгох ажлыг зохион байгуулах);

4.8 ТХГН-ийн биологийн төрөл зүйл, байгалийн нөөц баялаг, нутгийн оршин суугчдын нийгэм, соёл, уламжлалын талаар гадаад, дотоодын жуулчдад мэдээлэх, сурталчилах;

4.9 ТХГН-т амьдардаг иргэдийн нөхөрлөл, үйл ажиллагаагаа явуулдаг аялал жуулчлалын болон ТББ байгууллагуудад тодорхой газрыг менежментийн гэрээний нөхцлөөр хариуцуулан хамгаалуулах;

## Тав. Хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2008 оноос эхлэн дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

*Нэгдүгээр үе шат: 2010 он хүртэл*

- БОАЖЯ, Хамгаалалтын захиргаадын дэргэд аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах үндэсний болон орон нутгийн зөвлөлүүдийг байгуулж, байгалийн нөөц,

аялал жуулчлалын менежментийн чиглэлээр чадваржуулах;
- Аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах менежментийн төлөвлөгөөг талуудын оролцоотойгоор боловсруулах, хэрэгжүүлж эхлэх;

*Хоёрдугаар үе шат: 2010-2015 он*

- Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтийн дагуу хянан үнэлж, шаардагдах өөрчлөлтүүдийг оруулах;
- Аялал жуулчлалын байгууллагуудад "Ногоон гэрчилгээ" олгох ажлыг зохион байгуулж, мөрдлөг болгох;

**Зургаа. Санхүүжилт**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг улсын төсөв, аялал жуулчлалын үйл ажиллагаанаас тухайн ТХГН-т орсон орлогын тодорхой хувь, дотоод, гадаадын байгууллага, иргэдийн хандив, тусламж зэрэг эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

**Долоо. Гарах үр дүн**

- Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын үндэсний болон орон нутгийн түвшин дэх хамтын ажиллагаа сайжирна.
- ТХГН-т аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх эрх зүйн орчин, ТХГН-ийн менежмент сайжирна.
- Байгаль хамгаалах, ТХГН-ийн менежментийг сайжруулах санхүүгийн боломжууд нэмэгдэнэ.
- Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоо, идэвхи дээшилнэ.
- ТХГН-т амьдардаг иргэдийн орлого тогтвортой нэмэгдэнэ.

2009.07.20

# ХАВСРАЛТ-2

## 1. МОНИТОРИНГ ХИЙХ ЧИГЛЭЛҮҮД

Аливаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, төслийн нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүд нь урт хугацааны мониторингийн үр дүнгээр тодорхойлогддог. Тухайн ТХГН-т амьдарч буй оршин суугчдын амжиргааг дээшлүүлэх, байгаль орчны урт хугацааны тогтвортой байдлыг хангах үүднээс аялал жуулчлалаас орчинд үзүүлж буй нөлөөллийн мониторинг байнга хийгдэж байх хэрэгтэй. БОАЖЯ-ны ТХНУГ-ын захиалгаар ДДБОС/НҮБХХ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн "Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн сүлжээг бэхжүүлэх нь" төслөөс Монгол улсын ТХГН-т явагдаж буй аялал жуулчлалын үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчин, нийгэм эдийн засагт учирч болзошгүй нөлөөллийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулаад байна.

Хүснэгт 1. *Аялал жуулчлалын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд*

| Хамрах хүрээ | Зарчим | Шалгуурууд | Үнэлгээ |
|---|---|---|---|
| | *ТХГН-т аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглалт, газрын менежментийн зохистой байдлыг хадгалах* | АЖ-ын зориулалтаар ашиглагдаж буй газар | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | | АЖ-ын хөгжлөөс үүдэлтэй газар ашиглалтын хэлбэрт гарч буй өөрчлөлт, хөрсөн бүрхэвчид гарч буй өөрчлөлт | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | | ТХГН-т үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазуудын тоо, хоорондын зай | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | | АЖ-ын үйл ажиллагаанд зориулсан газрын менежмент | -3 аас +3 баллаар үнэлнэ |

| | | | |
|---|---|---|---|
| Байгаль орчин | *Аялал жуулчлалын зориулалтаар ашиглагдаж буй тээврийн хэрэгсэл, түүнээс үүдэн гарах үр дагаврыг бууруулах* | Тээврийн салбарын үйл ажиллагаанд АЖ-аас үүдэн гарч буй өөрчлөлт* | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | | Жуулчдын тээврийн хэрэгсэл ашиглалтын төрөл | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | | Тухайн тээврийн хэрэгслүүдээр АЖ-ын гол үзмэр, сайтуудад хүрэх боломж | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | *Эрчим хүчний хэрэглээ, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг дэмжих* | АЖ-ын үйлчилгээнд ашиглагдаж буй эрчим хүчний төрөл , эрчим хүч хэмнэх хөтөлбөртэй эсэх | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | | Сэргээгдэх эрчим хүч хэрэглэдэг эсэх | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | *Усны зохистой хэрэглээ, усны нөөц баялгийг хамгаалах* | АЖ-ын салбарын усны хэрэглээ | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | | Ахуйн хэрэгцээний ус ашиглалт, чанарын нөлөөлөл | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | | Борооны усыг цуглуулан ахуйн хэрэглээнд ашигладаг байх, ус хэмнэх арга хэмжээний хөтөлбөртэй эсэх | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | | Бохир ус зайлуулах, цэвэрлэх технологи | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| Байгаль орчин | *Хог хаягдлын менежмент, дахин боловсруулалт* | АЖ-аас үүдэлтэй хог хаягдлын хэмжээ | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | | Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн нөхөрлөл нь хог хаягдлыг дахин боловсруулж ашиглах хөтөлбөртэй буюу ийм хөтөлбөрт хамрагдсан эсэх | -3 аас +3 баллаар үнэлнэ |

| | | | |
|---|---|---|---|
| | *Биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийн шалгуур, хамрах хүрээ* | ТХГН-д зорин ирэгсэдийн тооны давтамжаас үүдэлтэй биологийн төрөл зүйлийн хомсдол* | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | | Ой бүхий талбай, АЖ-аас үүдэн ойн санд учирч буй нөлөөлөл* | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | | Аялал жуулчлалын бизнес эрхлэгчид нь байгалийн унаган төрх, ургамлыг хэвийн байдалд нь байлгах, хамгаалах, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд оролцдог эсэх | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | *Байгаль хамгаалах үйл ажиллагааны менежмент* | Бүс нутгийн цогцолбор газар/паркийн бүтээн байгуулалт* | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | | АЖ-ын бүс нутагт байгалийн гамшгаас сэргийлэх төлөвлөгөө | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | | ТХГН-д явагддаг тусгай сонирхолын аяллаас үүдэлтэй нөлөөллүүд* | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | | ТХГН-т барьж байгуулсан зочин байршуулах байгууламжийн хүрээлэн буй орчинд ээлтэй байдал | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | | АЖ-ын зорин очих газрууд, голлох үзмэрүүд, зам маршрутын тэмдэг, тэмдэглэгээ | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | | Эко аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг дэмждэг эсэх | -3 аас +3 баллаар үнэлнэ |
| | | Жуулчдын төлж буй төлбөр, татвараас ТХГН-ын хөгжил ба хамгаалалтанд зарцуулагдах байдал | -3 аас +3 баллаар үнэлнэ |

*Тайлбар: * Аялал жуулчлал төдийлөн хөгжөөгүй байгаа ТХГН-уудад одоохондоо тооцох шаардлагагүй үзүүлэлтүүд*

Хүснэгт 2. *Шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал*

| Шалгуур | Үзүүлэлтүүд | Тооцох аргачлал | Мэдээллийн эх үүсвэр | Тайлагнах хугацаа |
|---|---|---|---|---|
| ТХГН-т аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглалт, газрын менежментийн зохистой байдлыг хадгалах | АЖ-ын зориулалтаар ашиглагдаж буй газар | АЖ-ын зориулалтаар ашиглаж буй газрын хэмжээ, нийт ТХГН-ийн талбайтай харьцуулсан харьцаа, эзлэх хувь | Тухайн ТХГН-ын хамгаалалтын захиргаа | Жил бүр |
| | АЖ-ын хөгжлөөс үүдэлтэй газар ашиглалтын хэлбэрт гарч буй өөрчлөлт | АЖ-ын зориулалтаар газар ашигласнаас үүдэн байгалийн унаган төрхөд гарч буй өөрчлөлтүүд, ландшафтын өөрчлөлт, хөрсний эвдрэл, элэгдлийн хэмжээ, хурдац | ТХГН-ийн хамгаалалтын захиргаа | Тодорхой менежментийн төлөвлөгөөний хэрэгжих хугацаанд |
| | ТХГН-т үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазуудын тоо, хоорондын зай | Бааз хоорондын зай улсын стандартанд нийцсэн байх | ТХГН-ийн хамгаалалтын захиргаа | Жил бүр |
| | АЖ-ын үйл ажиллагаанд зориулсан газрын менежмент | Тухайн ТХГН-ийн онцлогоос хамаарсан АЖ-ын онцлог байгууламжууд: цанын бааз, гольфын талбай, загасчлах газар г.м | ТХГН-ийн хамгаалалтын захиргааны хамгаалтын үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт | Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаанд |
| Аялал жуулчлалын зориулалтаар ашиглагдаж буй тээврийн хэрэгсэл, түүнээс үүдэн гарах үр дагаврыг бууруулах | Тээврийн салбарын үйл ажиллагаанд АЖ-аас үүдэн гарч буй өөрчлөлт | Жуулчны улирлын хугацаанд тухайн ТХГН уруу чиглэсэн тээврийн хэрэгсэлийн давтамжийн өөрчлөлт | ТХГН-ийн нэвтрэх постын бүртгэл | Жил бүр |
| | Жуулчдын тээврийн хэрэгсэл ашиглалтын төрөл | Тухайн ТХГН-ийн орчны болон дотоод бүсэд аялал жуулчлалын зориулалтаар ашиглагдаж буй тээврийн хэрэгсэлүүдийн төрөл, бензин ашиглалтын хэмжээ, хүлэмжийн хий ялгаруулалтын хэмжээ | ТХГН-ийн гол нэвтрэх цэгүүдээр орсон автомашины тоо хэмжээ, агаарын чанарын улсын стандарт | Жил бүр |
| | Тухайн тээврийн хэрэгсэлүүдээр АЖ-ын гол үзмэр, сайтуудад хүрэх боломж | ТХГН-т хүрэх болон дотоодод зорчих замын урт, төрөл, зам тээврийн үйлчилгээ үзүүлдэг барилга байгууламж | ТХГН-ийн мэдээллийн сан | 4 жилд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Эрчим хүчний хэрэглээ, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг дэмжих | АЖ-ын үйлчилгээнд ашиглагдаж буй эрчим хүчний төрөл , эрчим хүч хэмнэх хөтөлбөртэй эсэх | АЖ-ын тээвэр, орон байр, үйлчилгээнд ашиглагдаж буй эрчим хүчний төрөл, эх үүсвэр, хэмжээ | Тухайн ТХГН-д үйл ажиллагаа явуулж буй жуулчны байгууллагууд, орон нутгийн захиргаа | Жил бүр |
| | Сэргээгдэх эрчим хүч хэрэглэдэг эсэх | Аялал жуулчлалын зориулалттай барилгын зураг төсөл, дизайн нь нарны халаалт, байгалийн сэрүүцүүлэх системийг шийдэлдээ оруулсан байх | Тухайн ТХГН-д үйл ажиллагаа явуулж буй жуулчны байгууллагууд, орон нутгийн захиргаа | Жил бүр |
| Усны зохистой хэрэглээ, усны нөөц баялгийг хамгаалах | АЖ-ын салбарын усны хэрэглээ | АЖ-ын салбарын ус ашиглалтын төрөл, хэмжээ | Тухайн ТХГН-д үйл ажиллагаа явуулж буй жуулчны байгууллагууд, орон нутгийн захиргаа | Жил бүр |
| | Ахуйн хэрэгцээний ус ашиглалт, чанарын нөлөөлөл | АЖ-ын зориулалтаар ашиглагдаж буй усны эх үүсвэр, төрөл, хэмжээ, чанарт гарч буй өөрчлөлт | Тухайн ТХГН-д үйл ажиллагаа явуулж буй жуулчны байгууллагууд, орон нутгийн захиргаа | Жил бүр |
| | Борооны усыг цуглуулан ахуйн хэрэглээнд ашигладаг байх, ус хэмнэх арга хэмжээний хөтөлбөртэй эсэх | Дахин ариутгасан болон байгалийн усыг усалгаа, угаалга, жорлонгийн ус, сэрүүцүүлэх хиймэл усан багануд зэрэгт хэрэглэдэг байх | Тухайн ТХГН-д үйл ажиллагаа явуулж буй жуулчны байгууллагууд, орон нутгийн захиргаа | Жил бүр |
| | Бохир ус зайлуулах, цэвэрлэх технологи | АЖ-ын үйлчилгээ, үйлдвэрлэлээс гарч буй бохир болон хаягдал усны хэмжээ, цэвэршүүлэх ба зайлуулах арга хэмжээний хэлбэр | Тухайн ТХГН-д үйл ажиллагаа явуулж буй жуулчны байгууллагууд, орон нутгийн захиргаа | Жил бүр |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Хог хаягдлын менежмент, дахин боловсруулалт | АЖ-аас үүдэлтэй хог хаягдалын хэмжээ | Нэгж жуулчинд ноогдох хог хаягдлын хэмжээ, хог хаягдлын хуримтлалын цаг хугацааны давтамж, хог хаягдал зайлуулах, цэвэрлэх хэлбэр | Тухайн ТХГН-д үйл ажиллагаа явуулж буй жуулчны байгууллагууд, орон нутгийн захиргаа | Жил бүр |
| | Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн нөхөрлөл нь хог хаягдлыг дахин боловсруулж ашиглах хөтөлбөртэй буюу ийм хөтөлбөрт хамрагдсан эсэх | Аюултай болон хортой хог хаягдлыг зүй зохистойгоор ангилж, зайлуулдаг байх | Тухайн ТХГН-д үйл ажиллагаа явуулж буй жуулчны байгууллагууд, орон нутгийн захиргаа | Жил бүр |
| Биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийн шалгуур, хамрах хүрээ | ТХГН-д зорин ирэгсэдийн тооны давтамжаас үүдэлтэй биологийн төрөл зүйлийн хомсдол | ТХГН-ийн биологийн төрөл зүйлд АЖ-аас үүдэн гарч буй өөрчлөлтүүд, ан амьтны тоон толгойн болон төрөл зүйлийн өөрчлөлт, хомсдол, ургамал бүрхэвчийн алдрал | ТХГН-ийн хамгаалалтын захиргаа, байгаль хамгаалагчдын «Орчинзүйн» ажиглалтын дэвтэр | 3-5 жилд |
| | Ой бүхий талбай, АЖ-аас үүдэн ойн санд учирч буй нөлөөлөл | ТХГН-ийн нийт ой бүхий газрын талбай, аялал жуулчлалын зориулалтаар ашиглагдаж буй ойн талбайн харьцаа, он сангийн бүрэлдэхүүн, түүнт гарч буй өөрчлөлтийн хэмжээ | ТХГН-ийн хамгаалалтын захиргаа, байгаль хамгаалагчдын «Орчинзүйн» ажиглалтын дэвтэр | 3-5 жилд |
| | Аялал жуулчлалын бизнес эрхлэгчид нь байгалийн унаган төрх, ургамалыг хэвийн байдалд нь байлгах, хамгаалах, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд оролцдог эсэх | Байгалийн баялгийг хэмнэж хамгаалахад, тухайлбал ТХГН, нуга, ой, бэлчээр зэрэг байгалийн эмзэг бүс нутагт байх ан амьтан, ургамалыг хамгаалахад тусалдаг байх, өөрийн үйл ажиллгааны хөтөлбөрт тусгасан байх | ТХГН-ийн хамгаалалтын захиргаа, байгаль хамгаалагчдын "Орчинзүйн" ажиглалтын дэвтэр, орон нутгийн захиргаа | 3-5 жилд\ хэрэгжилтийн үр дүн гарах хугацаа |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Байгаль хамгаалах үйл ажиллагааны менежмент | Бүс нутгийн цогцолбор газар/паркийн бүтээн байгуулалт | ТХГН-д АЖ-ын ба рекреацийн зориулалтаар ашиглагдаж буй талбай, шинээр бүтээн байгуулсан цэцэрлэгт хүрээлэн, үзмэр, паркууд | БОАЖЯ | Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаанд |
| | АЖ-ын бүс нутагт байгалийн гамшгаас сэргийлэх төлөвлөгөө | ТХГН-ын байгалийн гамшгаас сэргийлэх төлөвлөгөө | ТХГН-ын хамгаалалтын захиргаа | Тухайн ТХГН-ын хамгаалалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаанд |
| | ТХГН-д явагддаг тусгай сонирхолын аяллаас үүдэлтэй нөлөөллүүд | Тусгай сонирхолын АЖ-ыгн төрөл, хамрах цаг хугацаа, жуулчны тоон давтамж | ТХГН-ын хамгаалалтын захиргаа, байгаль хамгаалагчдын ажиглалтын дэвтэр | Тухайн ТХГН-ын хамгаалалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаанд |
| | ТХГН-т барьж байгуулсан зочин байршуулах байгууламжийн хүрээлэн буй орчинд ээлтэй байдал | ТХГН-д байгуулсан жуулчны баазуудын хэлбэр | ТХГН-ын хамгаалалтын захиргаа, Жуулчны баазуудын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан | Тухайн ТХГН-ын хамгаалалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаанд |
| | АЖ-ын зорин очих газрууд, голлох үзмэрүүд, зам маршрутын тэмдэг, тэмдэглэгээ | Тухайн ТХГН-т буй жуулчны зорин очих газрын төрөлжилт, хамгааллын зэрэг, хамгааллын үйл ажиллагаа, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа, тэмдэг, тэмлэглэгээний шинэчлэлт | БОАЖЯ, ТХГН-ын хамгаалалтын захиргаа | Тухайн ТХГН-ын хамгаалалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаанд |
| | Эко аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг дэмждэг эсэх | Экотуризмын бүтээгдэхүүн үйлчилгээ: төрөл, хэмжээ | ТХГН-ын хамгаалалтын захиргаа, Аялал жуулчлалын байгууллагууд | Тухайн ТХГН-ын хамгаалалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаанд |
| | Жуулчдын төлж буй төлбөр, татвараас ТХГН-ын хөгжил ба хамгаалалтанд зарцуулагдах байдал | АЖ-аас олж буй орлогоос тухайн орон нутагт төлж буй татвар, түүнээс байгаль орчныг хамгаалахад зарцуулагдагдаж буй хувь, боловсролд оруулж буй хөрөнгө оруулалт | ТХГН-ын хамгаалалтын захиргаа, орон нутгийн захиргаа | Жил бүр |

ТХГН-т аялал жуулчлалын үзүүлэх эдийн засаг, нийгмийн нөлөөллүүд болон шалгууруудыг a) эдийн засгийн b) нийгмийн c) соёлын нөлөөлөл хэмээн авч үзье. Эдгээр шалгууруудыг тухайн орон нутаг дахь ТХГН-н захиргааны мэргэжилтнүүд жилд нэг удаа үнэлж, БОАЖЯ-ны ТХГН-н захиргаа нь энэхүү үнэлгээг баталгаажуулан, ТХГН-т аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого тодорхойлоход ашиглаж байвал зохино.

Хүснэгт 3. *Аялал жуулчлалын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүд*

| Хамрах хүрээ | Зарчим | Шалгуурууд | Үнэлгээ |
|---|---|---|---|
| Эдийн засаг | *Орон нутгийн эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулахуйц АЖ-ыг хөгжүүлэх* | Орон нутгийн эдийн засагт оруулах хувь нэмэр | -3аас +3баллаар үнэлнэ |
| | | Жижиг дунд бизнест оруулах хувь нэмэр | -3аас +3баллаар үнэлнэ |
| | | Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтэд оруулах хувь нэмэр | -3аас +3баллаар үнэлнэ |
| Нийгмийн нөлөө | *ТХГН-ын нийгмийн аюулгүй байдлыг хамгаалах, нийгэмд үр ашигтайгаар АЖ-ын үйлчилгээг зохион байгуулах* | Хүн амын хэт төвлөрөл | -3аас +3баллаар үнэлнэ |
| | | ТХГН-ын талаарх хууль дүрмийн мэдээлэл, сурталчилгаа | -3аас +3баллаар үнэлнэ |
| | | Нийгмийн аюулгүй байдал | -3аас +3баллаар үнэлнэ |
| Соёлын нөлөө | *Нүүдэлчний соёл, уламжлалт ахуйг АЖ-ын бүтээгдэхүүн болгон оновчтой ашиглах, соёлын өвөө хадгалж хамгаалах* | Үндэсний хэв шинж хадгалж буй байдал | -3аас +3баллаар үнэлнэ |
| | | Уламжлалт соёл болон гадны соёлын уусалт | -3аас +3баллаар үнэлнэ |

Хүснэгт 4. *Аялал жуулчлалын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал*

| Шалгуурууд | Үзүүлэлтүүд | Тооцох аргачлал | |
|---|---|---|---|
| Орон нутгийн эдийн засагт оруулах хувь нэмэр | АЖ-ын ТХГН-т хамаарах шууд орлогын өсөлт | ТХГН-аар дамжин өнгөрсөний төлөө төлсөн хураамжийн орлогын өсөлтөөр тодорхойлогдоно. | |
| | Орон нутгийн эдийн засагт ТХГН-ын АЖ-аас орох хувь | Орон нутгийн татварын орлогод ТХГН-т үйл ажиллагаа явуулж буй АЖ-ын байгууллагуудаас оруулах татварын хувь хэмжээгээр тодорхойлогдоно. | |
| | Өрхийн орлогод АЖ-ын орлогын эзлэх хувь* | АЖ-ын харилцаанд оролцогч өрхүүдийн жилийн нийт орлогод АЖ-аас олж буй орлогын эзлэх хувиар тодорхойлогдоно. | |
| | Орон нутагт оруулсан шууд ба шууд бус хөрөнгө оруулалтын хэмжээ | АЖ-ыг хөгжүүлэх зорилгоор хийгдсэн шууд болон шууд бус хөрөнгө оруулалтын хэмжээгээр тодорхойлогдоно. | |
| Жижиг дунд бизнест оруулах хувь нэмэр | АЖ-ын байршуулах хэрэгслүүдийн өсөлт | Жуулчны бааз, зочид буудал, гэр буудлуудын тооны өсөлтөөр тодорхойлогдоно. | |
| | АЖ-тай холбоотой албан бус хөдөлмөрийн өсөлт | ТХГН-ын АЖ дагасан үйлчилгээний өсөлтөөр тодорхойлогдоно. | |

| | | | |
|---|---|---|---|
| Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтэд оруулах хувь нэмэр | Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтэд АЖ-ын хөдөлмөр эрхлэлтийн эзлэх хувь | АЖ-ын салбарт ажиллаж буй ажиллагсдын нийт хөдөлмөр эрхлэлтэд эзлэх хувиар тодорхойлогдоно. | |
| | АЖ-ын улиралд шинээр бий болж буй байнгын болон түр ажлын байрны тооны өсөлт | Байнгын ажлын байрны тооны өсөлт болон түр ажлын байрны тооны өсөлтөөр тодорхойлогдоно. | |
| Хүн амын хэт төвлөрөл | Хүн амын механик өсөлт* | АЖ түшиглэж бусад сумдуудаас шилжин ирэгсдийн тоогоор тодорхойлогдоно. | Тухайн жилийн нийт хүн ам – суурь оны нийт хүн ам |
| | Нийгмийн үйлчилгээний хүртээмж, алслагдсан байдал | ТХГН-т оршин сууж буй иргэдэд ноогдох эмч, цагдаагийн ажилчдын тоо, үйлчилгээнээс алслагдсан байдал | |
| | ТХГН-т оршин сууж буй хүн ам болон орон нутгийн нийт хүн амын харьцаа | ТХГН-т тухайн орон нутгийн нийт хүн амын хэдэн хувь нь суурьшиж байгаагаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл ТХГН дахь хүн амын нягтшил хэр байгаагаар тодорхойлогдоно. | |
| ТХГН-ын талаарх хууль дүрмийн мэдээлэл, сурталчилгаа | Мэдээллийн самбар болон нээлттэй байдал | Шинээр нэмэгдэж буй мэдээллийн самбар, веб хуудаст хийсэн шинэчлэлээр тодорхойлогдоно. | |

| | | | |
|---|---|---|---|
| Нийгмийн аюулгүй байдал | АЖ-ын бүсэд гарсан гэмт хэрэг, зөрчлийн тоо, түүний өсөлт | ТХГН-т гарсан гэмт хэрэг, зөрчлийн тооны өсөлтөөр тодорхойлогдоно. | |
| | Мансууруулах бодис, мөрийтэй тоглоомд өртсөн залуучуудын тоо, түүний өсөлт* | Мансууруулах бодисын хэрэглээ, мөрийтэй тоглоомд өртсөн залуучуудын тооны өсөлтөөр тодорхойлогдоно. | |
| | Нийгмийн эмх замбараагүй байдал үүсч буй эсэх | Нийгмийн эмх замбараагүй байдал хэдэн удаа үүссэн, ямар шалтгаанаар үүссэнээр тодорхойлогдоно. | |
| | Үндэсний хэв шинж, архитектурын шийдэл бүхий барилга, байгууламж хотхоны өсөлт* | Үндэсний хэв шинж хадгалсан барилга байгууламжийн тооны өсөлтөөр тодорхойлогдоно. | |
| Үндэсний хэв шинж хадгалж буй байдал | Аяллын багцад үндэсний уламжлалыг сурталчлах хөтөлбөрүүдийн тоо | АЖ-ын байгууллагуудын санал болгож буй аяллын багцад эзлэх хувиар тодорхойлогдоно. | |
| | Үндэсний хувцас хэрэглэдэг байгууллагууд, үйлчилгээний газруудын өсөлт | Үндэсний хувцас хэрэглэдэг АЖ-ын байгууллагуудын тооны өсөлтөөр тодорхойлогдоно. | |
| | Нутгийн түүх, соёл, ахуй, зан заншлыг илэрхийлсэн аяллууд, арга хэмжээний өсөлт | Нутгийн түүх, соёл, ахуй, зан заншлыг илэрхийлсэн аяллууд, арга хэмжээний өсөлтөөр тодорхойлогдоно. | |
| | Түүх, соёлын дурсгалт газруудын эвдрэл, гэмтлийн хувь* | АЖ-аас шалтгаалж эвдэрч гэмтсэн хувиар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл АЖ-ын даац хэтэрсэнээс үүсч болох эвдрэл гэмтлийн хувиар тодорхойлогдоно. | |

| | | | |
|---|---|---|---|
| Уламжлалт соёл болон гадны соёлын уусалт | Соёлын арга хэмжээнүүдийн харьцаа | Уламжлалт хэв маягийг хадгалсан соёлын арга хэмжээ болон орчин үеийн соёлыг илэрхийлсэн арга хэмжээний харьцаагаар тодорхойлогдоно. | |
| | Шинээр орж ирж буй шашны урсгалын өсөлт* | Шашны байгууллагуудын өсөлтөөр тодорхойлогдоно. | |

*Тайлбар: * Аялал жуулчлал төдийлөн хөгжөөгүй байгаа ТХГН-уудад одоохондоо тооцох шаардлагагүй.*

Аялал жуулчлалын хөгжлөөс шалтгаалан ТХГН-ын менежмент, дэд бүтцийн үзүүлэх нөлөөллүүд ба шалгууруудыг a) менежментийн, b) дэд бүтцийн буюу хөрөнгө оруулалтын төслийн c) аялал жуулчлалын байгууллага, жуулчдын нөлөөлөл хэмээн авч үзье. Эдгээр шалгууруудыг БОАЖЯ-ны ТХГН-ийн захиргаа нь ТХГН-ийн захиргааны ажилд мониторинг хийх зорилгоор жилд нэг удаа үнэлж байх нь зүйтэй юм.

*Хүснэгт 5. Аялал жуулчлалын менежмент, дэд бүтцэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд*

| Хамрах хүрээ | Зарчим | Шалгуурууд | Үзүүлэлтүүд |
|---|---|---|---|
| Менежмент | НИТАЖ-н хөгжилд нутгийн иргэдийн оролцоог хангаж, эрх ашиг, сонирхлыг хамгаалах | Тогтолцоо | НИТЭЖ-н орон тооны буюу орон тооны бус байгууллагын үйл ажиллагаа |
| | | | НИТЭЖ-н байгууллагын дүрэм, журам нь ил тод, оролцогчдын эрх ашгийг тэгш хамгаалсан байдал |
| | | Бодлого, хөтөлбөр | НИТЭЖ-н үндсэн зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн ойрын болон хэтийн төлөвлөгөөнүүдийн хэрэгжилт |
| | | | НИТЭЖ-н байгууллагын зорилго, төлөвлөгөө нь орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдсан байдал |
| | | Сургалт, сурталчилгаа | Орон нутгийн тогтвортой хөгжлийн чиглэлээр оролцсон сургалт, семинарын тоо, хамрагдсан хүрээ |

| | | | |
|---|---|---|---|
| | ТХГН, түүний орчны бүсэд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн, нэгж, байггууллагууд сайн дураараа, харин аялал жуулчлалын байгууллагууд заавал ногоон гэрчилгээ авсан байх | Ногоон гэрчилгээжүүлэлтэд сайн дураар хамрагдсан байдал | Ногоон гэрчилгээ авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоо |
| | | Ногоон гэрчилгээтэй аялал жуулчлалын байгууллагууд | Аялал жуулчлалын байгууллагуудаас ногоон гэрчилгээ авсан хувь |
| | | Ногоон гэрчилгээг жил бүр баталгаажуулж байх | Ногоон гэрчилгээг баталгаажуулсан аж ахуйн нэгж, байгууллагын тоо, хувийн өсөлт* |
| | Жуулчны ёс зүйн журам | Жуулчны ёс зүйн журмыг танилцуулж, мөрдүүлдэг байдал | Жуулчны ёс зүйн журамтай эсэх |
| | | | Жуулчны ёс зүйн журам тараагдсан тоо |
| | | | Дотоодын аялагчдад жуулчны ёс зүйн журам тараагдсан хувь* |
| Стратеги төлөвлөгөө болон үнэлгээ | Хөрөнгө оруулалт, дэд бүтцийн хөгжлийн төслүүд урьдчилан төлөвлөгдсөн байх, БОНҮ болон бусад холбогдох мэдээллүүд нийтэд ил тод байх | ТХГН, түүний орчны бүсэд хөрөнгө оруулалтын урт хугацааны стратегийг боловсруулсан байдал | Хөрөнгө оруулалт, дэд бүтцийн төслүүдийн чиглэлийг тодорхойлсон байдал |
| | | БОН үнэлгээ хийгдсэн эсэх | БОНҮ хийгдсэн байдал |
| | | Хөрөнгө оруулалтын төслүүдийн талаар мэдээлэл нийтэд ил тод байдал | Төслүүдийн талаарх мэдээлэл нийтэд ил тод болсон байдал |

*Тайлбар: * Аялал жуулчлал төдийлөн хөгжөөгүй байгаа ТХГН-үүдад одоохондоо тооцох шаардлагагүй.*

ТХГН-ын байгаль орчинд аялал жуулчалын үзүүлэх нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүдийг тооцсоны дараа үзүүлэлт тус бүрийг эерэг болон сөрөг нөлөөлөл талаас нь (-3)-аас (+3) баллаар үнэлнэ.

| -3 | -2 | -1 | 0 | 1 | 2 | 3 |
|---|---|---|---|---|---|---|
| Сөрөг нөлөө маш их | Сөрөг нөлөө дунд зэрэг | Сөрөг нөлөө багатай | Огт нөлөөгүй | Эерэг нөлөө багатай | Эерэг нөлөө дунд зэрэг | Эерэг нөлөө маш их |

Шалгуур үзүүлэлтүүдийг тооцохдоо дараах ангиллын дагуу аялал жуулчлал эрчимтэй хөгжиж, аялал жуулчлалын нөлөөлөл тодорхой хэмжээнд үүсээд байгаа ТХГН-ууд болон аялал жуулчлалын хөгжлийн түвшнөөс шалтгаалан нөлөөлөл гарч эхлэх хандлагатай байгаа ТХГН-уудад тооцогдох үзүүлэлтүүд нь ялгаатай байхаар бодолцсон болно. Өөрөөр хэлбэл аялал жуулчлал эрчимтэй хөгжиж буй ТХГН-уудад ***Хүснэгт 1-5 хүртэл*** тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүдийг бүгдийг тооцох шаардлагатай бөгөөд бусад ТХГН-уудад **()-**оор тэмдэглэсэн шалгуур үзүүлэлтүүдийг өнөөгийн байдлаар тооцох шаардлагагүй гэж үзсэн.

**Аялал жуулчлал эрчимтэй хөгжиж байгаа улсын ТХГН-ууд**

1. Горхи Тэрэлж БЦГ
2. Богд Хаан уул ДЦГ
3. Хөвсгөл нуур БЦГ
4. Хан Хэнтийн ДЦГ
5. Говь Гурван Сайхан БЦГ
6. Хангайн нуруу БЦГ
7. Орхоны хөндий БЦГ
8. Хөгнө Тарна БЦГ
9. Хорго Тэрхийн Цагаан нуур БЦГ
10. Хүйсийн найман нуур БДГ

**Аялал жуулчлал эрчимтэй хөгжиж байгаа орон нутгийн ТХГН-ууд**

11. Өгий нуур
12. Хархорин

**Аялал жуулчлалын нөлөөлөл тодорхой гарч эхлэх хандлагатай байгаа улсын ТХГН-ууд:**

1. Дарьганга БЦГ
2. Хустайн нуруу БЦГ
3. Молцог элс БЦГ
4. Онон Балж БЦГ
5. Даян дээрхийн агуй БДГ
6. Ээж хайрхан БДГ
7. Шилийн Богд БДГ
8. Уран тогоо-тулга уул БДГ

## 2. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ШАЛГУУРУУДЫГ ҮНЭЛЭХ УДИРДАМЖ

### *2.1 ТХГН-т аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглалт, газрын менежментийн*

***зохистой байдлыг хадгалах***

Тухайн ТХГН-ын аялал жуулчлалын бүс (БЦГ) болон аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй газрын (ДЦГ, БНГ) хэдэн хувь нь аялал жуулчлалын зориулалтаар ашиглагдаж буй байдал, жуулчны баазуудын хоорондын зайн харьцаа хадгалагдаж буй эсэх, аялал жуулчлалаас үүдэлтэй газрын хэв шинжид гарч буй өөрчлөлт зэргийг үнэлэх. Үнэлгээний оноог дараах байдлаар тооцоолно.

**+3 (эерэг нөлөө маш их):** Аялал жуулчлалын бүсэд зөвшөөрөл бүхий жуулчны баазуудын хоорондын зай 5 км буюу түүнээс дээш, зугаа цэнгээний болон спорт, үзмэрийн зориулалтын барилга байгууламжууд стандартын хүрээнд баригдсан, гадаргын хэв шинжид нөлөө үзүүлээгүй. Тухайн жуулчны байгууламжийг барихад хийгдсэн БОНБҮ-тэй бодит үйл ажиллагаа бүрэн нийцэж байгаа тохиолдолд.

**-3 (сөрөг нөлөө маш их):** жуулчны баазуудын хоорондын зай маш ойрхон (1 км буюу түүнээс дотогш), аялал жуулчлалын зориулалтын барилга байгууламжууд газрын гадаргын хэв шинж, өнгө үзэмжид зохицоогүй, БОНБҮ-ний дүгнэлт бодит үйл ажиллагааны хооронд зөрчил ихтэй.

**Анхаарах зүйл:** Газар ашиглалт, газрын менежментийн зохистой байдлын үнэлгээг байгаль хамгаалагчдын өдөр тутмын тэмдэглэлд тулгуурлан ТХГН-ийн хамгаалалтын захиргааны судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн хийх буюу, мэргэжлийн судлаачдаар хийлгэж, дүгнэлт гаргуулах шаардлагатай.

### *2.2 Аялал жуулчлалын зориулалтаар ашиглагдаж буй тээврийн хэрэгсэл, түүнээс үүдэн гарах үр дагаврыг бууруулах*

Аялал жуулчлалын улирлын хугацаанд тухайн ТХГН-аар нэвтэрч буй тээврийн хэрэгслийн тоо хэмжээ, давтамж, төрөл, ангилал, ашиглалтын хугацаа болон тээврийн хэрэгслүүдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллага, барилга байгууламж, замын төрөл, хэв шинж, зам ашиглалтын байдал.

**+3 (эерэг нөлөө маш их):** ТХГН-ийн дотоодод тээврийн хэрэгслүүдийн ашиглалтын хэмжээ харьцангуй бага, ердийн хөсгийн хэрэглээ өндөр, зориулалтын зам харгуйг бүрэн ашигладаг, хууль бусаар зам, салаа гаргах үзэгдэл байхгүй, жуулчдын тээврийн хэрэгслүүд стандартын шаардлага

хангасан.

**-3 (сөрөг нөлөө маш их):** Төвлөрсөн зам харгуй багатайгаас үүдэн зохион байгуулалтгүйгээр олон салаа зам гаргаж, хөрс маш ихээр сүйдсэн, ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүдийн чанар муу, стандартын шаардлага хангахгүй, агаарт хүлэмжийн хий маш их хаядаг.

**Анхаарах зүйл:** Тухайн ТХГН-т нэвтрэн орж буй машин тус бүрийн мэдээлэл постод тэмдэглэгддэг байх, байгаль хамгаалагчдын өдөр тутмын тэмдэглэлд тулгуурлан ТХГН-ийн хамгаалалтын захиргааны судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн хийх буюу, мэргэжлийн судлаачдаар хийлгэж, дүгнэлт гаргуулах шаардлагатай.

### *2.3 Эрчим хүчний хэрэглээ, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг дэмжих*

ТХГН-т аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, үйлчилгээний газрууд, жуулчны баазуудын эрчим хүчний хангамжийн эх үүсвэр, хэрэглээний хэмжээний мэдээлэлд үндэслэнэ.

**+3 (эерэг нөлөө маш их):** Жуулчны байгууллагууд эрчим хүчний эх үүсвэрээ 100 хувь сэргээгдэх эрчим хүчээр хангасан тохиолдолд эерэг нөлөө маш ихтэй гэсэн үнэлгээг өгнө.

**-3 (сөрөг нөлөө маш их):** Эрчим хүчний эх үүсвэрээ дизель түлшээр хангадаг, ой модыг 100 хувь дулааны эх үүсвэр болгон ашигладаг зэргийг харгалзан энэхүү үнэлгээг өгнө.

**Анхаарах зүйл:** ТХГН-ийн хамгаалалтын захиргааны судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн, тухайн бүс нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын холбогдох мэргэжилтэнтэй хамтран дүгнэлт гаргах.

### *2.4 Усны зохистой хэрэглээ, усны нөөц баялгийг хамгаалах*

Аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэж буй усны эх үүсвэр, ашиглалтын хэмжээ, чанар, бохир усыг зайлуулах буюу дахин цэвэршүүлэх технологи зэргийг үнэлэх, аялал жуулчлалаар дамжуулан усны нөөц хэмнэх үйл ажиллагааг дэмжих зорилгоор үнэлнэ.

**+3 (эерэг нөлөө маш их):** Жуулчны байгууллагуудын ус

ашиглалтын эх үүсвэр, ус ашиглалтын үр ашигт байдал өндөр, хур борооны ус цуглуулан ахуйн зориултаар ашигладаг, бохир усыг биологийн аргаар цэвэршүүлэн дахин ашигладаг тохиолдолд эерэг нөлөө маш ихтэй гэж үнэлнэ.

**-3 (сөрөг нөлөө маш их):** Усны эх үүсвэрээ 100 хувь гүний усаар хангадаг, усыг үр ашигтай зарцуулах хөтөлбөр байхгүй, хаягдал болон бохир усаа зориулалтын дагууд зайлуулдаггүй газрын хөрсөнд шууд шингээх буюу ил задгай асгадаг тохиолдолд сөрөг нөлөө маш ихтэй гэж үнэлнэ.

**Анхаарах зүйл:** ТХГН-ийн хамгаалалтын захиргааны судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн, тухайн бүс нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын холбогдох мэргэжилтэнтэй хамтран дүгнэлт гаргах. Байгаль хамгаалагчдын хяналт, мэдээлэл чухал ач холбогдолтой.

### *2.5 Хог хаягдлын менежмент, дахин боловсруулалт*

Аялал жуулчлалын үйл ажиллагаанаас үүдэлтэй хог хаягдлын хэмжээ, чанар, байгаль орчинд учруулж буй хохирлыг үнэлэх, хог хаягдалын менежментийн үр ашгийг дээшлүүлэх. Хог хаягдал зайлуулах, цэвэрлэх технологийг боловсронгуй болгох зорилгоор энэхүү шалгуурыг үнэлнэ.

**+3 (эерэг нөлөө маш их):** Жуулчны байгууллагууд хог хаягдалаа бүрэн ангилан цуглуулж, технологийн дагууд хадгалж, зайлуулдаг. Дахин ашигладаг. Жуулчны баазын эзэмшил газраас гадуур үндсэн зам дагууд болон, үзмэрүүдийн орчинд хогийн цэг тодорхой, хүртээмжтэй байдаг.

**-3 (сөрөг нөлөө маш их):** Жуулчны байгууллагууд хог хаягдалаа стандартын дагууд ангилан ялгадаггүй, ил задгай хаядаг, гол үзмэрүүдийн дагууд болон отоглох цэгүүдийн орчимд хогийн сав, цэг тодорхойгүй, ил задгай маш ихээр хаядаг.

**Анхаарах зүйл:** Байгаль хамгаалагчдын мэдээлэлд үндэслэн ТХГН-ын хамгаалалтын захиргаа, мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран үнэлнэ.

### *2.6 Биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийн шалгуур, хамрах хүрээ*

ТХГН-д аялагчдаас болон аялал жуулчлалын үйл ажиллагаанаас үүдэлтэй биологийн төрөл зүйлийн хомсдол,

ойн эдэлбэр газар, ойн санд учирч буй нөлөөлөл, аялал жуулчлалын бизнес эрхлэгчид, жуулчид байгалийн баялгийг хэмнэж хамгаалахад, тухайлбал ТХГН, нуга, ой, бэлчээр зэрэг байгалийн эмзэг бүс нутагт байх ан амьтан, ургамалыг хамгаалахад тусалдаг байх, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан байх.

**+3 (эерэг нөлөө маш их):** Аялал жуулчлалаас үүдэлтэй ан амьтны болон ургамалын төрөл зүйлийн алдрал байхгүй, ан амьтны тоо толгой өсөж байгаа, ургамлын гарц сайн, жуулчид болон аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчид биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагаа санаачлан хэрэгжүүлдэг.

**-3 (сөрөг нөлөө маш их):** Аялал жуулчлалын үйл ажиллагаанаас үүдэлтэй ан амьтны тоо толгой ихээр хорогдсон, дуу чимээнээс ихээр дүрвэж дайждаг, ургамал нөмрөгийн алдрал, талхагдал маш их, биологийн төрөл зүйлийг хамгаалах ямар нэгэн хөтөлбөр, үйл ажиллагаа бараг байхгүй.

**Анхаарах зүйл:** Мэргэжлийн судлаач, мэргэжилтнүүдийн тусламжтайгаар байгаль хамгаалагчид энэхүү үзүүлэлтийг үнэлэх боломжтой бөгөөд, байгаль хамгаалагчдын орчин зүйн ажиглалтын дэвтэр хөтлөлтийг сайжруулах, үр дүнг үнэлж байх нь чухал.

## 3. ТХГН-ЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

ТХГН-ын нийгэм соёл, эдийн засагт аялал жуулчлалаас үзүүлэх нөлөөллийг ***Хүснэгт 1-5 хүртэл*** тодорхойлсон шалгуур үзүүлэлт тус бүрээр үнэлсэний дараагаар бүлэг тус бүрээр ерөнхий үнэлгээ гаргаж, (-3)-аас (+3) баллаар үнэлнэ.

| -3 | -2 | -1 | 0 | 1 | 2 | 3 |
|---|---|---|---|---|---|---|
| Сөрөг нөлөө маш их | Сөрөг нөлөө дунд зэрэг | Сөрөг нөлөө багатай | Огт нөлөөгүй | Эерэг нөлөө багатай | Эерэг нөлөө дунд зэрэг | Эерэг нөлөө маш их |

### *3.1 Орон нутгийн эдийн засагт оруулах хувь нэмэр*

Орон нутгийн эдийн засагт оруулах хувь нэмрийг гол нь

татварын орлого бүрдүүлэхэд үзүүлж буй хувь нэмрээр үнэлж буй бөгөөд энэ тохиолдолд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагууд нь хаана бүртгэлтэй байгаа нь чухал нөлөөтэй болно.

**+3 /эерэг нөлөө маш их/:** ТХГН-т үйл ажиллагаа явуулж буй АЖ-ын байгууллагууд нь бүх төрлийн татварыг орон нутагт оруулдаг бөгөөд цаг хугацаанд нь татвараа төлдөгөөс гадна АЖ-ын орлогоор өрхийн амжиргаагаа залгуулдаг өрх олон байна гэсэн үг.

**-3 /сөрөг нөлөө маш их/:** ТХГН-т үйл ажиллагаа явуулж буй АЖ-ын байгууллагууд нь татварын орлого бүрдүүлэлтэд нөлөөлж чаддаггүй, газрын төлбөр, усны төлбөр болон бусад төлбөрийг цаг хугацаанд нь төлдөггүй гэсэн үр дүн гарна.

**Анхаарах зүйл:** Орон нутгийн эдийн засагт оруулах хувь нэмрийг татварын талаас нь тооцоолохдоо хоёрдогч мэдээлэлд үндэслэх бол, өрхийн амжиргааны талаарх мэдээллийг тухайн үнэлгээ хийх хугацаанд анхдагч хэлбэрээр цуглуулах нь бодитой болно.

### *3.2 Жижиг дунд бизнест оруулах хувь нэмэр*

Жижиг дунд бизнесийн хөгжилд оруулах хувь нэмрийг үнэлэхдээ АЖ-ын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бизнесийн байгууллагуудын өсөлтийг харгалзахын зэрэгцээ дагавар үйлчилгээний салбарууд хэр өсөж байгаагаар тодорхойлно.

**+3 /эерэг нөлөө маш их/:** ТХГН-т үйл ажиллагаа явуулж буй АЖ-ын байгууллагууд өсч байгаа бөгөөд энэ нь орон нутгийнхаа бусад бизнесийн салбарт дэмжих нөлөө үзүүлж чадаж байна гэсэн үг.

**-3 /сөрөг нөлөө маш их/:** ТХГН-т үйл ажиллагаа явуулж буй АЖ-ын байгууллагууд нэмэгдэхгүй байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор бусад үйлдвэр үйлчилгээний салбарууд ч хөгжиж чадахгүй байгааг илэрхийлнэ.

**Анхаарах зүйл:** АЖ-ыг дагасан бусад үйлдвэр үйлчилгээний салбарын өсөлтийг тооцоолохдоо гол нь гар үйлдвэрлэл болон хувиараа эрхлэх аж ахуйн өсөлтийг орхигдуулахгүй тооцоолох ёстой.

### *3.3 Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтэд оруулах хувь нэмэр*

**+3 /эерэг нөлөө маш их/:** ТХГН-т үйл ажиллагаа явуулж буй АЖ-ын байгууллагууд нь орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, ажлын байр шинээр бий болгоход анхаарч ажилладаг.

**-3 /сөрөг нөлөө маш их/:** ТХГН-т үйл ажиллагаа явуулж буй АЖ-ын байгууллагууд нь орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах тал дээр огт анхаардаггүй, хүний нөөцөө гаднаас бүрдүүлдэг.

**Анхаарах зүйл:** АЖ-ын байгууллагуудаас мэдээлэл цуглуулахдаа байнгын болон түр ажлын байрны ялгааг маш сайн гаргах ёстой. Түр хугацаагаар ажиллуулж буй тохиолдолд хөдөлмөрийн хөлсний хэмжээ байнгын ажлын байртай харьцуулахад хэр зэрэг бага байгааг мөн анхаарах ёстой.

### *3.4 Хүн амын хэт төвлөрөл, нийгмийн үйлчилгээний хүртээмж*

**+3 /эерэг нөлөө маш их/:** ТХГН-т АЖ-ын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор хүн амын механик өсөлт бий болохгүй, хэт төвлөрөл нь нийгмийн ямар нэгэн хурцадмал асуудал бий болгохгүйгээс гадна АЖ-ыг дагасан тохиромжтой шилжих хөдөлгөөн бий болсоноор хүн амын бүтэц тэнцвэржих боломжтой болсон байх.

**-3 /сөрөг нөлөө маш их/:** АЖ-ыг дагасан хүн амын механик өсөлт ихээр бий болж, хүн амын хэт төвлөрөл бий болсоноор нийгмийн хурцадмал асуудлууд үүсэх болсон.

**Анхаарах зүйл:** Хүн амын механик өсөлтийг тооцохдоо гол нь АЖ-ыг даган орж ирж буй хүн амын өсөлтийг тооцох ёстой бөгөөд бусад салбар болох уул уурхай болон модны аж ахуйгаас ялгаж ойлгох ёстой.

### *3.5 ТХГН-ын талаарх хууль дүрмийн мэдээлэл, сурталчилгаа*

**+3 /эерэг нөлөө маш их/:** ТХГН-ийн талаарх хууль, дүрмийн сурталчилгаа сайн хийгддэг бөгөөд, нутгийн иргэд болон аялагчид ТХГН-ийн талаарх мэдлэг мэдээлэл сайтай байх нь ТХГН-ыг хайрлах хамгаалах гол эх үндэс нь болдог байх.

**-3 /сөрөг нөлөө маш их/:** ТХГН-ийн таалархи мэдээлэл сурталчилгаа дутмагаас жуулчид болон дотоодын аялагчид

ямар газар нутагт аялж яваагаа мэддэггүйгээс байгаль орчин бохирдуулах, ан амьтан, ургамалд хор хөнөөл учруулах зэрэг үйлдэл их гардаг байх.

**Анхаарах зүйл:** Хууль дүрмийн сурталчилгаа, ТХГН-ийн талаарх мэдээллийн хүртээмжийг мэдээлэлжүүлэлт болон бусад мэдээллийн самбарын тоогоор тодорхойлж болохоос гадна жуулчдаас судалгаа авч болох юм.

### *3.6 Нийгмийн аюулгүй байдал*

Нийгмийн аюулгүй байдлыг тодорхойлохдоо АЖ-ыг дагасан нийгмийн сөрөг үзэгдлүүд тухайн газар нутагт хэр зэрэг нэмэгдэж байгаагаар тодорхойлно. Тухайлбал, гэмт хэрэг, зөрчлийн тоо, мансууруулах бодисын хэрэглээ, биеэ үнэлэгчид зэрэг сөрөг нөлөөллүүд бий болж буй эсэхээр тодорхойлогдоно.

